



British Embassy
Ulaanbaatar



50
YEARS

Empowered lives. Resilient nations.

Хариуцлагатай уул уурхай

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Энэхүү сургалтын гарын авлагыг Иргэний Шийдэл Бодлогын Судалгааны Хүрээлэнгээс Австралийн Квинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэнтэй хамтран боловсруулав.

Үндсэн зохиогч

Далайбуяны Бямбажав

Хамтран зохиогчид

Доржсүрэнгийн Мөнхзул (7, 8-р модулийг бичсэн)

Вигьяа Шарма (5, 6-р модулийг хамтран бичсэн)

Сайнжаргалын Өсөхбаяр (9-р модулийг хамтран бичсэн)

Иван Гёзо Сомлай (Зөвлөж, хянан тохиолдуулсан)

Эрдэнэбилэгийн Гэрэлд-Од (Жишээ туршлагын судалгаа)

Талархал

Энэхүү төслийг санаачилж, мөн энэ гарын авлагыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан Ганхуягийн Уянга (НҮБХХ) болон төслийг амжилттай удирдаж, дэмжин тусалсан Жамбалын Должинсүрэн (НҮБХХ), Дүнхэрсүрэнгийн Отгончимэг (НҮБХХ), Нацагийн Мягмарцоож (Иргэний Шийдэл), Пүрвээгийн Шинэбаяр (Иргэний Шийдэл), Сайнжаргалын Өсөхбаяр (Иргэний Шийдэл) нарт талархал илэрхийлж байна.

Энэ гарын авлагыг уншиж, хөндлөнгийн санал, шүүмж өгсөн Раавани Редди (НҮБХХ), Ливиана Зорзи (НҮБХХ), Дэвид Бреретон (Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн), Надя Кунз (Олон Улсын Санхүүгийн Корпораци), Намхайжанцангийн Дорждарь (Баялгийн Баялгийн Засаглалын Хүрээлэн), Дашдоржийн Эрдэнэчимэг (Нээлттэй Нийгэм Хүрээлэн), Лорэн Бонилла (Коллеж Лондон Их Сургууль), Дэвид Доли (Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн), Пэлжээгийн Хишигдэлгэр (Бие даасан зөвлөх), Амгаагийн Батжаргал (Энержи Ресурс ХХК) and Рэгжийбуугийн Эрдэнэчимэг (АНУ-ын Азийн Сан) нарт талархал илэрхийлж байна.

Гарын авлагын бичих зорилгоор Төв аймгийн Заамар сум, Өвөрхангай аймгийн Уянга суманд хийсэн судалгаанд оролцсон орон нутгийн удирдлага, уул уурхайн компаниуд, орон нутгийн иргэд болон 2016 оны 3 сарын 21-нд Улаанбаатар хотноо зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож өөрсдийн үнэтэй санал, туршлага, жишээ, шүүмж зэргийг харамгүй хуваалцсан нийт илтгэгч, оролцогч нартаа гүн талархал илэрхийлж байна.

Удиртгал

Энэхүү гарын авлагын гол зорилго нь орон нутгийн удирдлага, иргэд, жижиг, дунд уул уурхайн компаниудын хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх явдал юм. Энэ гарын авлага нь уурхайн төслийн мөчлөг, орон нутгийн оролцогч талуудын хэрэгцээ, тулгамдсан асуудлуудыг хамруулсан хариуцлагатай уул уурхайн тухай цогц ойлголтыг танилцуулна.

Энэ гарын авлага нь хариуцлагатай уул уурхайн нийгмийн, байгаль орчны, засаглалын асуудлуудыг онцлон анхаарч үзнэ.

Энэ гарын авлага нь:

- Уурхайн төслийн мөчлөгийн тухай цогц ойлголтыг уул уурхайн мэргэжлийн болон мэргэжлийн бус суралцагч нарт өгнө.
- Уурхайн төслийн мөчлөгийн бүхий л үе шатанд гарах уурхайн нийгэм, соёл, байгаль орчны нөлөөллийг ойлгох, сөрөг нөлөөллөөс зайлхийх, бууруулах арга замуудын талаар мэдлэг, чадвар олгоно.
- Сайн түршлага болон бусад жишээ баримтуудыг танилцуулна.
- Цаашид их, дээд сургуульд хэрэглэгдэх хичээлийн хөтөлбөрийн суурь болно.

Энэхүү гарын авлагын дагуу зохиогдох сургалтын үндсэн оролцогчид нь орон нутгийн бодлого боловсруулагчид, ажилтнууд, орон нутгийн иргэд, уул уурхайн компаниудын ажилтнууд, ялангуяа жижиг, дунд компаниудын удирдлага, ажилтнууд байна. Мэдээж хэрэг, эдгээр оролцогч талуудын хувьд мэдлэг, чадавхийн хувьд ихээхэн ялгаа, зөрөө гарч болно. Түүнийг харгалзахын зэрэгцээ, гол нь хариуцлагатай уул уурхайн талаар нийтлэг ойлголт, мэдлэгийг бий болгохыг зохиогчид эрмэлзсэн юм.

Энэ гарын авлагыг Монгол улсад зориулан бичсэн хэдий ч ижил төстэй бусад улсуудад ашиглах боломжтой юм. Тийм учраас, зохиогчид Монголын онцлогтой зарим ойлголт, асуудлуудыг илүү дэлгэрүүлэн тайлбарлахын зэрэгцээ, Англи хэл дээрх маш олон эх сурвалжуудыг нэгэн адил танилцуулсан болно.

Энэ гарын авлага хариуцлагатай уул уурхайн бүхий л асуудлыг хамруулан авч үзэхийг зориогүй бөгөөд энэ төслийн хүрээнд хийсэн өргөн хүрээтэй тойм судалгаа болон орон нутагт хийсэн хэрэгцээ тодорхойлох судалгааны үр дүнд тогтоосон гол сэдэв, асуудлуудыг онцлон авч үзсэн. Оролцооны аргаар сургалтын хөтөлбөр боловсруулах аргыг ашиглаж дараах үндсэн үе шатуудын дагуу энэ гарын авлагыг зохиосон юм. Үүнд:

- Гарын авлагын урьдчилсан цар хүрээг боловсруулсан
- Орон нутгийн хэрэгцээ тодорхойлох судалгааг хийсэн

- Урьдчилсан цар хүрээг шинэчилж, гарын авлагын агуулгыг бичсэн
- Үндэсний хэлэлцүүлэг хурал зохион байгуулсан
- Хөндлөнгийн шинжээчид уншиж, санал шүүмж өгсөн
- Зохих засвар, өөрчлөлтийг оруулсан.

Энэ гарын авлага сэдэвчилсэн модулиудаас бүрдэнэ. Сургагч багш нар нь суралцагч нарын хэрэгцээнд нийцүүлэн модулиудаас сонгож болно. Сэдэвчилсэн модуль тус бүр дараах үндсэн бүрдэл хэсгүүдийг агуулна. Үүнд:

- Сургалтын зорилтууд
- Ерөнхий тойм
- Санал болгож буй хичээлийн цагийн хуваарь
- Сургалтын хэрэглэгдэхүүн
 - Үндсэн асуудлууд, хууль эрх зүйн зохицуулалт, олон улсын туршлага зэргийг тайлбарласан лекцийн тэмдэглэл (холбогдох эх сурвалж, лавлагааг танилцуулсан)
 - Холбогдох жишээ, туршлагууд
 - Сургалтын үр дүнг сайжруулахад чиглэсэн нэмэлт хэрэгсэлүүд. Үүнд, хэлэлцүүлгийн асуултууд, бүлгийн ажлын заавар, нэмэлт унших материалууд, мэдлэг шалгах асуултууд зэрэг орсон.
 - Дэлгэцээр танилцуулга хийх жишээ слайдууд
- Нэмэлт унших ном материалууд, цахим эх сурвалж
- Нэр томъёоны тайлбар

Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ	6
МОДУЛЬ 1. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	1
МОДУЛЬ 2. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО.....	16
МОДУЛЬ 3. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН МЕНЕЖМЕНТ	36
МОДУЛЬ 4. УУЛ УУРХАЙ БА ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ	51
МОДУЛЬ 5. УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ.....	73
МОДУЛЬ 6. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	92
МОДУЛЬ 7. УСНЫ МЕНЕЖМЕНТ.....	110
МОДУЛЬ 8. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ	125
МОДУЛЬ 9. ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРИУЦЛАГА	146

ТОВЧИЛСОН ҮГ ХЭЛЛЭГ

АМГ	Ашигт Малтмалын Газар	НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ББЗХ	Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн	ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	ОНХС	Орон Нутгийн Хөгжлийн Сан
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	ОУУУМЗ	Олон Улсын Уул уурхай, Металын Зөвлөл
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	ОҮИТБС	Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилга
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	ТААЗ	Тогтвортой Амьжиргааны Арга Зүй
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ТББ	Төрийн бус байгууллага
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	ТБУ	Тогтвортой Бичил Уурхай
ИТБХ	Ил тод байдал ба хариуцлага	УУЯ	Уул Уурхайн Яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчидийн Хурал	УННМ	Усны нөөцийн нэгдсэн менежмент
КНХ	Компанийн нийгмийн хариуцлага	ХЭНБУ	Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар	ХШ	Хяналт-шинжилгээ
ННБУ	Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ	ЦҮ	Цогц үнэлгээ
НШХ	Нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр	ШХА	Швейцарийн Хөгжлийн Агентлаг

МОДУЛЬ 1. ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Хариуцлагатай уул уурхайн үндсэн асуудлууд
- Олон улс болон Монгол улсад уул уурхайн салбарын хувьд тулгамдаж ирсэн асуудлууд, өөрчлөлт
- Уул уурхайн бизнесийн гол онцлогууд, түүнд зайлшгүй тулгардаг байгаль орчин, нийгмийн нөлөөлөл зэрэг асуудлуудыг тайлбарлах
- Уул уурхайн төслийн мөчлөгт холбогдох суурь ойлголтууд
- Уул уурхайн үйл ажиллагааны бизнесийн болон нийгмийн асуудлуудыг уул уурхайн төслийн мөчлөгтэй уялдуулан судлах
- Хариуцлагатай уул уурхай ба тогтвортой хөгжлийн уялдааг авч үзэх

Удиртгал

Энэ модуль нь суралцагч нарт уул уурхайн бизнес, уул уурхайн салбарт тулгамдаж ирсэн асуудлууд, чухал өөрчлөлтийн талаарх суурь ойлголт өгөх юм. Энэ хичээл нь дараах үндсэн 3 асуудалд төвлөрч явагдана. Үүнд:

Нэгд, хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчимуудыг танилцуулж, уул уурхайн салбар байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийн улмаас олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч ирсэн талаар авч үзнэ. Чингэхдээ уул уурхайн салбар нийгмийн энэ шаардлагад хэрхэн хандаж ирсэн болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн ойлголт, хандлага болон бодлогын өөрчлөлтийн талаар авч үзнэ. Энэ хэсэг гол төлөв олон улсын түвшинд гарч буй өөрчлөлтийн талаар үзэх боловч Монголд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн санаачлагуудыг мөн танилцуулах юм.

Хоёрт, энэ модуль нь уул уурхайн үйл ажиллагааны талаарх ойлголтууд ба “уурхайн амьдралын мөчлөг” буюу уул уурхайн төслийн гол үе шатуудыг танилцуулна. Ингэснээр уул уурхайн бизнесийн талаарх нийтлэг ойлголтыг бий болгох зорилготой юм. Энэ хэсэгт уул уурхайн бизнест тулгардаг эрсдэл, хэлбэлзлийн талаар зөв ойлголт өгөхөд зориулж хайгуулын үе шатны талаар харьцангуй дэлгэрэнгүй авч үзнэ.

Гуравт, энэ бүлэгт Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхэд уул уурхайн салбарын үүрэг оролцооны талаарх ид яригдаж буй хэлэлцүүлгийг танилцуулж, уул уурхайн гол давуу үүрэг, хувь нэмэр оруулж чадахуйц зорилтуудыг авч үзнэ.

Энэхүү модуль нь уул уурхайн мэргэжлийн буюу салбарын биш хүмүүст уул уурхайн үйл ажиллагааны талаарх суурь ойлголт, тулгарч буй бэрхшээл, бизнесийн эрсдэлүүдийн талаар ойлгоход нь туслах зорилго агуулахын зэрэгцээ уул уурхайн мэргэжилтэнүүд, хөрөнгө оруулагч нарт уул уурхайн төслийн үе шат бүрт анхаарч үзвэл зохилтой асуудлуудыг ойлгох, шийдэх арга замуудыг эрэлхийлсэн юм.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Хариуцлагатай уул уурхайн суурь зарчим
- Тогтвортой хөгжлийн талаарх ойлголт
- Сүүлийн 10 гаруй жил уул уурхайн салбарт гарсан чухал өөрчлөлтүүд
- Уул уурхайн бизнесийн онцлог
- Уул уурхайн салбарын бүтэц
- Уул уурхайн төслийн үе шат бүрийн онцлогууд /хайгуул, уурхайн бүтээн байгуулалт, олборлолт, хаалт/

Жишиг хуваарь

- Сэдвийн үндсэн танилцуулга (20 минут)
- Уул уурхайн бизнес (40 минут)
- Уул уурхайн бизнесийн тухай бүлгийн ажил (20 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p>Сэдвийн үндсэн танилцуулга</p> <p>Хариуцлагатай уул уурхай ба тогтвортой хөгжил (20 мин)</p> <p>Хариуцлагатай уул уурхай</p> <p>Уул уурхай нь нарийн төвөгтэй, хурдан явцтай үйл ажиллагаа юм. Орчин үед эрдэс баялаг нийгмийн хатуу, зөөлөн бүхий л бүтцийн гол орц болж чаджээ. Хүн амын өсөлт, хотжилт, орлогын өсөлт нь</p>	

илүү олон барилга, машины хэрэгцээг бий болгож, хэрэглээг тэлснээр уул уурхайн түүхий эд олборлох хэрэгцээ, шаардлагыг нэмэгдүүлсээр байна.

Уул уурхайн салбарын нөлөөгөөр газарзүйн байршлаас үл хамааран байгаль орчин, нийгмийн бүтцэд өөрчлөлт ордог. Энэ нь мөн тухайн газар нутгийн байгалийн тогтоц, ард иргэдийнх нь амьжиргаанд нөлөөлнө. Хариуцлагатай уул уурхайн олон чухал бүрдэл хэсгүүд уг салбар, төр засаг, иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээс хамааралтай боловч дараах дөрвөн чиглэл нь хариуцлагатай уул уурхайг тодорхойлогч цөм нь болдог юм. Үүнд:

- Тухайн нутгийн байгаль экологи, түүх соёлын өвийг хадгалах шаардлагыг ойлгох
- Байгаль орчинд ээлтэй уурхайн ашиглалтыг хэрэгжүүлэх
- Уурхайг ашиглах нь ажилчид болон уурхайн бүсэд харьяалагдах ард иргэдэд эерэгээр нөлөөлөх
- Засаглалын зохистой бүтэцтэй байх

(Илүү дэлгэрэнгүйг <http://www.responsiblemining.net> ба <http://miningwatch.ca/publications/2014/2/5/evolving-standards-and-expectations-responsible-mining-civil-society>

Тогтвортой хөгжил

1987 онд НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн хорооноос хэвлэн гаргасан “Бидний ирээдүй” Брундтландын тайланд тогтвортой хөгжлийг "хойч үеийн хэрэгцээг хязгаарлахгүйгээр өнөөдрийн хэрэгцээгээ хангаж чадах хөгжил” гэж тодорхойлжээ. Ерөнхийдөө, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн тэнцвэртэй хөгжлийг тогтвортой хөгжил гэж ойлгодог.

Уул уурхайн салбарын хувьд тогтвортой хөгжлийн талаар нэгдсэн тодорхойлолт байдаггүй. Дараах тодорхойлолтуудыг авч хэрэглэх нь бий. Үүнд:

- Нийгэм, байгаль орчин, эдийн засгийн суурь хөгжлийг уул уурхайнхан дэмжиж тогтвортой хөгжилд хүрч болно – James 1999.
- Хорогдож буй уул уурхайн баялгаас тодорхой хэсгийг нь хасч тооцон буцааж хөрөнгө оруулалт хийснээр – Labonne 1999.

- Байгаль орчны тогтвортой байдлыг эдийн засгийн өсөлт, нийгмийн шударга ёстой зэрэгцүүлэн хөгжүүлснээр – Eggert 2006.

(Илүү дэлгэрэнгүйг: Carsten Drebenstedt. 2014. The Responsible Mining Concept – Contributions on the Interface between Science and Practical Needs, in C. Drebenstedt and R. Singhal (eds.), *Mine Planning and Equipment Selection*, 3 DOI: 10.1007/978-3-319-02678-7_1)

Өнгөрсөн арван жилд уул уурхайн салбарын өөрчлөлт

1990-ээд оноос дэлхийн уул уурхайн салбар нь оршихуйн том асуудалтай тулгарчээ. Түүхий эдийн үнэ унаснаар уул уурхайн томоохон төслүүдийн асуудал дэлхий дахинд уул уурхайн эсрэг байгаль орчны төлөөх хөдөлгөөнийг идэвхжүүлжээ. Түүхэн явцад уул уурхайн салбар байгаль орчинд сөргөөр нөлөөлж, хүн ам шилжин суурьшихад хүргэснээр эдийн засаг, нийгмийн тэгш бус байдлыг өдөөж, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж байжээ. Тухайн үедээ түүхий эдийн хамааралтай эдийн засаг болон ДНБ-ний харилцан хамаарлын талаар судалгаа хийгдэж, үүнээс үүссэн сөрөг хамаарлыг “Баялгийн хараал” гэж нэрлэх болсон юм. Ингээд байгаль орчны бохирдол, нийгмийн бүтцэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөөсөө болж уул уурхайг асуудалтай салбар гэж үзэх болжээ.

2002 онд, Канадын Торонтод болсон Дэлхийн Уул уурхайн Санаачилга хурлаар тогтвортой хөгжилд шилжихэд уул уурхайн үзүүлэх үүргийг судлах зорилгоор уул уурхай, ашигт малтмал, тогтвортой хөгжлийн талаар хоёр жилийн хугацаатай хийгдсэн төслийг (Mining, Minerals and Sustainable Development Project-MMSD) зогсоохоор шийдвэрлэсэн юм. Уг төслийн тайлан /Breaking New Ground/-д уул уурхайн салбар үйл ажиллагаагаа эрхлэн явуулах “нийгмийн зөвшөөрөл”-ийг тухайн нутгийн иргэд, оролцогч талуудаас авч чадаагүй гэдгийг хүлээн зөвшөөрчээ.

Салбарын “оршихуйн хямрал”-ын үед дэлхийн хэмжээний томоохон компаниудын төлөөлөлтэй Олон Улсын Уул уурхай, Металын Зөвлөл (International Council on Mining and Metals ICMM)-ийг 2001 онд тогтвортой хөгжлийн асуудалд анхаарал хандуулах зорилготойгоор байгуулжээ. Тус зөвлөлийн бүх гишүүд Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх ёстой. Энэхүү үзэл баримтлал нь 10 гол зарчим, зургаан томьёоллыг багтаасан бөгөөд эдгээрийг байгууллагын бодлогод тусгах, ил тод, хариуцлагатай тайлагнах тогтолцоог нэвтрүүлэхэд оршино.

(Дэлгэрэнгүйг Humphrey, David. 2015. *The Remaking of the Mining Industry*. Palgrave; Franks, Daniel. 2015. *Mountain*

Movers: Mining, Sustainability and the Agents of Change. Routledge; ICMM. 2016. Our history. www.icmm.com)

2002 оноос хойш тогтвортой хөгжлийн арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр дараах үндсэн өөрчлөлтүүд гарсан юм. Үүнд:

- Уул уурхай, ашигт малтмалын салбар дахь тогтвортой хөгжлийн тухай ойлголт дээшилж, тогтвортой хөгжилд уул уурхайн оруулах хувь нэмрийн талаар илүү өргөн хүрээнд нарийвчлан ярих болсон.
- Тогтвортой байдал, иргэд олон нийттэй харьцах асуудлаар, тухайлбал компанийн дотоод менежментийн системийг боловсронгуй болгох болон бодлогын чиглэлээр уул уурхайн салбар тодорхой мэдэгдэхүйц алхмууд хийсэн
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага нь дүрэм журам болж тогтсон.
- Олон асуудлаар сайн туршлагыг хэрэгжүүлэх зааварчилгааны өргөн сонголттой болов.

(Дэлгэрэнгүйг: IIED. 2012. MMSD+10: Reflecting on a decade of mining and sustainable development <http://pubs.iied.org/16041IIED.html>)

2015 оны 8-р сараас улс орны засгийн газруус хамтран Тогтвортой хөгжлийн 17 шинэ зорилтыг (Sustainable Development Goals SDGs) баталж, байгаль орчныг хамгаалах, ядуурлыг эцэс болгох, тэгш бус байдалтай тэмцэх, хөгжлийг дэмжих 169 хэмжүүрийг тогтоон 2030 он гэхэд хэрэгжүүлж дуусахаар зорьж байна. 2015 оны 9-р сард Нью-Йорк хотноо болсон НҮБ EAЧ-ны үеэр дэлхийн хөгжлийн чиг баримжааг тогтоох “Дэлхий ертөнцөө өөрчлөх нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг дэлхий удирдагчид баталжээ. Энэ нь ирж буй цагийн дэлхийн хөгжлийг тодорхойлох нийтлэг зорилт болох юм.

Өнөөгийн байдлаар олон улсын томоохон байгууллагууд тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад уул уурхайн салбарын үр дүнтэй оролцоо ямар байх талаар нийтлэг томъёололттой болохоор хамтран ажиллаж байна. Хэрэв зөвөөр удирдан залж чадах аваас уул уурхайн салбар нь ажлын байр шинээр бий болгож, инновацийг нэвтрүүлэн, хөрөнгө оруулалтыг татаж, урт хугацаандаа дэд бүтцийн хөгжлийг асар ихээр тэтгэдэг. Зөв удирдан залж чадахгүй бол байгаль орчны бохирдол, ард иргэдийн шилжин суурьшилтыг өдөөх, мөргөлдөөн, тэмцэл гэх мэт олон сөрөг үр дагаварт хүргэдэг. Иймд уул уурхайн салбарт ажиллаж буй компаниуд дээрх зорилттой нийцэхгүй үйл ажиллагаа явуулбал уг зорилтод хүрэх боломжийг үгүй хийх болно.

Уул уурхай ба тогтвортой хөгжил



(Дэлгэрэнгүйг SDSN. 2016. Public Consultation on How Mining Can Contribute to the Sustainable Development Goals <http://unsdsn.org/news/2016/01/13/mining/>)

Уул уурхайн бизнес (40 минут)

Уул уурхайн үйл ажиллагааг ойлгох нь бодлого тодорхойлох, сайн харилцаа холбоо үүсгэн хөгжүүлэх, гарах үр дүн, нөлөөллийг зохицуулах төдийгүй бүр ашигт малтмалын салбарт хөрөнгө оруулалт амжилттай хийх боломжийг ч нэмэгдүүлдэг аж.

Уул уурхайн үйл ажиллагааны онцлог

Уурхай гэдэг нь газраас хүдэр болон бусад түүхий эдийг олборлох үйл явц юм. Бусад бизнесүүдийн нэгэн адилаар уурхай нь ашиг орлогоо, зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх зорилготой. Гэхдээ бусад салбараас ялгагдах хэд хэдэн чухал шинж чанартай.

- Уурхай нь ашигт малтмалын байгалийн илэрц, орд газраа дагадаг. Иймд уурхайн байршлийг сонгох боломж байхгүй. Иймд техник, нийгэм, байгаль орчны шийдлүүд өгөгдлөө дагаад өөр өөр байдаг.
- Олборлож буй хүдрийн найрлагаас хамаараад өөр өөр боловсруулалтын технологи шаарддаг.
- Уул уурхайн компаниуд олон янзын эрсдэлд өртдөг. Түүхий эд нийлүүлэгчийн хувиар зах зээл дээрх үнэ ханшны өөрчлөлтийн мөчлөгүүдэд мэдрэг. Шинэ уурхайн зөвшөөрөл авч байх үеийн түүхий эдийн үнэ, уурхайн бүрэн ажиллагаанд орсон үеийн түүхий эдийн үнэ маш их зөрүүтэй байх нь бий.
- Өртөг маш чухал. Бүтээгдэхүүний үнэ үйлдвэрлэгчийн хяналтаас гадуур, ухаалаг маркетинг, зах зээлд брэнд үүсгэх ямар ч боломжгүй тул үйлдвэрлэгчийн ашигтай ажиллагаа өртөг зардлаас маш их хамаардаг. Ийм учраас нөхцөл байдал хүндрэхэд үйлдвэрлэгчид хамгийн эхэнд өртөг зардлаа бууруулахаас өөр замгүй болдог байна (Humphreys, 2015).

(Дэлгэрэнгүйг: Humphrey, David. 2015. The Remaking of the Mining Industry. Palgrave).

Уул уурхайн салбар

Уул уурхайн салбарт олон төрлийн ААН үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрээс олонх нь үйлчилгээ эрхэлдэг, барилга, хайгуулын ангилах, олборлох, баяжуулах бизнес эрхлэн уул уурхайн дагалдах салбаруудад ажилладаг байна.

Дэлхийн хэмжээний том уурхайд 6000 компани, 2.5 сая орчим хүн ажилладаг. Ихэнхдээ уурхай нь алслагдмал, хөгжил буурай бүсэд байрлаж, урт хугацаандаа ажлын байр шинээр бий болгох, инноваци, хөрөнгө оруулалтыг татан, тухайн бүс нутгийн дэд бүтцийг танигдахын аргагүй болтол өөрчилж чаддаг. Олон Улсын Уул уурхай, Металын Зөвлөл (ICMM)-ийн үзэж байгаагаар бага болон дунд орлоготой ихэнх орны хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт (FDI)-ын 60-90%, экспортынх нь 30-60%, татварын 20%, Үндэсний Нийт Орлогын 10% хүртэлхийг уул уурхайн салбар нь дангаар бүрдүүлдэг аж.

Уул уурхайн салбар нь том жижиг олон ААН-ээс бүрэлдэнэ. BHP Billiton, Rio Tinto, Vale зэрэг үндэстэн дамнасан том компаниуд хөрөнгө босгох боломж өргөн байдаг тул бие даан томоохон орд газарт олборлолт хийх чадалтай. Хэдийгээр төрийн мэдлийн олон компани байдаг хэдий ч газрын тос, байгалийн хийн олборлох салбартай харьцуулахад гол тоглогчдын олонх нь хувийн хэвшлийн олон улсын корпораци байдаг. Хятадын Шэньхуа, Энэтхэгийн Көүл Индия Лимитэд зэрэг төрийн өмчийн компаниуд ихэвчлэн хайгуулын ажил хийдэг. Хөрөнгө босгох боломж, бололцоо муу тул шинэ уурхай ашиглахдаа тухайн төслийн хувьд оруулсан хөрөнгө оруулалтаас хамааралтай байдаг юм. Эдгээрийн цөөнх нь бие даан эсхүл бусад компанитай хамтран олборлолт хийдэг.

Дэлхийн Банкны тооцоогоор 30 улсад 15-20 сая гар аргаар олборлогчид байгаа аж.

(Дэлхийн уул уурхайн салбарын талаар илүү дэлгэрэнгүй, сонирхолтой мэдээллийг www.mining-atlas.com –аас авч болно. Энэ цахим хуудас нь 13000 гаруй уул уурхайн төслүүд, уурхайн мэдээллийг үзэж, хэрэв таны Интернет хөтөч Google Earth-д холбогдсон бол виртуал орчинд уурхайн орчинтой танилцах, уурхайн олборлолт, нөөц, орд гэх мэт мэдээлэл авах боломжтой. Манай улсад байдаг уурхайнуудыг хайгаад үзээрэй)

Уурхайн ашиглалтын нас

Уурхайн ашиглалтын нас хэд хэдэн үе шатаас бүрдэнэ. Энэ нь хэдэн жилээс хэдэн арван жил, бүр 100 жил үргэлжлэх нь ч бий. Эхлээд хайгуулын ажил, үнэлгээний үе шат (1-10+ жил), дараа нь уурхайн төлөвлөлт, барилга барих үе (2-5 жил), олборлолтын үе (2-100 жил), тэгээд уурхайг хаах, нөхөн сэргээх, хүлээлгэж өгөх (5-30+ жил) ажил хийгддэг. Үе шат тус бүр нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн олон асуулт, боломжийг бий болгодог.

Цаашилбал, ашиглалтын үе шат тус бүрт түүхийн эдийн үнэ, нийгэм-эдийн засгийн учир шалтгаантай “өсөлт, “бүүралт” гэсэн үечлэлүүд байна. “Өсөлт”-ийн үед түүхий эдийн эрэлт ихсэж, үнэ өссөнөөр олборлолтыг нэмэгдүүлдэг. Үүний дараа нийлүүлэлт эрэлтээ давснаар түүхий эдийн үнэ унаж, компанийн үнэ цэн буурч, хөрөнгө оруулалтын царцалт, уурхай хаагдах зэргээр “бүүралт” болдог (Humphreys, 2015).


Хайгуул

Хайгуулын ажил ашигт малтмалын ордын мэдээлэл, түүний эдийн засгийн үр өгөөжийг улам тодруулж, нарийвчилахад чиглэсэн хэд хэдэн үе шатын дагуу явагддаг. Хайгуулын ажил нь геологи, геохими, геофизик, зайнаас тандан судлахуй зэрэг олон салбар шинжлэх ухааны судалгааны үр дүнд хийгдэнэ.

Ашигт малтмалын хайгуулын ажлын гол зорилго нь ашигт малтмалын орд илрүүлэх явдал юм. Түүнчлэн одоогийн ашиглаж буй орд болон орхигдсон орд газрын үргэлжлэл, нэмэлт ордыг илрүүлэх зорилго байж болно. Өөрөөр хэлбэл хайгуулын үйл ажиллагааг дараах 2 төрөлд хувааж үзэж болно. Үүнд

- “Ногоон талбайн” буюу алслагдсан, шинэ талбайд хайгуул хийх
- “Хүрэн талбайн” буюу уурхайн талбайн ойролцоо хайгуул хийх

Ногоон талбайн хайгуулыг эхлэлийн ба ахисан түвшний хайгуулын төсөл гэж 2 ангилдаг.



Геологийн судалгаа нь хайгуулын ажлын суурь юм. Геологийн судалгааг нарийвчилсан хайгуул хийж болох харьцангуй бага хэмжээний талбайг тодорхойлоход ашигладаг. Дэлхийн ихэнх улсууд засгийн газрын харьяа үндэсний геологийн байгууллагатай байдаг бөгөөд гол төлөв 1:50,000 ба 1:100,000 харьцаатай геологийн зураглал хийсэн байдаг. Монгол улсын хувьд 1:200 000 харьцаатай геологийн ерөнхий зураглалыг нийт нутаг дэвсгэрт хийсэн, Харин 1:50 000 харьцаатай хийгдсэн геологийн нарийвчилсан зураглал нь нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг хамарч байна. Геологийн газрын зураг нь зөвхөн уул уурхайн зориулалттай биш юм. Харин түүнийг гүний усны хайгуул, дэд бүтцийн төслүүд, хөдөө аж ахуйн зориулалттай хөрсний судалгаа зэрэг маш олон талын зүйлд ашигладаг.

Юуны өмнө өргөн нутаг дэвсгэрийг хамарсан геологийн судалгаа хийгдэж, эрдэсжилтийн зураглал хийж, магадлал өндөртэй талбайнуудыг тогтоодог. Үүнд соронзон долгионы тусламжтайгаар томоохон газрыг хамруулсан геофизик тандалт судалгааг түлхүү ашиглаж байна. Хайгуул хийх талбайгаа тодорхойлсны дараа газар хөдлөлтийн судалгаа, хөрснөөс дээж авах, өрөмдлөг хийх зэрэг арга ашиглан хээрийн нарийвчилсан судалгааг хийнэ. Хайгуулын аргаас хамааран өнгөн хөрс хуулах, эсхүл тухайн талбайд хөдөө аж ахуйн ашиглалтыг зогсоох зэрэг арга хэмжээ авах болдог. Гэхдээ, талбайг сайтар төлөвлөснөөр үр нөлөөг багасгаж болно.

Хайгуулын ажил нь эрсдэл ихтэй. Жишээ нь зарим статистик мэдээллээс үзэхэд дунджаар 5000 болон 10 000 эхлэлийн хайгуулын ажлын нэг нь л амжилт олж, олборлолтын шатанд хүрсэн байдаг. Өөр нэгэн жишээ бол өрөмдлөгийн дүнд орд илрүүлэх магадлал юм. Өрөмдлөг нь маш өндөр өртөгтэй, ашигт малтмалын орд, хүдрийн нөөцийг тогтоох хамгийн найдвартай арга юм. Орчин үеийн техникийн дэвшилтийг ашиглан өндөр үр чадвар гарган хийсэн хэдий ч өрөмдлөг бүр нь амжилтад хүрнэ гэж байхгүй. Зарим тооцооллоос үзэхэд өрөмдлөгийн амжилттай байх буюу өндөр орцтой хүдрийн биет илрүүлэх магадлал 1 хуваас хэтэрдэггүй байна.

(Хайгуулын ажил, түүнд тулгардаг эрсдэлийн талаар эндээс уншина уу, Д.Гарамжав. Дурсамж -1. УБ 2014, С.Санждорж. Оюу Толгой төслийн хайгуулын ажлын тухай эргэн дурсахуй. УБ 2011, Д.Гарамжав. Ашигт малтмалын ордуудын эрлийн шалгуур шинж тэмдэг. УБ 2009)

Геологийн судалгаа, хайгуулын ажлын дараа уул уурхайн компаниуд техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгаа хийдэг. Ингэхдээ гол төлөв геологийн мэдээллийг эдийн засгийн мэдээлэлтэй хослуулан дүн шинжилгээ хийдэг. Уул уурхайн компаниуд зах зээлийн төлөв, хэлбэлзэлд анхаардаг. Эрэлт одоо хэр их байна вэ, ирээдүйд ямар болох вэ гм. Компаниуд мөн улс

төр-нийгмийн эрсдэлийг тооцно. Үүнд: орд газрын байршил, улс төрийн тогтвортой тогтвортой байдал, хангалттай ажиллах хүч байгаа эсэх. Эдгээр өгөгдлүүдийг сайн тооцсоны үндсэн дээр төлөвлөлтийн шатандаа ордог.

(Уул уурхайн төслийг хөгжүүлэхэд тулгардаг санхүүгийн эрсдэлийн талаар эндээс уншина уу, Жадамбын Жамул. Уул уурхайг санхүүжүүлэх үндсэн зарчим. УБ: 2012)

Уурхай байгуулах

Уурхай байгуулах гэдэг нь уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг /ТЭЗҮ/ боловсруулах, дэд бүтэц, барилгын ажлын үе шат юм. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах үе шат нь ихэвчлэн тойм судалгаа, урьдчилсан ба эцсийн судалгаа зэрэг алхмуудын дагуу хийгдэж, мэргэжлийн өндөр түршлагатай хүмүүс оролцдог. Энэ ажлын гол зорилго нь тухайн төсөл нь технологийн хувьд бүтээн байгуулж, ашиглалт явуулах боломжтой, эдийн засгийн хувьд ашигтай гэдгийг тодорхойлох явдал юм. Түүнчлэн ТЭЗҮ нь төслийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг агуулж, банк болон бусад хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох суурь баримт бичиг юм. Уул уурхайн төслийн төлөвлөлт нь олборлолтын арга, баяжуулах арга зэрэг үйлдвэрлэлийн технологийн асуудлуудыг тусгахын зэрэгцээ уурхайг ажиллуулахад шаардлагатай оролтууд буюу дэд бүтэц, ажиллах хүчин зэргийг тооцдог.

Уурхайн бүтээн байгуулалт нь уурхай, дэд бүтцийн ажлын зөвшөөрөл бүхий талбайд барилгын ажлын бэлтгэл хангахаас эхэлдэг. Энэ нь ургамлын бүрхэвч, хөрс, чулуулгыг хуулах, зөөвөрлөх, өмнө байсан барилга, байгууламж зэргийг шилжүүлэх ажил юм. Анхаарах зүйл бол энэ ажлын улмаас үүдэн гарах байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тооцсон менежментийн төлөвлөгөөтэй байх явдал юм. Талбайг бэлдэх ажлын дараагаар уурхайн эдэлбэр газрыг хашаалдаг. Мөн уурхайн дэд бүтэц буюу тээврийн зам, төмөр замын шугам, гүүр зэргийг барьж байгуулдаг. Уурхайн ажиллагсдын тав тухыг хангах ажличдын байр, уурхайн хотхонг байгуулах ба түүний хэмжээ нь уурхайн төслийн хэмжээ, ажиллах хүчний хэрэгцээнээс хамаарна.

Уурхайн үйл ажиллагааны төрлөөс барилгын ажил хамаарна. Гүний уурхайн хувьд олон янзын хонгил барих хэрэгтэй болно. Ил уурхайн хувьд карьерийн эргэн тойронд төрөл бүрийн байгууламжууд байх хэрэгтэй болдог. Баяжуулах үйлдвэрийн хувьд уурхайн олборлолтын талбайн ойролцоо баригдана. Хаягдалын далан ба хаягдал чулуулгийн цэг нь уурхайгаас гарч буй хаягдлыг

хадгалах зориулалттай баригдана.

(Эх сурвалж: Gavin Mudd. The Sustainability of Mining in Australia: Key Production Trends and Their Environmental Implications for the Future. Research Report No RR5, Department of Civil Engineering, Monash University and Mineral Policy Institute. 2007 <http://users.monash.edu.au/~gmudd/sustymining.html>)

Уурхайн бүтээн байгуулалтын үе шатанд зайлшгүй анхаарах ёстой асуудал бол тогтвортой хөгжил, орон нутгийн хүлээлт зэрэг асуудлыг нухацтай авч үзэх явдал юм. Харвардын Их Сургууль, Шифт хүрээлэн, Күинсландын Их Сургуулийн хамтарсан судалгаанаас үзэхэд уурхайн төслийн ТЭЗҮ болон барилгын үе шат нь орон нутгийн зүгээс эсэргүүцэл гарах, улмаар удаашрах, хаагдах эрсдэл хамгийн өндөртэй үе аж. Энэ үе шат нь орон нутгийн иргэд, ялангуяа томоохон хэмжээний уурхайн үйл ажиллагаа эхэлж буй орон нутгийн иргэдийн хувьд маш огцом өөрчлөлтийг бий болгож, түүнийг дагасан эрсдэл, ашиг сонирхол, зовнилыг бий болгодог.

(Дэлгэрэнгүйг эндээс уншина уу: Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. "Costs of Company-Community Conflict in the Extractive Sector." Corporate Social Responsibility Initiative Report No. 66. Cambridge, MA: Harvard Kennedy School. <http://shiftproject.org/publication/costs-company-community-conflict-extractive-sector>)

Олборлолт


Олборлох аргаар нь ил, гүний гэж хоёр хуваана. Ордын байршил, олборлолтын өртөг зардлаас хамаарч аль нэг аргыг нь ашиглана.

Ил уурхайн (ил уурхай, хөрс хуулалт, карьер, уусгаж ялгах, даралтаар уусгах) аргаар гадаргууд ойрхон ашигт малтмалыг олборлодог. Их хэмжээтэй, хурдан хугацаанд олборлолт явуулах боломжтой, судалд хүрэх газар шорооны ажил бага үед энэ аргыг хэрэглэнэ. Жишээ нь нүүрс, хүрэн нүүрс, боксит олборлоход өргөн хэрэглэдэг. Далд уурхайн (таславч үүсгэх, босоо ам үүсгэх, хонгилын, босоо амнаас хөндлөн ухах, нураах) аргаар ашигт малтмалын цөм хэсэг газрын гүнд байгаа, хүдрийн найрлага нь гүний уурхай ажиллуулах зардлыг давахуйц ашигтай үед хэрэглэнэ. Ил уурхайтай харьцуулахад гүний уурхай нь өртөг өндөртэй, аюултай аргад тооцогддог.

Баяжуулах

Үнэтэй метал, ашигт малтмалыг хөрснөөс ялгахыг баяжуулах гэж хэлнэ. Ашигт малтмал, метал бүр нь

Уурхайн цогцолборын жишээ



Source: <http://www.mining.com.au>

өөрийн гэсэн баяжуулах арга барил шаардана. Нүүрс, төмрийн хүдрийг баяжуулах бараг шаардлагагүй, зөвхөн буталж, угааснаар тээвэрлэх боломжтой. Алт, зэс, хөнгөн цагааны хувьд цэвэршүүлэх ажил нь олон шат дамжлагатай. Алттай шороог химийн бодис ашиглан угаадаг бол хөнгөн цагааны хүдрийг маш өндөр хүчдэлээр цохиулж ялгаж авна.

Баяжуулалтын дараа үлдсэн шороо, хаягдлыг нуруулдаж овоолдог. Уурхайгаас гарч буй хаягдал маш их. Дэлхий дахинд зөвхөн 2000 онд гэхэд 900 сая тонн метал олборлосон ба үүний хаягдал шороо нь 6 тэрбум тонн болжээ. Энэ тоонд хөрс хуулалтаас гарсан шороог оруулж тооцоогүй юм. Энэ хаягдал шорооны ихэнх нь төмрийн хүдэр, зэс, алт олборлох ажиллагаанаас гарчээ. Зөвхөн нэг тонн зэс олборлоход 110 тонн хаягдал шороо, чулуу гардаг бол хөрс хуулалтаар дахиад 200 тонн шороо гардаг аж. Алтны хувьд бүр ч их, 300 тонн шороо хаяж байж зах зээлд борлуулагдахуйц 1 тонн алт олборлодог нь ойролцоогоор хуримын нэг бөгжинд 3 тонн хаягдал шороо ногдоно гэсэн үг. Энэ хаягдал шороо нь алт ялгахын тулд хэрэглэсэн цианид, бусад химийн бодисоор хордсон байдаг.

(Payal Sampat, "Scrapping Mining Dependence," in State of the World 2003-ыг уншина уу
<https://ecoculture.files.wordpress.com/2010/03/scrapping-mining-dependence-payal-sampat.pdf>)

Уурхайн хаалт

Яваандаа бүх уурхай хаагдана. Зарим уурхайг эдийн засаг, логистикийн шалтгаанаар, мөн нөөц нь шавхагдсан учраас хаадаг. Зарим тохиолдолд зах зээлийн нөхцөл байдал сайжиртал түр хаах нь ч бий. Ямар ч уурхайг хааж, үйл ажиллагааг зогсоох нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд нөлөөлнө. Эдгээр үр дагаврыг уурхайг хаах төлөвлөгөөнд тусгадаг ба энд нөхөн сэргээлт, нийгэм-эдийн засгийн нөлөө, дэд бүтцийг шилжүүлэх гэх мэт гол асуудлуудыг тодорхой тусгаж, уурхай ашиглагдсан талбайн аюулгүй, тогтвортой байдлыг хангадаг. Нөхөн сэргээлт, уурхайн хаалт нь шинжлэх ухааны ойлголтоос гадна орон нутгийн иргэдийн оролцоог хангах, тэдний үнэт зүйл, мэдлэгийг ашиглах стратеги ач холбогдолтой. Нөхөн сэргээлт, уурхайн хаалтын төлөвлөгөөг хийхдээ газар нутгийн ландшафтын хувьд зөв шийдэлд хүрэх нь маш чухал.

(Хамгийн сүүлийн үеийн сайн туршлага "Mine rehabilitation in the Australian minerals industry"
http://www.minerals.org.au/file_upload/files/reports/Mine_rehabilitation_in_the_Australian_minerals_industry_FINAL.pdf.)

Бүлгийн ажил (20 минут)

Хувилбар 1: Уул уурхайн нийгмийн ба бизнесийн эрсдэлийг ойлгох нь

Орон нутгийн иргэд уул уурхайн үйл ажиллагааны улмаас учрах нийгэм, эдийн засаг, соёл, байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөллийн талаар санаа зовнидог бол уул уурхайн компаниуд бизнест учрах эрсдэлийн талаар санаа зовних нь их байдаг. Оролцогч нараас энэ 2 төрлийн эрсдэлийн талаар юу гэж бодож буй талаар асууж, хоорондоо хэрхэн үялдаатай болох талаар ярилцана уу. Хэрэв цаг хүрэлцвэл, зарим гол эрсдэлүүдийг хянах, бууруулах компани ба орон нутгийн удирдлага, зохион байгуулалтын арга замуудын талаар хэлэлцүүлэг өрнүүл. Тухайлбал, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах нэг чухал арга юм.

Хувилбар 2: Уул уурхайн төслийн мөчлөгийн үүднээс Ашигт малтмалын хуулийг судлах нь

Оролцогч нараас Ашигт малтмалын хуулийг уншиж дараах гол мэдээллийг тодруулахыг хүснэ үү.

	Хайгуул	Уурхайн бүтээн байгуулалт	Олборлолт	Нөхөн сэргээлт/хаалт
Хугацаа				
Компанийн эрх, үүрэг				
Нутгийн удирдлагын эрх үүрэг				
Нутгийн иргэдийн эрх, үүрэг				

Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

- Хариуцлагатай уул уурхайн гол асуудлууд нь юу болох, тогтвортой хөгжилтэй тус бүрдээ хэрхэн үялддаг вэ?
- Уул уурхайн салбарын бусад салбараас ялгагдах онцлог юу вэ (жишээ нь үйлдвэрлэл)?
- Бусад улстай харьцуулахад уул уурхайн төсөл хэрэгжүүлэхдээ Монголд юуг анхаарах шаардлагатай вэ?
- Танай орон нутагт илэрсэн гол ашигт малтмалууд юу вэ, тэдгээрийг олборлоход анхаарах

асуудлууд юу вэ?	
<p>Унших ном, материал</p> <p>Пол Коллиер. 2009. Адагт үлдсэн тэрбум. Улаанбаатар: Адмон. Franks, Daniel. 2015. Mountain Movers: Mining, Sustainability and the Agents of Change. Routledge Humphrey, David. 2015. The Remaking of the Mining Industry. Palgrave. НҮБХХ. 2011. Монгол Улсын Хүний Хөгжлийн Илтгэл.</p>	
<p>Үндсэн нэр томъёо, ойлголтуудын тайлбар</p> <p>Агаарын тандалт судалгаа – Онгоц, дрон, нисдэг бөмбөлөг ашиглан агаараас авсан зураг ашиглан соронзон орон, цацраг идэвхжил гм-ийг судлах.</p> <p>Хайгуул - хайгуул судалгаа, дээж авах, зураглал хийх өрөмдөх гм ашигт малтмалын хүдэр (судал, илэрц) хайх ажиллагаа.</p> <p>Ашигт малтмал - Биогеохимийн үрт хугацааны үйл явцын дүнд бий болсон, химийн тодорхой агууламжтай, физик шинж чанартай хатуу бодис. Алт, нүүрс, бадмаараг гм олон төрлийн, ойролцоогоор 2,500 гаруй ашигт малтмал бий.</p> <p>Ашигт малтмал - Геологи хайгуулын дүнд эдийн засгийн хувьд ашиглахад боломжтой, мэдэгдсэн, тооцоо судалгаа хийгдсэн олдвор.</p> <p>Ашигт малтмалын орд - эдийн засгийн хувьд ашигтай гэж тогтоогдсон, илүү нарийвчилсан мэдээлэл шаардлагатай цөм эрдэс</p> <p>Ашигт малтмалын нөөц - геологи хайгуулын хувьд сонирхолтой, эдийн засгийн хувьд ач холбогдолтой байж болох, цаашид судлах эрдэсийн хуримтлал</p> <p>Хүдрийн нөөц - олборлоход нөлөөлж болох бүх хүчин зүйлийг судалж тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай ашигт малтмалын орд газрын олборлож болох хэсэг</p> <p>Хүдэр - ашиг олох зорилгоор олборлож болохуйц эрдэс агуулсан чулуу, шороо</p> <p>Тогтвортой хөгжил - хойч үеийн хэрэгцээг хязгаарлахгүйгээр өнөөдрийн хэрэгцээгээ хангаж чадах хөгжил</p> <p>Хаягдал - Хүдрийг угаах, баяжуулах, боловсруулахад гарсан хаягдал</p>	

МОДУЛЬ 2. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Орон нутгийн оролцоог хангахын ач холбогдол
- Оролцогч талууд, зөвлөлдөх зэрэг олон нийтийн оролцооны гол ойлголтыг ойлгож, хэрэглэх
- Олон нийтийн оролцоог хангах ажлыг төлөвлөх
- Олон нийтийн оролцоог хангах талаарх компанийн бодлого, чадавхийг үнэлэх

Удиртгал

Энэхүү модулийн эхний хэсэгт уул уурхайн үйл ажиллагаанд олон нийт оролцохын ашиг тус, үр дүнд хүргэх стратегийн талаар авч үзнэ. Энэ хэсэгт хөндөж байгаа чухал асуудал бол олон нийтийн оролцооны бизнест үзүүлэх давуу талууд юм. Оролцогч талуудын идэвхтэй бүтээлч оролцоог зөвхөн дүрэм журмыг сахиулахад /байгаль орчин, ашигт малтмалын тухай хууль, эсвэл орон нутгийн эрх мэдэлтнүүдээс тавих шаардлага эсвэл эрх ашиг нь хөндөгдсөн иргэдийн шаардлага г.м/ чиглэсэн шаардлага гэдгээр хязгаарлан ойлгож болохгүй юм. Уул уурхайн аливаа төслийг амжилттай хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай. Энэ зорилгыг хэрэгжүүлэх нэн чухал алхам бол итгэлцэлд суурилсан харилцаа, зөв ойлголцолыг бий болгохын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Ийм харилцааг бий болгох нь компаниуд, орон нутгийн удирдлага болон орон нутгийн иргэдэд харилцан ач холбогдолтой юм. Модулийн хоёрдох хэсэг нь уул уурхайн компаниудын хувьд санал гомдлыг хүлээн авч барагдуулах механизмтай байхын ашиг тусын талаар авч үзнэ. Түүнчлэн санал гомдлыг хүлээн авч барагдуулах тогтолцоог бий болгох үндсэн үе шатууд ба зарчмуудыг тоймлон танилцуулна.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Оролцогч талуудын хэлбэр, төрөл
- Олон нийтийн оролцооны ач холбогдол
- Уул уурхайн үйлдвэрийн зүгээс оролцогч талуудын хувьд баримталж ирсэн хандлагууд: уламжлалт ба шинэлэг хандлагууд
- Олон нийтийн оролцоог хангах цогц хандлага
- Санал гомдол хүлээн авч шийдвэрлэх үр дүнтэй механизмын ач холбогдол

- Санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам боловсруулах
- Санал гомдол хүлээн авч шийдвэрлэх журамд тусгагдах шаардлагатай зүйлс

Жишиг хуваарь

- Сэдвийн танилцуулга (10 минут)
- Олон нийтийн оролцоог хангах цогц хандлага (30 минут)
- Олон нийтийн оролцооны тухай бүлгийн ажил (20 минут)
- Санал гомдол хүлээн авч, шийдвэрлэх механизм (20 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p>Сэдвийн танилцуулга (10 минут)</p> <p>Орон нутгийн иргэд ба оролцогч талууд</p> <p>Жижиг, дунд уурхайн хувьд олон нийт эсвэл орон нутгийн олон нийт гэдэгт компанийн үйл ажиллагаа явуулж байгаа шууд болон эргэн тойрны газар нутагт амьдардаг оршин суугчдыг ойлгоно. Монголын жишээн дээр эрдэс баялаг олборлох төсөл хэрэгжүүлж байгаа нэг болон хэд хэдэн сумын оршин суугчдыг ихэвчлэн ойлгодог.</p> <p>Уул уурхайн нэгэн чухал ойлголт бол оролцогч талууд юм. Оролцогч тал гэх ойлголт нь нилээд түгээмэл болсон боловч хүн ам, олон нийтээс ялгаатай ойлголт юм. Оролцогч талын түгээмэл тодорхойлолт нь “тодорхой шийдвэр гаргахад оролцох сонирхолтой бүлгийн төлөөлөгч эсвэл хувь хүнийг хэлнэ. Үүнд шийдвэр гаргахад нөлөөлөх эсвэл шийдвэр гаргаж чадах, түүнчлэн гаргасан шийдвэрт өртөх хүмүүс багтана”.</p> <p>Оролцогч талуудыг анхдагч болон хоёрдогч гэж ангилж болно. Үйл ажиллагаа явуулах орон нутгийн хүн амыг “анхдагч” оролцогч тал буюу “үндсэн” оролцогч тал гэнэ. Зарим нэг чухал</p>	<p>The diagram illustrates the hierarchy of stakeholders. At the center is a red circle representing the 'Төсөл' (Project). Surrounding it is a green circle representing 'Анхдагч оролцогч тал (шууд нөлөөлөлд өртсөн)' (Primary stakeholder (directly affected)). The outermost layer is a blue circle representing 'Хоёрдогч оролцогч тал (шууд бус нөлөөлөлд өртсөн)' (Secondary stakeholder (indirectly affected)).</p>

оролцогч тал орон нутгийн бус байх нь бий. Жишээ нь аймаг, улсын удирдлага, улс төрч, худалдаа болон үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, үндэсний нийгэм, байгаль орчны бүлгүүд, нутгийн зөвлөл, хэвлэл мэдээлэл багтана.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. “Иванс.Р, Кемп.Д 2011. Олон нийтийн асуудлууд. Шинжлэх ухаан ба инженерчлэлийн хэрэглэгдэхүүн- Уул уурхайн инженерчлэлийн гарын авлага”)

Оролцогч талын үр дүнтэй оролцооноос үүсэх бизнесийн давуу талууд

Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль дараах чухал заалтуудтай:

42.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

42.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

Мөн Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна (18.4 дүгээр заалт).

Оролцогч талын үр дүнтэй оролцоог хангана гэдэгт ашигт малтмалын тухай, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шиг зөвхөн нутгийн захиргааны удирдлагууд, хүн амтай уулзана гэсэн ерөнхий шаардлагаар хязгаарлагдахгүй юм. Компани болон нутгийн оролцогч талуудын харилцан ашигтай үр дүнтэй харилцаа, оролцоог хангах нь үр дүнтэй оролцооны чухал алхам юм. Жишээ нь:

- Хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагааны үе шатууд удаашрах нь компаниудад ихээхэн зардал төвөг учруулдаг. Иймд аль болох эрт оролцоо, харилцааг хангаж, зөвлөлдөх нь "үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл" авахад зайлшгүй шаардлагатай байдаг.
- Монгол дахь хайгуулын зөвшөөрөл хүсэгчид ихэвчлэн сумын захиргааны удирдлагуудаас хэд



хэдэн шалтгаанаар няцаагдсан байдаг. Хайгуул, олборлолтын төслийн үр ашиг, нөлөөллийн талаарх эрсдэлийг ойлгосон хэдий ч үүний гол учир нь тодорхойгүй байна.

- Монголд уул уурхайн компанид итгэх итгэл нилээд доогуур байна. Нээлттэй, хүмүүсийн санаа зовж буй асуудлыг сонсдог, хариулдаг, хүн амд санаа тавьдаг, тэднийг хөгжүүлэхэд анхаардаг компаниудыг бодоход хаалттай, хариуцлагагүй гэж танигдсан компаниудад олон нийт итгэл, дэмжлэг үзүүлэхдээ мүү байна.
- Сонсдог, оролцоог хангадаг компаниуд олон нийтэд тулгамдсан асуудлыг бага дээр нь шийдэж, том асуудал үүсгэлгүй “галыг унтраадаг”.
- Загвар, төлөвлөлт, хуваарь гаргах, бүтээн байгуулалтын ажлын байршил зэрэг тодорхой асуудлыг зөвлөлдөх маягаар хөндөх, боломжит хувилбаруудыг хэлэлцэх нь үр дүнтэй оролцоог хангана.
- Үйл ажиллагаа явуулах дэмжлэг үзүүлэх, батлах, жишээ нь газар, ус ашиглалтын зөвшөөрөл олгох нь сумын түвшинд ихэвчлэн тодорхойгүй шалтгаанаар хойшлогддог. Орон нутгийн оролцогч талуудыг аль болох эрт оролцуулах, үр дүнтэй зөвлөлдөх нь илүү хялбар зөвшөөрүүлэх, батлуулах ба эргэлзээ маргааныг багасгаснаар батлагдах сүүлийн хугацааг богиносгож чадна.
- Төрийн бус байгууллагууд, үндэсний хэмжээний иргэний хөдөлгөөнүүд компанид ихээхэн шахалт үзүүлэх боломжтой ба хэрэв компани харилцаа, оролцоог хангахгүй тохиолдолд төслийг түр болон бүр мөсөн зогсоох нь бий. Компани болон нутгийн оролцогч талуудын харилцан ашигтай харилцаа нь компанид болон төслийн нэр хүндэд эерэгээр нөлөөлж, шүүмжлэлээс зайлсхийн, гадны хүчинд тэсвэртэй болгодог.

Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг хангахад нутгийн удирдлагын үүрэг

Уул уурхайн компаниуд болон орон нутгийн оролцогч талуудын хооронд эерэг харилцааг бий болгоход аймаг, сумын удирдлага чухал үүрэгтэй. Энэ талаар Монгол улсад мөрдөж бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан байдаг.

УИХ-аас 2014 онд баталсан Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичигт (2014-2025) энэ талаар тодорхой заасан байна. 3.5-р зүйлд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч,

орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

- Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах.

Монгол улсын хувьд сүүлийн жилүүдэд орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоог хангах чиглэлд нилээдгүй ахиуц гарч байна. Энэ төр засгийн бодлого, эрх зүйн шинэтгэлийн санаачилгуудаас гадна олон нийтийн шахалт шаардлагын үр дүн юм. Иргэний танхим, Шилэн данс, Орон нутгийн хөгжлийн сан зэрэг санаачилгууд ардчилсан оролцоо, төрийн ил тод байдлыг хангахад чиглэгдэн хэрэгжиж байна. Түүнчлэн орон нутгийн засаг дарга нар, хурлууд мэдээллийн ил тод байдал, орон нутгийн иргэдийн саналыг авах талаар санаачилгатай ажиллаж буй маш олон жишээ байна. Жишээ нь зарим сумын захиргаанаас олон нийтийн, иргэдийн нээлттэй хурлуудыг иргэдэд илүү ойр газар зохион байгуулж байгаа бол зарим орон нутагт орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өргөтгөсөн хуралдаан зохион байгуулж иргэдийн саналыг сонсдог байна.

Монгол улсад ихэнх уул уурхайн төслийн хувьд сумын удирдлага олон нийтийн оролцоог хангаж, итгэлцэлд суурилсан харилцан ашигтай харилцааг бий болгоход хамгийн чухал үүрэгтэй субъект юм. Уул уурхайн төслийн бүхий л үе шатанд сумын удирдлагатай шууд харилцах явдал нь хамгийн нийтлэг байдаг. Сумын удирдлагын хувьд уул уурхайн төсөлд хамгийн ойр байж, нөлөөлөлд өртөж буй оролцогч талуудын эрх ашгийг илэрхийлэх эрхтэйн зэрэгцээ газар ашиглах, ус ашиглах гэрээ байгуулах эрхтэй байдгийн үлмаас уурхайн үйл ажиллагаанд нөлөөлөх боломж байдаг. Энэ эрхийг ашиглан зарим сумын удирдлагууд уул уурхайн компаниудтай орон нутагт илүү үр өгөөжтэй байх талаар хэлэлцээ хийх тохиолдол байна. Харамсалтай нь олон нийтийн оролцоог хангахгүй аваас энэ эрх нь авилгалын эх үүсвэр болох мөн урт хугацааны биш зөвхөн богино, ойрын эрх ашгийг харсан шийдвэр гаргах эрсдэл дагуулж ирсэн. Сайн засаглалын зарчмууд болох ил тод байдал, оролцоо зэргийг ханган ажиллах нь орон нутгийн удирдлагын хувьд уул уурхайн компаниудтай сайн харилцааг хөгжүүлж, орон нутгийн хөгжлийг хэмжих эхний чухал алхам юм.

(Эх сурвалж Byambajav, D. 2015. Mining and social license to operate in Mongolia. In Perspectives on the Development of

Energy and Mineral Resources Hawai'i, Mongolia and Germany. Ulaanbaatar: MAPA)

Олон талт оролцогч талуудын оролцоог хангах, хамтын ажиллагааг дэмжих алхмууд зарим аймагт хэрэгжиж байна. Жишээ нь Баянхонгор аймгийн удирдлага жил бүр аймагтаа үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудыг урьж зөвлөгөөн зохион байгуулдаг. Баянхонгор аймгийн Галуут сум орон нутгийн удирдлага, компаниуд, иргэдийн төлөөлөл бүхий 3 талт зөвлөлийг ажиллуулж компаниудын байгаль орчин, нийгмийн хариуцлагын ажлын гүйцэтгэлийг хэлэлцдэг байна.

Зарим сумдад Сумын ИТХ нь компани ба орон нутгийн харилцааг зохион байгуулахад манлайлж оролцож байна. Жигээ нь Дундговь аймгийн Өлзийт сумын ИТХ жил бүр баг тус бүрт очиж багийн иргэдийн хурлыг зохион байгуулж, түүнд холбогдох уул уурхайн компаниуд танилцуулга хийдэг байна. Төв аймгийн Заамар сумын ИТХ хурал жил бүр сумын нутаг дэвсгэр үйл ажиллагаа явуулж буй компаниудын байгаль орчин, нийгмийн хариуцлагын тайланг хэлэлцэж, хамтын ажиллагааны гэрээ байгуулах эсэхээ шийддэг байна. Мөн Өмнөговь аймгийн Ханбогд суманд орон нутгийн малчид, Оюу Толгой компани, орон нутгийн төлөөлөл бүхий 3 талт зөвлөл байгуулагдан маргаантай асуудлыг эв зүйгээр шийдэхээр ажиллаж байна.

(Орон нутгийн удирдлагын иргэний оролцоог дэмжих санаачилгуудын тухай эндээс уншина уу <http://www.khural.mn/>)

Олон нийтийн оролцоог хангах цогц хандлага

Уул уурхайн салбарт олон нийтийн оролцооны шинэ хэлбэрүүд

Уул уурхайн олон улсын туршлагаас үзэхэд уул уурхайн оролцогч талуудын оролцоо нь жил ирэх тутам өөрчлөгдөн нийгмийг хамарсан, уриалсан хандлагатай болж байна. Монголын уул уурхайн салбарт ч оролцогч талын оролцооны ялгаатай хэлбэрүүд байна. Үүнийг хоёр хэлбэрт хувааж болох юм.

Уламжлалт хандлага: Оролцогч талуудтай харилцахдаа эхний ээлжинд сөргөлдөөнийг намжаах, бодит байдал, түүнийг хүлээн зөвшөөрүүлэх тал дээр төвлөрөх нь одоо байгаа харилцаанд тулгуурлахаас илүү дээр байдаг. Оролцооны механизм нь ерөнхийдөө албан ёсны ба тусгай бүлэг хамруулахаас илүү мэдээллийн зорилгыг урьдчилан тодорхойлох нь дээр байдаг. Ихэнх

компаниуд өөрсдийн нэр хүндийн талаар ихээхэн анхаардаг. Үүний тулд нийтийн дундах нэр хүндийг өсгөхдөө компанийн давуу талуудыг тусгасан хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулах хэлбэр нь гол хандлага болно.

Шинэ хандлага: Ихэнх компаниуд нутгийн удирдлага болон хүн ам нь ашигт малтмал олборлоход нөлөөлөх чадвартай гэдгийг ойлгосон ба олон нийтийн оролцооны уламжлалт хандлагыг хөгжүүлэх нь үр дүнгүй болсон. Дэвшилтэт компаниуд нь өөрсдийгөө хамгаалах, сэтгэлгээний хямралаас гарахын тулд нутгийн хүн амтай нээлттэй харилцан зөвлөлдөх аргыг хэрэглэх болсон (гал унтраах). Эдгээр компаниуд нь оролцогч талын асуудал, орон нутгийн хүн амын анхаарал татсан асуудал, олон нийтийн хүсэл эрмэлзэл зэргийг идэвхтэй ойлгон шийдвэрлэхэд олон нийтийн харилцааны хэд хэдэн механизмыг ашиглаж байна.

(Хүннү Коал компанийн жишээг уншина уу)

Олон нийтийн оролцооны түвшинг тодорхойлох

Нутгийн удирдлага болон уул уурхайн компаниудын аль аль нь олон нийтийн оролцоо бол бодит байдал дээр тогтдог гэдгийг ойлгох хэрэгтэй. Олон нийтийн оролцоо үргэлжилсэн гурван гол түвшнээс тогтдог. Үүнд: мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй оролцоог хангах.

Оролцооны түвшин бүр нь тодорхой орчин нөхцөлд тодорхой үр дүнд хүрдэг. Хэдийгээр хүссэн үр дүнд хүрэхийн тулд хоёр болон түүнээс дээш түвшин шаардлагатай болох нь бий. Түвшин бүрийг тодорхой авч үзье.

Мэдээлэл

Төслийн талаарх олон нийтийн мэдээлэл нь нутгийн хүн амд зөв гэдгийг ойлгуулах нь чухал.

Мэдээлэл нэг чиглэлийн харилцаатай гэдэг нь нэг тал мэдээллийг нөгөө талд хүргэх юм. Үр дүнтэй мэдээллийн стратеги нь мэдээллийн дараах шаардлагыг хангах хэрэгтэй:

- үнэн зөв, хүртээмжтэй, ойлгоход хялбар
- сонсогчдод хамааралтай, сонирхолтой
- зохих сувгаар хүргэгдсэн байх
- хэл, загвар, агуулга нь зохимжтой байх нь чухал

Олон нийтийн оролцооны түвшин



- хэрэв иргэдэд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол хаанаас авах боломжтойг тусгасан байх.

Зөвлөлдөөн

Зөвлөлдөөн гэдэг нь хоёр талт харилцаа ба нэг тал нөгөө талын үзэл бодлыг ойлгон хүлээж авах юм. Жишээ нь, нутгийн удирдлага бодлого, хөтөлбөрүүд, үйлчилгээ зэрэг шууд нөлөөлөх хүчин зүйлсэд илүү анхаарал хандуулах. Үр дүнтэй зөвлөлдөөний хамгийн гол бүрэлдэхүүн нь стратегийн талаарх мэдээллийг үр дүнтэй хүргэх, олон нийт хэрхэн бодлого, шийдвэр гаргах үйл явцад оролцох (нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор, ажил эрхлэх боломж, оролцооны хяналт шинжилгээ) талаар ойлголт өгөх ба эцсийн үр дүнгийн талаар оролцогчдод тогтмол эргэн мэдээлэл хийх багтана.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. “Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь”.

http://www.iri.org/sites/default/files/flip_docs/Mongolian%20Manual%20on%20Town%20Halls/files/assets/common/downloads/publication.pdf)

Биечлэн оролцох

Оролцоо нь хэлэлцүүлгийн аргаар хангагдана. Жишээ нь багийн уулзалт, олон талт ажлын хэсэг, зөвлөгөөний бүлгүүд орно. Хэлэлцүүлгийн явцад оролцогчид хэрхэн үр дүнтэй хувь нэмрээ оруулах талаарх ойлголт, мэдлэгийг авдаг тул нилээд цаг хугацаа, хүч хөрөнгө шаарддаг.

(“Ухаа Худаг”-ын жишээг уншина уу)

(Олон нийтийн оролцооны талаар мөн НҮБХХ, 2011 он. Нутгийн удирдлагад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь: Гарын авлага (монгол хэл дээр)

Англо Американ компани. 2015 он. Нийгэм эдийн засгийн үнэлгээний аргачлал (НЭЗҮА))

Уурхайн мөчлөгөөс хамаарсан олон нийтийн оролцоо

Уурхайн үйл ажиллагааны үе шатуудаас хамааран олон нийтийн оролцооны зорилго, хэлбэр нь өөр өөр байна. Хайгуулын үе шатанд олон нийтийн оролцооны зорилго нь газар нутгийн зөвшөөрөл авах, ус ашиглалтын хэлэлцээр, бусад гэрээ хийх, соёлын өвийн асуудлыг тодорхойлон шийдвэрлэх, орон нутгийн хүн амд хайгуулын үйл ажиллагаа, ажиллах хуваарь зэргийг

танилцуулах юм. Олон нийтийн оролцооны үйл ажиллагааны зорилго нь хайгуулын ажлын үр нөлөө, ирээдүйд хөгжих боломж, хүн амд бий болох бусад боломж зэргээр олон нийтийн төслийн талаарх ойлголт, хүлээлтийг зөв чиглүүлэх явдал юм.

Төсөл боловсруулах шатанд оролцооны гол зорилго нь газар устай харьцах байнгын зөвшөөрөл авах болон хамтын ажиллагааны гэрээний үүргийг биелүүлэх юм. Энэ шатанд, төслийн боловсруулалттай холбоотой мэдээлэл хүргэхэд анхаарна. Ялангуяа төслийн боловсруулалт тодорхойгүй үед оролцоог хангах нь нэн шаардлагатай. Энэ талаар Энержи Ресурс ХХК-ийн олон нийтийн оролцооны төлөвлөгөөг жишээ болгон хүргэе.

Бүтээн байгуулалтын үе шатанд түлхүүр зорилго нь уул уурхайн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн нөлөөллийн байдлын талаар олон нийтэд ойлгуулах юм. Компани нь олон нийтэд бүтээн байгуулалтын үеийн ажлын байр, эдийн засгийн боломжийн талаар хуваалцах хэрэгтэй.

Үйл ажиллагааны үе шатанд олон нийтэд гэрээгээ мөрдөн үүргээ биелүүлдэг гэдгээ батлан харуулах үйл ажиллагааны менежментийн тогтолцоо чухал хэрэгтэй. Хүмүүсийг уурхайд болж буй мэдээллээр (нээлттэй хаалганы өдөр, сонин, вебсайт зэрэг) хангах нь нэн чухал болно.

Уурхайн мөчлөгийн төгсгөл үеийн зорилго нь хүн амд үнэмлэхүй хөгжлийн талаар болон хаах хугацааг тогтмол мэдээлнэ. Оролцооны зорилго нь олон нийтийн уул уурхайн дараах ирээдүйг тодорхойлоход туслах юм.

Хайгуулын үеийн олон нийтийн оролцоо

Хайгуулын төслөөс нутгийн хүн ам уул уурхайн аж үйлдвэрлэлийг хэрхэн хүлээн авч дэмжих нь хамаардаг гэдгийг ойлгох нь зүйтэй. Хайгуул нь олон нийтийн оролцооны хэтийн байдалд маш чухал гэдгийг дараах шалтгаанаар тайлбарлая:

- Хайгуул нь хайгуулч болон олон нийтийн хоорондын анхны харилцаа болно
- “Хуурамч уурхай” байх аюул тулгарч болно. Хайгуулын үед газар дээр идэвхтэй ажилласан хэдий ч жинхэнэ эрдэс баялаг байхгүй байдаг. Олон нийт том оврын техник

Хайгуулын шатан дахь оролцоо

Дээрхи учир шалтгааны улмаас орон нутгийн хувьд хайгуул бол нэн чухал шат болно. Үүнд:

- Хайгуул бол олборлогч болон орон нутгийн анхны “учрал” юм.
- Төсөөллийн уурхайн нөхцөл байдал үүсэж болзошгүй.
- Тодорхой хүлээлтүүд үүсдэг.
- Амлалтууд хийгдэж бозошгүй.



тоног төхөөрөмж (зам гаргагч машин, өрмийн машин) хараад уул уурхайн ажил эхэлсэн гэж ойлгодог.

- Хүлээлт бий болсон байна. Хайгуулын үед олон нийт ихэнх төсөл бүтэлгүйдэг гэдгийг мэддэггүй учраас уурхай ашиглалтанд орж эхэлвэл яах тухай төсөөлж эхэлдэг. Хайгуулын баг бодит бус хүлээлтийн эрсдэлийн талаар ойлголттой байж олон нийтэд үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээллийг хүргэх ёстой.
- Хайгуулын баг хувь хүмүүс, олон нийтэд эерэг үр нөлөөний талаар амлалт өгөхгүй байх нь уул уурхайн ажил үйлдвэрлэлд шилжихтэй хүчтэй хамааралтай байдаг. Биелээгүй амлалтууд нь бухимдал, гомдол, болзошгүй мөргөлдөөнийг үүсгэнэ.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Канадын хайгуулч, хөгжүүлэгчдийн холбоо (PDAC). Хариуцлагатай хайгуулын төлөө E3 Plus Хүрээ., 2008 он)

Олон нийтийн оролцооны цогц хандлага

Цогц хандлагын гол давуу тал нь байгууллагын санах ой бөгөөд хувь хүн ажлаас гарахад болон үйл ажиллагаа нь өөрийн мөчлөгөөр явагдаж дууссан тохиолдолд мэдээлэл алдагдах, бусад үед үүрэг даалгаврыг тодорхой хугацаанд өгөх, жишээ нь хайгуулын үед, гүйцэтгэлийн биелэлт нь үйл ажиллагааны бүхий л үе шатанд хэрэгждэг. Иймд зарим уул уурхайн компаниуд олон нийтийн оролцооны цогц менежментийг боловсруулан хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө төсөвлөдөг. Цогц менежментийн бүрэлдэхүүнүүд нь нийгэм эдийн засгийн суурь судалгаан дээр үндэслэгддэг ба нийгмийн нөлөөлөх байдлын үнэлгээ, төлөвлөлтийн үйл явц, үйл ажиллагааны баримтжуулалт, хөтөлбөр хэрэгжилт, стандарт, зорилтын хэрэгжилтийг тогтмол хянаж дүгнэх, мэдээллийн менежментэд хатуу хяналт тавих багтана. Эдгээр бүрэлдэхүүнүүд уурхайн бүх мөчлөгийн үе шат, хаалтын үед ч хэрэглэгдэнэ.

Олон нийтийн оролцооны цогц хандлагын зарим нэг чухал бүрэлдэхүүн хэсэгт олон нийт ба оролцогч талын тодорхойлолт, дүн шинжилгээ, нийгэм эдийн засгийн суурь судалгаа ба нийгмийн нөлөөлөх байдлын үнэлгээ, оролцооны төлөвлөгөө багтана.

- Олон нийт оролцогч талын тодорхойлолт, дүн шинжилгээ нь оролцогч талууд, ялангуяа нутгийн олон нийтийн харилцан эерэг харилцааг тогтооход анхны алхам нь болж өгдөг. Үүнд оролцогч талын мэдээллийн багц боловсруулах, оролцогчийн тодорхой

Орон нутгийн оролцооны цогц хандлага

- Орон нутаг ба оролцогч талуудыг тодорхойлох оролцогч талуудыг тодорхойлох, зураглал хийх, оролцогч талуудын мэдээллийн сан бүрдүүлэх.
- Нийгэм-эдийн засгийн суурь судалгаа Нийгэм, эдийн засаг байгаль орны зуучин зүйлс болон хүн ам зүй, хөдөлмөрийн зах зээл, боловсрол, гэр бүл, хувь хүмүүсийн нөхцөл байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх.
- Орон нутгийн оролцооны төлөвлөгөө Орон нутгийн хэрэгцээ санаа бодлыг өйтөх, түүнд нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх төлөвлөгөө ба процессыг бүрдүүлэх.
- Тасралтгүй ба "нийт компаниараа" байх хандлага

тохиолдол дээр дасгалжих багтана.

- Нийгэм эдийн засгийн суурь судалгаа нь нийгмийн орчин, эдийн засгийн хүчин зүйлс, хүн амын мэдээллийг цуглуулах, хөдөлмөрийн зах зээл, боловсролын байдал, гэр бүл хувь хүний сайн сайхан, бизнесийн одоогийн болон үзүүлж болох нөлөөлөл, учирч болох эрсдэл, боломжийг тодорхойлоход ихээхэн дэм болдог.
- Олон нийтийн оролцооны төлөвлөгөөнд үйл ажиллагааны хүрээнд хийгдэх арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэл хийхийг багтаах ёстой ба энэ харилцааг асуудал тулгарах үеэс өмнө урьдчилан тогтоох хэрэгтэй. Төлөвлөгөөнд мөн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг багтааснаар компанийн санаачилсан ажлын үр дүнг тооцох боломжтой болдог ба хэрэв шаардлага гарвал сайжруулдаг.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Азийн сан. 2013. Байгалийн нөөцийн хариуцлагатай ашиглалтанд талуудын оролцоог хангах нь. Гарын авлага; CSRМ. 2015. Монголын хариуцлагатай уул уурхай. (монгол хэл дээр)

Олон нийтийн оролцооны тухай бүлгийн ажил (20 минут)

Жижиг бүлгүүдэд хуваагдан дараах асуултуудын дагуу ярилцан дүгнэлтээ бусад хүмүүст танилцуулна. Зохиомол дүрийг ашиглан хүснэгтийг нөхөж бич.

Өгөөж Алт уул уурхайн төслийн хүрээнд Ховд аймгийн Баялаг суманд нээлттэй алтны уурхай ажилладаг. Сум нь Улаанбаатараас 1500 км, аймгийн төвөөс 250 км алсад оршдог. Хүн ам нь 4500. Мал аж ахуй нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагааны үндсэн төрөл болдог. Уул уурхай нь энэ газарт шинэ ойлголт юм. Эзэмшигч RM компани нь үйл ажиллагаа эрхлэхийн тулд Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ ба холбогдох менежментийн төлөвлөгөөг хийхээр бэлтгэж байна. Мөн тус компани гидрогеологийн судалгаа хийж орон нутгийн усны нөөцийн байдлыг судлан өрөмдлөг хийх, ус татах шугам хоолойн загвар боловсруулахаар ажиллаж байна.

“Олон нийт, оролцогч талын тодорхойлолт” слайдад тусгасан мэдээллийг туслах байдлаар ашиглана.

Хамрагдсан оролцогч бүлгүүд болон оролцооны хэлбэрүүд

	Гол оролцогч талууд	Оролцоог хангах тохиромжтой аргууд
Хайгуул		
Уурхайн бүтээн байгуулалт		
Олборлолт		
Хаалт		

Гомдол барагдуулах механизм

Гомдол барагдуулах үр дүнтэй механизм: бизнесийн давуу талууд

Олон нийт ихэвчлэн юу болж байгаад хэт анхаарч, харин анхаарал татахуйц, асуудал болохоор нуугдмал, ноцтой юмыг бага анхаардаг. Хожим энэ нь зарим тохиолдолд гомдол болон хувирдаг. Жишээ нь, орон нутгийн асуудлыг шийдэж чадахгүй бол хүмүүс гомдол нэхэх нь аргагүй юм. Компанийн хүний нөөцийн хэлтэс гомдол, сөрөг саналыг хэлэлцэхдээ үйл ажиллагааг дээшлүүлэх, эрсдлийг бууруулах, олон нийттэй харилцах харилцааг дэмжих мэдээллийн эх үүсвэр гэж хандана. Компанийн хүний нөөц нь олон нийтийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизм ба үйл явцыг судалж мэдсэн байх шаардлагатай.

Яагаад санал гомдлыг газар дээр нь шийдвэрлэх механизм компанид хэрэгтэй вэ?

- Бизнесийн эрсдлийг бууруулах

Уул уурхайн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний тээвэрлэлт, үйлчилгээг амжилттай явуулах, ажиллах хүчин татахын тулд уул уурхайн үйл ажиллагаа тогтвортой орчинг шаарддаг. Санал гомдол шийдвэрлэх механизмын үндсэн зорилго нь асуудлыг бага түвшинд эрт шийдвэрлэх юм.

- Зохион байгуулалтын зардал, хохирлоос зайлсхийх

Сөргөлдөөнтэй байдлыг шийдвэрлэх нь хүн хүч, цаг хугацаа, төсөвт ихээхэн дарамт үзүүлдэг. Сөргөлдөөний менежмент нь нилээд стресстэй, ёс суртахууны хэм хэмжээ доошлох, гол боловсон хүчнээ алдах нь ч бий. Сөргөлдөөнд оролцсон бүх хүмүүс сэтгэл зүйн дарамтанд ордог.

Компанийн эрх ашгийг хамгаалахын тулд маргаан, зөрчилдөөнөөс аль болох зайлсхийх хэрэгтэй, хэрэв нэгэнт үүссэн бол зохион байгуулалттай тогтолцоо, үйл ажиллагаагаар гадна, дотны харилцаа, ирээдүйн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бууруулна. Энэ тохиолдолд үр дүнтэй өргөдөл гомдлын механизм л тусална.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. ШХА, ТБУ төсөл. 2012 он. Байгалийн баялгийн ашиглалтаас үүдэлтэй зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замууд)

- Хүний эрхийг дээдлэх хамгаалах

Уул уурхайн компаниуд үйл ажиллагааныхаа туршид хүний эрхийг дээдлэх үүрэгтэй.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Бизнес ба хүний эрхийн зарчмын удирдамж (монгол хэл дээр).

- Санхүүгийн үйлчилгээ авах

Банк, санхүүгийн байгууллагууд компаниудад санхүүгийн үйлчилгээ үзүүлэхдээ тодорхой шалгуурыг нарийн тавьдаг ба эрсдлийн менежментийг нийгмийн хэмжигдэхүүнээр хатуу ханддаг.

Гомдол барагдуулах сайн механизм боловсруулах

Гомдлыг шийдвэрлэхээ арга хэмжээ, ажиллах дарааллын жишээг дараах байдлаар харуулав.

Санал, гомдлыг уурхайн талбайн байранд гаргаж болно. Хэдийгээр гомдол хүлээн авах цэгүүд хязгаарлагдмал байдаг боловч тэд олон нийтэд нээлттэй ба долоо хоногт тогтмол цагт ажилладаг, ингэснээр олон нийт, хүн бүр хэзээ хаана хүлээн авахыг мэддэг байх ёстой.

Менежментийн үүрэг хариуцлага тодорхой байх ёстой ба үүнд асуудал, гомдлыг шийдвэрлэх үр дүнтэй цаг хугацааг тогтоосон байна. “Угтах үйлчилгээний ажилтан” нь гомдол гаргагчтай эхэлж ярилцлага хийж зохих маягыг бөглөн “Шийдвэрлэх мэргэжилтэн”-д хүргүүлнэ. Шийдвэрлэх мэргэжилтэн нь (долоо хоногийн дотор) хариу мэдэгдэх ба 20 хоног дотор бүрэн шийдвэрлэнэ. “Өргөдөл гомдлын мэргэжилтэн” нь тогтолцооны менежментийг бүрэн хариуцаж ажиллана. Жишээ нь, компьютерын мэдээллийн санд (Гомдолд нэвтрэх) бүртгэгдсэн эсэх ба гомдлын хариууг

Гомдол, маргаан шийдвэрлэх үйл явц

Гомдол шийдвэрлэх үйл явц:

- Үндэгэний процесс (Үнэлгээг хэн, хэрхэн хийх вэ?)
- Асуудлыг уламжлал ба зохих хүн тодорхой байх
- Шийдвэр гаргах үйл явцын зарчмыг тодорхой байх
- Санал бөглөж буй шийдлийн талаар шийдвэр гаргах зарчмыг
- Гомдол шийдвэрлэх процессийн элхэм бүрд зарцуулбал зохих хугацаа
- Гомдол гаргагчид хариу мэдээлэл хүргэх горим



бичгээр (гарт олгох) өгсөн эсэхэд хяналт тавина (30 хоног дотор).

Эцэст нь “Өргөдөл, гомдлын хороо” нь эрх бүхий шийдвэрлэх мэргэжилтний түвшнээс гадна шийдвэр гаргах эрхтэй ба хэрэв шаардлагатай бол асуудал гомдлыг ахлах менежер эсвэл бие даасан гадны байгууллагад хүргүүлдэг.

Компаниуд санал гомдлыг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх ба онцгой яаралтай тохиолдолд боломжит хамгийн бага хугацаанд шийдвэрлэнэ. Хамгийн чухал нь гомдлыг нууцлал сайтай, хохиролгүйгээр шийдвэрлэх хэрэгтэй.

Энержи ресурс ХХК-ийн санал гомдлыг шийдвэрлэх бодлогын дагуу “Гомдол бүртгэл”-д дараах зүйлсийг хадгална:

- Гомдол гаргасан он сар өдөр
- Гомдол гаргагч хувь хүн
- Гомдол гаргагчид хүргүүлсэн авч шийдвэрлэсэн арга хэмжээний талаарх мэдээлэл
- Гомдол хаагдсан он сар өдөр
- Гомдол гаргагчид хариу илгээсэн он сар өдөр

Компаниуд “Гомдол бүртгэл”-ийг хэрэглэснээр гомдлын давтамж, ямар сэдэв ихэвчлэн хөндөгдсөн зэргийг мэдэх боломжтой ба үр дүнг мэдээлэхэд ашиглана. Жишээ нь, Оюу толгой ХХК орон нутгийн сонинд санал гомдлыг талаарх мэдээлэл, шийдвэрлэсэн байдлыг дүгнэн нийтэлсэн байна.



Санал гомдол шийдвэрлэх журмыг шалгах хуудас:

- Үнэлгээний журам (хэн үнэлгээ хийж, хэрхэн үнэлгээ хийгддэг)
- Компанийн асуудалд хамааралтай хүмүүсийг тодорхойлох журам
- Зохих шийдвэрлэх арга замыг тодорхойлох журам (гомдол гаргагчтай зөвшилцөх)
- Санал болгож буй зохицуулалтаар шийдвэр гаргах журам
- Санал гомдол шийдвэрлэх үе шат бүрд зохистой хугацаа (үүнд эхний үнэлгээ, үнэлгээ, шийдвэр)
- Гомдол гаргагчид мэдэгдэл хүргүүлэх журам

Санал гомдол хүлээн авч, шийдвэрлэх тухай асуулт, хэлэлцүүлэг (нэмэлт)

Санал гомдол, түүнийг авч үзэж буй одоогийн бодлого, хандлагаа үнэлэх нь

- Компанийн үйл ажиллагаатай холбоотой гомдол бол ямар хэлбэрт хамаарах вэ?
- Гомдлын боломжит шалтгаанууд юу вэ?
- Гомдлыг хэрхэн шийдвэрлэх вэ? Компани доторх гомдолд чиглэсэн албан ёсны, албан бус, түр хугацааны хандлагыг тодорхойлох

<ul style="list-style-type: none"> • Асуудлыг хүндрэхээс өмнө эрт үед оролцох, шийдвэрлэх механизм байгаа эсэх? • Олон нийтийн санал гомдлыг шийдвэрлэх зохих журам хэрэглэж байсан эсэх? • Цоорхой хаана байна вэ? 	
<p>Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)</p> <ul style="list-style-type: none"> • Үр дүнтэй олон нийтийн оролцоог хангах аргууд юу вэ? • Үр дүнтэй олон нийтийн зөвлөлгөөнд тавигдах шаардлага юу вэ, үр дүнг хэрхэн үнэлэх вэ? • Санал гомдлын шийдвэрлэхэд орон нутгийн удирдлага ямар алхмууд хийх боломжтой вэ? 	
<p>Жишээ туршлага</p> <p>Терра Энержи: Терра Энержи нь Өмнөговь аймгийн Ноён сумын нүүрсний уурхай Баруун ноён уулыг эзэмшин үйл ажиллагаа эрхэлдэг. Тус компани өөрийн тогтвортой байдлыг хангах бодлогын гол тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна:</p> <ul style="list-style-type: none"> - Хамтарсан төслөөр дамжуулан тогтвортой байдлыг хангах - Одоогийн ба ирээдүйн хөрөнгө оруулалтын төсөлд стандарт тогтоосон байх - Хяналтанд тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг тохиролцсон байх - Гол байгууллагуудтай нэмүү өртгийн түншлэлийг эрэлхийлэх. <p>Компани нь олон нийтийн оролцооны стратегийг боловсруулсан ба дараах гол оролцогч талуудыг тодорхойлсон:</p> <ul style="list-style-type: none"> - Нутгийн удирдлага ба хүн ам - Аймгийн удирдлага, агентлагууд, салбарын байгууллагууд - Улсын яамд, агентлагууд, салбарын байгууллагууд - Аж үйлдвэрийн үе тэнгийн - Үйлчилгээ үзүүлэгч <p>Тус компани нь орон нутгийн асуудалд хурдан шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авах</p>	

зорилгыг өөрийн бодлогод тусгасан бөгөөд гомдлыг шийдвэрлэх механизмыг сурталчлан, хэрэгжүүлдэг; олон нийтийн эерэг харилцааг хөгжүүлэхэд өөрийн ажилчид болон үйл ажиллагааны түншүүдэд тэдний үүрэг чухал болохыг өндөр зэргээр, соёлын ойлголцолтойгоор итгүүлэн таниулдаг. Хамгийн чухал нь, Терра Энержи ХХК уурхайн үйл ажиллагааны санал гомдлыг шийдвэрлэхдээ Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчимд нийцэж байгаа эсэхийг хянах дотоод хяналтын шалгах хуудсыг боловсруулсан байна.

Сайн дурын зарчим (<http://www.voluntaryprinciples.org/>) нь олборлох аж үйлдвэртэй гэрээ байгуулсан аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч нь хүний эрхийг зөрчсөн талаарх баттай мэдээллийн дагуу боловсруулагдсан ба хоорондоо холбоогүй зарчмууд нь олборлох аж үйлдвэрийн компаниуд аюулгүй байдлыг хангах болон хүний эрхийн тэнцвэртэй байдлыг үнэлэхэд зориулагдсан байдаг.

Ухаа худаг: Ухаа худаг коксжуулсан нүүрсний төслийг Энержи ресурс ХХК боловсруулан эзэмшиж байсан. Төслийн хүрээнд уурхайн ажлыг явуулах, зам сайжруулах төсөл, олон нийтийн оролцооны нарийн төлөвлөгөө хийгдсэн. Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-наас төслийг хэсэгчлэн санхүүжүүлсэн. Малчид болон бусад төсөлд хамаарагдсан олон нийтийн оролцоо хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрч, тус компани нь орон нутгийн оролцооны цогц стратегийг боловсруулсан байна. Олон нийтийн оролцооны төлөвлөгөө нь хамгийн эрсдэл ихтэй бүлгүүдийг гэрээр эргэж, багийн удирдлагуудтай аль болох тогтмол (сар тутам) уулзах, “нээлттэй гэр” байдлаар олон нийтийн зөвлөлдөөний арга хэмжээг хөдөөд болон хотожсон газруудад зохион байгуулж төслийн төлөвлөгөө, оролцогч талын хүсэлтийн хариуг танилцуулах зэргээс тогтоно. 2011 онд “Хариуцлагатай уул уурхай ба олон нийтийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг 5 суманд зохион байгуулагдсан ба нутгийн хүн амын 1090 гишүүн хамрагджээ.

Нутгийн иргэдийг хамруулсан олон нийтийн зөвлөлдөөнийг Ашигт малтмалын тухай хуулийн 42.3-т зааснаар “орон нутгийн зөвлөлдөөний зөвлөл”-ийн хурал хэлбэрээр 2010 оноос эхлэн явуулж байна. Цогтцэций сумын Хуралд өөр бүлгээс сонгогдсон 13 гишүүн байдаг.

1. Дарга: Орон нутгийн засаг даргын тасгийн газрын төсөв захиран зарцуулагч
2. Нарийн бичиг: ИТХ-ын нарийн бичгийн дарга
3. Гишүүн: ЕБС-ийн багш
4. Гишүүн: ИТХ-ын гишүүн

5. Гишүүн: Лам
6. Гишүүн: Өрх толгойлсон эмэгтэй
7. Гишүүн: Залуучуудын байгууллагын төлөөлөл
8. Гишүүн: Төрийн бус байгууллагын төлөөлөл (Цэций нутаг)
9. Гишүүн: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
10. Гишүүн: Эмэгтэйчүүдийн зөвлөлийн төлөөлөл
11. Гишүүн: Ахмадын зөвлөлийн төлөөлөл
12. Гишүүн: Орон нутгийн эмч (эх баригч)
13. Гишүүн: Тухайн нөлөөлөлд өртсөн нутгийн малчин

Зөвлөлийн гол зорилго нь орон нутгийн хүрээлэн буй орчин, уламжлалын асуудлаар компанид зөвлөх, компанийн олон нийттэй холбоотой хийх ажлыг дэмжин идэвхтэй оролцох, олон нийттэй холбоотой үйл ажиллагааг дэмжих шинэ санаа, санаачилгаа хуваалцах юм. Зөвлөлийн гол үйл ажиллагаа нь тогтмол уулзалтууд юм. Уулзалтуудад зөвлөл Энержи ресурсаас зөвлөлийн гаргасан зөвлөмж бүхий улирлын тайланг авч хэлэлцдэг. Энержи ресурс, нөгөө талаас зөвлөлийн гишүүдийн холбоо харилцаа, тээврийн зардлыг бөөнд нь олгодог.

Хүннү Коул уурхай: Хүннү Коул ресурсес ХХК нь Хүннү коул ХХК-ийн охин бөгөөд тус компани анхнаасаа буюу 2009 оноос Австрали улстай хамтран Монгол Улсад хэрэгжүүлэх нүүрсний төслийг боловсруулж эхэлсэн. Компани нь Монголын уул уурхайг хөгжүүлэх зорилгоор Австралийн хөрөнгийн бирж дээр хөрөнгө босгон өсгөж чадсан дунд хэмжээний анхны компани юм. Компанийн гол төсөл нь Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Цант-Уул нүүрс олборлолт ба Хүннү коул ресурсес юм. Цант-Уулын гэрээ нь 3 жилд хүчинтэй. 2015 оны эцсээр уурхай бүтээгдэхүүн гаргаагүй байсан хэдий ч гэрээнд заасан амлалтын дагуу үйл ажиллагааг гүйцэтгэж байсан. Компанийн стратеги нь гэрээний амлалтын дагуу эдийн засгийн хүнд үеийн туршид ч зорилтот үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн орон нутгийн эерэг хүлээлт, итгэлийг олж авах юм. Компани нь сар, улирал тутам Баян-Овоо суманд мэдээлэл хийж, хөгшчүүл, малчдыг хамруулсан уурхайн аяллыг тогтмол зохион байгуулдаг. Хамгийн чухал нь компанийн санал гомдлыг шийдвэрлэх механизмыг мэдээлэл, харилцааны олон хэлбэрээр сурталчилж байна.

(Эх сурвалж: Byambajav, D. forthcoming. Local level agreements: Lessons from Mongolia)

Унших ном, материал

Luc Zandvliet & Mary Anderson. 2009. Getting it Right: Making Corporate-Community Relations Work, Greenleaf Publishing. (англи хэлээр)

Network for Business Sustainability. 2014. A Getting Started Toolkit for Exploration and Development Companies. <http://nbs.net/knowledge/community-engagement-guide/> (англи хэлээр)

IRI. Багийн түвшинд иргэдийн оролцоо, эргэх холбоог сайжруулах нь.

http://www.iri.org/sites/default/files/flip_docs/Mongolian%20Manual%20on%20Town%20Halls/files/assets/common/downloads/publication.pdf) (монгол хэлээр)

НҮБХХ. 2011 он. Нутгийн удирдлагад иргэний оролцоог дээшлүүлэх: гарын авлага

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс ба НҮБХХ, 2012 он. “Монголын уул уурхайн бизнес ба хүний эрх”. Олон улсын бага хурлын материал.

Үндсэн нэр томъёо, ойлголтуудын тайлбар

Нутгийн олон нийт - компанийн үйл ажиллагаа явуулж байгаа шүүд болон эргэн тойрны газар нутгийн оршин суугчид

Оролцогч тал - тодорхой шийдвэрт сонирхол бүхий хувь хүн эсвэл хэсэг бүлгийн төлөөлөл. Үүнд шийдвэрт нөлөөлдөг, нөлөөлж чадах, түүнчлэн түүнд хамаарагдсан хүмүүсийг хэлнэ.

Анхдагч оролцогч тал - тухайн үйл ажиллагаа явуулах газар нутгийн хүн ам

Хоёрдогч оролцогч тал - төсөлд шүүд бус өртөх бүлэг нь орон нутгийн бус байдаг, жишээ нь аймаг улсын удирдлага, улс төрч, худалдаа болон үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, үндэсний нийгэм, байгаль орчны бүлгүүд, нутгийн зөвлөл, хэвлэл мэдээлэл багтана.

Олон нийтийн оролцооны төлөвлөгөө - төсөл хэрэгжүүлэгч нь өртөх боломжтой ямар ч олон нийт, олон нийтийн хандлага, хүлээлт, олон нийтэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, олон нийтээс эргүүлэн мэдээлэл авах хэлбэрийг тодорхойлдог, олон нийтээс авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхийг тусгасан баримт бичиг юм.

Санал - хувь хүн эсвэл олон нийтийн бүлэг нь асуудал, тулгамдсан бэрхшээл, анхаарал татсан зүйл, мэдэгдэл (ойлголт эсвэл бодит) зэргийг компани, гэрээ байгуулагчдад хүргэн шийдвэрлүүлэхийг хүсдэг.

Гомдол - компанитай холбоотой сэтгэл ханамжгүйн илэрхийлэл, ихэвчлэн тодорхой шалтгааныг

үндэслэсэн ба эсвэл тодорхой шийдлийг эрэлхийлсэн байдаг.

Гомдлыг бүртгэх - хүлээн авсан гомдлын талаарх мэдээллийг хадгалагч өгөгдлийн сан

МОДУЛЬ 3. НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН МЕНЕЖМЕНТ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Уул уурхайн нийгмийн нөлөөлөл болон эрсдэлийн талаарх мэдлэг
- Тогтвортой Амьжиргаа хандлагыг үнэлэх, шийдвэр гаргах, төлөвлөхөд ашиглах
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээг төлөвлөх үндсэн алхамуудыг тодорхойлох
- Нүүлгэн шилжүүлэлтийн нийгмийн үр дагавар, үр дүнтэй менежмент
- Нийгмийн нөлөөллийг үнэлэх, менежмент хийх талаарх компанийн чадавхийг үнэлэх

Удиртгал

Уул уурхайн төслүүд нь иргэдэд ашиг тус, боломж бий болгохын зэрэгцээ сөрөг нөлөөллийг учруулах эрсдэлтэй. Уул уурхайн төслийн бүхий л үе шатанд сөрөг нөлөөллөөс аль болох зайлсхийх, нөлөөллийг бууруулах, үр ашиг, боломжийг аль болох нэмэгдүүлэхийн тулд сайн менежментийн бодлого, хэрэгжилт шаардлагатай. Энэ модулийн эхний хэсэгт уул уурхайн нийгэмд үзүүлэх нөлөөлөл, түүний менежментийн талаар авч үзнэ. Энэ модульд Тогтвортой Амьжиргааны Арга Зүйг /ТААЗ/ уул уурхайн байгаль орчны ба нийгмийн нөлөөллийг цогцоор нь ойлгоход ач холбогдолтой болохын хувьд онцлон танилцуулна. Модулийн удаах хэсэгт уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг авч үзэж, цаашид энэ талаар хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжүүдийг мөн танилцуулна.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Нийгмийн нөлөөллүүдийг ойлгохын ач холбогдол
- Нийгмийн нөлөөллийн төрлүүд
- Тогтвортой Амьжиргааны Арга Зүй
- Нөлөөллийг бууруулах, боломжийг нэмэгдүүлэхүй
- Уул уурхайгаас үүдэлтэй нүүлгэн шилжүүлэлт

Жишиг хуваарь

- Нийгмийн нөлөөллийг ойлгохуй (35 минут)
- Тохиолдолд дүн шинжилгээ хийх бүлгийн ажил (20 минут)
- Уул уурхайгаас үүдсэн нүүлгэн шилжүүлэлт (30 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (5 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p>Нийгмийн нөлөөллийг ойлгохуй (35 минут)</p> <p>Уул уурхайн нийгмийн нөлөөллүүд</p> <p>Нийгмийн нөлөөллийн жишээнд ажил эрхлэлтэд гарах өөрчлөлт, эрүүл мэнд болон хүүхэд асаргаа хамгаалал гэх мэт өөрчлөлтүүд, өрхийн орлогын хүртээмж; соёлын өөрчлөлт, гэр бүлийн гишүүдийн уламжлалт үүрэг байр суурьт гарах өөрчлөлтүүд зэргийг дурьдаж болох юм..</p> <p>Мөн түүнчлэн уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь нийгмийн үр дагавартай байдаг. Жишээ нь уул уурхайн үйл ажиллагаа нь газар болон усны чанар ба хүртээмжтэй байдалд нөлөөлж, улмаар иргэдийн эрүүл мэнд, харилцаа, амьжиргаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий.</p> <p>Нийгмийн нөлөөллийг шууд ба шууд бус гэж үзэж болно. Шууд нөлөөллийн жишээ нь тоос шороо болон чимээ шуугианы нөлөө байна. Харин шууд бус гэдэгт жишээ нь замын хөдөлгөөнд гарсан өөрчлөлттэй холбоотойгоор ихэссэн зам тээврийн осол орох юм.</p> <p>Нийгмийн нөлөөллүүд нь ихэнх тохиолдолд бусад нөлөөллүүдтэй холбоотой үүсэх буюу харилцан нөлөөлж, хуримтлагддаг. Хуримтлагдсан нөлөөллүүд нь нэг уурхайн урт хугацааны хуримтлагдсан нөлөөллийг, нэг бүс нутагт оршиж буй хэд хэдэн уурхайн нөлөөллөл, мөн түүнчлэн уул уурхайтай холбоотой биш байж ч болох бусад үйл ажиллагааны хавсарсан нөлөөллүүд юм.</p>	

(Дэлгэрэнгүйг эндээс уншина уу, Franks D. 2011. Management of the Social impacts of Mining, SMI Mining Engineering Handbook. 3rd edition. 2011)

Олон улсын Оксфам байгууллагын үзсэнээр уул уурхай нь хүмүүст дараах сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй. Үүнд:

- тэднийг орон гэр болон газар нутгаас нь нүүхэд хүргэх
- цэвэр ус болон газар ашиглах боломжинд нь саад учруулах
- эрүүл мэнд болон амьжиргаанд нь нөлөөлөх
- орон нутгийн иргэдийн дунд уул уурхайгаас ашиг хүртэгч, үл хүртэгч гэсэн талцал үүсгэх
- орон нутгийн нийгэм, хүн ам зүй өөрчлөгдөх
- засаг захиргааны болон уул уурхайн хамгаалалтын албад хүний эрхийг зөрчих

Эдгээр нөлөөллүүд нь уул уурхайн төлөвлөлтийн талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд өгөөгүй болон зөвшилцөөгүй тохиолдолд улам даамжирдаг.

(Дэлгэрэнгүйг эндээс уншина уу, Oxfam. 2015. Impacts of Mining. <https://www.oxfam.org.au/what-we-do/mining/impacts-of-mining/>)

Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ /ННБҮ/

ННБҮ нь аливаа төлөвлөгөөт үйл ажиллагааны /бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл/ болон түүнээс улбаатай нийгмийн өөрчлөлтүүдийн улмаас шүүд болон шүүд бусаар үүсч болох эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох, мониторинг хийх, хариу арга хэмжээ авах үйл явц юм. Уул уурхайн төслүүд нь эдийн засгийн үр шим, давуу талыг бий болгох боломжтой боловч олон янзын сөрөг нөлөөллийг үүсгэх эрсдэлтэй. Эерэг үр дүн нь нэмэгдэж сөрөг үр дагавраас сэргийлэхийн тулд сайн менежментийн бодлого, тогтолцоо хэрэгтэй. Үүнд ННБҮ-ний гол зорилго оршдог.

(Дэлгэрэнгүй унших материал: Vanclay, F., Esteves, A.M., Aucamp, I. & Franks, D. 2015 Social Impact Assessment: Guidance for assessing and managing the social impacts of projects. Fargo ND: International Association for Impact

Assessment.)

Монголд сүүлийн жилүүдэд тодорхой асуудалд зориулсан нарийвчилсан үнэлгээ хийж эхлээд байна. Тухайлбал, Эрүүл Мэндэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ /ЭМНБҮ/, Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ /ХЭНБҮ/ гэх мэт шинэ үнэлгээнүүд хийгдэж байна.

(Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийн эндээс уншина уу: БОНХАЖЯ. 2010. БОНБҮ-ий дагалдах журам 2: Эрүүл Мэндэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ; Иргэний Шийдэл Бодлогын Судалгааны Хүрээлэн. Хүний Эрхэд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ <https://civicsolutions.mn/2015/07/13/mongolian-human-rights-impact-assesment/>

Уул уурхайн нийгэмд үзүүлэх нөлөөллийг ойлгох, менежмент хийх талаар уул уурхайн салбарт баримталдаг, олон улсын, үндэсний хэмжээний, тухайн аж ахуйн нэгжийн гэх мэт олон янзын бодлогын баримт бичгүүд, стандартууд бий. Тухайлбал, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн санхүүжилт бүхий бүхий л төслүүдэд нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, менежмент хийх шаардлага тавьж, хэрэгжилтийг хянадаг. Сүүлийн жилүүдэд Олон Улсын Санхүүгийн Корпорацийн “Гүйцэтгэлийн Стандартууд” нь олон улсын түвшинд уул уурхайн салбарт жишиг болон хүлээн зөвшөөрөгдөх болсон. Уг байгууллага нь дэргэдээ бие даасан Гомдол Маргаан Шийдвэрлэх Омбудсманн байгууллагатай бөгөөд тус байгууллагын санхүүгийн оролцоотой төслүүдийн талаарх иргэд, олон нийтийн гомдол хүлээн авч, шийдвэрлэдэг.

Монгол улсын тухайд, Оюу Толгой компани Олон Улсын Санхүүгийн Корпорацийн шаардлагуудыг хангахад чиглэсэн бодлого, үнэлгээг хэрэгжүүлж ирсэн байна. Тус компани нь олон улсын зээлдэгч нарын /үүнд Олон Улсын Санхүүгийн Корпораци мөн хамаарна/ стандартууд болон өөрийн компанийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаарх бодлогын дагуу Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг хэрэгжүүлсэн. Энэ үнэлгээний баримт бичгийг 2012 оны 8 сард олон нийтээс санал авах зорилгоор танилцуулсан байдаг. Уг үнэлгээнд төслийн нийгэмд учруулах гол эрсдэл, нөлөөллийн дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эдийн засгийн нөлөөлөл
- Хүн ам ба шилжих хөдөлгөөн
- Ажил эрхлэлт
- Газар ашиглалт ба нүүлгэн шилжүүлэлт

- Соёлын өв
- Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- Хуримтлагдах үнэлгээ

Түүнчлэн, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкнд хэрэглэгч нартаа зориулсан Гүйцэтгэлийн Шаардлагууд гэдэг бодлогын баримт бичиг байдаг. Түүний нэг нь Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, асуудлуудын үнэлгээ ба менежмент гэдэг стандарт юм. Монгол улсад МАК компанийн Цагаан Суварга төсөл болон Энержи Ресурс компанийн Ухаа Худаг төсөл тус банкнаас санхүүжилт авч байсан бөгөөд стандартын дагуу нийгмийн нөлөөллийн үнэлгээ, төлөвлөгөө боловсруулж байжээ. МАК компанийн төслийн нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний хураангуйг эндээс танилцах боломжтой байна: EBRD. 2011. MAK Phase II. Non-technical summary. <http://www.ebrd.com/work-with-us/projects/esia/mak-phase-ii.html>)

Зарим уул уурхайн компаниуд нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, төлөвлөгөөний талаар компанийн түвшинд тухайн улсын хуульд заасан шаардлагуудаас давсан шаардлагууд бүхий стандарт, бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг. Жишээ нь, Англо-Американ компанийн Нийгэм-Эдийн Засгийн Үнэлгээний Удирдамж нь томоохон уул уурхайн төслийн нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, менежментийн талаарх нарийвчилсан заавар, зөвлөмжүүдийг агуулдаг.

(Эндээс дэлгэрүүлж уншина уу: Franks, D, Fidler, C, Brereton, D, Vanclay, F and P, Clark. 2009. Leading Practice Strategies for Addressing the Social Impacts of Resource Developments. Centre for Social Responsibility in Mining, Sustainable Minerals Institute, The University of Queensland. http://www.csr.uq.edu.au/docs/Franks_etal_LeadingPracticeSocialImpacts_2009.pdf.)

Тогтвортой Амьжиргааны Арга Зүй /ТААЗ/

Уул уурхайн төслийн үе шат бүрийн онцлогоос хамаарч янз бүрийн нийгэмд үзүүлэх нөлөөлөх үүсч болох бөгөөд түүнийг үнэлэх олон янзын аргууд байдаг. Үндсэндээ, орон нутгийн нийгмийн нөлөөлөл, учирч болох эрсдэлийг үнэлэх 2 төрлийн арга зүйн хандлага байдаг. Үүнд:

- Мэргэжилтнүүдэд түшиглэсэн буюу дээрээс доош чигтэй
- Орон нутгийн иргэдэд түшиглэсэн буюу доороос дээш чигтэй

Эхний хандлага нь нийгмийн шинжлэх ухаан болон бусад судалгааны үр дүнд суурилсан, түүнээс эхтэй юм. Үүний жишээ нь Ухаа Худаг, Оюу Толгой зэрэг том төслүүдийн суурь судалгаа, үнэлгээ юм.

(Нэмэлт мэдээллийг эндээс үзнэ үү: the Ukhaa Khudag Environmental and Social Impact Assessment (ESIA) www.energyresources.mn/uploads/14649Hrpt_-_ESIAfinal.pdf)

Хоёр дахь хандлага нь илүү орон нутгийн онцлогыг харгалзсан, орон нутгийн нийгмийн нөхцөл байдал, үнэлэмж, амьжиргаа зэргийг нарийвчлан авч үзэхэд анхаардаг.

Энэ 2 хандлагыг сайтар хослуулан хэрэглэх нь уул уурхайн нийгмийн нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тодорхойлж, хариу арга хэмжээ авахад ихээхэн ач холбогдолтой юм. Түүнчлэн нөлөөллийг тодорхойлох, мониторинг хийхэд олон шинжлэх ухааныг хослуулсан хандлага нилээд дэлгэрч байна.

Сүүлийн үед Тогтвортой Амьжиргааны Арга Зүйг /ТААЗ/ уул уурхайн орон нутгийн нийгэмд үзүүлэх нөлөөлөл ба бий болгох боломжуудыг ойлгоход нилээд ашиглах болсон. ТААЗ-н гол давуу талууд нь үнэлгээний аргуудыг хослуулж болдог, бичил түвшинд анхаардаг, олон талт мэдээллийг системтэй авч үздэг, оролцооны аргыг ашигладаг зэрэг юм. Энэ арга зүй нь уламжлалт арга зүйн макро түвшин, эдийн засгийн нөхцөлд л анхаардаг байдлаас ихээхэн ялгаатай юм. Жишээ нь байгаль орчны байдлаас шууд хамааралтай малчдын амьжиргааны эмзэг байдлыг сайн ойлгоход ТААЗ ач холбогдолтой.

Амьжиргаа гэдэг нь хувь хүн ба өрхийн амьдрах арга, орлогын эс үүсвэр юм. Ялангуяа энэ нь хувь хүн, өрх гэр амьдралын суурь хэрэгцээ буюу хоол хүнс, ус, орон байр, хувцас зэрэгтэй байж, нийгмийн харилцаанд оролцож байх явдал юм. Амьжиргааны эх үүсвэрүүд нь харилцан хамааралтайн зэрэгцээ тэдгээрт гадаад орчин нөхцөл чухлаар нөлөөлж байдаг.

Амьжиргаа нь гэнэтийн өөрчлөлт, хямралыг даван туулах, мөн ирээдүйн нөөц сууриа эвдэлгүйгээр одоогийн болон цаашдын чадавх, хүчин зүйлүүдээ хадгалж, тэлэх чадвартай бол тогтвортой буюу даван туулах чадвартай байна гэсэн үг юм. Хүмүүс амьдрахын тулд тулд тогтвортой амьжиргаатай байх хэрэгтэй. Тиймээс уул уурхайн төсөл зэрэг үйл ажиллагаа нь

хүмүүсийн амьжиргаанд ямар нөлөөлөл үзүүлэх тухай сайтар авч үзсэн байх хэрэгтэй.

(Дэлгэрэнгүйг эндээс уншина уу: Robert Chambers and Gordon R. Conway. 1991. Sustainable rural livelihoods: practical concepts for the 21st century. IDS Discussion Paper 296)

ТААЗ нь орон нутгийн түвшинд иргэдийн амьжиргааг бий болгох, хадгалж байхад дараах 5 капитал чухал үүрэгтэй гэж үздэг. Эдгээр нь хүний, нийгмийн, эдийн засгийн буюу санхүүгийн, биет, байгалийн капитал юм.

- Хүний капитал – орон нутгийн хүний капиталыг хүн амын хэмжээ, нас, онцлогууд, боловсрол, чадвар, эрүүл мэнд зэргээр төлөөлүүлэн авч үздэг.
- Нийгмийн капитал – Хувь хүн амьжиргаагаа залгуулахад хэрэгтэй нийгмийн хүчин зүйлс, хүмүүсийн холбоо хэлхээ, бүлэг, байгууллага дахь оролцоо зэрэг юм. Орон нутгийн түвшин дэх нийгмийн капиталыг хн амын шилжих хөдөлгөөн, орон нутгийн хүн амын бүтэц, онцлог, хоршоо, бүлгүүдийн тоо, гэр бүлийн бүтэц, гэмт хэргийн гаралт зэрэг янз бүрийн үзүүлэлтээр авч үздэг.
- Эдийн засгийн ба санхүүгийн капитал – амьжиргаагаа хангах, дээшлүүлэхэд шаардлагатай хувь хүний хөрөнгө, санхүүгийн нөөц (жишээ нь ажил, гэр бүлийн орлого, бэлэн мөнгө, хадгаламж, зээл).
- Биет капитал – хувь хүний амьжиргаанд шаардлагатай суурь дэд бүтэц, үйлдвэрлэлийн хэрэгсэл. Нийтийн ззэмшлийн, бүтээн байгуулсан, орон нутгийн дэд бүтэц (барилга, байгууламж, үйлчилгээ гэх мэт) болон байр сууцанд хүртээмж ямар байдаг, тэдгээрийн төрөл, хэмжээ зэрэг асуудлыг ойлгоно.
- Байгалийн капитал – орон нутгийн давуу тал, тогтвортой хөгжилд хувь нэмэртэй байгалийн нөөц, орчин юм. Энэ нь эрдэс баялаг, бэлчээр, ус, газар тариалангийн үржил шимт хөрс, ой мод орон нутагт санхүүгийн болон бусад үр ашгийг бий болгож байдаг нөөцүүд болон нуур, гол горхи зэрэг аялал жуулчлалыг дэмжиж, мөн нийгмийн, соёлын, амралтын үнэ цэнийг агуулдаг хүрээлэн буй орчны бусад нөөцүүд юм.

Уул уурхайн төсөл нь эдгээр капиталд нөлөөлөл үзүүлэх, улмаар орон нутгийн амьжиргаанд нөлөөлөх боломжтой.

(Нэмэлт унших материалууд: Horsley, Julia, Prout, Sarah, Tonts, Matthew and Ali, Saleem H. 2015. Sustainable livelihoods and indicators for regional development in mining economies. Extractive Industries and Society. doi:10.1016/j.exis.2014.12.001; Cane, I. Schleger, A. Ali, S. Kemp, D. McIntyre, N. McKenna, P. Lechner, A. Dalaibuyan, B. Lahiri-Dutt, K. and Bulovic, N. 2015. Responsible Mining in Mongolia: Enhancing Positive Engagement. Sustainable Minerals Institute: Brisbane (English & Mongolian))

ТААЗ-н гол санааг таван талт дүрслэлээр илэрхийлэх нь элбэг. Таван талт дүрслэл нь хүмүүсийн хувьд төрөл бүрийн капитал ямар хэмжээтэй буйг харуулдаг. Дүрслэлийн гол цаг нь тэг буюу тухайн капитал огт байхгүй гэдгийг илэрхийлнэ. Хувь хүмүүс, өрх гэрүүд ба орон нутгуудын хувьд ямар капитал ямар хэмжээтэй байх нь янз бүр байдаг. Олон төрлийн, зохих хэмжээний капиталтай нь амьжиргааны илүү баялаг сонголт, боломжуудтай байдаг.

Эмзэг байдлыг бий болгогч олон янзын хүчин зүйлс /жишээ нь байгаль орчны өөрчлөлт, бэрхшээлт нөхцөл гэх мэт/ нь капиталуудад шууд нөлөөлдөг. Мөн бодлого, тогтолцоо, засаглалын үйл явц нь капиталтай байх арга замд шууд бусаар нөлөөлдөг.


(Дэлгэрүүлж унших материал: DFID. 2000. Sustainable Livelihoods Guidance Sheets. <http://www.eldis.org/vfile/upload/1/document/0901/section2.pdf>. and Coakes, S and Sadler, A. 2011. Utilising a sustainable livelihoods approach to inform social impact assessment practice).

Нөлөөллийг бууруулах, боломжийг нэмэгдүүлэх арга зам

Сөрөг нөлөөллийн эсрэг үйл ажиллагаа олон янзын хэлбэртэй. Жишээ нь уурхайн зураг төслийг хэрхэн хийснээр нийгэмд үзүүлэх олон чухал нөлөөллийг бууруулах буюу тэдгээрээс зайлсхийж болно. Олон нийтийн оролцоог хангах нь нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс зайлсхийх чухал арга зам юм.

Нөгөө талаар уул уурхайн төсөл нь эерэг өөрчлөлт, нөлөөлөл буюу боломжийг бий болгодог. Боломж гэдэг нь уул уурхайн төслийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ төслийн шууд ба шууд бүс үр ашиг нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах асуудлыг сайтар тусгах явдал юм. Уул уурхайн компаниуд нь орон нутгийн хөгжилд олон талаар хувь нэмэр оруулж болно. Үүнд: орон нутгийн ажиллах хүчин ба худалдан авалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, түүний ашиглалт, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх, нийгмийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн төсөл,


Эмзэг байдал ба амжиргаа



Нийгмийн нөлөөлөл ба боломж

Асуултууд:

- Нийгмийн капитал болон биет капиталын бууралт нь бусад капиталын хэмжээ, хүртээмжинд хэрхэн нөлөөлөх вэ?
- Санхүүгийн капиталын хүртээмж нь бусад капиталын хэмжээ, хүртээмжинд хэрхэн нөлөөлөх вэ?



хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэх мэт орно. Уул уурхайн төслүүд эдгээрээс зохих байдлаар хослуулан хэрэгжүүлэх нь илүү ач холбогдолтой юм (Модуль 4 энэ асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн).

(Дэлгэрүүлж унших материал: Vanclay, F., Esteves, A.M., Aucamp, I. & Franks, D. 2015 Social Impact Assessment: Guidance for assessing and managing the social impacts of projects. Fargo ND: International Association for Impact Assessment; Elsa João, Frank Vanclay & Lea den Broeder. 2011. Emphasising enhancement in all forms of impact assessment: introduction to a special issue, Impact Assessment and Project Appraisal, 29:3, 170-180, DOI: 10.3152/146155111X12959673796326)

Бүлгийн ажил (20 минут)

Хувилбар 1: Нийгэмд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг ойлгох нь

Дараах зохиомол жишээг жижиг баг болон хэлэлцэж, дүгнэлтээ нийт оролцогчдод танилцуулна.

Хөх алт ХХК нь Улаанбаатар хотоос зүүн урагшаа ойролцоогоор 165 км-т байршилтай РИЧИ хэмээх өндөр орцтой алтны уурхайн төслийг хэрэгжүүлэхээр шийджээ. Компани нь ойролцоогоор 15 км хайрган зам тавьжээ. Ричи төсөл нь алтны гүний уурхай болон холбогдох байгууламжууд гэсэн 2 үндсэн хэсэгтэй юм.

Төслийн үндсэн байгууламжууд дараах болно. Үүнд:

- Ил уурхай
- Хаягдал чулуулгийн овоолго
- Уурхайд нэвтрэх зам
- Эрчим хүчний хангамж, түгээлт
- Шинэ / зөөврийн /усан хангамж, түгээлт
- Хаягдал ус / бохир ус цэвэрлэлт ба боловсруулалт
- Уурхайн үйлчилгээний барилга
- Агуулах
- Харилцаа холбоо

Олборлолтоос гарсан хүдрийг уурхайн хашаанд хураах буюу овоолно. Дараа нь түүнийг туузан дамжуурга ашиглан боловсруулах үйлдвэрт хүргэнэ. Олборлолт, боловсруулалтын үйл

ажиллагаа нь жилийн 350 хоногт, 12 цагийн хоёр ээлжээр явагдахаар төлөвлөгдөж байна.

Барилгын ажил 2017 оны хоёрдугаар улирал гэхэд дуусахаар төлөвлөж байна. Уурхайн сайтын дэд бүтцийн ажил дууссаны дараа буюу 2017 оны гуравдугаар улиралд олборлолт эхлэх юм. Уурхайн үйл ажиллагаа 2023 гэхэд дууссан байхаар төлөвлөж байгаа бөгөөд төслийн хүрээнд нийт 400 орчим ажилчин шаардлагатай.

Байгаль орчны хамгаалал нь энэ төслийн хамгийн чухал асуудлуудын нэг юм.

- Хаягдал чулуулгийн менежмент
- Уурхайн усны менежмент
- Сайтын ус зайлуулах систем
- Уурхайн хаалт ба нөхөн сэргээлт

Уурхай Баян сумын төвөөс 25 км-ийн зайд оршдог. Уурхайн ойр орчимд хэд хэдэн малчин өрх амьдардаг. Тус сум нийт 2507 хүн амтай, 731 өрхтэй юм. Үүнээс малчин өрхийн тоо 515 байна. Тухайн нөхцөл байдлыг шинжилж, төслийн орон нутгийн нийгмийн нөлөөллийг бууруулах болон боломж бий болгох асуудлыг аргыг багаараа хэлэлцэж, дараах хүснэгтийн дагуу танилцуулга хийнэ үү.

Нөлөөлөл	Төслийн үе шат	Нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга зам	Боломжийг нэмэгдүүлэх арга зам

Хувилбар 2: Тогтвортой Амьжиргааны Арга Зүйг /ТААЗ/ бодит нөхцөлд ашиглах нь

Уул уурхайн төслөөс үзүүлж болох нийгмийн эрсдэл, нөлөөллийг зөв тодорхойлж, хянахад орон нутгийн түвшний 5 капитал ямар байгааг ойлгох нь ач холбогдолтой юм. ТААЗ-г бодитойгоор ашиглахад шалгуур үзүүлэлтүүдийг зөв тодорхойлох нь чухал. Сургалтанд оролцогч нарыг жижиг бүлэгт хуваагдаж, капитал тус бүрийн тодорхой шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, нийтэд танилцуулна. Жишээ нь эмнэлгийн багтаамж нь биет капиталын үзүүлэлт, хоршоодын тоо нь нийгмийн капиталын нэг үзүүлэлт гэх мэт. Шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход тулгарах

Олборлолтын үе шат: Энэ үе шатанд шүүлгэн шилжүүлэлт хийх шаардлага их байдаг. Уул уурхайн үйл ажиллагааны нэг онцлог нь шинэ орд, ашигт малтмалын нэмэлт нөөц үйл ажиллагааны явцад илрэх, мөн уурхайн төлөвлөлт өөрчлөгдөх зэрэг өөрчлөлтүүд юм. Түүний улмаас уурхайн төлөвлөлт өөрчлөгдөх, улмаар зам, дэд бүтэц, хог хаягдлын цэгүүд, боловсруулах үйлдвэр, ил уурхайн карьер гэх мэтийг барих газар шаардлагатай болдог.

Нүүлгэн шилжүүлэлт амьжиргаанд нөлөөлөх нь

Байгалийн капитал:

Нүүлгэн шилжүүлэлт байгалийн капиталд хэрхэн сөрөг нөлөөлөл үзүүлдгийг нотолсон маш олон судалгаа бий. Жишээ нь малчдын хувьд бэлчээрийн хэмжээ багасах, бэлчээр хуваагдах, отор нүүдэл хийх боломж хумигдах гэх мэт бэрхшээл үүсгэдэг. Эдгээр нь малчдын амьжиргаанд шууд нөлөөлдөг. Тухайлбал уул уурхайн бүсэд үлдсэн малчин өрхүүд харьцангуй цөөн тооны малтай байх хандлагатай байдаг.

Хүний капитал:

Нүүлгэн шилжүүлэлт нь нөлөөлөлд өртсөн иргэдэд ажлын байр, тэдний хүүхдүүдэд зориулсан сургалтын тэтгэлэг зэрэг боломж бий болгох боломжтой ч хүмүүс нүүн шилжсэний улмаас сэтгэл санааны, орчны өөрчлөлтөөс болж эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх зэрэг асуудал учруулдаг.

Эдийн засгийн ба санхүүгийн капитал:

Нөхөн олговор нь өрх бүрийн хувьд ялгаатай байж болох юм. Монгол улсын хувьд нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын багцад мөнгөн төлбөр болон сургалтын тэтгэлэг, ажлын байр, өвөлжөө хаваржааг нүүлгэх, шинээр барих, банкны зээл авахад дэмжлэг үзүүлэх гэх мэт зүйлс орсон жишээнүүд байна.

Биет капитал:

Нүүлгэн шилжүүлэлт хийхдээ компани нь худаг, өвөлжөө зэрэг шинэ биет дэд бүтцийг барьж өгч болох юм. Зарим компаниуд иргэдэд ногооны хүлэмж барих, жижиг үйлдвэрийн барилга зэрэг дэд бүтэц барих, мөн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад нь шаардлагатай

зээлийн тусламж үзүүлдэг. Нүүлгэн шилжүүлэлтээс биет капиталд үзүүлэх олон янзын сөрөг нөлөөлөл бий. Зарим малчдын ярьснаар уул уурхайн үйл ажиллагааны улмаар бэлчээр хомсдож жил тойрон өвөлжөөндөө байх тохиолдол гардаг байна.

Нийгмийн капитал:

Шинэ газар нутагт нүүн ирсэн иргэдийн хувьд тэр нутагт амьдарч буй иргэдтэй зөрчилдөх, мөн өмнөх нийгмийн байр суурь, холбоо харилцаагаа алдах эрсдэл байдаг. Зарим нутагт нүүлгэн шилжүүлэлт нь бэлчээрийн даацад нөлөөлж, улмаар уугуул-суугуул гэсэн маргаан дэгдээх тохиолдол байна.

Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогод баримтлах зарчим

Шүүлгэн шилжүүлэлт хийхээр болсон бол орон нутгийн захиргаа, уул уурхайн компаниуд дараах асуудлыг сайтар авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Орон нутгийн захиргаа болон компаниуд нүүлгэн шилжүүлэлтэнд орсон иргэд, өрхүүдтэй харилцах, зөв удирдан зохион байгуулах талаар хангалттай мэдээлэл, чадавхтай байх
- Компани нь өрхийн түвшний нийгэм, эдийн засгийн нөхцөл, нүүлгэн шилжүүлэлтээс үзүүлэх нөлөөллийн тухай судалгаа хийх
- Компани нь судалгаа болон орон нутгийн удирдлага, нөлөөлөлд өртсөн иргэдтэй зөвлөлдөх замаар Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө /НШТ/ боловсруулж хэрэгжүүлэх
- Төрийн байгууллагын ажилтнууд компаниудад зохих хяналтыг тавихад нийтлэг мөрддөг стандартууд болон компанийн бодлогын талаар мэдээлэлтэй байх
- Орон нутгийн захиргаа нь нүүлгэн шилжүүлэлтийн ажлын бэлтгэлийг хангах, зохицуулах чиглэлээр идэвхтэй оролцох
- Компаниуд нь тогтвортой амьжиргаанд нүүлгэн шилжүүлэлтээс үзүүлэх нөлөөллийг тооцох тодорхой арга зүй, томъёог ашиглан нөхөн олговрын зохистой, ойлгомжтой шалгууртай байх
- Компаниуд нь нүүлгэн шилжүүлэлтийг иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж, чингэхдээ иргэн, өрх тус бүртээ ганцаарчлан тохиролцох хэлбэрээр бус хамтын зарчмаар нөхөн олговрын болон бусад асуудлыг шийдвэрлэх
- Орон нутгийн захиргаанаас нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой иргэд, бусад оролцогч

талуудад үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, зохион байгуулах

(References: Cane, I. Schleger, A. Ali, S. Kemp, D. McIntyre, N. McKenna, P. Lechner, A. Dalaibuyan, B. Lahiri-Dutt, K. and Bulovic, N. 2015. Responsible Mining in Mongolia: Enhancing Positive Engagement. Sustainable Minerals Institute: Brisbane; ICMM. 2015. Land acquisition and resettlement: lessons learned <https://www.icmm.com/news-and-events/news/icmm-shares-lessons-learned-on-resettlement>; IFC Handbook for Preparing a Resettlement Action Plan <http://www.ifc.org/wps/wcm/connect/22ad720048855b25880cda6a6515bb18/ResettlementHandbook.PDF?MOD=AJPERES>.)

Асуулт, хэлэлцүүлэг (15 минут)

- Монгол улсын хувьд нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулахад зайлшгүй авч үзэх шаардлагатай онцлогууд юу вэ?
- Нийгэмд үзүүлэх нөлөөллийн эсрэг арга хэмжээ авах, орон нутагт боломж нэмэгдүүлэхэд орон нутгийн удирдлага ямар үүрэгтэй вэ?

Унших ном, материал

Бакей, А & Б.Чимид-Очир. 2010. Малчин өрхийн амьжиргаа: нөлөөлөх хүчин зүйлс, дээшлүүлэх арга зам http://www.maas.edu.mn/index.php?option=com_content&view=article&id=310:2010-03-01-17-

Cane, I. Schleger, A. Ali, S. Kemp, D. McIntyre, N. McKenna, P. Lechner, A. Dalaibuyan, B. Lahiri-Dutt, K. and Bulovic, N. (2015). Хариуцлагатай уул уурхай Монголд: Хамтын Зүтгэл. Sustainable Minerals Institute: Brisbane

https://www.csr.mn/publications?task=download&file=pub_link&id=1330. /Монгол/ Chuluun, T. et al. Vulnerability of Pastoral Communities in Central Mongolia to Climate and Land-Use Changes. In Vulnerability of Land Systems in Asia.

<http://dx.doi.org/10.1002/9781118854945.ch4>

Franks D. 2011. Management of the Social impacts of Mining, SMI Mining Engineering Handbook. 3rd edition. 2011

Цахим хэрэглэгдэхүүн

Anglo American plc Socio-Economic Assessment Toolbox (SEAT)

<http://www.angloamerican.com/sustainability/communities>(in Mongolian.)

SIAnhub. <http://www.socialimpactassessment.com/index.asp>

Mining & Resettlement eLibrary. <http://www.miningresettlement.org/>

Boomtown toolkit. <https://boomtown-toolkit.org/>

Үндсэн нэр томьёо, ойлголтуудын тайлбар

Тогтвортой Амьжиргааны Арга Зүй /ТААЗ/ - төслийн улмаас иргэд, орон нутгийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг авч үзэх арга бөгөөд 5 капиталыг үндэс болгодог.

Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ – аливаа төлөвлөгөөт үйл ажиллагааны /бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл/ болон түүнээс улбаатай нийгмийн өөрчлөлтүүдийн улмаас шууд болон шууд бусаар үүсч болох эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох, мониторинг хийх, хариу арга хэмжээ авах үйл явц юм.

Нүүлгэн шилжүүлэлт – төслийн улмаас хүмүүс нэг газраас нөгөөд нүүн шилжих үйл явц

Биет алдагдал – уул уурхайн төсөлд шаардлагатай газар олголтын улмаас иргэд орон байр ба газартай холбоотой бусад капиталаа алдах явдал.

Нөлөөлөлд өртсөн өрх – уул уурхайн төслийн улмаас амьжиргааны эх үүсвэр нь шууд болон дам байдлаар нөлөөлөлд орсон өрх.

Эдийн засгийн алдагдал – уурхайн төслийн газар олголтоос болон ус, газар зэрэг нөөцийг ашиглах байдалд гарсан өөрчлөлтөөс болж амьжиргаанд учрах сөрөх нөлөөлөл

Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө – нүүлгэн шилжүүлэлтийг хэрхэн зохион байгуулах талаарх нарийвчилсан стратеги, төлөвлөгөө

МОДУЛЬ 4. УУЛ УУРХАЙ БА ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Уул уурхай болон орон нутгийн хөгжлийн эерэг болон сөрөг харилцааны тухай мэдлэг ойлголт
- Орон нутгийн хөгжлийг дэмжих үндсэн зарчмуудыг тодорхойлох чадвар
- Уул уурхай болон орон нутгийн хөгжлийн талаарх сайн практик, хандлагын талаарх мэдлэг
- Уул уурхайгаас орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмрийг дүгнэх чадвар
- Үр өгөөж бүхий орон нутгийн гэрээ байгуулах, түүний тулгуур заалтуудын талаарх ойлголт, мэдлэгтэй болно.

Удиртгал

Энэ модулийн эхний хэсэгт уул уурхайгаас орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн тухай тоймлон авч үзнэ. Уул уурхайн компаниуд ба орон нутгийн оролцогч талуудын хувьд орон нутгийн хөгжил гэдгийг хамтын оролцоот, олон талт үйл явц гэж ойлгох нь чухал юм.

Энэ модулийн нэг онцлууштай зүйл бол орон нутгийн эдийн засгийн хөгжилд уул уурхайн оруулж болох хувь нэмрийг нарийвчлан авч үзсэн явдал юм. Уул уурхайн орон нутгийн хөгжилд шууд ба шууд бусаар хувь нэмэр оруулдаг. Түүнчлэн орон нутгийн ажил эрхлэлт ба мэргэжлийн сургалт, орон нутгийн худалдан авалт, орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр гэсэн уул уурхайн төслөөс орон нутгийн эдийн засгийн хөгжилд шууд хувь нэмэртэй 3 гол үйл ажиллагааг авч үзсэн.

Модулийн хоёр дахь хэсэгт уул уурхайн компаниуд ба орон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулагдах гэрээний тухай авч үзэж, гэрээний талаарх олон улсын ба үндэсний сайн туршлагаас танилцуулна. Түүний дараа орон нутгийн хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг тусгай сангаар дамжуулан зарцуулах арга замуудын талаар авч үзнэ.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Уул уурхай ба орон нутгийн хөгжил: бизнесийн үнэ цэнэ ба үндсэн зарчим
- Орон нутгийн хөгжлийг харах цогц хандлага
- Уул уурхайн орон нутгийн эдийн засгийн хөгжлийн оролцоо

- Орон нутгийн эдийн засгийн оролцоо /ажил эрхлэлт, худалдан авалт/
- Орон нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт
- Орон нутгийн гэрээ ба хөгжлийн сан

Жишиг хуваарь

- Уул уурхай ба орон нутгийн хөгжил: бизнесийн үнэ цэнэ ба үндсэн зарчим (40 минут)
- Бүлгийн ажил (20 минут)
- Орон нутгийн гэрээ ба сан (20 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

	Жишээ слайдууд
<p>Уул уурхай ба орон нутгийн хөгжил: бизнесийн үнэ цэнэ ба үндсэн зарчим (40 минут)</p> <p>Хэрэв сайн зохион байгуулж чадвал, уул уурхайн үйлдвэрлэл нь Монгол Улсын орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад дорвитой хувь нэмэр оруулах бололцоо байна. Гэвч Монгол Улсад урьд өмнө хийгдсэн судалгааны дүнгээс харахад олонх уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаадад уул уурхайгаас орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг сайжруулах, нэмэгдүүлэх талаар баримтлах тууштай, тогтолцоот хандлага байхгүй байна.</p> <p>Энэ нөхцөл байдлыг сайжруулах олон нийтийн эрэлт хэрэгцээ их бөгөөд саяхан уул уурхайн хууль тогтоомжид зарим ахиц дэвшил гарсан билээ. Жишээлбэл, Ашигт малтмалын тухай хууль уурхайн ажиллах хүчний 90-ээс дээш хувь нь Монгол Улсын иргэн байхыг шаарддаг болов. Мөн Төсвийн тухай хуулийн (2015 он) сүүлд хийсэн өөрчлөлтөөр өөрсдийн газар нутаг дээр идэвхтэй уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй сум, аймаг нь Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтаас илүү үр өгөөж авах боломжтой боллоо.</p> <p>Заамар, Уянга сумдад бидний хийсэн судалгааны дүнд уул уурхайн компаниудаас орон нутгийн хөгжилд ихэвчлэн нэг удаагийн хандив, төсөл хэрэгжүүлэх хандлага зонхилж байгаа бөгөөд уул уурхайн салбарын оруулах хувь нэмрийн талаар системтэй, урт хугацааны үзэл баримтлал дутагдаж байгааг харуулж байна. Нэгэн уул уурхайн компанийн гүйцэтгэх удирдлага дараах зүйлийг бидэнд хэлсэн билээ:</p>	

"Манай компанийн хувьд өмнөх жилд 100 гаруй сая төгрөгийг сумын захиргаанд хандивлажээ. Гэвч бид одоо ч гэсэн орон нутгийн шүүмжлэлтэй нүүр тулгарч, заримдаа бидний тусалж дэмжиж буй нутгийнхан бидний ажлыг тасалдуулдаг. Бидний хувьд ямар асуудал дутагдаад байгааг би мэдэхгүй байна" хэмээн өгүүлэв.

Энэ нь олон компаниудын дунд буй нийтлэг асуудал буюу "Аргацаах" хандлага юм. Дэлхийн уул уурхайн үйлдвэрлэлийн шинэ хандлага, зарим Монголын уул уурхайн компаниудын түршлагаас харахад уул уурхайн компаниуд орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, мөн үйл ажиллагаа явуулах нийгмийн тусгай зөвшөөрөл авахын тулд илүү тогтолцоот хандлагыг баримтлах хэрэгтэй болжээ.

Орон нутгийн хөгжлийн бизнест бий болгох давуу тал

Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр нь бизнесийн үнэ цэнэ болохыг уул уурхайн компаниуд ойлгох нь нэн чухал. Компанийн хувьд хүртэх гол ашиг тус нь:

- Уул уурхайн салбар дахь болон Засгийн газар, бусад оролцогч талуудын дунд нэр хүнд өснө
- Орон нутгийн эсэргүүцэл улам бүр нэмэгдэж буй байгаль орчны болон бусад шинэ нөөц, бүс нутагт нэвтрэх боломж сайжирна
- Орон нутгийн засаг захиргаа, ТББ-үүд, иргэдтэй илүү сайн харилцаатай болж, төсөл боловсруулах, батлуулах үйл явцыг илүү амар хялбар болгоход хувь нэмрээ оруулна
- Үйл ажиллагаанд саад болох эрсдэл бүхий орон нутгийн эсэргүүцлээс зайлсхийнэ
- Үйл ажиллагаанд нөлөөлөх орон нутгаас хараат байдлыг бууруулна
- Орон нутгаас дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүртээмж сайжирч, бүтээмж ба үр ашиг нэмэгдэнэ
- Орон нутгийн ажиллах хүчний боловсрол, чадварын түвшинг сайжруулснаар өндөр хөлс бүхий ажилчдыг авчрах, тэднээс хамаарах байдлыг бууруулна
- Үйл ажиллагааны явцын талаар нутгийн иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ. Энэ нь цаг хугацаа, хүчин чармайлт болон хөрөнгө хэмнэх болно.
- Ажилтан ажилд авах, нөөцөд байлгах, оролцоог хангах байдалд ахиц гарна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Орон нутгийн хөгжлийн гарын авлага. УУМОУЗ (ICMM) 2015 он)

Судалгаа, шинжээчдийн зөвлөмжид үндэслэн орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор дараах үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа тусгахыг УУМОУЗ-өөс уул уурхайн компаниудад

What is the business case of local development for mining companies?

Business reputation:
Increased reputation in the mining industry to government stakeholders

Local support:
Better understanding and support of local stakeholders and people who are using products and services from the company

Local government relations:
Better relations with local governments, NGOs and communities for security and operational permits

Local talent pool:
Attract local people to the industry

Local knowledge:
The companies, without investment in the operations will have to gain business benefits

Market penetration:
Increase efficiency and reduce the cost of the supply chain

Operational efficiency and safety:
The local workforce will be more experienced and skilled

зөвлөжээ. Үүнд:

Стратегийн хандлагыг баримтлах

Үйл ажиллагааны түвшин дэх бүтээн байгуулалтыг компанийн урт хугацааны стратегийн зорилтуудтай холбон авч үзэх, мөн одоо байгаа болон ирээдүйд бий болох олон нийт, эсвэл бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөх

Зөвлөлдөх болон оролцох үйл явцыг хангах

Орон нутгийн иргэдийг төслийн төлөвлөлт, үйл явцын талаарх шийдвэр гаргахад оролцох боломжийг хангах, улмаар орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн тогтвортой байдлыг аль болох боломжит хувилбараар санал болгох

Түншлэлийн түвшинд хамтран ажиллах:

Хувийн, төрийн, төрийн бус буюу олон нийтийн байгууллагууд нь өөр өөр чадвар, хөрөнгө нөөцийг нийлүүлдэг. Харин нийтлэг ашиг сонирхол, зорилго нь тус тусдаа ажиллахаас илүү их боломжид хүрч чадна. Албан болон албан бус түншлэл нь зардлыг бууруулах, зэрэгцэн өрнөж буй давхардлаас зайлсхийж, үүл уурхай, металын үйл ажиллагаан дахь олон нийтийн хараат байдлыг багасгах болно.

Чадавхийг бэхжүүлэх:

Нутгийн иргэд, олон нийт, ТББ болон Засгийн газрын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг чухалчлан бэлэн мөнгө, материаллаг зүйлс, дэд бүтцийн хангамжаас илүүтэй урт хугацааны тогтвортой хөтөлбөр болгоход анхаарна. Алслагдсан бүс нутгийн хөгжилд дэд бүтэц зайлшгүй чухал боловч энэ нь нутгийн иргэд, засаг захиргааны оролцоотойгоор сайн зохион байгуулагдсан, сайтар төлөвлөгдсөн хөтөлбөр байгаа тохиолдолд илүү тогтвортой байх болно.

Хэмжих болон харилцах:

Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийг сайн хэрэгжүүлэхийн тулд тогтвортой зорилгод чиглэх шаардлагатай. Иймд тогтвортой байдлыг хангах зорилгоор хөтөлбөрт хяналт тавьж, сонгон авсан тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтийг тогтмол үнэлэх нь чухал.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Орон нутгийн хөгжлийн гарын авлага. УУМОУЗ (ICMM) 2015 он)



Орон нутгийн хөгжилд уул уурхайн оруулах хувь нэмрийг ойлгох нь

Сүүлийн үеийн судалгааны бүтээлүүдэд уул уурхай болон орон нутгийн хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийхэд Таван капиталын онол буюу Тогтвортой амьжиргааг дэмжих хандлага нь зохих арга зүйгээр хангах боломжтой хэмээн харуулж байна. Тогтвортой амьжиргаа хандлагыг өргөн хүрээнд эсхүл таван капиталын түвшинд хэрэглэсэн эсэхээс үл хамааран хувь хүн, өрх гэр, кластер, орон нутаг, бүс нутаг, үндэсний түвшинд эсхүл бүр түүнээс чинагш гэх мэтээр бүх түвшинд гарах үр дүнг үнэлэхэд хэрэглэх боломжтой.

Санхүүгийн капитал

Уул уурхай нь цалин, хадгаламж, орон нутгийн худалдан авалт, бизнесийн хөгжил, зардал болон бусад санхүүгийн урсгалаар дамжуулан орон нутгийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.

Хүний капитал

Уул уурхайн компаниуд орон нутгийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд орон нутгийн ажиллах хүчний чадавхийг бэхжүүлэхэд тусалдаг.

Нийгмийн капитал

Уул уурхай нь орон нутгийн эдийн засаг, нийгмийн эс ширхэг бүрт нөлөөлдөг. Үүний хамт орон нутгийн ашиг сонирхолд суурилсан бүлгүүд, хоршоо, эмэгтэйчүүд, залуучуудын үйл ажиллагаа зэрэгт хувь нэмэр оруулдаг.

Байгалийн капитал

Байгалийн капитал нь нөхөн сэргээгдэх болон үл сэргээгдэх байгалийн нөөц, байгаль орчны хүртээмж зэрэгт хамааралтай.

Биет капитал

Уул уурхайн төслүүд нь орон нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөхүйц дэд бүтцийг шинэчлэх буюу бий болгох зэрэг боломжтой байдаг.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Жулиа Хорслей, Сара Проут, Матью Тонтс, Салим Х. Али нар, “Уул уурхайн эдийн засаг дахь бүс нутгийн хөгжлийн төлөө тогтвортой амьжиргааны шалгуур үзүүлэлтүүд”, Олборлох үйлдвэрлэл ба Нийгэм, 2-р боть, 2015 оны 4-р сар, 368-38 талууд)

Уул уурхайгаас орон нутгийн эдийн засаг оруулах шууд ба шууд бус хувь нэмэр

Ерөнхийдөө уул уурхайгаас тодорхой орон нутгийн, эсвэл бүс нутагт үзүүлэх үр ашиг нь тохиолдол бүрт өөр өөр байдаг. Уул уурхайн орон нутгийн эдийн засагт үзүүлэх үр нөлөөг хэмжих хоёр үндсэн хандлага байдаг.

Уул уурхай нь орон нутгийн эдийн засагт шууд болон шууд бусаар хувь нэмрээ оруулдаг. Эдийн засгийн хөгжилд оруулж буй шууд хувь нэмэр нь уул уурхайн компанийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний гарц, мөн хөдөлмөр, хөрөнгө, үйлчилгээ зэрэгт зарцуулах зардал юм. Шууд бус хувь нэмрийн хэмжээг тухайн бүс нутаг дахь эдийн засгийн бусад үйл ажиллагаатай хэрхэн уялдаа холбоотой байгаагаар тодорхойлогддог. Эдгээр уялдаа холбоо нь дөрвөн өөр хэлбэртэй байдаг.

Орцод чиглэсэн холбоо: Орон нутгийн болон бүс нутгийн орц худалдан авалт. Эдгээрт ихэвчлэн хоол хүнс, хүнс хүргэх үйлчилгээ, цахилгаан эрчим хүч, тээврийн үйлчилгээ болон бусад түүхий эд материал ордог. Нөгөө талаас, тухайн бүс нутгийн ханган нийлүүлэгчид өөрсдийн орцоо уул уурхайд худалдах бөгөөд энэ бүс нутгийн хүрээнд худалдан авалт хийсэн бол үр өгөөж нь бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих болно.

Гарцад чиглэсэн холбоо: Хүдэр, баяжмал зэрэг түүхий эдийг боловсруулах, цэвэршүүлэх, баяжуулах зэрэг боловсруулалтын үйл ажиллагаа нь хүдрийг эцсийн хэрэглээнд хүргэхийн өмнөх хэд хэдэн үе шат дамжин явагдах тул чухал ач холбогдолтой.

Уялдаа холбоо бий болгосноор түүхий эдийн олборлолт боловсруулалт нь орон нутгийн үйлдвэрлэлийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Нөөцийн олборлолт нь орц, гарцад чиглэсэн холбоог бий болгох замаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг хэмээн тайлбарлах тал байдаг. Гэсэн хэдий ч Пеггийн (2006) тэмдэглэсэнчлэн, ихэнх олборлох төслүүд орон нутгийн болон бүс нутгийн ханган нийлүүлэгчдэд төдийлэн сайн үр дүн авчирдаггүй байна.

Эцсийн эрэлтийн холбоо: Уурхайн ажилчдын болон тэдний өрхийн орлого нь тухайн бүс нутагт үйлдвэрлэсэн бараа, ажил үйлчилгээнд зарцуулагддаг (жишээ нь, хүнсний бүтээгдэхүүн, хувцас, үзвэр, зоогийн газрууд зэрэг) байна.

Санхүүгийн холбоо: Орон нутгийн засаг захиргаад нь татвар, ашигт малтмалын нөөц ашигласны орлого зэргийг эмнэлэг, сургууль гэх мэт дэд бүтцийг хөгжүүлэх, мөн бусад бараа, үйлчилгээ худалдан авахад ашигладаг байна.

Эдгээрийн илүү хялбараар тайлбарлавал шууд бус хувь нэмэр бол уул уурхай дахь орон нутгийн ажил эрхлэлт, орон нутгийн худалдан авалт, мөн нийгмийн хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт юм. Шууд бус хувь нэмэр гэвэл уул уурхайн нөлөөгөөр бусад салбарт /барилга, ХАА, зам% оёдол, худалдаа гэх мэт/ бий болж буй ажлын байр, ашиг орлого, уурхайн компани болон гэрээт аж ахуйн нэгжид ажиллагсадын худалдан авалт, уул уурхайн компаниудаас хураасан татварын орлогын шилжүүлгээр орон нутагт ирэх хөрөнгө оруулалт зэрэг юм.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Eggert R. Mining and Economic Sustainability: National Economies and Local Communities, Division of Economic and Business, Colorado School of Mines; Radetzki M.1982. Regional development benefits of mineral projects, Resources Policy, 8 (3), pp 193-200; T Gunton, 2003. Natural Resources and Regional Development: An Assessment of Dependency and Comparative Advantage Paradigms: Economic Geography [Econ. Geogr.]. Vol. 79, no. 1, pp. 67-94)

Орон нутгийн ажил эрхлэлт

Орон нутгийн хувьд уул уурхайн төсөлтэй холбоотой ажил эрхлэлт нэмэгдэнэ гэдэг маш том хүлээлт байдаг. Гэвч уул уурхайн салбарт ажиллах хүчний тоо нь төслийн хэмжээтэйгээ харьцуулахад бага байдаг. Өөрөөр хэлбэл төслийн эдийн засгийн үзүүлэлт, орлого ашиг өндөр байх нь ажиллах хүчний тоотой шууд хамааралгүй байдаг.

Ашигт малтмалын хуулинд зааснаар уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уул уурхайн нийт ажиллах хүчнийхээ болон гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажиллах хүчний 90-ээс доошгүй хувь нь Монгол улсын иргэд байлгах үүрэг хүлээдэг.

Уул уурайн салбарын ихэнх ажлын байранд тавигддаг шаардлагууд нарийн мэргэжлийн шинжтэй байдаг. Ялангуяа цахилгаан, барилга, механик зэрэг ажлын байранд нарийн мэргэжлийн шаардлагууд тавигддаг.

Орон нутагт хэдийгээр энэ чиглэлээр боловсрол эзэмшсэн хүмүүс байх боловч ихэнхдээ уул уурхайн компаниудын тавьж буй шаардлагад нийцэх мэргэжлийн үр чадвартай хүмүүс ховор байх бэрхшээл

тулгардаг.

Түүнчлэн, хоол хүнс бэлтгэх зэрэг нарийн мэргэжлийн бус ажлын байранд тохирох чадвартай ажиллах хүчин хомс байх явдал ч гардаг. Малчдын бүлэг, ХАА-н хоршоод нь уурхайд мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэхийг хүсдэг боловч уул уурхайн компанийн хувьд их хэмжээний, чанартай бүтээгдэхүүнийг найдвартай нийлүүлэгчээс тасралтгүй авах сонирхолтой байдаг. Тийм учраас малчид, орон нутгийн ААН-үүд урт хугацааны нийлүүлэгч болохын тулд уул уурхайн компанийн тавьж буй чанар, хэмжээнд нийцэхүйц түвшинд бүтээгдэхүүн нийлүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлага юм.

Уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй орон нутгийн засаг захиргааны хувьд орон нутгийн иргэдийн мэргэжлийн сургалт, боловсролыг хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг дэмжих чухал бодлого юм. Хэдийгээр засгийн газар энэ чиглэлийн төсвийг шийдэж, шилжүүлдэг боловч орон нутгийн захиргаа нь уул уурхайн компаниудтай хамтарч шинэлэг, харилцан ашигтай байдлаар орон нутгийн мэргэжлийн боловсролд зориулсан санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой. Тухайлбал уул уурхайн компаниудтай хууль заасны дагуу орон нутгийн гэрээ байгуулахдаа орон нутгийн мэргэжлийн ажилчдыг мэргэжлийн ажлын байранд тэргүүн ээлжинд авч үзэх, мэргэжлийн боловсролыг дэмжих гэх заалт оруулж болно. Мэргэжлийн боловсрол нь зөвхөн тухайн салбарын ажил эрхлэлт гэдгээр ач холбогдол нь тодорхойлогдохгүй. Мэргэжлийн сургалт нь алсдаа орон нутгийн иргэдийн мэдлэг, чадавхийн суурийг нэмэгдүүлнэ. Жишээ нь хөгжлийн өөр чиглэлийн төслүүдэд хувь нэмэр оруулах боломж нэмэгдэнэ /техникч хүн дэд бүтцийн төсөлд ажиллах гэх мэт /. Мөн гаднаас шилжин ирэгсдийн тоог бууруулж орон нутгийн нийгмийн харилцаанд эерэг нөлөөтэй юм.

Орон нутагт ажлын байрыг бий болгох нь уул уурхайн төслийн хэмжээ, үе шат зэргээс хамаарч янз бүр байдаг. Жишээ нь харьцангуй богино хугацааны, жижиг төслийн хувьд орон нутгийн мэргэжлийн боловсрол, сургалтанд шууд хувь нэмэр оруулах боломж бага бол том төслүүдийн хувьд орон нутгийн иргэдийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх олон төрлийн ажлууд хийх боломж бий. Гэвч энэ нь жижиг төслүүд орон нутгийн ажил эрхлэлтэнд огт хувь нэмэргүй гэсэн үг биш юм. Жишээ нь Канадын Хайгуул, Уурхайн Компаниудын Холбооноос жижиг дунд компаниудын хувьд дараах зарчмын дагуу орон нутгийн ажил эрхлэлтийг дэмжиж болно гэж үзсэн байна. Үүнд:

- Ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх бодлого боловсруулж, орон нутагт мэдээлэл хүргэх
- Нээлттэй ажлын байр, түүнд шаардлагатай үр чадвар, сургалтын талаар орон нутгийн иргэдэд

мэдээлэх

- Орон нутгийн, чадварлаг ажиллах хүчний нөөцийн мэдээллийг компанийн мэдээллийн сан бүрдүүлэх, орон нутгийн удирдлагаас авах, иргэдийн оролцоог хангах зэргээр боловсруулж ашиглах
- Эмэгтэйчүүд, залуучууд, бусад цөөнх, эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх

Орон нутгийн ажил эрхлэлттэй холбоотой ямар алдаа, дутагдал гардаг вэ?

- "Орон нутгийн" хэмээх ойлголтыг компаниуд болон олон нийт өөр өөрөөр тодорхойлсон байдаг.
- Мерит зарчимд суурилсан ажилд авах үйл явц нь бүлгүүдийн дунд хагарал үүсгэдэг.
- Ажилд авах ил тод бус бодлого нь компанийн эсрэг бухимдсан ажил хайгчдыг чиглүүлж болзошгүй.

Ямар бодлогын алхмууд байж болох вэ?

Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн үрт хугацааны боломжид хөрөнгө оруулалт хийх

- Боловсролын тогтолцоог дэмжих
- Нутгийн иргэдийг ажилд авахыг зорилгоо болгох

Нутгийн иргэд, ялангуяа залуучууд ажлын байртай болох боломжийг нэмэгдүүлэх

- Залуучуудад ажил эрхлэх, хөдөлмөрийн чадвараа сайжруулахад нь туслах
- Түршлага багатай нутгийн иргэдэд сургагч багш хөлсөлж ажиллуулан тодорхой чадварыг дэмжих
- Нутгийн иргэдийг бэлтгэх зорилгоор мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өрнүүлэх

Хуваарилалтын үр нөлөө бүхий хөдөлмөр эрхлэлтийн бодлого батлах

- Хүн амын төлөөллийг хангах
- Нийгмийн болон техникийн сонгон шалгаруулах үзүүлэлт

Ажлаас чөлөөлөх үйл явц хүндэтгэлтэй, шударга ёсонд нийцсэн эсэхэд анхаарах

- Харилцаа холбоо
- Цомхотголын дараа дэмжлэг үзүүлэх

Ажилд авах шалгуурын ил тод байдлыг хангахад анхаарах

- Олон нийтийн мэдээллийн самбар
- Ажил эрхлэх боломжийг тодруулан мэдээлэх

Орон нутгийн худалдан авалт

Орон нутгийн худалдан авалт нь орон нутгийн хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой. Худалдан авалт нь

- Уул уурхайн компанид нийлүүлэлт хийж буй орон нутгийн ААН-ийн чадавхийг нэмэгдүүлдэг
- Орон нутгийн ААН-үүдэд шинэ технологи, ур чадвар шилжих, хөгжих давуу тал үүсгэнэ
- Бүс нутгийн бизнесийн сүлжээ, түншлэлд хувь нэмэр оруулна
- Орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ

Хөгжиж буй улсуудын туршлагаас үзэхэд орон нутгийн худалдан авалт хөгжлийн маш чухал хөшүүрэг болдог. Орон нутгийн бараа, үйлчилгээг худалдан авах нь олон улсуудын хувьд хөгжлийн нэг чухал стратеги байдаг. Жишээ нь БНСУ-ын хувьд аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний өрсөлдөх чадвар, хөгжлийг хангахад орон нутгийн худалдан авалтын бодлого чухал байж ирсэн..

Уул уурхайн салбарт орон нутгаас аль болох их худалдан авалт хийх нь сайн туршлага болж байна. Юуны өмнө уул уурхайн салбарын хувьд орон нутгийн худалдан авалт нь урт хугацаанд зардал буурах давуу талыг бий болгодог. Түүнчлэн орон нутгийн худалдан авалт нь компаниуд орон нутгийн захиргаа, иргэдтэй сайн, итгэлцэлт харилцааг үүсгэхэд тустай юм.

Монгол улсад зарим уул уурхайн компаниуд орон нутгийн ханган нийлүүлэгч нартаа эрүүл ахуйн шаардлагыг дээшлүүлэхэд зориулсан сургалт явуулах, хөнгөлөлттэй зээл олгох зэргээр дэмжих хөтөлбөр хэрэгжүүлдэг. Зарим компаниуд хүний нөөц, маркетинг, санхүү, үйлдвэрлэлийн технологи зэрэг сэдвээр сургалт явуулж, туршлага судлах танилцах аялал зохион байгуулдаг. Ингэхдээ төрийн байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Зарим компаниуд дотооддоо орон нутгаас худалдан

авч болох бараа, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, зохих шаардлагуудыг танилцуулж, хэрэгцээтэй дэмжлэг үзүүлдэг.

Орон нутгийн ААН-үүд уул уурхайн компанийн ханган нийлүүлэгч болох боломжийг нэмэгдүүлэх, цаашид зах зээлээ тэлэхэд орон нутгийн удирдлага үр дүнтэй хөгжлийн бодлого төлөвлөлт, зохион байгуулалтаар дэмжиж өгөх нь чухал юм. Жишээ нь Австралид Күинсланд мужийн засгийн газраас 25 доош тооны ажиллагсадтай уул уурхайн бүс нутаг дахь орон нутгийн ААН-үүд уул уурхайн компаниудад бараа үйлчилгээ ханган нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, дагнасан байгууллага ажиллуулдаг.

(Эндээс дэлгэрүүлж үзнэ үү <http://c-res.com.au>)

Уул уурхай харьцангуй өндөр хөгжсөн Австрали, Канад гэх мэт улсад орон нутгийн удирдлага, иргэд уул уурхайн компаниудтай гэрээ байгуулахдаа орон нутгийн худалдан авалтын асуудлыг түлхүү оруулдаг. Монгол улсын хувьд мөн адилаар орон нутгийн үүнийг сайтар тусган өгөх боломж бий. Жишээ нь Ховд аймаг болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан Хамтын Ажиллагааны Гэрээнд дараах заалт оржээ:

14.1 Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай мах, сүү, хүнсний ногоо, ус, ажлын хувцас, автобус болон жижиг машины түрээсийн үйлчилгээ, харуул хамгаалалт, гурилан бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн болон бусад бараа, ажил үйлчилгээний 50-иас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжин чадавхжуулах чиглэлээр Талууд хамтран ажиллана. Төслийн бараа, ажил үйлчилгээний ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тухайн бизнес үйлчилгээний шаардлага хангасан орон нутгийн аж ахуйн нэгжүүд давуу эрхтэйгээр оролцох ба Компанийн зүгээс тавигдах шаардлагыг хангасан нөхцөлд тэдгээртэй гэрээ байгуулж ажиллана. Компани нь Ховд аймгаас нийлүүлэх бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зах зээлийн үнэ, чанар болон тасралтгүй ханган нийлүүлэх чадавхийг харгалзана. Компани орон нутгийн аж ахуй нэгжүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, ханган нийлүүлэлт хийх боломж нөхцөл бүрдүүлэх чиглэлээр зөвлөгөө, тусламж үзүүлж хамтран ажиллана.

Орон нутгийн худалдан авах ажиллагааны стратегийн гол зарчмууд:

- Төлөвлөлт, зөвлөлдөх үйл явцыг эрт эхлэх
- Төслийг боловсруулах үйл явцад олон нийтийн санаа бодлыг тусгах
- Хүртээмжийг өөрөөр дахин хуваарилах
- Хүнд суртал, чирэгдлийг арилгах
- Эхлэлийн хөрөнгөөр хангах
- Орон нутгийн гэрээлэгчдийн эрсдэлийг бууруулах

- Компанийн бизнес стратегид орон нутгийн худалдан авалтыг тусган оруулах

(Дэлгэрүүлж унших материал: Luc Zandvliet & Mary Anderson. 2009. Getting it Right: Making Corporate-Community Relations Work, Greenleaf Publishing; Esteves, A.M., Brereton, D., Samson, D. and Barclay, M.A. (2010), Procuring from SMEs in Local Communities: A Good Practice Guide for the Australian Mining, Oil and Gas Sectors. Brisbane: Centre for Social Responsibility in Mining, Sustainable Minerals Institute, University of Queensland; Byambajav Dalaibuyan.2016. Local-level agreements in Mongolia: a source book)

Бүлгийн ажил (20 минут)

Хувилбар 1: Орон нутгийн хөгжлийн төслүүд боловсруулж, хэрэгжүүлэх

Ихэнх компаниуд орон нутгийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг. Гэсэн хэдий ч, компаниудын орон нутгийн төслүүдэд зарцуулах мөнгөний хэмжээ, компани ба олон нийтийн харилцааны төлөв байдлын хооронд ямар нэгэн хамаарал (заримдаа урвуу хамааралтай) байхгүй байна. Орон нутгийн хөгжлийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх талаар ямар алдаа дутагдал гардаг болон үүнийг хэрхэн зөв төлөвлөх талаар оролцогчдоос асууна. Жишээ авахад орон нутгийн хөгжлийн төслүүд нь нөлөө бүхий нутгийн иргэдийг урамшуулж, үйл ажиллагаанд оролцуулах, эсхүл компаниуд олон нийтийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тодорхойлсон байх зэрэг нь бүрүү эсэхийг асуувал зохино.

Хувилбар 2: Орон нутгийн төлөвлөлтийн механизмыг боловсронгуй болгох нь

Оролцогчдыг Баянхонгор аймгийн Галуут сумын дараах жишээг уншиж, хэлэлцэхийг хүснэ.

Галуут суманд уул уурхайн 8 аж ахуйн нэгж 2998,84 га талбай бүхий 11 ашиглалтын лиценз, 7 аж ахуйн нэгж 12284,57 га талбай бүхий хайгуулын 10 лиценз эзэмшиж байгаа бөгөөд энэ нь тус сумын нийт нутаг дэвсгэрийн 5.03 хувьтай тэнцэнэ. Өнөөг хүртэл алт олборлогчид, нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага аль нь ч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон орон нутгийн хөгжлийн талаарх ямар нэг тодорхой гэрээг дүгнээгүй байна. 2008 оноос хойш орон нутгийн оролцогч талууд, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний төлөөлөгчдөөс бүрдсэн "Олон талт зөвлөл" үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. 2010 оноос хойш нутгийн иргэд байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан, хуваарилалт, зориулалт, уурхайн компаниас ирүүлсэн хөрөнгө оруулалтын

зардлын талаар мэдээлэл авах боломжтой болжээ. Тайлангуудыг оршин суугчид, уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа багийн иргэдийн Хуралд тогтмол танилцуулж байна. Жил бүрийн эхэнд, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөний саналыг хамтран хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдэд илгээж, хамтран хэрэгжүүлэх талаар саналыг асууж, дараа нь хэлэлцүүлэг болон баталгаажуулах зорилго бүхий олон талт зөвлөлд танилцуулдаг байна. Тэдний орон нутагт "Олон талт зөвлөл"-ийн ижил бүтцийг байгуулах боломж болон хязгаарлалтын талаар оролцогчдоос асууна.

Орон нутгийн гэрээ ба орон нутгийн хөрөнгө оруулалт (20 минут)

Уул уурхайн төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд хөгжлийн үр шимийг хүргэх гол арга болгон ашигладаг олон тооны бүтэц, үйл явцууд байдаг. Үүнд компанийн хяналттай нийгмийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн форум, хоёр талт ба салбар хоорондын түншлэл, хамтын ажиллагаа, албан ёсны гэрээ, олон нийтийн хяналттай итгэлцлийн, хөгжлийн сан зэрэг орно. Энэ хэсэгт бид Монгол улсад шинээр үүсэж буй гэрээ болон хөгжлийг дэмжих санг авч үзэх болно.

Орон нутгийн гэрээ

Монгол улсад уул уурхайн салбар сүүлийн арван жилд огцом өсөхийн хирээр нутгийн иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн бүлгүүдийн зүгээс уул уурхайн хөгжилд орон нутгийн оролцогч талууд, олон нийтийн ашиг сонирхлыг тусгахыг шаардсан шахалтууд улам бүр нэмэгдэж байна. Олон нийт болон компани хоорондын харилцааг шийдвэрлэхэд чиглэсэн уул уурхайн хууль тогтоомжийн нэг чухал өөрчлөлт нь орон нутгийн засаг захиргаа, уул уурхайн компанийн хооронд "Орон нутгийн гэрээ"-г заавал байгуулах шаардлагыг 2006 онд хуульчлан баталгаажуулжээ.

Хэдийгээр өөр өөр нэрээр нэрлэгддэг ч уул уурхайн компаниуд болон тухайн орон нутгийн хоорондын гэрээг байгалийн баялаг ихтэй Австрали, Канад зэрэг зарим оронд ихээхэн ашиглаж байна. Эдгээр гэрээ нь, уул уурхайгаас орон нутагт үзүүлэх нөлөө, үр ашгийг зохицуулах, мөн уурхайн нийгмийн зөвшөөрөл авах зэрэг харилцан ашигтай харилцаа үүсгэдэг. Австрали улсын хувьд 1990-ээд оноос өмнө ямар ч төрлийн орон нутгийн гэрээ ихээхэн ховор байсан. Канад улсын хувьд нилээд эрт буюу 1970-аад оны байдлаар уул уурхайн компаниуд болон уугуул иргэдийн бүлгүүдийн хооронд гэрээ байгуулсан тухай тайлангууд байдаг боловч сүүлийн үеийн судалгаагаар дээр үеэс хойш 1990 оныг хүртэл "харилцан ашиг

тус бүхий гэрээ" ердөө 13-т гарын үсэг зурсан нь тодорхой болжээ. Сүүлийн хорин жилийн дотор гэрээ хийх нь хууль эрх зүйн практик болж, өргөн тархах болжээ. 2005 оны эрдэс баялгийн огцом өсөлтийн дараах ойрын жилүүдэд Канад, Австралийн эрдэс баялгийн компаниуд болон уугуул иргэдийн хооронд хэдэн зуун гэрээ хэлэлцээр байгуулагдсан байна.

Дэлхийн ихэнх хэсэгт орон нутгийн талыг оролцуулсан албан ёсны гэрээ байгуулах явдал уул уурхайн салбар дахь үндсэн дүрэм болж чадаагүй хэвээр байна. Харин үүний оронд, компани, засгийн газрууд үндсэндээ хууль, эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, илүү уян хатан зохицуулалтуудад тулгуурлаж байна. Үүнд нийгмийн нөлөөллийн менежментийн төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, орон нутгийн сан, олон нийтийн оролцоог хангах олон талт төлөвлөгөө, зөвлөх хороо, хуулийн үүрэг үл хүлээх харилцан ойлголцлын санамж бичиг зэрэг зохион байгуулалтын хэлбэрүүд байна.

Үүний зэрэгцээ, орон нутгийн гэрээ нь наад зах нь харилцан тохиролцсон, олон нийтэд хандсан, мөн олон төрлийн тохиргоо, загварыг авч үзэх болжээ. Латин Америкт үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд, ялангуяа нутгийн уугуул иргэд нөлөөлөлд өртөж буй хэсэгт орон нутгийн гэрээ байгуулах талаар ихээхэн шахалтад орох болжээ. Үүний зэрэгцээ хөгжлийн хувьд чухал ач холбогдолтой, байгалийн нөөц баялаг ихтэй хөгжиж буй орнууд компаниудаа нутгийн иргэдтэй хөгжлийн асуудлуудыг тусгасан, үр өгөөж бүхий гэрээ байгуулахыг шаардах хууль гаргасан байна. Эдгээр орнууд нь тухайлбал, Нигери, Сьерра-Леон, Гвиней, Өмнөд Судан, Монгол зэрэг улс болно.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Д.Бямбажав, Монгол Улс дахь орон нутгийн гэрээ: Сурвалж ном)

Орон нутгийн гэрээ нь оролцогч талуудын харилцан хүлээж буй үүргийн хэрэгжилтийг хангуулах зорилготой, компани, орон нутгийн байгууллагын хооронд бичгээр хийгдсэн гэрээ юм. "Орон нутгийн байгууллага" гэдэг нь тодорхой газар зүйн холбоо бүхий бүлэг хүмүүсийн хамтын ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий байгууллага, холбоо, орон нутгийн байгууллага юм. Монгол улсын хувьд ихэвчлэн орон нутгийн засаг захиргааны байгууллагууд компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна. "Хэрэгжүүлбэл зохих" гэдэг нь гэрээний талууд нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ хүндэтгэх, биелүүлэхгүй байвал шүүх буюу өөр гуравдагч этгээдэд (жишээ нь, бие даасан арбитрч) хандан шийдвэр гаргуулах замаар хохирол учирсныг төлүүлэх, гэрээг дуусгавар болгох, эсвэл зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг тодорхой үр дагавар бүхий хариуцлага тооцох байдлыг илэрхийлнэ.

Монгол Улсын хувьд Орон нутгийн гэрээг Хамтын ажиллагааны гэрээ, Нийгмийн хариуцлагын гэрээ, Олон талт оролцогчдын гэрээ гэх мэтээр өөр өөрөөр нэрлэдэг бөгөөд тэдгээрийн бүтэц, агуулга харьцангуй өөр өөр байдаг.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд дараах чиг хандлага байгааг судалгаа харуулж байна:

- Гэрээнд тусгах асуудлуудын цар хүрээ нэмэгдсээр байна
- байгаль орчны менежментэд олон нийтийн оролцоог хангах, уурхайн хаалтын төлөвлөлт зэрэг арга замаар дамжуулан уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах ихээхэн хүчин чармайлт гаргах болсон
- гэрээнд хамрагдсан байх хөгжлийн үйл ажиллагаа илүү өргөн хүрээтэй болж байна
- зам, боомт болон эрчим хүчний шугам зэрэг уурхайн дэд бүтцийн олон нийтийн хэрэгцээнд зориулан ашиглах, мөн уурхайн мөчлөгийн эцэст орон нутгийн ашиг сонирхолд нийцүүлэн дэд бүтцийг шилжүүлэх байдал өсөн нэмэгдэж буй
- компаниудын үүрэг, амлалт нь өмнө байсанчлан "хамгийн их хүчин чармайлт гаргах" гэх бус харин илүү тодорхой шаардлагатай (жишээ нь ажлын байрны тоо, бизнесийн хөгжлийн зорилтууд) гэх мэт нарийвчлагдсан байна
- хэрэгжилтийг дэмжихийн тулд засаглалын механизм дээр анхаарлаа төвлөрүүлэх болсон
- олон нийтэд хүрэх үр өгөөжийн хэмжээ мэдэгдэхүйц өссөн зэрэг сайн талууд байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. O'Faircheallaigh, C. Уул уурхай дахь орон нутгийн хөгжлийн гэрээ: Өсөн нэмэгдэж буй глобал үзэгдэл, 2012 он.)

Орон нутгийн гэрээг үр дүнтэй байгуулснаар дараах үр өгөөжийг өгөх болно. Үүнд:

- Гэрээ хийх үйл явц нь орон нутгийн засаг захиргаа, иргэд олон нийтийн хөгжлийн зорилго, хүсэл эрмэлзлэлээ тодорхой болгон хэлэлцэхийг идэвхжүүлэх болно;
- Яриа, хэлэлцүүлэгт оролцох замаар нутгийн оролцогч талууд санхүүгийн болон бусад саад бэрхшээлийн талаар илүү сайн ойлголттой болох ба ингэснээр талуудын харилцан ойлголцол илүү хялбар дөхөм болно.
- Гэрээ нь оролцогч талуудыг урт хугацааны амлалтуудад "түгжих" болно.
- Харилцан хүлээх үүргээ тодорхойлох замаар гэрээ нь хамтын хариуцлагын мэдрэмжийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- Гэрээ нь бүх талуудын хувьд тодорхой байх шаардлагыг хангах ёстой. Гэрээний талууд нь зөвхөн

компаниудаас бус бусад талаас юу хүлээгдэж байгааг мэдэх болно. Энэ нь ирээдүйд гарч болзошгүй будлиан, тодорхой бус эрсдлийг бүүруулдаг.

Үр дүнтэй, сайн орон нутгийн гэрээ байгуулах тухай олон тооны гарын авлага, зөвлөмж материалууд байдаг. Эдгээр хэрэглэгдэхүүн, мөн Монгол Улсад байгуулсан орон нутгийн гэрээний талаарх судалгаанд тулгуурлан орон нутгийн гэрээ байгуулахдаа орон нутгийн оролцогч талууд, уул уурхайн компаниуд зайлшгүй анхааралтай авч үзэх хэрэгтэй зарим нэг чухал зарчмуудыг танилцуулж байна.

- Гэрээг ажил хэрэг болгох талаар бүх талуудын дунд ижил тэгш амлалт байдаг. Амлалт гэдэг нь энгийнээр хэлбэл, гэрээний талууд тус бүр гэрээний үнэ цэнийг чухалчлан үзэж, түүний дагуу хүлээсэн үүргээ бүрэн үхамсарлаж, түүнийг нуун дарахын оронд гэрээгээ дахин бататган нотолсон байвал зохино.
- Орон нутгийн гэрээ нь өдөр тутмын стандарт арилжааны гэрээ хэлэлцээрээс өөр байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, учирч болох хор үршгийн талаар нэхэмжлэх, хэрэг, мэдээллийг дарагдуулах болон "хатуу үнэ хаялцах" зэрэг нийтлэг тактиктэй байж болно. Орон нутгийн гэрээ амжилттай болох эсэх нь хэлэлцээ хийх үйл явц оролцож буй талууд хэр зэрэг шударга, эрх тэгш байна хэмээн үзэхээс шууд хамааралтай.
- Үр дүн (гэрээний үр дүн) нь тухайн орон нутаг, олон нийтийг төлөөлөн эдгээр хэлэлцээрийг эрхэлж буй төлөөллийн шударгаар хэлэлцэж буй эсэхээс хамаарна.
- Оролцогч тал бүр нөгөө талынхаа зорилго, хэрэгцээг бүрэн ойлгохын хамт гэрээний үүрэг, амлалтууд нь маш тодорхой байна. Эдгээр нь маш тодорхой байдлаар гэрээнд илэрхийлэгдсэн байна.
- Гэрээнд оролцогч талуудын хоорондын харилцааг сайтар удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий үр дүнтэй засаглалын зохицуулалт агуулсан, мөн гэрээний хэрэгжилтийг хангахад шаардлагатай нөөц хуваарилсан байвал зохино.
- Гэрээний засаглалын механизм үр дүнтэй ажиллаж, гол зорилтуудыг хангахуйц ахиц дэвшил гарч буй эсэх талаар тохируулга хийх, тогтмол хяналт-шинжилгээ, хяналт хийх үйл явц байвал зохино.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Бретон, Б, Оуэн Жи ба Ким нар,. 2011. Дэлхийн банк Олборлох үйлдвэрийн Эх сурвалж: Орон нутгийг хөгжүүлэх гэрээний талаар сайн тэмдэглэл, тэмдэглэл)

Итгэлцлийн сан болон бусад сангаар дамжуулан орон нутгийн хөрөнгө оруулалтыг удирдах нь

Итгэлцлийн сан болон бусад сангууд нь (FTFs) уул уурхайтай холбоотой орон нутгийн хөрөнгө оруулалт, нөхөн олговор болон Засгийн газрын төлбөр зэргийг удирдан зохицуулах үндсэн суваг болох явдал нэмэгдсээр байна. Итгэлцлийн сан болон бусад сангуудын эрх зүйн зохицуулалт нь өөр өөр байдаг хэдий ч тэдгээр сангууд нь уул уурхайн үйл ажиллагаанд хамааралгүй ч тухайн төслийн оролцогч талуудын хоорондын засаглалын үндсэн бүтэц байх боломжтой. Хэдийгээр олонх тохиолдолд итгэлцлийн сан болон бусад сангуудын нэр томъёог зэрэгцүүлэн хэрэглэдэг ч тэдгээрийн ялгаатай байдлыг илүү тодорхой болгох нь зөв билээ.

Монгол Улсын Иргэний хуульд “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна” хэмээн заасан бөгөөд “Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ” хэмээн тодорхойлжээ. Иргэний хуулийн 37 дугаар зүйлд санг дараах байдлаар тодорхойлжээ.

37 дугаар зүйл. Сангийн тусгай зохицуулалт

37.1. Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

37.2. Сангийн эрх барих байгууллага нь гүйцэтгэх удирдлага болон хяналтын байгууллагыг томилно.

37.3. Сангийн гүйцэтгэх удирдлага сангийн дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрх барих байгууллагаараа хэлэлцүүлэн хэвлүүлж, олон нийтэд түгээнэ.

Олон улсын туршлагаар бол сангийн үндсэн бүтэц нь компани/аж ахуйн нэгжийн сан болон олон нийтийн сан гэсэн үндсэн хоёр төрөлтэй байдаг.

- Аж ахуйн нэгж/ компанийн сан - Нийгмийн хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх зорилгоор компаниудын санаачилгаар байгуулсан бие даасан хуулийн этгээд юм. Одоогоор Монгол улсын зарим компаниуд, тухайлбал, МАК сан, Оюу Толгойн Говийн Оюу сан, Ховд аймаг дахь Хөшөөтийн хөгжлийн сан зэрэг ийм сангууд байгуулсан байна.
- Орон нутгийн буюу олон нийтийн сан - Тодорхой газар зүйн бүс, цаг хугацаанд олон эх үүсвэрээс санхүүжилтээ босгодог бие даасан, ашгийн бус байгууллага юм.

(Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд дараах илтгэлүүдтэй танилцана уу: Үндэсний хөгжлийн хүрээлэн, “Орон нутгийн хөгжлийн сангийн журмын хэрэгжилт” 2014 он; НҮБХХ, Монгол Улс дахь олборлох салбарын орон нутгийн түвшинд орлого хуваарилж буй байдал, 2016 он)

Итгэлцлийн сан болон бусад сангууд байгуулах явдал ихээхэн өсөж буй байдал харагдаж буй ч хамгийн чухал өсөлт нь орон нутгийн хөрөнгө оруулалтын загварыг хэрэглэх явдал юм. ОУСК-ийн хувьд олон нийтийн хөрөнгө оруулалт гэдэг нь “бизнесийн хэвийн үйл ажиллагааны хамрах хүрээнд үл хамаарах, гагцхүү тухайн газар нутагт нутгийн иргэдэд ашиг тус болох зорилготой сайн дурын үйл ажиллагаа” хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл энэ нь тухайн төслийн улмаас байгаль орчин, нийгмийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдэд нөхөн олговор олгох, учирсан саад бэрхшээлийг арилгах зэрэг компанийн үндсэн чиг үүргээс ялгаатай болохыг анхаарах ёстой.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаарх нийт компанийн зорилгыг дараах байдлаар нэгтгэж болно:

- Орон нутгийн оролцогч талуудтай харилцан ашигтай урт хугацааны харилцаа тогтоож, зэрэг харилцааг хадгалах;
- Амьдралын чанарыг урт хугацаанд сайжруулахад хувь нэмэр оруулах;
- Хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоход туслах зэрэг болно.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Дэлхийн банк 2011 он, Уул уурхайн сангууд, Итгэлцлийн сангууд: Эх сурвалж., <http://documents.worldbank.org/curated/en/2010/06/18550631/mining-foundations-trust-funds-sourcebook>)

Жишээ туршлагын судалгаа

Гана Улс: Уул уурхайн салбар нь орон нутгийн эдийн засагтай шууд холбоос багатай (экспортод баримжаалсан, гадаад хөрөнгө оруулалтаас хамааралтай) тухай асуудлыг олон тооны судалгаагаар хэлэлцсэн байдаг. Энэхүү “тусгаар” эдийн засаг нь орон нутгийн эдийн засагт үр өгөөж муутай, үйлдвэрлэлийн үндсэн орц болон гарц нь түүхий эдээс шууд хамааралтай байдаг. Блоч болон Овусу нар (2012) Гана улсын алт олборлолтын салбарт энэ байдал хэрхэн өөрчлөгдсөн талаар нарийвчлан судалжээ. Алт олборлолтыг тухайн улсын эдийн засгийн бусад салбараас тусгаарлагдсан, хавсарга байдлаар төсөөлж авч үздэг. Гэвч их хэмжээний хөрөнгө оруулалт, үүнээс үүдэлтэй өсөлтийн улмаас алтны салбар нь зөвхөн “тусгаар” эдийн засаг биш харин Гана улсын эдийн засгийн нэгэн чухал тулгуур болохыг тэдний хийсэн судалгааны үр дүнд тодорхойлжээ. Гана улсын алтны салбар маш олон

холбоосоор нийт эдийн засагтай уялдаж байгааг гаргасан байна.

Гана улсын эрдэс баялаг, уул уурхайн салбарт ханган нийлүүлэгчдийн шатлал:

Шат 1: Шууд нийлүүлэгч

- Инженеринг болон үйлчилгээ үзүүлэгчид (жишээ нь, төслийн инженерийн компаниуд)
- Үндсэн тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид (OEMs) (капитал тоног төхөөрөмж)
- Тогтмол хэрэглэгддэг орц нийлүүлэгчид (тэсэрч дэлбэрэх бодис, химийн бодис)
- Мэргэшсэн агентууд болон дистрибьюторууд (насос, холхивч, тээврийн хэрэгслийн эд анги)

Шат 2: Шууд бус нийлүүлэгчид

- Мэргэшсэн инженерингийн үйлчилгээ (цахилгааны ба агааржуулалтын инженер)
- Бүрдэл хэсгийн үйлдвэрлэгчид
- Стандарт бүрдэл хэсгийн үйлдвэрлэгчид (кабелиуд, цахилгаан моторын эд анги)
- Төрөлжсөн жижиг эд ангиуд үйлдвэрлэгчид (өргөх дэгээ, хавхлага, татлага)
- Цувимал болон машин, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ
- Орц нийлүүлэгчид (химийн бодис, ган бүтээгдэхүүн)

Гана улсын уул уурхайн салбарын хувьд бүрэн дүр зургийг гаргахын тулд уул уурхайн үйлчилгээнд шууд холбогдох дараах хоёр түвшинг нэмж оруулсан байна:

Шат 3: Уул уурхайн шууд үйлчилгээ

- Геологийн, судалгааны, газар ашиглалт ба төлөвлөлт
- Лабораторын үйлчилгээ
- Өрөмдлөгийн үйлчилгээ

Шат 4: Шууд бус үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчид (энгийнээс мэргэшсэн хүртэл):

- Санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө
- Хууль зүйн үйлчилгээ
- Тээвэр, ложистик
- Иргэний барилгын инженер

- Байгаль орчны үйлчилгээ
- Барилга, газар зохион байгуулалт
- Хоол хүнсний үйлчилгээ
- Цэвэрлэгээ
- Аюулгүй байдал, хамгаалалт

Гана улсын хууль тогтоомжид заасны дагуу 2013 оноос эхлэн уул уурхайн компаниуд нь Гана улсын бүтээгдэхүүнийг агуулсан "Орон нутгийн худалдан авалтын жагсаалт"-ыг боловсруулж, мөн "Орон нутгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г мэдүүлэх үүрэг хүлээжээ. 2013 онд Уул уурхайн танхим нь гишүүдийн нэрийн өмнөөс Орон нутгийн худалдан авах ажиллагааны хамтарсан төлөвлөгөөг боловсруулж, мэдүүлсэн байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг дараах эх сурвалжаас авна уу. Р. Блоч, Г. Овусу нар, 2012 он, Гана улсын алтны уурхайн салбарын орц, гарц: Хамааралт асуудлын сорилт. Нөөцийн бодлого, 37 (2012), 434-442 дахь тал)

Оюу Толгой: 2015 оны дөрөвдүгээр сард Оюу Толгой ХХК болон Өмнөговь аймаг, төслийн нөлөөлөлд өртсөн дөрвөн сумдын хооронд Хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан байна. Гэрээний дагуу байгуулагдсан Хамтын ажиллагааны хороо, Говийн Оюу сан нь гэрээг хэрэгжүүлэх үндсэн механизм юм.

Хамтын ажиллагааны хороо нь Оюу Толгой ХХК-ийн дөрвөн удирдлага, Өмнөговь аймгийн есөн удирдлагаас бүрдэх бөгөөд Оюу Толгой ХХК болон түүний түншлэгч орон нутгийн хоорондын бүх хамтын ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй. Хорооны ажлын нэг чухал хэсэг бол Оюу Толгойн орон нутгийн бүх харилцаанд иж бүрэн, ил тод зөвлөлдөх үйл явцыг хангах явдал болно. Энэ хүрээнд заримдаа ОТ-н менежер, ажилтнуудыг Хамтын ажиллагааны хороонд тайлангаа танилцуулахыг шаардах болно. Хорооны ажлын бас нэг чухал хэсэг нь Оюу Толгой төслийн болон Өмнөговь аймгийн урт хугацааны хөгжлийн чиг хандлага, ирээдүйн эрхэм зорилгод нийцэх эсэхэд үндэслэн Хөгжлийг дэмжих санд ирүүлсэн төслийн саналуудыг хянаж, Сангийн Удирдах зөвлөлд зөвлөгөө өгөх явдал юм. Хөгжлийг дэмжих сангийн Удирдах зөвлөлд ОТ-н дөрвөн ахлах удирдагч, Өмнөговь аймгийн гурван ахлах албан тушаалтан орно. Хөгжлийг дэмжих сан Оюу толгой төслөөс Өмнөговь аймагт хандсан төсөл, хөтөлбөрт зориулан хуваарилсан хөрөнгийг удирдан зохицуулах болно. Энэ хороо нь жилд дөрвөн удаа хуралдаж, олон нийтийн бүлгүүд, Өмнөговь аймгийн орон нутгийн засаг захиргаадаас ирүүлж буй олон нийтэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийн саналуудыг хянаж үнэлдэг.

Санхүүжилтийн журам нь олон нийтэд нээлттэй байдаг. Санхүүжилтийн ерөнхий үе шат, журмыг товч авч үзье:

1. Хөгжлийг дэмжих санд төслийн санал ирүүлэх - Эрх бүхий өргөдөл гаргагч
2. Төслийн саналыг хүлээн авч, бүртгүүлэх - "Говь Оюу ХДС"
3. Төслийн саналыг хянах, үнэлэх, ач холбогдлоор нь эрэмбэлэх - Улирал тутмын Хамтын ажиллагааны хорооны уулзалт
4. Тэргүүлэх ач холбогдол бүхий саналуудыг урт, богино хугацааны төлөвлөгөө, стратегид үндэслэн санхүүжүүлэх - "Говь Оюу ХДС"
5. Шийдвэр гаргаж төслийн саналыг батлах - "Говь Оюу ХДС"-ийн улирал тутмын ТУЗ-ийн хурал
6. Батлагдсан төсөл буюу хөтөлбөрийн өргөдөл гаргагчид албан ёсны тайлан өгөх - "Говь Оюу ХДС"
7. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх - Шаардлага хангасан өргөдөл гаргагчид
8. Хэрэгжүүлэх явцад үнэлгээ, дүн шинжилгээ хийх - "Говь Оюу ХДС"
9. Аудит хийлгэх - Итгэмжлэгдсэн төлөөлөгч
10. Аудит хийлгэх - Аудитын фирм

Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

- Уул уурхайн үр шим хэрхэн хуваарилагдсанаас хамаарч капиталын төрлүүдэд ямар өөрчлөлт гарах вэ? Өөр өөр капиталын хувьд ямар өөрчлөлт, хамаарал үүсэх вэ?
- Монгол Улсын орон нутгийн тогтвортой хөгжлийн төлөө уул уурхайн компаниудын эдийн засгийн хувь нэмрийг зохицуулахад сумдын засаг захиргаа ямар үүрэг хүлээх вэ?
- Уул уурхайн компаниуд болон орон нутгийн засаг захиргаад нь уул уурхайн үр ашгийг нийт олон нийтэд болон нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд хэрхэн хуваарилах вэ?
- Уул уурхайн компаниуд хамгийн үр дүнтэй хувь нэмрээ оруулах боломжтой сумдын түвшин дэх орон нутгийн бизнесийн үйл ажиллагаанууд юу вэ?

Унших ном, материал

Eggert R. 2001. Mining and Economic Sustainability: National Economies and Local Communities.

<p>Division of Economic and Business, Colorado School of Mines. Esteves, A.M., Brereton, D., Samson, D. and Barclay, M.A. (2010), Procuring from SMEs in Local Communities: A Good Practice Guide for the Australian Mining, Oil and Gas Sectors. Brisbane: Centre for Social Responsibility in Mining, Sustainable Minerals Institute, University of Queensland) ICMM. 2015. Community development toolkit. Luc Zandvliet & Mary Anderson. 2009. Getting it Right: Making Corporate-Community Relations Work, Greenleaf Publishing. WEF. 2013. Responsible Mineral Development Initiative. Geneva, Switzerland: WEF. http://www3.weforum.org/docs/WEF_MM_RMDI_Report_2013.pdf</p>	
<p>Үндсэн нэр томьёо, ойлголтуудын тайлбар</p> <p>Орон нутгийн агуулга - уул уурхайн компаниудын ажиллах хүчин дэх орон нутгийн иргэдийн тоо ба хувь, мөн орон нутгаас бараа, үйлчилгээ худалдан авсан хэмжээ</p> <p>Орон нутгийн гэрээ – талуудын хувьд нэгдсэн ойлголт, хэлэлцээний үндсэн заавал биелүүлэх үүрэг хүлээж, хэрэгжилтийг хангах зорилготой уул уурхайн компани ба орон нутгийн төлөөллийн хооронд байгуулсан гэрээнүүд</p> <p>Чадавхийг бэхжүүлэх - хувь хүн, бүлэг, байгууллагын чадавхийг бэхжүүлэх талаар авч буй арга хэмжээ, хөгжлийн асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэх үйл ажиллагаа</p>	

МОДУЛЬ 5. УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Уурхайн үе шат бүрийн байгаль орчны гол нөлөөллийг тодорхойлох
- Уул уурхайн байгаль орчны засаглал ба менежментийн гол ухагдахуунууд
- Монгол улсын уул уурхайн байгаль орчны засаглал, үүний дотор хууль, стандартууд болон институцуудын (байгууллагууд, практик)

Удиртгал

Энэ модульд уул уурхайн байгаль орчны засаглалын талаар танилцуулна. Үүнд уул уурхайн байгаль орчны гол нөлөөллүүдийг авч үзэж, эдгээр нөлөөллийг бүүруулахад шаардлагатай төрийн зохицуулалт болон менежментийн аргыг танилцуулна.

Уг модулийн эхний хэсэгт уурхайн үе шатыг дахин авч үзэх бөгөөд шат бүрт бий болдог байгаль орчны янз бүрийн нөлөөллүүдийг судална. Мөн түүнчлэн эдгээр нөлөөлөлтэй холбоотой үндсэн зарчмууд, нэр томъёонуудыг танилцуулна. Байгаль орчны нөлөөлөл нь шүүд, шууд бус, эсвэл хуримтлагдсан, тухайн хэсэг газарт төвлөрсөн эсвэл өргөн тархсан, хэмжихэд хялбар эсвэл нарийвчилсан арга аргачлал шаардсан хэмжихэд төвөгтэй гэх мэтчилэн янз бүр байж болно.

Энэ модулийн хоёрдугаар хэсэгт Монгол улсын уул уурхайн байгаль орчны засаглалын ерөнхий дүр зургийг танилцуулах бөгөөд олон улсын гол гол стандартуудын талаар мөн оруулж өгсөн. Энэ хэсэгт уул уурхайн байгаль орчны засаглалыг зохицуулдаг заавал мөрдөх болон сайн дурын журмууд, байгаль орчны менежментийн стандарт болон дүрэм журмыг тодорхойлдог, хэрэгжилтийг хангадаг үйл явц, институцуудыг танилцуулна. Энэ хэсэгт зөвхөн албан ёсны дүрэм журам, институцуудыг танилцуулахаас гадна уул уурхайн байгаль орчны засаглалын үрт хугацааны өөрчлөлтийг тодорхойлдог нийгмийн идэвхжил болон шүүн тогтоох үйл ажиллагааны талаар мөн дурдах болно.

Жишиг хуваарь

- Уурхайн үе шат ба байгаль орчин (30 минут)
- Бүлгийн ажил (15 минут)
- Хариуцлагатай уул уурхайн байгаль орчны засаглал (35 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (10 minutes)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл					Жишээ слайдууд
<p>Уурхайн үе шат ба байгаль орчин (30 минут)</p> <p>Уул уурхайн төслийн явцад хайгуулаас эхлэн уурхайн хаалт хүртэл хэд хэдэн үе шатыг хэрэгжүүлдэг (Модуль 1-ээс уурхайн үе шатын талаар үзнэ үү). Уурхайн үе шат бүрийн байгаль орчны нөлөө ялгаатай байдаг тул эдгээр нөлөөллийг багасгахын тулд өөр өөр стратеги, арга хэрэгсэл болон технологийг ашигладаг. Түүнчлэн уул уурхайн байгаль орчны нөлөө нь олборлолтын аргаас шалтгаалан нэлээд ялгаатай байж болно. Доорх хүснэгтээс уул уурхайн байгаль орчны нөлөөлөл, холбогдох зохицуулалтын болон менежментийн шаардлагуудыг авч үзнэ үү.</p>					
Үе шат	Нөлөөллийн эх сурвалж	Нөлөөнд автсан орчин	Байгаль орчны гол асуудлууд	Менежментийн арга барилууд	
Хайгуул	Эрчимжсэн хайгуул (шороон замаар хүнд машин механизм явах, агаарын хэмжилт, суваг шуудуу ухах, ерөмдөх г.м.)	Ургамлын бүрхэвч Газар ашиглалт Дуу чимээ Усны чанар Хөрс	Эвдрэл, тунадасжилт Мал амьтдыг дүйвээх Ой мод сүйтгэх Газрыг талхлах Химийн бодис, тос асгарснаас т хөрс, ургамлын бүрхэвч хордох	Төлөвлөгөө ба талуудын оролцоо Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө Гэрээлэгчийг сонгох Хяналт шалгалт хийх Хайгуулын дараах нөхөн сэргээлт	
Уурхайг барьж байгуулах	Барилга угсралт Тээвэрлэлт Уурхайн бэлтгэл Кэмп	Хөрс Ургамлын бүрхэвч Зэрлэг ан амьтан Агаарын чанар Усны чанар, хүрэлцээ Дуу чимээ, чичиргээ	Ой мод устгах, байгалийн унаган хэв шинжээ алдах Хөрсний эвдрэл, гол горхины тунадасжилт Мал амьтдыг дүйвээх Тоосжилт ихсэх	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ Уурхайн зураг төсөл хийх Уурхайн ерөнхий загвар гаргах Байгаль орчныг хамгаалах	

			Гол горхи устах Худгийн усны түвшин буурах Хаягдлын улмаас усны чанар муудах Химийн бодис, тос асгарснаас хөрс ургамлын бүрхэвч хордох	төлөвлөгөө боловсруулах Гэрээлэгчийг сонгох Хяналт тавих
Олборлолт	Олборлолтын үйл ажиллагаа Боловсруулалт Тээвэр Хаягдлыг устгах	Хөрс Ургамлын бүрхэвч Зэрлэг ан амьтан Агаарын чанар Усны чанар, хүрэлцээ Дуу чимээ, чичиргээ	Хөрсний эвдрэл, гол горхины тунадасжилт Газрын гүний болон гадаргын усны чанар, хүртээмж багасах Ой мод устах , байгаль унаган хэв шинжээ алдах Тоосжилт нэмэгдэх Хаягдлын далан эвдрэх Уурхайн хүчиллэг усыг шүүрүүлэн зайлуулах (төмөрлөгийн болон нүүрсний уурхайд) Газрын гүний болон гадаргын ус цианидэд бохирдох (төмөрлөгийн уурхайд) Химийн бодис, тос асгарснаас хөрс ургамлын бүрхэвч хордох	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө Гэрээлэгчийг сонгох Усыг цэвэршүүлэх Хөрсийг цэвэршүүлэх Хяналт тавих
Уурхайн хаалт	Уурхайн гадаргыг тэгшлэх, дүүргэх Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа Хаалтын дараах ажил	Хөрс ба геологи Ургамлын бүрхэвч Усны чанар Зэрлэг ан амьтан Агаарын чанар	Хүдрийн хаягдлын овоолго, уурхайн налуугийн хана, уурхайн далангийн бат бэх байдал Газрын гүний болон гадаргын усны бохирдол Ургамлан бүрхэвч дахин сэргэхгүй байх Уурхайн хүчиллэг усыг шүүрүүлэн зайлуулах (төмөрлөгийн болон нүүрсний уурхайд)	Иргэдийн оролцоо Хаалтын төлөвлөгөө ба хаалтыг санхүүжүүлэх Хяналт тавих

(Adapted from U.S. EPA. 2011. Volume I EIA Technical Review Guideline: Non-Metal and Metal Mining. <https://www.epa.gov/international-cooperation/eia-technical-review-guidelines-mining-sector>)

Хайгуул

Хайгуулын эхэн үед хийгдэх агаарын судалгаа, газрын зураглал, гол горхиноос дээж авах зэрэг ажлууд нь байгаль орчинд нөлөөлөх нөлөө багатай байдаг. Гэвч эдгээр үйл ажиллагааг орон нутгийн иргэдийн амьжиргаа, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр явуулах ёстой. Уул уурхайн компаниуд орон нутгийн засаг захиргаатай хамтарч галын аюулгүй байдал, уугуул ургамлын бүрхэвчийн доройтолоос сэргийлэх, мөн уул уурхайн машин механизмаар тээвэрлэгдэж болох элдэв төрлийн мэрэгчээс сэргийлэх шаардлагатай. Хайгуул эрчимжихийн хэрээр байгаль орчны нөлөөллийн эрсдэл улам нэмэгддэг. Хайгуулын сүүлийн бөгөөд эрчимтэй шатанд ургамлын бүрхэвчийг устгах, гол горхийг бохирдуулах, хөрс эвдрэх, тунадасжилт үүсэх, газар талхлагдах зэрэг сөрөг нөлөөллүүд үүснэ. Тухайлбал, өрөмдлөг хийхийн тулд зам гаргах, өрөмдлөг хийх талбайг бэлтгэх, өрөмдлөгөөс гарах хог хаягдлыг агуулах зэрэг ажил хийгдэнэ. Уул уурхай өмнө нь явагдаж байгаагүй эсвэл маш бага хэмжээгээр хийгдэж байсан газар нутагт хайгуул хийхийн өмнө орон нутгийн засаг захиргаа нь Монголд үйл ажиллагаа эрхэлж буй уул уурхайн компаниудын боловсруулах шаардлагатай байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрхэн үнэлэх дүгнэх талаар сургалтанд хамрагдсан байх хэрэгтэй. Ингэснээр орон нутгийнхан хайгуултай холбоотой байгаль орчны нөлөөлөлд илүү бэлтгэлтэй болно.

Уул уурхайн компаниудын хувьд хайгуулын шатны байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгахын тулд дараах хүчин зүйлс чухал ач холбогдолтой:

- Хайгуул эхлэхээс өмнө компани болон орон нутгийн засаг захиргаа сайн төлөвлөгөө хийх
- Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгчдийг сонгох, удирдах, тэдний ажлын гүйцэтгэлд хяналт тавих зэргээр байгаль орчны хамгааллын ажлыг зүй зохистойгоор хэрэгжүүлэх.
- Хайгуулын ажил сайн явагдаж байгааг магадлахын тулд үе шаттайгаар хайгуулын ажилд хяналт тавих

(References: PDAC. The Excellence in Environmental Stewardship e-toolkit Good Practice Guidelines. <http://www.pdac.ca/programs/e3-plus/toolkits/environmental-stewardship>)

Ашигт малтмалын хуулийн дагуу хайгуулын шатанд уул уурхайн компаниуд байгаль орчныг хэрхэн хамгаалах заалтуудыг танилцуулав:

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны хамгааллын талаар хүлээх үүрэг:

38.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

38.1.1.тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;

38.1.2.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах;

38.1.3.энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

38.1.4.энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

38.1.5.хайгуулын ажлын явцад үүссэн байгаль орчны сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн тайланд тусгах бөгөөд уг тайланг байгаль орчны хяналтын алба болон тухайн сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

38.1.6.энэ хуулийн 38.1.5-д заасан тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг тусгаж уг өөрчлөлтийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулах;

38.1.7.байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

38.1.8.байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх

38.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

Уурхайг байгуулах

Уурхайг төлөвлөх, зураг төслийг гүйцэтгэх явцад байгаль орчны нөлөөлөл, түүнийг бууруулах арга замуудыг сайтар судлан, байгаль орчны мэргэжилтнүүд, орон нутгийн засаг захиргаа болон нутгийн иргэдтэй хэлэлцэх шаардлагатай. Уурхайн барилга угсралт, замын ажлыг гүйцэтгэх

шатанд байгаль орчны томоохон нөлөөллүүд үүсдэг.

Уул уурхайн төслүүд нь олборлолтыг гүйцэтгэх аргаас хамаарч янз бүр байна. Үүнээс шалтгаалан байгаль орчны засаглалын арга барил, стратеги нь мөн харилцан адилгүй байна. Үүнд:

Ил аргаар олборлох үед байгаль орчны дараах гол арга хэмжээг авсан байх ёстой:

- Уурхайгаас ус шүүрэн газрын гүний болон гадаргын усыг бохирдуулдаг тул ус шүүрэлтийг хязгаарлах
- Уурхай руу урсан орж буй ус уурхайгаар дамжин бохирдох тул үүнийг хязгаарлах
- Уурхайн ойролцоо гүний усны түвшинд хяналтын худаг гарган байнга хяналт тавих
- Хаягдлын агуулах, даланг төлөвлөж, байгуулахдаа эвдрэхээс сэргийлж, газрын гүний болон гадаргын усыг хамгаалах
- Тоосжилтыг хязгаарлах
- Уурхай руу чиглэх хүнд машин механизмын тээвэрлэлтийн байгаль орчны нөлөөллийг багасгах.

(References: Darling, Peter. (2011). SME Mining Engineering Handbook (3rd Edition) - 16.1 Site Environmental Considerations. Society for Mining, Metallurgy, and Exploration (SME). Online version available at: <http://app.knovel.com/hotlink/pdf/id:kt008K1EX7/sme-mining-engineering/site-environmental-considerations>)

Шороон орд нь ил уурхайн нэг төрөл юм. Шороон орд голдуу голын сав газраар байрладаг тул олборлолтын үед их хэмжээний тунадасжилт үүсэж ордоос хэдэн километрийн түрш гадаргын усны чанарыг доройтуулж болно. Тухайлбал: Төв аймгийн Заамар сумын алтны шороон ордын байгаль орчны нөлөөллийн талаарх 2000 онд хийсэн судалгаанд, уурхайнууд шаардлагын дагуу ажиллахгүйгээс Туул голыг бохирдуулан лаг болон тунадас их хэмжээгээр үүсгэсэн нь, голын экосистемийг алдагдуулах байгаль орчны хамгийн ноцтой нөлөөлөл болсон гэсэн дүгнэлт гарчээ.

(References: Farrington, John. 2000. Environmental problems of placer gold mining in Zaamar Goldfield, Mongolia https://www.researchgate.net/publication/228975338_Environmental_problems_of_placer_gold_mining_in_Zaamar_Goldfield_Mongolia)

Гүний ордыг олборлоход байгаль орчны нөлөөллийн бууруулахаар дараах арга хэмжээг авах

Уурхайн цогцолборын жишээ



ёстой байдаг. Үүнд:

- Хаягдлын овоолгын зураг төслийг гүйцэтгэхдээ хөрсний эвдрэлийг аль болох бага байлгах, гүний болон гадаргын усыг хамгаалахад анхаарах
- Гүний болон гадаргын усны бохирдлоос сэргийлэхийн тулд уурхайгаас ус алдагдаж байгаа эсэхэд хяналт тавих
- Гадаргын ус уурхай руу орж бохирдохгүй байхыг анхаарах
- Уурхай болон уурхайн ойр орчимд гүний усны түвшинг байнга хянах, шинжилгээний худгуудыг ашиглах
- Олборлолттой холбоотойгоор хөрсний суулт үүсэх магадлалыг шинжилж, урьдчилан тогтоох

(Уурхайг хэрхэн байгуулдаг, уурхайн талбайд байдаг гол бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар мэдэхийн тулд www.mining-atlas.com – с үзнэ үү. Энэ интерактив вэбсайт дээр дэлхийн 13000 гаруй уурхайн талбайг үзэх боломжтой. Уг вэбсайт нь Google Earth –тэй холбоотой бөгөөд уурхайн үйлдвэрлэл, нөөц, эзэмшил болон бусад мэдээллийг агуулдаг.)

(References: Darling, Peter. (2011). SME Mining Engineering Handbook (3rd Edition) - 16.1 Site Environmental Considerations. Society for Mining, Metallurgy, and Exploration (SME). Online version available at: <http://app.knovel.com/hotlink/pdf/id:kt008K1EX7/sme-mining-engineering/site-environmental-considerations>)

Олборлолт

Ил уурхай болон гүний уурхайнуудын байгаль орчны нөлөөлөл ихээхэн ялгаатай байдаг. Доорх хүснэгтэд байгаль орчны томоохон нөлөөллүүдийг танилцуулав.

Байгаль орчны асуудал	Ил уурхай	Гүний уурхай
Хатуу хаягдлыг агуулах	Их хэмжээний талбай шаардлагатай бөгөөд уусмал болон тоосжилтыг багасгах шаардлагатай	Ил уурхайг бодвол чулуулгийн хаягдал багатай боловч ижил төстэй менежмент шаардлагатай
Завсрын хаягдал	Хаягдал ихтэй	Хаягдал багатай
Нөхөн сэргээлт	Уурхай болон хатуу хаягдлын чулуулаг агуулсан газрыг нөхөн сэргээх шаардлагатай	хаягдлын чулуулаг агуулсан газрыг нөхөн сэргээх шаардлагатай
Тоосжилт	Уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлт	Тээвэрлэлт болон хаягдлын чулуулгаас

	болон хаягдлын чулуулгаас тоосжилт үүснэ	тоосжилт үүснэ
Уурхайн ус	Уурхайн усны хэмжээ нь хур тунадас, гадаргын болон гүний ус нэвтрэх байдлаас хамаарна	Уурхайн усны хэмжээ голдуу тогтвортой байдаг

(Adapted from Government of Canada. <https://www.ec.gc.ca/lcpecepa/default.asp?lang=En&n=CBE3CD59-1&offset=5&toc=show>)

Ашигт малтмалтын тухай хуулинд, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг бүхий байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах гэж заасан байдаг бөгөөд уг төлөвлөгөөнд дараах арга хэмжээ тусгагдсан байх ёстой гэж заасан байдаг. Үүнд:

- хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих;
- газрын гадаргын болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах;
- уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах;
- нөхөн сэргээх арга хэмжээ;
- тухайн уурхайн ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ.

Уурхайн хаалт

Зуун жилийн өмнө ашигт малтмалын ордын нөөц шавхагдахад олборлолтыг зогсоож уурхайг тэр чигээр нь орхидог байсан бөгөөд үүнийг уурхайн хаалт гэж ойлгодог байсан. Өнөөдрийн байдлаар дэлхийд 200 гаруй мянган ийнхүү орхигдсон уурхай байдаг гэсэн тооцоо байдаг. Монгол улсад ийм “хаалт” саяхныг хүртэл хийгддэг байсан харин өнөөдөр уул уурхайн ихэнх компаниуд уурхайн хаалт гэдэг нь үүнээс хавьгүй илүү их зүйлийг хийнэ гэсэн үг гэсэн ойлголттой болоод байна. 2012 оны байдлаар Монгол улсад 600 шахам орхигдсон уурхайн талбай тоологдоод байна. Орхигдсон болон буруу нөхөн сэргээлт хийгдсэн уурхайнууд мөнгөн ус, уран зэрэг хорт бодисын бохирдлыг бий болгох, хүн мал уурхайн нүхэнд унаж үрэгдэх эрсдэл дагуулах бөгөөд цөлжилтийн эх үүсвэр болох зэрэг олон сөрөг талуудтай. Уурхайн хаалтын талаар Модуль 8-аас үзнэ үү.

(Шоколадтай печень ашиглан уурхайн газрын төлөвлөлтийг хийхийн ач холбогдлыг харуулсан энэ сонирхолтой товч видео үзнэ үү: <https://www.youtube.com/watch?v=39BFptCQgwE>)

Бүлгийн ажил (15 минут)

Нэгдүгээр хувилбар

Оролцогчид дөрөв дөрвөөр бүлэг болж хуваагдана. Дээрх хэсгийн хүснэгтүүдийг ашиглан өөрийн сумын хувьд уул уурхайн төслүүдээс байгаль орчинд үзүүлж буй гол нөлөөллүүдийг нэрлэнэ. Эдгээр нөлөөллийг багасгах, урьдчилан сэргийлэхийн тулд менежментийн ямар стратеги, ямар арга хэмжээ авах шаардлагатай тухай ярилцах.

Хоёрдугаар хувилбар

Оролцогчид уул уурхайн компаниуд, орон нутгийн засаг захиргаа болон орон нутгийн иргэд гэсэн гурван бүлэгт хуваагдана. Бүлэг тус бүрт доорх хүснэгтийг тараасан байх бөгөөд бүлгүүд энэ хүснэгтийг бөглөнө. Өөрийн амьдарч буй орон нутгийн, эсвэл өөрийн аймгийн аль нэг орон нутгийн нэг хайгуулын ажил, нэг олборлолтын ажлын байгаль орчны нөлөөллийг нэрлэнэ үү. Мөн танай бүлэг эдгээр нөлөөллийг багасгах эсвэл урьдчилан сэргийлэхийн тулд авч болох арга хэмжээг нэрлэнэ үү.

Хайгуулын ажлын нөлөөлөл	Олборлолтын ажлын нөлөөлөл	Эдгээр нөлөөллийг багасгах буюу сэргийлэхэд авч болох арга хэмжээ

Хариуцлагатай уул уурхайн төлөөх байгаль орчны засаглал (35 минут)

Байгаль орчны засаглал

Уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал гэдэг нь байгаль орчны менежментийн стандарт, журмуудыг тодорхойлж, тэдгээрийг бүх түвшинд мөрдүүлдэг тогтолцоо бөгөөд үүнд албан ёсны дүрэм журам, албан ёсны байгууллагуудаас гадна иргэдийн идэвхтэй үйл ажиллагаа, шүүн таслах үйл явц эг мөн багтдаг. Байгаль орчны засаглалын бас нэгэн тодорхойлолтод үүнийг “улс төрийн оролцогчид байгаль орчны арга хэмжээ, үр дүнд нөлөөлдөг дүрэм журам, механизм болон байгууллагуудын цогц” гэсэн байдаг (Lemos and Agrawal 2006).

(References: Lemos MC, Agrawal A (2006) Environmental governance, governance annual reviews environment resources, Annual Reviews, School of Natural resources and Environment, University of Michigan, pp. 298–303; Harashima Y (2000) Environmental governance in selected Asian developing countries. Institute for Global Environmental Strategies 1(1): 193–194)

Байгаль орчны сайн засаглал тэгвэл ямар байх ёстой вэ? Heldeweg (2005) хэмээх судлаач байгаль орчны сайн засаглалын жишээ болгож Европын байгаль орчны хууль, бодлогыг авч үзсэн байдаг. Байгаль орчны сайн засаглал нь нээлттэй, оролцоотой, хариуцлагатай, үр дүнтэй байхаас гадна мөн хоорондоо уялдаатай байх гэсэн таван зарчимд тулгуурладаг бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Байгаль орчны мэдээллийн хүртээмжтэй байдал, олон нийтийн оролцоог хангах
- Байгаль орчны хэргүүдийг шүүх хэрхэн шийдсэн мэдээлэл хүртээмжтэй байх
- Байгаль орчны бодлогод хариуцлага тооцох зарчимд урьдчилан сэргийлэх, бохирдуулагч өртгийг нь даах зэрэг байгаль орчны зарчмуудыг тусгасан байх
- Хэвтээ арга хэрэгслүүдийг түлхүү хэрэглэсэн байх /салбарын дотоод, салбар дундын/
- Салбарын бодлогууд хоорондоо уялдсан байх

(References: Heldeweg, M. A. (2005). Towards good environmental governance in Europe. European Environmental Law Review, January, 2-24. <http://www.kluwerlawonline.com/abstract.php?area=Journals&id=EELR2005001>)

Түүнчлэн НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр (UNEP) нь, байгаль орчны сайн засаглалд төр засаг, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм зэрэг байгаль орчинд нөлөөлдөг бүхий л оролцогч талуудын үүргийг хамруулдаг гэжээ.

(<http://www.unep.org/environmentalgovernance/>).

Хариуцлагатай уул уурхайн төлөөх байгаль орчны засаглал

Дээрх зарчмуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн төлөөх байгаль орчны засаглалын дараах асуудлуудыг авч үзье:

- Олон улсын стандарт болон сайн дурын дүрэм журмууд
- Бодлого тодорхойлох, зохицуулалт хийх төрийн байгууллагууд
- Гол хууль тогтоомж, дүрэм журмууд
- Орон нутгийн засаг захиргааны бодлого ба үялдаа
- Салбарын санаачилга болон сайн дурын дүрэм журмууд
- Иргэдийн идэвх
- Шүүн тогтоох үйл ажиллагаа

Олон улсын стандарт болон сайн дурын дүрэм журмууд

Уул уурхайн компаниуд өөрийн үйл ажиллагаандаа байгаль орчны нөлөөллөөс сэргийлэх, түүнийг багасгахад ямар арга хэмжээ авах талаар удирдамж өгдөг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой байдлын хэд хэдэн стандартууд байдаг. Эдгээр нь голдуу сайн дурын, заавал мөрдөх шаардлагагүй стандартууд бөгөөд дэлхийн шилдэг компаниуд, уул уурхайн салбарт хариуцлагагүй ажилласнаар зөрчил, сөргөлдөөн нэмэгдэж тэдний бизнест сөрөг нөлөө үзүүлж байгаад анхааран эдгээр стандартуудыг тогтоож үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг болжээ. Санхүүгийн болон олон улсын зээлдэгч байгууллагууд ч бас өдгөө ийм стандартуудыг ашигладаг болсон бөгөөд компаниудад уул уурхайн төслүүдээ санхүүжүүлэхээр зээл авахыг хүсэхэд эдгээр стандартуудыг дагаж мөрдөхийг шаарддаг. Байгаль орчны зарим чухал стандартуудыг дор танилцуулав.

Ерөнхий стандартууд	Танилцуулга
ISO стандартууд	ISO 14001 нь байгаль орчны менежментийн системд удирдамж өгч, магадалдаг. Уг стандарт 2004 онд боловсруулагдсан бөгөөд үүнд компанийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа болон төрийн журмуудыг дагаж мөрдөхөд компани ямар арга хэмжээ авахыг энэ стандартад тайлбарласан байдаг. Энэ стандартыг байгууллага дотооддоо ашиглаж ажлынхаа явц дарааллын журмандаа тусган хэрэгжүүлэх бөгөөд эдгээр нь байгаль орчны менежментийн цогц систем болдог аж. ISO 14001 нь техникийн стандарт биш тул энэ нь хууль, журамд тусгагдсан

	байгаль орчны техникийн шаардлагуудыг орлож чадахгүй. Мөн энэ нь байгууллагуудын ажлын үр дүнг үнэлдэг стандартуудыг тогтоодоггүй. Монгол улсад Эрдэнэт ХХК нь ISO 14001-г 2007 онд хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын анхдагч компани болж байсан юм.
ОУСК (Олон улсын санхүүгийн корпораци)-н байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандарт	Эдгээр стандарт нь ОУСК-н зээлдэгч нар, байгаль орчны болон нийгмийн эрсдэлээ удирдах хариуцлагыг тогтоож өгдөг. ОУСК-н байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны энэхүү стандартыг уул уурхайн олон компаниуд мөрдөж өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн эрсдэлээ зохицуулдаг. ОУСК-н байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартад байгаль орчин ба нийгмийн нөлөөллийн үнэлгээ ба менежментийн систем, бохирдлоос сэргийлэх ба багасгах, биологийн төрөл зүйлийг хамгаалах зэрэг нийт 8 сэдэв бүхий стандартууд ордог. Хэрэв зээл авсан компани ОУСК-н байгаль орчин, нийгмийн энэхүү стандартыг хангахгүй байгаа нь тогтоогдвол ОУСК нь тус уул уурхайн компаниас тодорхой хугацаанд залруулах арга хэмжээ авахыг шаардаж, үүнийг тус компанитай харилцах санхүүгийн харилцааны нөхцөл болгодог. Монгол улсад Оюу Толгой ХХК нь ОУСК-н зээлдэгч бөгөөд эдгээр стандартыг дагаж мөрдөх үүрэг авсан байдаг.
Тогтвортой хөгжлийн төлөөх Олон улсын Уул уурхай, металын зөвлөлийн зарчмууд	Тогтвортой хөгжлийн төлөөх уул уурхайн салбарын баримтлах 10 зарчим
ЕСБХБ (Европын сэргээн босголт хөгжлийн банк)-ны үр дүнгийн шаардлагууд	Эдгээр шаардлагуудад ЕСБХБ-ны зээлдэгчид байгаль орчны болон нийгмийн эрсдэлээ удирдах хариуцлагыг тогтоож өгсөн байдаг (ОУСК-н байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны стандартын адилаар). Тус банк нь хариуцлага тооцох механизм болох Төслийн гомдлын механизм (PCM)-г нэвтрүүлсэн бөгөөд үүгээр тус банкны санхүүжүүлсэн төслүүдийн талаарх гомдлуудыг хүлээн авч, үнэлж дүгнэдэг. Тухайлбал: 2015 онд PCM нь ЕСБХБ-аас санхүүжүүлсэн, Говь-Алтай аймагт олборлолт хийж буй Алтайн Хүдэр компаний уурхайг шалгана гэдгээ мэдэгджээ. Тус уурхайгаас хохирсон малчдаас гомдол ирсний мөрөөр энэ шалгалт хийгдэх болжээ.
Тодорхой чиглэлийн стандартууд	Танилцуулга
Цианидын журам	Энэ нь алтны олборлолт, цианидын үйлдвэрлэл, тээвэрлэлт эрхэлдэг компаниудын сайн дурын санаачилга юм (www.cyanidecode.org). Монгол улсад Бороо Гоулд ХХК нь 2013 онд Цианидын кодыг бүрэн дагаж мөрддөг гэсэн магадалгаа авчээ.
Олон улсын цөмийн энергийн агентлагийн	Эдгээр стандартуудад цөмийн цацраг, эрүүл мэнд, аюулгүй байдал, хог хаягдлын менежментийн зарчмуудыг тусгасан байдаг бөгөөд дэлхийн хаана ч үйлчилдэг.

олборлолтой аюулгүй стандартууд	холбоотой байдлын	
Мөнгөн Минаматагийн конвенц	усны талаарх	Үүнд шинээр мөнгөн ус олборлохыг хориглох, одоогийн олборлолтыг шат дараатайгаар “тэтгэвэрт гаргах” мөн алтны бичил уурхайд мөнгөн усыг хэрэглэх зааврыг тусгасан байдаг. Монгол улс 2013 онд уг конвенцид нэгджээ.

Бодлого тодорхойлох, зохицуулалт хийх төрийн байгууллагууд

Монгол улсад энэ чиглэлийн бодлого тодорхойлох, зохицуулалт хийх төрийн байгууллагуудыг Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид зааж өгсөн байдаг. Уул уурхайн яам (УУЯ) нь бодлого тодорхойлдог гол байгууллага бөгөөд Ашигт малтмалын газар (АМГ) болон Газрын тосны газар (ГТГ) хэмээх хоёр агентлаг нь энэхүү яаманд харьяалагдан ажилладаг. Хуулийн хэрэгжилтийн зохицуулалтыг хангах гол байгууллага нь Мэргэжлийн хяналтын газар (МХГ). Мөн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (БОНХАЖЯ) нь мөн энэ чиглэлийн хуулийн хэрэгжилтийг хангах тодорхой үүргүүдтэй.

УУЯ нь Монгол улсад уул уурхайн бодлого, хууль эрх зүйн болон зохицуулалтын орчныг тодорхойлох үүрэгтэй бодлогын яам юм.

АМГ нь хэрэгжилтийг хангах байгууллага бөгөөд геологийн судалгаа, нүүрсний менежмент, кадастр, тусгай зөвшөөрлийн менежмент, хяналт шинжилгээ үнэлгээ, статистик мэдээ, мөн уул уурхайтай холбоотой сургалт судалгаа зэрэг асуудлуудыг хариуцдаг.

БОНХАЖЯ нь уул уурхайн байгаль орчны стандартуудыг тогтоож, эрдэс баялгийн хэрэглээний хязгаарыг тогтоож өгдөг үүрэгтэй. 2014 онд Монгол улсын Ногоон хөгжлийн бодлого батлагдсанаар тус яамны статус нь чиглэлийн яамнаас больж, Сангийн Яам, Хууль Зүйн Яамны адил үндсэн чиг үүргийн яам болж өөрчлөгджээ. БОНХАЖЯ нь байгаль орчны журам дүрмүүдийг хариуцаж, мөн Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлийн үнэлгээ (БОННУ) болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталдаг.

МХГ нь уул уурхайн салбарт хууль журмын хэрэгжилтийг хангадаг үүрэгтэй агентлаг. Тус агентлаг нь мэргэжлийн хяналтыг өндөрсгөж, стандартчилсан чанарын хяналт болгох үүрэгтэй. Байгаль орчны хамгааллын тухай хууль болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар МХГ нь уул уурхайн

компаниудын байгаль орчны үр дүн, хууль журмыг биелүүлж байгаа байдалд төрийн өмнөөс хяналт шалгалт хийдэг. Байгаль орчны хууль журмын биелэлт, үр дүнг хянаж шалгахад анхны хяналт шалгалт, газар дээрх хяналт шалгалт, мөн удаа дараагийн хяналт шалгалтууд хийгддэг. Гэвч сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд МХГ-ын хяналт шалгалтын үр дүн нь дүрэм журмын хэрэгжилттэй тэр бүр таарахгүй, мөн тус байгууллагын мэргэжлийн хүний нөөц дутагдалтай байгаа нь харагдсан. Түүнчлэн МХГ-ын аймаг, сумдын ажилтнууд мэргэжлийн сургалтанд тэр бүр хамрагдаж чаддаггүй, мэргэжил эзэмшсэн байдал дутагдалтай, хангалттай нөөц боломж олддоггүй нь анзаарагдсан. Түүнээс гадна МХГ-ын байцаагч нар газар дээрх хяналт шалгалт хийхдээ стандартчилсан шалгах хуудсуудыг ашигладаг ба энэ нь уул уурхайн байгаль орчны асуудлуудыг хангалттай хамруулж чадаагүй байдаг ажээ. (Цэцэгжаргал, 2015).

(References: Butcher, David and Ron Smit.2013. Policy Advice to the Ministry of Mining on a Functional Review of Institutions engaged in the Management and Regulation of the Mining Sector. World Bank MSISTAP project; UNDP Mongolia; Энхбаярын Цэцэржаргал .2015. Монгол улсад институцийн зохион байгуулалт, уялдааг хангах замаар уул уурхайн байгаль орчны мониторингийн төрийн чадавхийг бэхжүүлэх нь. Күинсландын их сургууль)

Гол хууль тогтоомж, дүрэм журмууд

Хууль тогтоомж, дүрэм журмын нэр	Танилцуулга
Байгаль орчны хамгааллын тухай хууль (2012)	2012 онд “байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх” зарчмыг, мөн байгалийн нөөцийн хамтын менежментийн зарчмуудыг нэвтрүүлжээ. Мөн 2012 оны нэмэлт өөрчлөлтүүдээр байгаль орчны аудитын тухай ойлголтыг оруулсан. Үүнд уул уурхайн болон газрын тосны зэрэг байгалийн баялгийг ашигладаг компаниуд хоёр жил тутамд өөрийн зардлаар байгаль орчны аудитыг санхүүжүүлэн хийлгэж ёстой бөгөөд аудитын дүгнэлтүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасан байдаг.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)	2012 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулж, түүний хэрэгжилтийн талаар орон нутгийн иргэд, засаг захиргаанд тайлагнах шаардлагыг оруулжээ. Уул уурхайн компаниуд уурхайн хаалтын төлөвлөгөөгөө БОНХАЖЯ-нд өгөх ёстой. Тус хуулийн 18.4-д “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн

	захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.” гэж заасан байдаг. Гэвч тус хуулийн шинэлэг нэмэлт өөрчлөлтүүд болох олон нийтийн оролцоо, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг ил тод болгох зэрэг заалтууд нь тэр бүр сайн хэрэгжихгүй байгаа.
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)	2012 онд хийсэн нэмэлт өөрчлөлтүүдээр ус ашиглах зөвшөөрлийн хугацааг багасгаж, усыг ашиглах, зайлуулахад илүү хатуу шаардлагуудыг тавьж, ус ашиглалтын төлбөрийг нэмэгдүүлжээ.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам (2014)	Уг журамд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн компани нь олон нийтийн саналыг хэлэлцүүлгийн журмаар авах шаардлагуудыг заасан байна.
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих тухай журам	Сумын засаг захиргаанаас Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны хяналт муу байснаас БОНХАЖЯ-аас уг дансны менежментийг хийх заавар гаргажээ. Гэвч олон компаниуд хууль тогтоомжийг биелүүлэхгүйгээс гадна орон нутгийн засаг захиргааны ажилтнууд уг баталгааны мөнгийг нөхөн сэргээлтээс өөр зориулалтаар ашигласан тохиолдлууд гарсан.

Уур амьсгалын өөрчлөлт ба уул уурхай

Монгол улс газар зүйн байршил, мөн эмзэг экосистемтэй учраас уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг улсуудын нэг юм. Уур амьсгал нь Монгол улсын түүхэн ба өнөөгийн байдлыг тодорхойлж, цаашид ч тодорхойлсоор байна. Манай малчдын ахуй амьдрал байгалийн цаг уурын байдалтай нарийн уялдсан байдаг. Одоогоор нийт газар нутгийн 80 хувь нь уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралтай гамшигт үзэгдэлд эмзэг гэж тооцогдож байна.

Монгол улсын хувьд хөдөөгийн алслагдсан орон нутаг, уул уурхайн үйл ажиллагаа, уур амьсгалын нөхцөл байдал хэрхэн уялдах вэ гэдэг асуудал чухал нөлөөтэй. Мал аж ахуй нүүдлийн хэлбэрээр голдуу явагддаг тул хуурай газар нутагт усны хүртээмж, чанар нь хөдөө орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргаанд маш чухал ач холбогдолтой (Sternberg, 2008). Уул уурхай өргөжиж усны хэрэглээ нэмэгдэхэд нийт усны хэмжээнд төдийгүй мөн усны чанарт ихээхэн нөлөөлнө. Уул уурхай болон холбогдох дэд бүтэц нь малчдад хэрэгцээтэй бэлчээрийн газрыг ашигласнаараа газрын төлөөх өрсөлдөөнийг нэмэгдүүлдэг. Энэ нь алсдаа

талуудын хоорондын зөрчил, сөргөлдөөний эх үүсвэр болох талтай.

(References: Sharma, V, Byambajav D, Gerelt-Od, E, Myagmartsooj, Natsag, & Saruulzaya, A. 2016. Traditional Livelihoods and Mining in Mongolia's Changing Climate: Exploring the Potential of Crosssectoral Partnerships in Achieving Sustainability. APN Science Bulletin. Sternberg, T 2008. Environmental challenges in Mongolia's dryland pastoral landscape. Journal of Arid Environments, 72, pp. 1294-1304)

Орон нутгийн засаг захиргааны бодлого ба уялдаа

Улсын хууль тогтоомж, дүрэм журмаас гадна орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь өөрийн орон нутагт ажиллаж буй уул уурхайн компаниудын байгаль орчны үйл ажиллагааг сайжруулахын тулд тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлж болно.

Тухайлбал Төв аймгийн Заамар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал нь сумын газар нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагааны болон нөхөн сэргээлтийн тайлангуудтай танилцаж, тэдэнтэй орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажилладаг. (Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний талаар Модуль 4-с үзнэ үү).

Орон нутгийн засаг захиргаа хэрхэн зохицуулалт хийж ажилладагийн сайн жишээнүүд байдаг. Австралийн Квинсланд мужийн Моранба хот нүүрсний уурхайнуудаар хүрээлэгдсэн хот юм. Хотын иргэд тоосжилт эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа талаар гомдол мэдүүлснээс тус хотын захиргаа нь 2009 онд хурал зохион байгуулж энэ нөлөөллийг яаж бууруулж болох талаар ярилцжээ. Уг хуралд уул уурхайн компаниуд, иргэд, орон нутгийн засаг захиргааны төлөөлөгчид оролцож Моранба хотын хавсарсан нөлөөллийн бүлэг хэмээх бүлэг байгуулан уул уурхайн нөлөөлөлд хяналт тавьж, тайлагнадаг болжээ.

Салбарын санаачилга болон сайн дурын дүрэм журмууд

Австрали, Канад, Чили зэрэг эрдэс баялаг ихтэй орнуудад уул уурхайн салбарт байгаль орчны сайн туршлагыг дэмжин хэрэгжүүлэхэд уул уурхайн компани, салбарын холбоод чухал үүрэг гүйцэтгэж, сайн дурын дүрэм журмууд, хамтын санаачлагуудыг хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, Баруун Австралид Уул уурхайн ба хайгуулын компаниудын холбоо (AMEC) нь Эрдэс баялаг, эрчим хүчний танхимтай хамтран 2010 онд хайгуулын шатны байгаль орчны сайн дурын дүрэм журмуудыг боловсруулж, улмаар байгаль орчны хувьд хайгуулын компаниудад тавигдах шаардлагуудыг биелүүлэхэд нь тус болдог байна. Монгол улсад 2016 онд уул уурхайн 9 компани Усны

менежментийн сайн дурын дүрэм журамд нэгдэж усны нөөцийн менежментийн талаарх чухал мэдээллийг ил тод болгох, удирдах, мэдээлэх тал дээр хамтран ажиллах болжээ.

Уул уурхайн компаниуд мөн биологийн төрөл зүйлийг хамгаалах менежмент дээр хамтарч ажиллах боломжтой. Доорх шигтгээнд дэлхийн янз бүрийн уурхайн хувьд хэрэгжүүлсэн биологийн төрөл зүйлийг хамгаалах менежментийн арга замыг танилцуулна.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах менежментийн арга

Уг арга нь экосистемийн бүрэлдэхүүн хэсэг тус бүр хоорондоо хамаатай болохыг, мөн экосистемүүд хоорондоо хамааралтай болохыг, мөн эдгээр хамаарлууд нь цаг хугацааны явцад өөрчлөгддөгийг ойлгуулдаг. Энэ аргыг хэрэгжүүлснээр компаниуд тухайн орон нутгийн нийгмийн, соёлын, оюун санаа болон гоо зүйн үнэт чанаруудыг илүү сайн ойлгоно. Биологийн төрөл зүйлийг хамгаалж, менежмент хийх нь иргэдийн амьжиргаа, соёлын хувьд чухал Монгол шиг оронд нь өндөр ач холбогдолтой.

Хэдийгээр энэ арга нь компаниудаас биологийн төрөл зүйлийг хамгаалах сайн дурын арга хэмжээ боловч энэ нь нийгмийн хэрэгцээ, хүлээлт, нэн чухал ач холбогдлыг цогцоор нь ойлгуулдгаараа компаниудын одоо хэрэглэж буй аргуудаас давуу талтай юм. Энэ нь “уул уурхайн төсөл эхлэхээс өмнө эхэлж, уурхайн хаалтын дараа ч үргэлжлэн хийгдэж байдаг. Энэ нь зөвхөн олборлолтод өртсөн газар нутагт хамаараад зогсохгүй тухайн газрын, орон нутгийн, улсын, мөн олон улсын хүртэл хүчин зүйлсүүдийг харгалзан үздэг” урт хугацааны стратеги юм.

(Биологийн төрөл зүйлийг хамгаалах арга барилын зарчмуудыг яаж хэрэгжүүлэх талаар дараах бичиг баримтаас үзнэ үү: Leading practice sustainable development program for the mining industry – Biodiversity management (Australian Government, Department of Industry, Tourism and Resources, February 2007)).

Иргэдийн идэвх

Байгаль орчны болон нийгмийн шударга байдлын төлөөх иргэдийн идэвх шаардлагуудын улмаас Улсын Их Хурлаас 2009 онд (Урт нэртэй хууль гэж нэрлэгддэг) Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталжээ. Уг хуулиар усны эх, ойгоос 200 метрийн зайнд олгогдоод байсан 200 гаруй ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалжээ. Уг хуулийн нөлөөнд уул уурхайн ажлыг голдуу хуурай болон хагас хуурай газар нутагт хэрэгжүүлэх болжээ. Энэ нь байгаль орчны засаглалд иргэдийн идэвхи хэрхэн нөлөөлж болохын жишээ юм.

Шүүн тогтоох үйл ажиллагаа

Хуулийн дагуу төрийн бус байгууллагууд нь олон нийтийн өмнөөс хариуцлага бүхий этгээдийг байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөнийх нь төлөө шүүхэд өгч болно. Тухайлбал Хөвсгөлийн ойр хавьд Талстмаргад компанид олгосон ашиглалтын лиценз нь Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний тухай хуулийг зөрчсөн тул 2013 шүүхийн шийдвэрээр уг лицензийг хурааж авчээ. Бас нэг жишээ гэвэл Петро Чайна Дачин Тамсагийн жишээ юм. Тус компани нь байгаль орчинд ихээхэн хохирол учруулсны улмаас 2013 онд Баянзүрх дүүргийн анхан шатны шүүхээр 1,3 тэрбум төгрөгөөр торгох шийдвэр гаргажээ.

Хэлэлцүүлэг (10 минут)

- Ил болон гүний олборлолтын үед байгаль орчны ямар асуудлуудыг голлон анхаарах вэ?
- Уул уурхайн байгаль орчны нөлөөлөл нь нийгмийн болон орон нутгийн иргэдийн сайн сайханд ямар хамааралтай вэ?
- 1990-ээд онтой харьцуулахад сүүлийн хэдэн жилд Монгол улсад уул уурхайн байгаль орчны засаглалд хууль тогтоомжийн ямар томоохон өөрчлөлтүүд хийгдсэн бэ?

Унших ном, материал

CSRM. 2015. Responsible Mining in Mongolia. <https://www.csrn.uq.edu.au/publications/responsible-mining-in-mongolia-enhancing-positive-engagement>

Darling, Peter. (2011). SME Mining Engineering Handbook (3rd Edition) - 16.1 Site Environmental Considerations. Society for Mining, Metallurgy, and Exploration (SME). Online version available at:

<http://app.knovel.com/hotlink/pdf/id:kt008K1EX7/sme-mining-engineering/site-environmental-considerations>

ELAW. 2010. Guidebook for Evaluating Mining Project EIAs - complete Guidebook (English & Russian) <https://www.elaw.org/mining-eia-guidebook>

PDAC. The Excellence in Environmental Stewardship e-toolkit Good Practice Guidelines.

<http://www.pdac.ca/programs/e3-plus/toolkits/environmental-stewardship>

Үндсэн нэр томьёо, ойлголтуудын тайлбар

Хуримтлагдсан нөлөө – өнгөрсөн, одоо, мөн ойрын ирээдүйд таамаглаж болох үйл ажиллагаануудын тус бүрийнх нь нөлөөнүүд нийлж байгаль орчинд үзүүлэх нөлөө

Шууд нөлөө – тухайн үйл ажиллагаатай ижил хугацаанд, ижил газар нутагт бий болж буй нөлөө

Ус шүүрүүлэн зайлуулах – газрын гадаргын болон гүний усыг хиймлээр буюу байгалийн аргаар зайлуулах

Байгаль орчин нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ (БОННУ) – санал болгож буй ажлын нөлөөллийг үнэлсэн бичиг баримт.

Экосистем – ургамал, амьтан, бичил биетүүд, амьд бус орчин зэргээс бүрдсэн, нэгэн нэгж шиг хоорондоо холбоотой цогц, хөдөлгөөнтэй систем.

Уугуул биш төрөл зүйл – уугуул биш ургамал, амьтдын төрлүүд бөгөөд эдгээрийг тухайн газар нутагт нэвтрүүлснээр эдийн засгийн болон байгаль орчны сөрөг нөлөө үүсч болдог.

Нөлөө – төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд гарах өөрчлөлт

Тунадасжилт – бодисыг ус, салхи, таталцлын хүч болон бусад замаар зөөж улмаар усанд тунах явцын үр дүн

Хаягдал – цаашид боловсруулахад эдийн засгийн ач холбогдолгүй ордны боловсруулагдсан (угаагдсан) хүдрийн хэсэг

Чулуулгийн хаягдал – бага хүдрийн агуулга бүхий чулуулаг хэсэг

МОДУЛЬ 6. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- БОНБУ-ний үндсэн зарчмууд, үг хэллэг ба аргачлалуудын талаарх ойлголт
- Учирч болзошгүй төрөл бүрийн нөлөөллийг тодорхойлох, БОНБУ-ний судалгааг уншиж, дүгнэлт хийх
- Шийдвэр гаргах үйл явц, ялангуяа, олборлох үйлдвэрлэлтэй холбоотой бодлого, төслүүдийн хувьд БОНБУ-ний гүйцэтгэх үүрэг
- Монгол Улсад хэрэгжүүлж буй БОНБУ-ний чиг хандлага, түршлага ба тулгарч буй бэрхшээл, асуудлууд

Удиртгал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэг /БОНБУ/ нь тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг системтэйгээр тодорхойлох, урьдчилан тооцох үнэлэхэд туслах зорилготой хэрэгсэл юм. БОНБУ нь бизнесийн үйл ажиллагаанд дарамт учруулах хүнд суртлын нэг хэлбэр биш юм. Харин уул уурхайн компаниудад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зөв тодорхойлж, хариу арга хэмжээ авахад туслах зорилготой. Орон нутгийн иргэд, захиргаа, ТББ-уудын хувьд БОНБУ-ний явцад идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэх нь чухал юм. Энэ модулиор БОНБУ-ний хэлбэр, үе шатуудын зорилго, зорилтууд, оролцогч талуудын үүрэг оролцооны тухай авч үзнэ. Энэ модуль Монгол улсад БОНБУ хийхэд олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлийн талаар анхаарч авч үзнэ.

Энэ модуль оролцогч нарт “бүтээлчээр суралцах” бүлгийн ажлын даалгаврууд өгч ажиллуулна. Үүнд:

- Жишээ сайт ба нутагт БОНБУ хийхэд тулгарах бэрхшээл
- Бүдүүвч, дүрслэл дээр ажиллаж, танилцуулга хийх
- Зохиомол нөхцөл байдлын тухай уншаад, асуудал шийдэх дүрд тоглох

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- БОНБУ-ний үйл явц, түүний уул уурхайн үйлдвэрлэлийн үе шаттай хамааралтай уялдаа холбоо
- БОНБУ-ний үр дүн, хязгаарлагдмал талууд
- Монгол улс дахь БОНБУ-ний тогтолцоо
- Орон нутгийн засаг захиргаа ба иргэдийн БОНБУ-ний явцад гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа

Жишиг хуваарь

- БОНБУ-ний тухай удиртгал (25 минут)
- Бүлгийн ажил (15 минут)
- Монгол улс дахь БОНБУ-ний тогтолцоо (30 минут)
- Бүлгийн ажил (20 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p data-bbox="188 584 1160 619">Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай удиртгал (25 минут)</p> <p data-bbox="188 663 450 699">БОНБУ-ний зорилго</p> <p data-bbox="188 743 1447 852">Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНБУ) нь аливаа төсөл, үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг системтэйгээр тодорхойлох, урьдчилан харах, үнэлэхэд туслах хэрэгсэл юм.</p> <p data-bbox="188 896 1447 1088">БОНБУ-г төслийг хэрэгжүүлж эхлэхээс хийгддэг. БОНБУ-ний гол зорилго нь төслийг хэрэгжүүлэх болон хэрэгжиж дууссаны дараа үүсч болох сөрөг нөлөөллийг тооцоолон урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино. БОНБУ нь төслийн хэрэгжилтээс гарах техник, эдийн засаг болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тооцоолох, шийдвэр гаргах үйл явцын уялдаа холбоог зэрэг хангахад чухал үүрэгтэй.</p> <p data-bbox="188 1133 1447 1362">БОНБУ нь 2 ерөнхий зорилготой: шууд /богино хугацааны ба явцын/ урт хугацаа. Богино хугацааны зорилго нь төслийн хэрэгжилтээс байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийг тодорхойлсноор шийдвэр гаргахад шууд нөлөөлөх явдал юм. Урт хугацааны зорилго нь тухайн төслийг хөгжлийн асуудлуудтай уялдуулан өргөн цар хүрээгээр авч үзэх, төслийн байршил орчмын экосистем, иргэд ба байгалийн нөөцөд үзүүлэх нөлөөллийг тооцож үзэхэд оршино.</p>	

БОНБУ-ний зорилгын талаар доорх хүснэгтэд үзүүлэв:

<i>БОНБУ-ний богино хугацаанд үзүүлэх нөлөөлөл:</i>	<i>БОНБУ-ний урт хугацаанд үзүүлэх нөлөөлөл:</i>
Байгалийн нөөцийг үр дүнтэй ашиглах	Байгалийн нөөцийг урт хугацаанд ашиглах, хамгаалах
Сөрөг нөлөөллийг тодорхойлж, бууруулах арга хэмжээг тодорхойлох	Экосистемд учруулах нөхөгдөшгүй гарз, хохирлоос зайлсхийх замаар тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах
Үүсэж буй ба бий болох төлөвлөлтийн сонголтуудыг шийдвэр гаргагчдад	Хүний эрүүл мэнд ба аюулгүй байдалд эерэг нөлөөллийг үзүүлэх
Нөлөөллийг тодорхойлох, үнэлэх ба удирдах үйл явцуудад олон талын оролцоог бий болгох	Төслийг хүлээн авах нийгмийн хүлээлтийг дээшлүүлж, нийгмийн капиталыг бэхжүүлэх

БОНБУ-ний үйл явц

БОНБУ-ний үйл явц хэд хэдэн үе шаттай. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний гол зорилт, шаардлага, мэдээлэл цуглуулах хүрээг тодорхойлох

энэ нь БОНБУ-ний үйл явцын эхний үе шат бөгөөд санал болгож буй төсөлтэй танилцах, хууль эрх зүйн шаардлагуудтай нийцэж буй байдал болон тухайн төсөл орчмын байгаль орчинд учруулж болзошгүй хохирол, эрсдэлийн талаар эхний дүгнэлт гаргах үе шат юм. Шийдвэр гаргалтад төслийн талаар тодорхой санал, зөвлөмж өгөх холбогдох талуудыг тодорхойлно.

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөлөөллийн цар хүрээг тодорхойлох

Төслийн хэрэгжилтээс үүсч болзошгүй нөлөөллийг эхний байдлаар тодорхойлсон үнэлгээ, эрсдэл, нөлөөлөлд өртөж болзошгүй талуудын тухай мэдээлэл, нарийвчилсан судалгааны ажлын удирдамж боловсруулахад шаардлагатай мэдээлэл зэрэг суурь нөхцөл байдал, сонголт, боломжуудын талаар мэдээлэл өгөх үе шат юм.

- Нөлөөлөлд дүн шинжилгээ хийх

илрүүлэх, урьдчилан харах, хүрээ - Төслөөс үүсч болох бүхий л нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийг илрүүлэх үе шат юм. Түүнээс гадна, БОНБУ-ний энэ үе шатанд нөлөөллийн зэргийг үнэлэхэд чухал үүрэгтэй. Нөлөөллийн зэрэг, нөлөөллийг ойлгохын зэрэгцээ тэдгээрийг бууруулах, урамшуулал олгох боломжуудаас хамааран сонголтуудыг харьцуулах боломжийг олгодог. Нөлөөлөл нь богино, урт, шууд, шууд бус, эерэг, сөрөг, хуримтлагдах зэрэг янз бүр байдаг.

- Нөлөөллийг бууруулах – төлөвлөлт, удирдлага

Төслийн хэрэгжилтээс үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах боломжит, боломжгүй бол зайлсхийх нөхцөлүүдийг тодорхойлох боломжийг бий болгох үе шат юм. Оролцогч талууд, тэдгээрийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсныг анхаарч үзнэ. Төслийг хэрэгжүүлж дуусах сүүлчийн хугацаа, тайлан болон үйл ажиллагааны хуваарьт төлөвлөгөөг боловсруулсан байна.

- Тайлан

Тодорхой, товч тайлан нь шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангахад чухал үүрэгтэй. Чанартай тайлан нь хураангуй, Байгаль орчны Нөлөөллийн Мэдэгдэл, төслийн товч танилцуулга, суурь судалгаа, баримт, ноцтой эрсдэлийн үнэлгээ, үүсч болзошгүй нөлөөллүүд, бууруулах арга замууд ба зөвлөмжийг агуулсан байдаг.

Перу улс дахь Конга төслийн БОНБУ

2010 оны 10 сард Перу улсын Эрчим хүч, уул уурхайн Кажамарка хотоос 73 кмт орших алтны мега төслийн БОНБУ-г баталсан. Конга хэмээх энэ төсөл нь далайн төвшнөөс дээш 4000 метрт олон гол мөрнүүдийн эх орших газарт байршсан байв. Конга төсөлд 4.5 тэрбум америк долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөсөн байв. Төслийн анхны төлөвлөгөөгөөр 4 нүүрны оронд 4 усан сан үүсгэж 5000 ажлын байр шинээр бий болгох байв. Орон нутгийн иргэдийн хөдөлгөөнүүд үүнийг шууд эсэргүүцжээ. Тэд шинээр үүсгэх усан сангууд нь хүмүүсийн үндны болон ХАА-н усны хэрэгцээг хангаж чадахгүй гэж үзсэн. Түүнчлэн төслийг хэрэгжүүлэгч компанийн өмнөх төслийн түүхтэй холбоотойгоор

итгэл үзүүлж чадахгүй гэж мэдэгдсэн. 2011 оны 7 сард Кажамарка мужийн Ерөнхийлөгч орон нутгийн эсэргүүцэлд нэгдсэн байна. 2011 оны 9 сард компанийн зүгээс засгийн газраас нэгэнт батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлаа эхэлнэ гэж үзэж байсан боловч орон нутгийн хөдөлгөөнүүд эсэргүүцсээр байсан. 2011 оны 11 сард эсэргүүцлийн үйл ажиллагаа өргөжиж, Засгийн газраас мөн хүсэлт тавьсан тул компани төслийн үйл ажиллагааг зогсоосон. Төслийн БОНБҮ-д асуудал байснаас гадна оролцогч талуудтай хэрхэн харилцан ойлголцол үүсгэх тал дээр асуудал байсан. Үл ойлголцолд түлхэж байсан маш том шалтгаан бол БОНБҮ-ний тайланг энгийн хүнд ойлгогдохуйц байдлаар танилцуулаагүй явдал юм. Маш олон янзын мэргэжлийн үг хэллэг, дүрслэл, хувьсагчууд гэх мэт нь иргэд болон компанийн хооронд ойлголцол үүсэхэд саад болж байсан. БОНБҮ-д дүгнэлт өгсөн тайлангаас үзэхэд уг БОНБҮ-ний цахим хувилбар нь 9030 хуудастай байжээ. Цаашлаад хамгийн чухал мэдээллүүд нь энэ тэнд орчихсон, ойлгож унших, дүгнэлт гаргахад маш хэцүү байдлаар бичигдсэн байв.

(References: Fiorella Triscritti. 2013. Mining, development and corporate–community conflicts in Peru. Community Dev. J. 48: 437-450)

- БОНБҮ-ний дүгнэлт, шинжилгээ

Энэ үе шатанд БОНБҮ-ний тайлан байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг хир чадварлаг, бодитой мэдээлсэн байдалд үнэлгээ, дүгнэлт өгнө. Энэ нь төсөлд оролцогч талуудын оролцоо хангагдсан байдал, зөвлөмж нь шинжлэх ухааны болон амьдралд хэрэгжих байдлаасаа бодитой тусгагдсан байдал болон мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүдтэй зөрчилдөж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулах үе шат юм. Мөн үнэлгээнд орхигдуулсан, цаашид дахин судлах шаардлагатай асуудлууд болон судалгааны аргачлалын хувьд өөр хувилбарыг хэрэглэх зөвлөмж зэрэг дээр дүгнэлт, зөвлөмж өгдгөөрөө чухал ач холбогдолтой.

- Шийдвэр гаргалт

Хөгжлийн сонголтуудад үнэлэлт хийх, янз бүрийн нөлөөллүүдийг илрүүлэх замаар шийдвэр гаргахад мэдээллээр хангах нь БОНБҮ-ний үндсэн зорилго юм. БОНБҮ нь шийдвэр гаргагчид болон төсөлд хамтран оролцогч талуудад зааварчилгаа, зөвлөмжөөр хангадаг.

БОНБҮ-ний үйл явцад идэвхтэй хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргахад шаардлагатай чухал асуудлуудыг гаргаж тавих, шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах, шийдвэрийг олон нийтэд ил тод нээлттэй байлгах зэрэг бүхий л арга, зарчмууд нь бодитой, зөв шийдвэр

гаргахад чухал ач холбогдолтой.

Австралийн Баруун Австрали муж дахь БОНБУ

Олон улсын түвшинд Баруун Австралийн БОНБУ-ний үйл явцыг хамгийн үр дүнтэй системүүдийн нэг гэж үздэг. Тус мужид БОНБУ-г Захиргааны Журмууд гэдэг эрх зүйн актаар тодорхойлсон байдаг. Байгаль орчныг хамгаалах газрын болон Байгаль орчны яамны сайдын БОНБУ-ний талаарх шийдвэр нь олон нийтэд ил байх ёстой. БОНБУ нь доорх үе шатуудаар дамжуулан олон нийтийн мэдээлэл авах, оролцох боломжийг хангадаг. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах газрын үнэлгээний шийдвэрүүд нь 7 хоног бүр олон нийтэд ил тавигдах ёстой
- Үнэлгээ хийгдэж буй төслийн тухайд олон нийтээс санал авах хугацаа болон олон нийт хэрхэн мэдээлэл, БОНБУ-ний хувийг авах талаарх мэдээллийг олон нийтийн зар мэдээнд оруулсан байна
- Аливаа иргэн БОНБУ-ний дүгнэлтийн талаар давж заалдах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд үнэлгээг улам нарийвчлах магадлал ихсэнэ.
- Албан ёсны үнэлгээ хийж буй БОНБУ-нд олон нийтээс санал авах хугацаа 4-10 долоо хоног байдаг.
- Олон нийтийн зүгээс өгсөн санал, шүүмжийг төсөл хэрэгжүүлэгчид өгөх ба хариултыг мэдэгдэх ёстой
- Байгаль хамгаалах газрын үнэлгээний тайланд олон нийтийн санал, төсөл хэрэгжүүлэгчийн хариулт орсон байна.
- Байгаль хамгаалах газар нь дүгнэлт, зөвлөмжөө Байгаль орчны яаманд хүргүүлэх ба тэдгээр нь олон нийтэд ил байна.
- Аливаа иргэн Яамны сайдын тушаал гарахаас өмнө Байгаль хамгаалах газрын дүгнэлт, зөвлөмжийг давж заалдаж болно.
- Сайдын шийдвэр олон нийтэд ил байна.

Эх сурвалж: Angus Morrison-Saunders and John Bailey. 2000. Transparency in environment impact assessment decision-making: recent developments in Western Australia, *Impact Assessment and Project Appraisal*, 18:4, 260-270, DOI: 10.3152/147154600781767321

- Хяналт-шинжилгээ, аудит ба үнэлгээ

БОНБУ-ний дараагийн үе шатанд хийгдэх үйл ажиллагаа ба БОНБУ-ээс гарсан бүх зөвлөмжүүдийг хангалттай хэрэгжүүлсэн эсэхэд хяналт-шинжилгээ, аудит хийх үе шат юм. БОНБУ-ний чухал зорилго болох аливаа бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх нь чухал юм. Байнгын хяналт нь, өмнөх үнэлгээгээр тодорхойлогдоогүй, тооцоолоогүй нөхцөл байдлын талаар шинэ мэдээлэл өгөх боломжийг олгодог.

Олон нийтийн оролцоо

Олон нийтийн оролцоог хангах явдал нь БОНБУ-ний бүхий л үе шат, үйл явц, сурталчилгаа болон төслийн өмнөх ба дараах үеийн ойлголт, дүрслэлийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Олон нийтийн дуу хоолойг сонсох өдөр, хэлэлцүүлэг, зорилтот бүлгийн ярилцлага, судалгаа, Оролцооны аргын үнэлгээ гэх мэт олон төрлийн арга, замуудыг ашиглан олон нийтийн оролцоог хангаж болно.

Ингэснээр, БОНБУ-ний үр дүн нь төслийн хэрэгжилт эхлэхээс өмнө сөрөг нөлөөллийг бууруулах эсвэл учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг тодорхойлох зорилготой. Эдгээр нөлөөлөлд зөвхөн байгаль орчинд бүс тухайн бүс нутагт амьдардаг иргэд, эсвэл тухайн орчмын байгаль орчноос амьжиргаагаа тэтгэж байдаг иргэд, тэдний амьдрах орчинд шууд болон шууд бусаар нөлөөлөх нөлөөллүүд ч хамааралтай. Тийм учраас, аливаа аж ахуйн нэгж, хувь хүний хэрэгжүүлэх төсөл нь хүний эрүүл мэнд ба байгаль орчинд нөлөөлөл үзүүлэх учраас орон нутгийн нөхцөл байдал, хөгжил рүү хөтөлж буй тэргүүлэх үйл ажиллагааны талаар сайн ойлголт, мэдлэгтэй байх нь чухал.

БОНБУ-ний нийтлэг үр дүн

БОНБУ-г чанартай, ил тод, үр дүнтэй хийсэн тохиолдолд, БОНБУ нь талууд, засаг захиргаа болон иргэдэд үнэ цэнэтэй мэдээллийг өгнө. Ерөнхийдөө, БОНБУ нь дараах чиглэлээр зөвлөгөө өгөх боломжтой. Үүнд:

- Байгаль орчинд ноцтой хохирол, нөлөөлөл үзүүлэх тохиолдолд төслийг хэрэгжүүлэхгүй байх
- Төслийн үйл ажиллагаа, үйл явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн өөрчлөлтийг оруулах

- Сайн мэдээлэл, бодитой үр дүнд тулгуурлан шийдвэр гаргах үйл явцад мэдээллээр хангах
- Урт хугацаанд байгаль орчны тогтвортой байдлыг хангах хамгийн тохиромжтой хөгжлийн сонголтууд
- Сонголт бүрээс гарах өөр өөр үр дагаваруудыг олон янзын аргаар бууруулах арга зам, нарийвчилсан дүгнэлт
- Байгаль орчны хууль журмуудтай нийцүүлэн байгаль орчны хамгаалах
- Тооцоолоогүй нөлөөллүүдийг бууруулахад зарцуулагдах төлөвлөгдөөгүй зардлуудыг бууруулах ‘урьдчилан харж зайлсхий’ арга хандлагыг ашиглах

БОНБУ-ний хязгаарлагдмал байдал

Зарим тохиолдолд, БОНБУ хийхэд хэд хэдэн бэрхшээлтэй асуудлууд тулгардаг. Эдгээр нь ихэвчлэн дараах шалтгаантай байдаг. Үүнд:

- Үнэлгээний гол зорилго ба хандлагыг алдагдуулдаг. Тухайн төсөл байгаль орчинд хохирол учруулах талаар бодитой судалгаа, дүгнэлт байсан байсан ч төслийг зогсоох шийдвэрийг гаргах боломжгүй байдаггүй олон жишээнүүд байдаг.
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, удирдлагыг араас нь хөөж үзэх, шалгах нь бэрхшээлтэй байдаг, ялангуяа, засаг захиргааны нэгжийн чадавх сул, тодорхой ба хүчтэй хуулийн зохицуулалт байхгүй, хяналт-шалгалтыг хангалттай хийдэггүй зэргээс шалтгаалан бэрхшээлүүд гарч ирдэг.
- БОНБУ нь томоохон төслийн хувьд заавал хийгдэх ёстой үнэлгээ юм. Гэвч, том төсөл доторх жижиг үйл ажиллагаанууд болон төслүүд дээр цаг хугацаа болон төсвийн дутмаг байдлаас шалтгаалан сайн, бодитой БОНБУ хийх үйл явцад бэрхшээл учруулдаг. Ихэнх тохиолдлуудад БОНБУ-г “дүр үзүүлэх” байдлаар хийдэг явдал нь урт хугацаанд хөгжлийн эерэг нөлөөлөл үзүүлэх өнцгөөс харж үнэлэх байдлыг орхигдуулдаг.
- БОНБУ нь чухал ач холбогдолтой – гэвч хангалтгүй байдлаар хийгддэг – төлөвлөлтийн нэг арга, хэрэгсэл юм. БОНБУ нь санал болгож буй төсөл нь хэрэгжилт үед болон дараа сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэдгийг баталж чадавхгүй. Энэ утгаараа, БОНБУ нь бас тийм ч төгс арга хэрэгсэл биш.
- Өргөн олон нийтийг хамруулан БОНБУ-г хийх нь тийм амар ажил биш, ялангуяа, ‘дуу

хоолой' бага хүргэдэг иргэдийн бүлгийг хамруулахад хэцүү байж болно. Тэдгээр нь ядуу, орлого багатай өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгшид болон алслагдсан өрх айлууд байж болох ба тэд тухайн төслийн үйл ажиллагааны талаар сайн ойлголт, мэдлэггүй байдаг.

Цогц үнэлгээ (ЦҮ)

Сүүлийн үед цогц үнэлгээг өргөн хэрэглэж байна. Цогц үнэлгээ нь нийгэм, соёл, эдийн засаг ба байгаль орчны өөрчлөлтийг цогцоор нь авч үзэн тэдгээр хоорондын уялдаа холбоо, шалтгаан- нөлөөлөл, олон талт нөлөөлөл зэргийг илрүүлэх, удирдах зорилгоор үнэлдэг. Цогц үнэлгээ нь тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай тохиролцоог хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд хэрэгжүүлэх бодлого барих ба бодлого боловсруулагчдад эдгээр боломжийг олгодог.

Цогц үнэлгээ нь уламжлалт байдлаар нэг талын оролцоотой хийгддэг байсан болон бусад хамааралтай шалтгаан, нөлөөллүүдийг үл тооцоолон хийгддэг байсан туршлагыг халж, талуудын оролцоог бий болгох сэдлийг ихээр төрүүлэх замаар салбар дундын уялдааг хангах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс, цогц үнэлгээ нь оролцогчдын идэвхтэй оролцоог нэмэгдүүлж, иргэдэд тулгарч буй асуудал, тэдгээрийг бууруулах арга замуудын талаар хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэх боломжийг дээшлүүлдэг.

Сүүлийн үеийн хөгжлийн чиг хандлага нь үнэлгээний цар хүрээг илүү өргөн хүрээнд тухайлбал, тогтвортой хөгжлийн 3 тулгуур болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийг үнэлэх , харах боломжийг эрэлхийлж байгаа бөгөөд стратегийн бодлого ба төлөвлөлтөд үзүүлэх нөлөөллийг Байгаль орчны стратегийн үнэлгээ (БОСҮ), Эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ үнэлгээ (ЭМНБҮ), Хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ХЭНБҮ) ба Жендерийн ялгаатай нөлөөлөх байдлын үнэлгээ (ЖЯНБҮ) гэх мэт олон үнэлгээний төрлүүд бий болж байна.

Бүлгийн ажил (15 минут)

Оролцогчдыг хоёр хоёроороо бүлэг болж, өмнөх хэсэгт өгсөн мэдээллийн дагуу БОНБУ-ний үе шатыг зургаар үзүүлж тайлбарлах даалгавар өгнө.

Монгол улс дахь БОНБУ-ний тогтолцоо (30 минут)

Монгол улсын БОНБУ-ний тухай хууль 2012 онд шинэчлэгдэн батлагдсан. Чингэхдээ олон улсын стандарт, сайн туршлагыг харгалзан 1998 батлагдсан өмнөх хуулийн агуулгын 80 орчим хувьд өөрчлөлт оруулж нэмэн засварлажээ.

БОНБУ-ний тухай хуульд БОНБУ гэдгийг “аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг” хэлнэ гэж заажээ (3.1.6). Хуульд зааснаар дараах 4 төрлийн үнэлгээ байна. (Article 4.1):

- Байгаль орчны стратегийн үнэлгээ
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ

Дараах дүрслэлд эдгээр үнэлгээний чиг үүрэг, хийх ерөнхий дарааллыг харуулав.

Монгол улс дахь БОНБУ





(Adapted from Oyunaa Lkhagvasuren. 2015. Impact Assessment: Story of Mongolia. The IAIA Proceedings. http://conferences.iaia.org/2015/iaia15_proceedings.php)

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий ба нарийвчилсан үнэлгээ


БОНБУ-ний хуулиар аливаа төсөл, хөгжлийн санаачилгуудыг хэрэгжүүлэхийн өмнө Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ /БОНЕУ/ буюу байгаль орчны тойм судалгаа хийлгэх шаардлагатай. Уул уурхайн төслүүдийн хувьд БОНХАЖЯ нь БОНЕУ-г хариуцаж шийдвэр гаргадаг. Төслийн хариуцагч нь дараах бичиг баримтуудыг БОНЕУ хийлгэхэд илгээх ёстой. Үүнд:

- Төслийн танилцуулга
- Техник, эдийн засаг болон эдийн засгийн судалгаа
- Ажлын зураг төсөл
- Бусад шаардлагатай бичиг баримтууд.

Үнэлгээг шинжээч ажлын 14 хоногт багтаан хийж дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Техник, технологи, үйл ажиллагаа нь байгаль орчинд халтай, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, стратегийн үнэлгээний дүгнэлт болон холбогдох хууль тогтоомжид нийцээгүй төслийг хэрэгжүүлэхээс татгалзах, эсхүл буцаах;
- Төслийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэлгүйгээр тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэх;
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /БОННУ/ хийлгэх шаардлагатай гэж үзэх.

Дараах дүрслэлд БОННУ-ний шийдвэр ба түүний дараах үйл явцыг харуулав.



БОННУ



Хэрэв БОННУ хийх шаардлагатай бол төслийг хариуцагч нь БОНХАЖЯ-нд бүртгэлтэй мэргэжлийн байгууллагаар БОННУ хийлгэх гэрээ байгуулж ажиллана. Уг мэргэжлийн байгууллага нь БОННУ-ний Тайланг боловсруулах ёстой ба дараах агуулгатай байна (Article 8.4):

- 8.4.1.төсөл хэрэгжих орчны байгаль орчны төлөв байдал;
- 8.4.2.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эрчим, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгааны үр дүн;
- 8.4.3.төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж;
- 8.4.4.төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй бохирдлыг бууруулахад боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй техник, технологийг ашиглах зөвлөмж;
- 8.4.5.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд эрсдэлийн үнэлгээ хийхээр заасан бол төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ;
- 8.4.6.газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;
- 8.4.7.байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд;
- 8.4.8.төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл;
- 8.4.9.төсөл хэрэгжих газрын түүх соёлын үнэт зүйлс, төслийн онцлогтой үялдсан бусад асуудал.

Хуульд зааснаар үнэлгээ хийсэн байгууллага нь БОНХАЖЯ, төсөл хариуцагч буюу захиалагч, төсөл хэрэгжих сүм, дүүргийн захиргаанд БОННУ-ний Тайлангийн хувийг тус бүр хүргүүлэх үүрэгтэй. Хуулийн 8.8-р зүйлд төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина гэж заасан байна.

БОНХАЖЯ нь БОННУ-ний Тайланг хүлээн авснаас хойш доод тал нь 18 хоногт багтааж шийдвэр гаргана. Тайланд үнэлгээ хийлгэхээр яамны шинжээч болон гадны бие даасан шинжээчийг томилж ажиллуулж болно. БОНХАЖЯ-ны Мэргэжлийн Зөвлөл нь шинжээчийн

дүгнэлт, БОННУ-ний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж үзээд эцсийн дүгнэлт гаргадаг. Засгийн газрын Байгаль орчны нөлөөллийн журам батлах 374 тогтоолын 6.4-д заасны дагуу Зөвлөл дараах шийдвэрүүдээс аль нэгийг гаргана.

- Зарим шаардлагатай засвар, нэмэлт тодруулгыг тусгаж үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж, төсөл хэрэгжүүлэхийг албан бичгээр зөвшөөрөх;
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал бодит бус, нэмэлт судалгаа, мэдээлэл шаардлагатай гэж үзсэн тохиолдолд батлахаас татгалзаж, төсөл хэрэгжүүлэгчид албан бичгээр буцаах;
- Төсөл нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд нэн халтай, нөхөх боломжгүй хохирол учруулна гэж үзсэн тохиолдолд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах.

Мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.6-д заасны дагуу Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ерөнхий шинжээч гарын үсэг зурж албажуулна.

Монгол улс дахь БОНБУ-ний үйл явц дахь олон нийтийн оролцоо

БОНХАЖЯ-наас 2014 онд БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах журмыг баталсан. Энэ журмын дагуу БОНХАЖЯ эь БОНБУ хийлгэсэн төслүүдийн талаарх мэдээллийг өөрийн цахим хуудаснаа байршуулах үүрэгтэй. Уг журмын 1.5 зүйлд Менежментийн төлөвлөгөөг олон нийтэд нээлттэй байлгана гэж заасан.

Дараах хүснэгтэнд төрөл бүрийн үнэлгээг хийх явцад олон нийт, оролцогч талуудын оролцоог хэрхэн хангах ёстойг хууль, журмаар хэрхэн тодорхойлсныг тоймлон харуулав.

<p>Стратегийн үнэлгээ</p> <p>Хуримтлагдах үнэлгээ</p> <p>БОНБУ</p> <p>БОННУ</p>	<ul style="list-style-type: none"> • Стратегийн үнэлгээ хийх мэргэжлийн баг нь үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтээс санал авах тухай мэдээллийг санал авч эхлэхээс өмнө олон нийтэд мэдээлж, ажлын 21 хоногт багтаан санал авах • Мэргэжлийн баг нь хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд тухайн орон нутгийн иргэд, байгууллагаас санал авч, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах хэлэлцэх • Орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах, үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах • Мэргэжлийн үнэлгээний байгууллага нь таамаглах үе шатанд иргэдтэй уулзалт хийх, оролцооны аргаар үнэлэх аргачлалыг ашиглан иргэдийн саналыг бүрэн авах; • Нөлөөллийн үнэлгээний үе шатанд олон нийтийн оролцоог зөвлөлгөөн, хэлэлцүүлэг, санал асуулга явуулах замаар төслийн шууд болон шууд бус нөлөөллийг үнэлж, иргэдийн амьжиргаа, нийгмийн асуудлыг тусгахад анхаарах. • Төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна. • Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахас өмнө хүргүүлсэн байна. • Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна. • Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангаж, хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, олон нийтэд танилцуулж байна. 	
<p>Бүлгийн ажил (20 минут)</p> <p>Хувилбар 1: БОНБУ-г ашиглахад тулгардаг бэрхшээл</p> <p>Хоёр хоёроороо бүлэг болон өмнө ярилцсан сэдвийн дагуу Монгол Улсад шийдвэр гаргах үйл явцад БОНБУ-г ашиглахад тулгардаг гол бэрхшээлүүдийн талаар ярилцана. БОНБУ-ний үр дүнг шийдвэр гаргахад ашиглах үйл явцад тулгарч буй 3 бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлж, түүнийг сайжруулах 3 арга замыг тодорхойлно.</p>		

Хувилбар 2: Дүрд тоглох

Доорх нөхцөл байдлыг танилцуулна. Үүнд:

Баянхонгор аймгийн нэгэн суманд гадаадын уул уурхайн компани дөнгөж алт олборлох үйл ажиллагаагаа дуусав. Алт олборлолт ашигтай байсан ба одоо дахин засаг захиргааны байгууллагад хандан 2018 оны 1 сараас эхлэн дахин ил аргаар алт олборлох зөвшөөрөл авах хүсэлтээ тавих гэж байна. Компани олборлох явцдаа жилд 200,000 унц алт олборлох төлөвлөгөөтэй байгаа ба энэ нь 25 жил үргэлжлэх магадлалтай. Олборлох үйлдвэрлэлийн газар нь сумаас 8 км-ын зайтай оршдог.

Компанийн удирдлага хэд хэдэн хөрөнгө оруулагчдад хандан олборлолт явуулахад дэмжлэг үзүүлэх санал хүсэлтээ тавьсан. Гэвч, Монгол Улсын БОНБУ-ний тухай хууулийн дагуу, БОНХАЖЯ нь энэхүү үйлдвэрлэлийг явуулахын тулд БОНБУ хийх шаардлага тавьсан. Түүнээс гадна, сумын иргэд төслийн хэрэгжилтийг дэмжихгүй байгаа бөгөөд хэрэв төслийг хэрэгжүүлвэл тэдний амьжиргаа, МАА-гаа эрхлэх үйл ажиллагаа болон эрүүл мэндэд маш ихээр нөлөөлнө гэж үзэж байгаа.

Дөрөв дөрвөөр бүлэгт хуваагдана. Бүлэг дотор төсөл боловсруулагч, төслийн зөвлөх, сумын төвд амьдардаг учраас төслийн талаар сайн ойлголттой малчны төлөөлөл ба БОНХАЖЯ-ны ажилтны төлөөлөл байна гэж төсөөлнө.

БОНБУ хийх явцад төсөл боловсруулагчид нь эдгээр талууд оролцож, төслөөс үүсч болзошгүй эрсдэл, тэдэнд нөлөөлөх нөлөөллийн талаар хэлэлцэх ёстой.

Эдгээр талууд төсөлтэй танилцаж, төслийн хэрэгжилт тухайн бүс орчмын байгаль экологи, биологийн төрөл зүйл, хүн амын суурьшил, мал, амьтны бэлчээрт учруулж болзошгүй хохирол, эрсдэлийг тодорхойлно.

Бүлэг тус бүр 5 минутад багтаан дараах мэдээллийг танилцуулна. Үүнд: а) учруулж болзошгүй 4 гол нөлөөллийг тодорхойлох, б) нөлөөлөлд хамгийн их өртөж болзошгүй

<p>иргэдийг тодорхойлох, в) нөлөөлөл тус бүрийг бууруулах эсвэл уул уурхайн олборлолтоос үүсэх сөрөг нөлөөллийг багасгах 1 арга замыг тодорхойлно.</p> <p>Сүүлийн 1 минутад төслийн хэрэгжилтийн талаар дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд: а) төслийн хэрэгжилтийг зөвшөөрөх, б) нөлөөлөл маш их, хүчтэй, эргэн нөхөн сэргэх боломжгүй учраас төслийг хориглох, в) томоохон төлөвлөлт/аргачлалын өөрчлөлт шаардалгүйгээр төслийг зөвшөөрөх.</p>	
<p>Унших ном, материал</p> <p>Glasson, J., Therivel, R. and Chadwick, A. Introduction to Environmental Impact Assessment. http://www.inforse.org/doc/Final%20EIA%20Training%20Resource%20Manual%20(a).pdf</p> <p>UNDP. 2011. Mongolia Human Development Report. From Vulnerability to Sustainability Environment and Human Development. (In Mongolian)</p> <p>Ojima, D., Chuluun, T., & Altanbagana, M. (2014). Vulnerability and Resilience of the Mongolian Pastoral Social-Ecological Systems to Multiple Stressors Vulnerability of Land Systems in Asia (pp. 27-40): John Wiley & Sons, Ltd.</p> <p>Цахим хэрэглэгдэхүүн</p> <p>UNU. Open educational resource on Environmental Impact Assessment (EIA) http://eia.unu.edu/course/images/Generalised_EIA.pdf</p> <p>ELAW. 2010. Guidebook for Evaluating Mining Project EIAs - complete Guidebook (English & Russian) https://www.elaw.org/mining-eia-guidebook</p>	
<p>Үндсэн нэр томьёо, ойлголтуудын тайлбар</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) - аливаа төслийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлох үйл явц.</p> <p>Байгаль орчны аудит - аливаа төслийн үйл ажиллагаа нь тодорхой хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур, стандартын дагуу явагдаж буй эсэхийг тодорхойлох системтэй хандлага юм.</p>	

Байгаль орчин үзүүлэх нөлөөлөл - аливаа төсөл буюу үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учрах хохирол

Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ) – компанийн байгаль орчны хамгааллын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх дотоод нэгдсэн тогтолцоо

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө – төслийг хэрэгжүүлэхээс өмнөх, хэрэгжих үеийн, мөн хэрэгжилтийн дараах байгаль орчны нөлөөллийг бууруулах талаар авах арга хэмжээг тодорхойлсон бичиг баримт. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Хуримтлагдах нөлөөлөл - урд өмнө, одоо хэрэгжиж буй, ирээдүйд хэрэгжих төслүүдийн хам сөрөг нөлөөлөл.

Байгаль орчны хяналт-шинжилгээ – байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэхийн тулд байгаль орчны үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, үнэлэх үйл явц

МОДУЛЬ 7. УСНЫ МЕНЕЖМЕНТ

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Уул уурхай дахь тогтвортой усны менежмент, түүнийг хэрэгжүүлэх, практикт нэвтрүүлэх арга, туршлагууд
- Уурхайгаас усны чанар, тоо хэмжээнд үзүүлэх нөлөөллүүд, нөлөөллийн менежментийн арга, туршлагууд
- Усны хяналт шинжилгээ, түүнд талуудын оролцоог хангах арга замууд
- Холбогдох мэдээллийг хаанаас олж авахаа мэддэг болох

Удиртгал

Ус бол иргэд, бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн үнэт баялаг билээ. Усгүйгээр уул уурхай явагдах боломжгүй юм. Модульд уул уурхайн үйл ажиллагаанаас усанд үзүүлэх шууд ба шууд бус нөлөөллүүд, тэдгээрийн өрхийн амьжиргаа, эдийн засаг, нийгэмд гарах үр дагавруудын тухай авч үзэх ба усны менежментэд оролцогч талууд нөлөөллийн шалтгаан, ялангуяа үүнд хүний болон байгаль экологийн хүчин зүйлүүдийн онцлогийн талаар үндсэн мэдэгдэхүүн олгох зорилготой. Хичээл лекц, семинар, харилцан ярилцлага, бүлгээр дасгал ажиллах хэлбэрээр явагдах бөгөөд үүнд дотоод, гадаадын уул уурхай дах усны менежментийн сайн туршлагуудад анализ дүгнэлт хийлгэх, оролцогчид туршлагаа хуваалцах зэргийг багтаасан болно.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Уурхайн үйл ажиллагаанаас усны чанар, тоо хэмжээ, хүртээмжид үзүүлэх нөлөөлөл
- Нөлөөлөл тархах замууд
- Усны нөөцийн менежментэд талуудын оролцоо, түншлэлийн ач холбогдол
- Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийхийн ач холбогдол
- Хяналт шинжилгээг газар дээр нь, хурдан хийх арга, хэрэгслүүд

Жишиг хуваарь

- Уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг ойлгох нь (20 минут)
- Бүлгээр ажиллах: Усны менежментийн төлөвлөлтийг талуудын оролцоотой хийх нь (20 минут)

- Усны менежментийн стратеги (30 минут)
- Усны хяналт шинжилгээ (15 минут)
- Дүгнэлт, ярилцлага (5 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p data-bbox="181 459 1279 491">Уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг ойлгох нь (20 минут)</p> <p data-bbox="181 539 405 571">Уул уурхай ба ус</p> <p data-bbox="181 619 1581 1042">Уул уурхайн усны хэрэглээ, уурхайн үйл ажиллагаанаас усанд үзүүлэх нөлөөллүүдээс үүдэн байгаль орчин, нийгмийн чухал асуудлууд хөндөгддөг. Усны нөөц хязгаарлагдмал хуурай бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй уурхайн ойр орчмын иргэдийн хувьд усны хүртээмж, болзошгүй усны бохирдол санаа зовоосон асуудал юм. Зарим тохиолдолд усны менежмент уурхайн компанийн хамгийн чухал бөгөөд төвөгтэй асуудал болдог. Өнгөрсөн арван жилийн хугацаанд уул уурхайгаас усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн улмаас Монгол оронд олон эсэргүүцэл, жагсаал цуглаан өрнөсөн. Тухайлбал, 2013 оны 7 дугаар сард, хэд хэдэн томоохон хэмжээний уурхайн төслүүд хэрэгжиж буй Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчидийн Хурлаас 2016 оноос эхлэн уурхайн үйл ажиллагаанд гүний усны нөөцийг ашиглуулахгүй байх тогтоол гаргасан байдаг. Уг тогтоол удалгүй цуцлагдсан ч энэ мэт шийдвэр нь уурхайн үйл ажиллагаанаас гүний усны нөөцөд үзүүлэх нөлөөллийн менежментэд төрийн зүгээс хатуу бодлого, хуулийн зохицуулалт хийхийг шаардаж буй олон нийтийн байр суурийг илтгэж байгаа юм.</p> <p data-bbox="181 1090 1581 1281">Өнгөрсөнд бий болсон уул уурхайн сөрөг үл мөрийг дахин гаргахгүйн тулд, төр, олон улсын байгууллага, олон нийт уурхайд усыг хариуцлагатай, өндөр бүтээмжтэй, зөв менежментээр ашиглах шаардлага тавих болсон. Жишээ нь, Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын харъяа НҮБ-Ус байгууллагаас уул уурхай дахь усны менежментэд тэргүүлэх ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлсон. Эдгээрт нь:</p> <ul data-bbox="237 1289 1581 1385" style="list-style-type: none"> • Ус ашиглалтын бүтээмж, уурхайгаас гадагш гарч буй хаягдал усанд тавих хяналт • Уурхайгаас усаар дамжин тархах олон тооны дагавар бүтээгдэхүүнүүдээс хүрээлэн буй орчинд үзүүлэх урт хугацааны нөлөөлөл 	

- Зарим сав газарт усыг хамгийн ихээр ашиглагч нь уурхайн үйл ажиллагаа байгаа явдал

Дээр дурдсан асуудлуудад дараах шийдлүүд байх боломжтой. Үүнд:

- Уурхайн ус ашиглалтын бүтээмж, хаягдал усанд тавих хяналт, төлөвлөлт, зохицуулалтыг хангах үр нөлөөтэй, хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох
- Уурхайн онцлог нөхцөлд тохирсон, усны тогтмол хяналт шинжилгээнд тулгуурласан бохирдлоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах
- Хүрээлэн буй орчин, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийх хууль эрхзүйн орчны сайжруулах

(Эх сурвалж: НҮБ-Ус. 2010. Усны асуудлууд: Тогтвортой Хөгжлийн Хорооны арван найм, арван есдүгээр хэсгийг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах нь http://www.unwater.org/downloads/UN-Water_UNSGAB_CSD_18_19.pdf)

2015 онд Олон Улсын Уул Уурхай Металлын Зөвлөл (ОУУУМЗ)-өөс усны нөөцийн төлөвлөлт, менежментийг хийх бодлогын хүрээнд олборлох салбарын усны нөөцийн менежментэд баримтлах зарчмуудыг тодорхойлсон. Эдгээр нь:

- Ил тод, хариуцлагатай байх. Усны нөөцтэй холбоотой аливаа эрсдэл, компанийн зүгээс тэдгээрт авах хэмжээ, менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт зэрэг нь олон нийтэд нээлттэй байх.
- Идэвх, санаачилгатай, оролцоог дэмжсэн хамтын ажиллагаа, харилцааг эрхэмлэх. Талуудыг нарийвчлан тогтоох, тэдний санаа бодлыг сонсох, нээлттэй илэн далангүй ярилцах, эрсдэлээс зайлсхийх, бууруулахад түншлэлийн хэлбэрээр хамтран ажиллах боломжоор хангах
- Үр нөлөөтэй усны менежментийг хэрэгжүүлэх. Уурхайн үйл ажиллагаанд ашиглах цэвэр ус (орц), үйлдвэрлэлд ашиглалт, хаягдал ус (гарц)-ыг зохицуулах. Ус ашиглалтын бүтээмжийг сайжруулах.
- Сав газарт түшиглэсэн усны менежментийн аргыг нэвтрүүлэх. Энэ аргаар сав газарт ус ашиглагч ба хэрэглэгч талууд, тэдгээрийн хэрэгцээг ойлгон мэдэхээс гадна сав газарт үзүүлэх нөлөөллийг цогцоор нь үнэлнэ.

(Эх сурвалж: Уул уурхай метал боловсруулах салбарт сав газарт түшиглэсэн усны менежментийг хэрэгжүүлэх гарын авлага, ОУУУМЗ, 2015. <http://www.icmm.com/document/8329>)

Уул уурхай дахь усны хэрэглээ-ашиглалт

Уурхайн бүх л үе шатанд усыг ашигладаг бөгөөд уурхайн үйл ажиллагааны эрчимтэй шууд

Гаарын доорх усны нөөц

Сэргээхэн нөөц

"Жил бүр хур тунадсан нөмцөлт, доторлын усны нөмцөлт, гэрэлт, ажгуурын урсгалын нөлөөгөөр дотоо бүрдсэн боломжтой усны хэмжээ"



Үл сэргээхэн нөөц

"Хур тунадсан нөмцөлт, ажгуурын урсгалас танаараа боломжгүй газрын доорх усны хуримтлал"

хамааралтайгаар олборлолтын үе шатанд усны хэрэглээ хамгийн их байх ба хаалтын үе шатанд хэрэглээ буурна. Олборлолтын шатанд алт, зэс зэрэг металлуудыг боловсруулах, хүдрийн биеэс ялган авахад усыг хамгийн ихээр ашигладаг байна. Түүнчлэн олборлолтын шатанд усыг металл боловсруулалтын дараах хөргөлт, уурхайн овоолго, шороон замын тоосжилт дарах зэрэгт ашиглана. Эдгээрээс тоосжилт дарахад үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг дахин ашиглаж болдог.

(Эх сурвалж: Усны менежмент. Уул уурхай дах тогтвортой хөгжлийн тэргүүн туршлагауд, Австралийн Хамтын Нөхөрлөл, 2006. <http://www.industry.gov.au/resource/Programs/LPSD/Pages/LPSDhandbooks.aspx>)


Монгол орон хуурай уур амьсгалтай, далайн төвшнөөс өндөрт өргөгдсөн, хур тунадас бага (жилд дунджаар хангайн бүсэд ~260 мм, говийн бүсэд ~60 мм) учраас орох хур тунадасны ихэнх нь уурших буюу гадаргын болон гүний усанд шингэдэггүй (Усны Үндэсний Төв, 2015).

Гадаргын болон гүний ус нь хур тунадас (цас, бороо), цэвдгийн гэсэлтийн усаар нөхөн төлжиж байдаг харилцан шүтэлцээт, нэгдмэл систем юм. Гүний ус хур тунадасын нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр тэжээгдэн, нөхөн сэргэж байдаг. Үүнийг гүний усны сэргээгдэх нөөц гэнэ. Хөрсний гүний үе давхаргуудад хур тунадасны нэвчилт, хажуугийн урсацаас тэжээгдэх боломжгүй гүний усыг дарагдмал ус буюу үл сэргээгдэх нөөц гэнэ. Монгол орны хувьд усны хэрэглээний 90 гаруй хувийг нийт усны нөөцийн өчүүхэн хэсгийг (~2%) эзэлдэг гүний уснаас авдаг. Үүнээс 55 гаруй хувь нь уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдаж байна (Усны Ассоциаци, 2015). Усны нөөцийн дийлэнх (98 хувь) хувийг эзлэх гадаргын ус нутаг дэвсгэрийн хэмжээнд харилцан адилгүй тархан байдал, ус хадгалах, түгээх дэд бүтцийн хөгжил сул зэргээс шалтгаалан ашиглагдах боломж хязгаарлагдмал.

Азийн Хөгжлийн Банкны тооцооноор, 2010 он гэхэд Монгол улсын усны хэрэглээ усан цахилгаан станцад ашиглах усыг оруулахгүйгээр жилд 321.0 сая шоо метр болно гэсэн үзүүлэлт бий. Ус ашиглалт-хэрэглээний хэмжээгээр хөдөө аж ахуйн салбар (31% нь усалгаатай газар тариалан, 24% нь мал аж ахуй) тэргүүлж, түүний дараа ахуйн болон үндны усны хэрэглээ (20%), уул уурхай (13%), эрчим хүчтэй холбоотой цахилгаан хөргөлтийн үйл ажиллагаа (10%) ордог.

(Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк. 2014. Элсэн цөл дэх хэрэгцээ: Монгол орны ус-эрчим хүч-уурхайн шүтэлцээ. <http://www.adb.org/sites/default/files/publication/42820/demand-desert.pdf>)

МУ-ын засгийн газраас тухайн сав газарт гүний усны сэргээгдэх нөөцийн ашиглах боломжит хэм, хэмжээг байгалийн нөхөн сэргээгдэх онцлогт нь нийцүүлэн нарийвчлан тогтоодог. Үйлдвэрлэлийн



зориулалтаар ашиглах усны хэм хэмжээг “Усны экологи эдийн засгийн үнэлгээ”, бусад холбогдох журмын (Засгийн Газрын 302, 327 дугаар тогтоолын хавсралтууд) дагуу экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглагдах боломжит нөөцөд үндэслэн тогтооно.

Уул уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаагаар тухайн орчны гидрологийн тэнцвэрт байдал алдагдаж ойр орчмын хүн, амьтны амьдрах орчинд шууд ба шууд бусаар нөлөөлдөг. Үүнийг дараах дүрснээс харж болно.



(Эх сурвалж: Ус, Ойн Асуудал Эрхлэх Газар, 2006. Тэргүүн туршлагын гарын авлага А1: Жижиг уурхай (Стандарт хувь). Өмнөд Африк <https://www.dwa.gov.za/mzimvubu/documents/IAP/Final/Appendix%20A%20Best%20Practice%20Guidelines.pdf>)

Усны чанарт нөлөөлөх байдал

Уурхай явагдаж буй орон нутгуудад хүнд металын болон органик нэгдлүүдийн агуулга зөвшөөрөгдөх хэмжээнээс ихсэх, булингартах зэрэг байдлаар гадаргын усны бохирдол илэрч байна. Ус бохирдуулагч эх үүсвэрүүд хүрээлэн буй орчинд тархах үндсэн 2 зам байна. Үүнд:

- *Цэгэн*, хэрэв бохирдол тодорхой нэг газарт үүсэх, тухайлбал үйлдвэрийн газар, айл өрх, цэвэрлэх байгууламж гэх мэт.
- *Цэгэн бус*, хэрэв бохирдуулагч анх үүсэн газраасаа шилжин зөөвөрлөгдөж бохирдол үүсгэх.

Уурхайн үйл ажиллагаа энэ ангилалд багтана. Нэг цэгт төвлөрөх боловч уурхайн талбараас бохирдол агаар, хөрс, усаар дамжин тархах бололцоотой байдаг.

Уурхайн талбараас бохирдол дараахын аль нэг эсхүл хавсарсан байдлаар тархаж болно. Үүнд:

- Гадагшаа урсац хяналтгүй байх. Метал (алт, зэс гэх мэт) боловсруулах процессын хаягдал усны найрлаганд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хортой элементүүд (мөнгөн ус, цианит гэх мэт) зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээр агуулагддаг.
- Гадаргын урсац. Үер усны нөлөөгөөр уурхайн талбараас хаягдал, боловсруулалтын дараах хаягдал ус угаагдал, урсацаар гадагш зөөвөрлөгдөнө.
- Голын гольдрол өөрчлөх, хурдас хөндөх. Драгаар олборлох процесст голын хурдас, эх чулуулаг хөндөгдөж, ус булингартаж ундад хэрэглэхэд тохиромжгүй болно. Түүнчлэн зарим бичил биетнүүдэд “идэвхгүй” байдлаас гарч, өсөн нэмэгдэх таатай нөхцөл бүрдэнэ (хүчилтөрөгчөөр баялаг, дулаан орчин, илүүдэл азот, фосфор гэх мэт). Энэ нь ундны усыг бохирдуулж хүн амьтанд өвчин үүсгэх нөхцөл бүрдэнэ гэсэн үг.
- Хүчиллэг урсац. Хаягдлын сан (лаг), овоолгоос шүүрэх усны найрлаганд хүнд металлууд ихээр агуулагддаг бөгөөд хөрсөнд нэвчин газрын доорх ба гадаргын ус бохирдох эх үүсвэр болдог.
- Химийн бодисын буруу хадгалалт, ашиглалт (тосоол, цианит, мөнгөн ус гэх мэт).

Гол усны бохирдол хүн амьтны эрүүл мэндэд шууд ба шууд бус замаар нөлөөлнө. Жишээ нь ус эргүүлэх цөөрөм эсхүл хаягдлын далангийн (лаг) дэвсгэр хүчилтыг хийгээгүйгээс хаягдалд агуулагдах органик нэгдлүүд, хүнд металлууд аажмаар хөрсний усанд нэвчиж гүний усны чанарт нөлөөлдөг. Мөн уурхайн талбарын зохион байгуулалтыг хийхэд газрын хотгор гүдгэр, цаг уурын онцлогийг бодолцон ус зайлуулах суваг шуудуу гаргаагүйгээс, талбар усанд автах, угаагдах замаар бохирдуулагч хүрээлэн буй орчинд тархах нөхцөл бүрдэнэ.

Хөрс, усны бохирдлоор хүний хоол тэжээлийн хэлхээнд орсон хортой бодисуудыг цэвэрлэх, арилгахад их цаг хугацаа, хөрөнгө хүч шаардагдана. Тухайлбал, хүнд металаар бохирдсон голын усны загасыг хоол хүнсэнд хэрэглэх замаар хорт бодисууд хүний биед дамжина. Дархан-Уул аймгийн Хонгор сумын хөрс, усны мөнгөн усны бохирдол бол үүний жишээ юм.

(Дэлгэрэнгүйг харах: Монгол орны уул уурхай олон жил явагдсан бүс нутгууд дахь мөнгөн усны бохирдол, Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн хийсэн судалгаа, 2007 http://awsassets.panda.org/downloads/mn_toxics_mining.pdf)

Монгол улсын хуулиар 2012 оноос “бохирдуулагч төлөх” зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулинд (2012) бохирдлыг тооцох, төлбөр тогтоох, хариуцагчийн хүлээх үүрэг зэргийг заасан байна. Энэ хуулиар бохир ус буюу үйлдвэрлэлд ашигласан усаа эргүүлэн ашигласан тохиолдолд ашигласан хэмжээгээр нь усны ашиглалтын төлбөрөөс чөлөөлнө (8 дугаар зүйл).

Усны тоо хэмжээнд нөлөөлөх байдал

Усны хомсдол бий болох нь тухайн орчинд усан хангамж, усны хэрэгцээнд хүрэлцэхгүй байгааг илэрхийлнэ. Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр усны чанар доройтох, хэрэгцээний шаардлагад нийцэхгүйн улмаас усны хомсдол үүсч болно.

Уурхайн бүс нутгуудад усан хангамж, нөөцийн олдоц буурах дараах шалтгаанууд байна:

- Зохицуулалтгүй голын гольдрол, суваг өөрчлөх (ил уурхайн олборлолт, томоохон дэд бүтцийн төслүүд гэх мэт)
- Гол мөрний эх, голын хөндийн ой модыг огтлох (хөрс хуулахад ургамлын нөмрөг үгүй болох)
- Усны бохирдол, чанарын доройтол
- Хэрэглээ нэмэгдэх, хэтрүүлэн ашиглах (нэг дор олон тооны үйлдвэрлэл, ашиглалт явагдах)
- Ашиглах боломж хязгаарлагдмал (айл өрх аж үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас нүүлгэн шилжүүлэлтэд өртөх)
- Уур амьсгалын өөрчлөлт (ган, байгалийн усны нөөцийн нөхөн төлжилт удаашрах)

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)-д заасны дагуу аливаа уурхайн компани Ус Ашиглах Зөвшөөрөл авах, түүний дагуу орон нутгийн захиргаа, Сав Газрын Захиргаат ус ашиглалтын гэрээ хийх, гэрээний биелэлтийг жил бүр тайлагнах, хэлэлцүүлэх, ус ашиглалтын төлбөрөө төлөх, усны хяналт шинжилгээг тогтмол явуулах үүрэгтэй. Усны тухай хуулийн 27, 28 дугаар зүйлд усны нөөцийг ашиглах төлбөр, төлбөрийг тооцох итгэлцүүрүүдийг ус ашиглалтын (боловсруулалт, аж үйлдвэрт) болон хэрэглээ-ашиглалтын төрөл (хүн, малын үндэнд)-өөр ялгавартай тогтоосон байдаг. Түүнчлэн байгалийн бүс, бүслүүр дэх усны нөөцийн тархалт, гадаргын болоод гүний усны ашиглалт зэргээс хамаарч ус ашиглалтын төлбөр зарим орон нутгууд, сав газарт ялгаатай тооцогдоно (Засгийн газрын 326 дугаар тогтоолын хавсралт, 2013).

Усны ашиглалтын зөвшөөрлийг хоногт ашиглах усны эзлэхүүнээр (шоо метр) тооцож олгоно.

Үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах усны зориулалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сав газарт усны тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглах боломжит нөөцөд харьцуулан дүгнэлт хийж зөвшөөрөл олгоно (Усны тухай хууль, 2012). Компани гэрээнд заасан хэмжээг хэтрүүлэхгүй ашиглаж буй эсэхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтмол хяналт тавина. Ус ашиглалтын гэрээнд заасан тоног төхөөрөмжийн хүчин чадал (ус шахуургын моторын эзлэхүүн гэх мэт), уурхайн талбарын усны тоолуур, ус ашиглалт хариуцсан орон тооны менежер болон гэрээнд заасан бусад нөхцлүүдийн дагуу ус ашиглалтад хяналт тавина. Дээрх шаардлагуудыг хоногт 50 шоо метрээс дээш ус ашигладаг уурхайн зомпаниуд хангаж үүрэгтэй (Усны тухай хуулийн 30, 31 дүгээр зүйл). Зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлүүлнэ.

Бүлгийн ажил (20 минут)

Оролцогчдыг хэд хэдэн бүлэгт хуваарилан дараах даалгаврыг өгнө

- 15 хүнтэй, 60 га газарт, алтны шороон орд ашиглах жишээ, орчны төлөв байдлын бичлэг үзэх
- Уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг нэрлэх
- Нөлөөллийг бууруулах, түүнээс зайлсхийх хоёр ба түүнээс дээш шийдэл гаргах
- Үр дүнг танилцуулах, ярилцах

Усны менежментийн стратеги (30 минут)

Усны менежментийн үндсэн зорилго нь:

- Усны чанар, хүртээмжит байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах, арилгах, зайлсхийх
- Тухайн сав газарт ус хэрэглэгчдэд усны нөөцийг зохистой хуваарилах
- Усны хэрэгцээ, хангамж буюу “эрэлт, нийлүүлэлт”-ийн тэнцвэрт байдлыг хангах болно.

Эдгээр зорилтын хүрээнд уул уурхайн бүс нутагт усны нөөцийн менежмент хоёр хэсгээс бүрдэнэ.

Сав газрын түвшний зохицуулалт буюу Усны Нөөцийн Нэгдсэн Менежмент (УННМ).

УННМ нь сав газарт усны нөөц, түүнтэй холбоотой байгалийн баялгийг байдлаар удирдан зохицуулахыг хэлнэ. 2009 оноос БОНХАЖЯ Монгол оронд УННМ-ийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд



нэгдэн, холбогдох хууль, журмуудыг баталсан. 2014 оны байдлаар нийт 29 сав газрын захиргаа (СГЗа), түүний харьяа 2 сав газрын зөвлөл (СГЗө) байгуулагдан ажиллаж байгаа. Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, төрийн бус байгууллага, сум, дүүргийн иргэн, ус ашиглагч, эрдэмтэн, судлаач, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл багтана (Усны тухай хууль, 20.2 зүйл). Мөн СГЗө нь хуулийн хүрээнд олгогдсон эрхийн дагуу уурхайн ашиглалт хайгуулын лизенц, ус ашиглах зөвшөөрөл олголт, цуцлалт, ус ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, биелэлтэд хяналт тавих, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх эрх, үүрэгтэй.

(Эх сурвалж: НҮББОХ. 2014. УННМ-ийн зүгт: Сав газрын байгууллагуудыг хөгжүүлсэн олон улсын түршлага.

<http://www.unep.org/disastersandconflicts/portals/155/countries/Sudan/pdf/SudanWRM.pdf>)

Уурхайн талбарын усны менежмент

Уурхайн компани төрөөс тогтоосон бодлого, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бол төрийн зүгээс хууль боловсруулах, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн уялдаат байдлыг хангах, хяналт үнэлгээ хийх, усны менежментийн үр дүнтэй байдлыг сайжруулах чиг үүрэгтэй. Уурхайн компаниуд усны менежментийн төлөвлөлт, төсөв санхүү, хэрэгжилт, менежментийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийг үнэлэх дотоод бодлоготой байдаг.

Уурхайн үйл ажиллагаанаас усны чанар, хүртээмжид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, болзошгүй нөлөөллөөс зайлсхийхийн тулд дараахыг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Төлөв байдлын болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний дүгнэлтийн дагуу болзошгүй нөлөөллийг бууруулах арга замыг боловсруулж байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМ Төлөвлөгөө)-нд тусгах
- Тогтмол ашиглалт хэмжилт, хяналт шинжилгээ хийх (талбарт, түүний гадна орчинд)
- Байгаль орчинд ээлтэй, өндөр бүтээмжтэй ус ашиглалтын технологи ашиглах

Нөлөөллийн эрсдэлийг үнэлэх нь компани уурхайн үйл ажиллганы улмаас ус бохирдох эх үүсвэр, бохирдол тархах замыг тодорхойлох, хүрээлэн буй орчинд гарч болзошгүй үр дагаврыг үнэлэх эхний алхам болно. Уурхайн талбар дах ус (цөөрмийн ус, хаягдал ус гэх мэт) болоод уурхайн хилээс гадна орших байгалийн ус, уст цэгт хяналт шинжилгээг тогтмол хийх нь усны бохирдлоос сэргийлэх хямд, үр дүнтэй арга юм (дэлгэрэнгүй тайлбар доор бий).

Орчин үед уурхайн амьдралын үе шат бүрт усны менежментэд дараах дүрмийг баримтална. Үүнд:

- Цэвэр усны хэрэглээ, хаягдал усны гадагшаа урсацыг **Бууруулах**
- Эргүүлэн ашиглах (тоосжилт дарах гэх мэт), цэвэршүүлэх замаар хэрэглэсэн усыг **Дахин ашиглах**
- Гүний уснаас шүүрэл, илүүдэл усыг ирээдүйн ашиглалтад зориулан **Нөөцлөх, хуримтлуулах**
- Овоолго, хаягдал хураах сангийн усны ялгаралд хяналт тавьж, бохирдлоос **Зайлсхийх**

Эдгээрийг хэрэгжүүлэх олон янзын арга, туршлага байдгаас заримыг нь дурдвал:

- Илүүдэл усыг нөөцлөх, түүнийг уурхайн дотоод болоод орон нутгийн иргэдийн хэрэгцээнд ашиглах (чанарт нийцүүлэн), хаягдалгүй ажиллах
- Голын эрэг, эхийн ургамалжилт, уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээх
- Шинээр ус цэвэршүүлэх, дахин ашиглах барилга байгууламжид хөрөнгө оруулах буюу засаж сайжруулах. Гар худаг гаргах, засмал зам тавих зэргээр орон нутагт ундны ус ашиглах боломжийг сайжруулахын зэрэгцээ бэлчээр зохицуулалтгүй замын нөлөөгөөр талхлагдах нөлөөллийг бууруулах ач холбогдолтой.
- Илүүдэл ус зайлуулах, усанд автахаас сэргийлэх далан барих, суваг шуудуу гаргах (үер, гадаргын урсац, усны элэгдэл эвдрэл)

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага болоод төрийн захиргааны төв байгууллагын хоорондын уялдаа чухал. Орон нутагт усны барилга байгууламжийг сайжруулахад уурхайн компани, орон нутгийн удирдлага, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд түншлэлийн зарчмаар харилцан ашигтай ажилласан туршлага олон бий (Жишээ 1-ийг харах). Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлыг орон нутгийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулах нь түншлэл өгөөжтэй байхын үндэс болдог байна. Тухайн нэг голын сав газарт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн компаниуд хамтран орон нутагтай нийгмийн хариуцлагын дундын гэрээ байгуулах, олон талт түншлэл бий болгох замаар хуримтлагдах нөлөөллийг бууруулах үр дүнтэй хэлбэр юм. Түншлэлийн үр дүнд хяналт шинжилгээ, байгаль хамгааллын үйл ажиллагаанд хамтрах, хамтран санхүүжүүлэх боломжтой. Тухайлбал, Өмнөговь аймагт Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-ийн санаачилга дор компаниуд түншлэлийн зарчмаар усны менежментийг хэрэгжүүлж буйг дурдаж болно (Жишээ 2-ыг харах). Түүнчлэн Оюу Толгой ХХК, Энержи ресурс ХХК, АРЕВА Монгол ХХК зэрэг компаниуд усны чанар, нөөцийн хяналт шинжилгээний хөтөлбөрт талуудын оролцоог хангах арга барилыг амжилттай хэрэгжүүлж байгаа ба энэ нь компани орон нутгийн харилцаанд эерэг нөлөө үзүүлэхээс гадна, хамтын

Усны ХШ-нд ажиглалт хэмжилтийн ба өртөг багатай аргууд нь усны мэргэжлийн бус, ХШ хийхэд суралцаж буй уурхайн ажилтнууд, олон нийтийн төлөөлөлд заахад хялбар бөгөөд үр дүнтэй арга юм. Тухайлбал, Засгийн Газрын 326 дугаар тогтоолын хавсралтад заасан усны өнгө, үнэрийн ажиглалтыг пи-аш, цахилгаан дамжуулах чанар тодорхойлох зөөврийн, хэмжих хэрэгслүүдтэй хослуулбал жижиг дунд уурхайнуудад усны чанарын анхан шатны үнэлгээг газар дээр нь, бага өртгөөр, тогтмол хийхэд тохиромжтой. Мөн гар утасны камер ашиглан ажиглалтыг дүрсжүүлэх, газар зүйн байршил тогтоох зэрэгт тустай ба олон нийтийг усны ХШ-нд оролцуулах нэг хэлбэр юм. Гэхдээ компани мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих хэрэгтэй. Усны чанарын ХШ-нд үр дүнтэй өөр нэг арга бол Газарзүйн мэдээллийн Систем (ГИС) юм. ГИС-ийг голын хөндий, сав газарт ажиллаж буй ус ашиглагч, хэрэглэгчийн байршил тогтоох, газар ашиглалтын хэлбэрийг том зургаар харах, ХШ-ний төлөвлөгөө гаргах зэрэгт түгээмэл ашигладаг. Монгол орны усны нөөцийн мэдээллийг ГИС-д зурагласан байдлаар БОНХАЖЯ-ны харьяа Байгаль орчны мэдээллийн сангийн цахим хуудаснаас үзэх боломжтой (www.eic.mn).



Жишээ туршлагауд

Жишээ 1. Олон нийт-хувийн хэвшлийн түншлэл, дэд бүтцийн хөрөнгө оруулалт

Фрипорт Макмораны Серро Верде уурхай (зэс, молибден). Перу улсын хуурай гандуу бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг тус уурхай түүний ойр орших 300 гаруй мянган хүнтэй Арекуйпа хотын иргэдийн хувьд цорын ганц цэвэр усны эх үүсвэр болох Чили голоос ус ашиглах болсон. Үүний зэрэгцээ Чили гол хотын цэвэрлэх байгууламж чанарын шаардлага хангалтгүйн улмаас голын бохирдлын эх үүсвэр болсон байв. Компани нийгмийн хариуцлагын гэрээний дагуу орон нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудтай ярилцаж, санал нэгдсэнээр хотхонд ус цэвэрлэх, шүүх байгууламжийг өөрийн зардлаар барьж өгчээ. Уг байгууламжид хотын хаягдал усыг дахин боловсруулж, цэвэршүүлэхээс гадна, иргэдийн үндны болон хөдөө аж ахуйг усны хэрэгцээг хангадаг болов. Голын бохирдол багассан нь байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулсан байна.

Эх сурвалж: Уул уурхай метал боловсруулах салбарт сав газарт түшиглэсэн усны менежментийг хэрэгжүүлэх гарын авлага, ОУУМЗ, 2015. <http://www.icmm.com/document/8329>

Жишээ 2. Уул уурхай дах усны менежментийн сайн дурын кодекс (ОУСК-ийн санаачилга, 2015).

2015 онд ОУСК-иас Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумдын нутагт үйл ажиллагаа явуулж буй 8 компани “Усны менежментийн сайн дурын кодекс”-т нэгдсэн. Усны нөөц хомс (жилийн дундаж хур тунадас <60 мм), уул уурхай олноор төвлөрсөн нутагт компаниуд хамтран уурхайн үйл ажиллагаанаас усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хяналт тавих, ХШ хийх, мэдээлэл солилцох нь усны менежементийг илүү үр дүнтэй болгох юм. Энэхүү санаачилга нь сав газрын ус хэрэглэгч, ашиглагч талуудыг хамарч чадсанаараа УННМ-ийг хэрэгжүүлэх үйл явцад чухал ач холбогдолтой.

Санаачилгад компаниуд нэгдэх нь дараах зүйлд эерэгээр нөлөөлнө:

- Байгаль орчны ХШ, ил тод, бодитой тайлагнах
- Тогтмол ХШ хийх, мэдээлэл солилцох
- Орон нутгийн оролцоо
- Компанийн төлөөлөл харилцан мэдээлэл, туршлага солилцох, олон талын байр сууринаас зөвшилцөх (нийгмийн болоод байгаль орчны)
- Олон талт уулзалт, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах (Өмнийн говийн ус ба уул уурхай)

Эх сурвалж: ОУСК. 2014. Ус, уул уурхай, олон нийт.

https://commdev.org/userfiles/IFC_140201_Water%20Mining%20Communities_0519c%20web.pdf

Жишээ 3. Усны ХШ-ний хөтөлбөрт орон нутгийн иргэдийн оролцоо

Рио Тинто ХХК-ний Оюу Толгой уурхай олон нийтийн оролцоотой байгаль орчны ХШ-ний хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин иргэдтэй хамтран усны ХШ хийдэг. Уурхайгаас иргэдийг зохих багаж хэрэгсэл (GPS, фото аппарат, метр)-ээр хангах, эдгээрийн ашиглан хэмжилт хийх аргад дадлагажуулдаг. Иргэдийн цуглуулсан мэдээллийг уурхай өөрийн хэмжилттэй нэгтгэн мэдээллийн санг баяжуулдаг байна. Уурхайн байгаль орчны ажилтнууд малчдаас орчны төлөв байдал, уур амьсгал, ан амьтан ургамлын тухай хэвлэсэн ном материалд бүртгэгдээгүй мэдээллийг олж авах замаар суралцдаг. Хяналт шинжилгээ хийхэд оролцсоноор малчид бэлчээр, ус, уур амьсгалд гарч буй өөрчлөлт, түүнд хүний болон байгалийн хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлдөг тухай шинжлэх ухаанаар батлагдсан мэдээлэл олж авах, суралцах давуу талтай. Хэмжилтээр гарч буй үр дүнг сум, багийн хурал дээр олон нийтэд нээлттэй танилцуулдаг заншил тогтжээ.

Эх сурвалж: <http://ot.mn/participatory-environmental-monitoring/>; УСК. 2014. Ус, уул уурхай, олон нийт.

https://commdev.org/userfiles/IFC_140201_Water%20Mining%20Communities_0519c%20web.pdf

Асуулт, хэлэлцүүлэг

<ul style="list-style-type: none"> • Танай сум, сав газарт ус хэрэглэгч, ашиглагч талуудыг нэрлэнэ үү? • Танай орон нутагт усны нөөцийг хариуцлагатай ашиглах, хэрэглэхэд дутагдаж буй хамгийн чухал зүйл юу вэ? • Танай орон нутагт уурхайн компани, орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллага, иргэд хамтран шийдэж болох устай холбоотой нэг асуудлыг нэрлэнэ үү? Үүнд талуудын гүйцэтгэх үүргийг нэрлэнэ үү? 	
<p>Унших ном, материал</p> <p>Усны үнэ, тариф, төлбөрийн тооцох гарын авлага, Усны газар (хуучин нэрээр), 2012. http://www.riverbasin.mn/</p> <p>Уул уурхай метал боловсруулах салбарт сав газарт түшиглэсэн усны менежментийг хэрэгжүүлэх гарын авлага, ОУУМЗ, 2015 (Англи) https://www.icmm.com/document/8329</p> <p>Ус, уул уурхай, олон нийт: Тогтвортой усны менежментийг хэрэгжүүлж хамтын үнэт зүйлийг бий болгох нь, ОУСК, 2014 (Англи) https://commdev.org/wp-content/uploads/2015/06/Water-Mining-and-Communities-Discussion-Draft.pdf</p>	
<p>Үндсэн нэр томъёо, ойлголтуудын тайлбар</p> <p>Сав газар – газрын гадарга дээрх гол мөрөн, хур тунадас, цас мөсний хайлалтаас урсан нэг цэгт буюу нам дор газарт хураагдан, өөр нэг гол, уст цэгт (нуур, намаг, далай тэнгис) цутгах газар.</p> <p>Уурхайн ухаш, хонхор газар – дүүргэлт, нөхөн сэргээлт хийгдээгүй хотгор газар, нүх, сүв.</p> <p>Тунгаах сан, тунгаагуур – илүүдэл усыг түр хугацаанд хадгалах, холилдлсн чулуу, шороо, хатуу биетүүдийг усны ёроолд тунгаах цөөрөм.</p> <p>Шүүрэл – уурхайн хаягдал, овоолго, хөрсний нүх сүвүүдээс шүүрэн хөрс, гадаргын усанд нэвчих ус</p> <p>Усгүйжүүлэлт – хөрс (гүний ус) болон уурхайн хаягдлаас шүүрэх усыг шахуургаар татан зайлуулж, тунгаагуур болон нуур цөөрөм үүсгэн хадгалалт хийх</p> <p>Усны тэнцвэржүүлэлтийн тооцоо – гадаргын болон гүний усны боломжит нөөцийг одоогийн болон ирээдүйд ашиглах хэрэгцээнд харьцуулах тооцоо, үнэлгээ.</p> <p>Уурхайн талбарын усны менежмент – уурхайн үйл ажиллагаанд ашигласан буюу хаягдал усны ялгарал орчин тойрныг бохирдуулахаас сэргийлэх хөрс, усны хосолсон менежментийн арга.</p> <p>Уурхайн усны хаягдал – эрдсийн боловсруулалт, хөргөлт гэх мэт талбарт ашигласан усыг зайлуулах.</p> <p>Гүний усны нөхөн төлжилт – газрын гадаргаас хөрсний үе давхаргууд руу доошоо чиглэлтэй явагдах</p>	

гидрологийн үйл явц

Бохирдуулагч төлөх зарчим –стандарт, нормд зөвшөөрсөн хэм, хэмжээг хэтрүүлэн, нийгэмд хохирол үзүүлсэн бол түүнийг бууруулахад шаардагдах нөхөн төлбөрийг бохирдуулагч бүрэн хариуцна.

МОДУЛЬ 8. УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Сургалтын зорилт

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Нөхөн сэргээлтийг уурхайн амьдралын мөчлөгтэй уялдуулан, системтэйгээр төлөвлөхийн ач холбогдол
- Нөхөн сэргээлтийн зорилго, зорилтууд, биелэлтийг үнэлэх итгэлцүүрүүдийг зөв тодорхойлох
- Уурхайн хаалтын төлөвлөгөөтэй уялдуулан нөхөн сэргээлтийг хийх үндсэн үе шатууд
- Мэдээлэл хаанаас авахаа мэддэг болох

Удиртгал

Дэлхийн улс орнуудад уурхайг зохих шаардлагын дагуу хаагаагүй орхисон эсхүл санхүүжилт дутсанаас нөхөн сэргээлт бүрэн хийгдээгүй жишээ олон бий. Уурхайн нөхөн сэргээлтийг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу, тогтмол хяналт шинжилгээ хийж бүрэн, төгс гүйцэтгэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн шаардлага юм. Нөхөн сэргээлт бол уурхайн амьдралын түршид шат дараатай үргэлжлэх үйл явц байдаг. Энэхүү модулиор нөхөн сэргээлтийн үйл явцыг төлөвлөх, гүйцэтгэх үндсэн дараалал, үе шатуудтай танилцана. Хичээлийн эхний хэсэгт нөхөн сэргээлтийг амжилттай гүйцэтгэхэд төлөвлөлтийг хэрхэн хийх, анхаарах зүйлсийн талаар ярих бол хоёрдугаарт хэсэгт, нөхөн сэргээлтийг гүйцэтгэх үйл явц, хяналт шинжилгээ хийх тухай танилцуулна.

Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Уурхайн хаалт ба уурхайлсан газрын нөхөн сэргээлт
- Нөхөн сэргээлтийн төлөвлөлт
- Хаалтын дараах газар ашиглалт
- Нөхөн сэргээлтийн гүйцэтгэл ба олон нийтийн оролцоо
- Санхүүгийн баталгаа
- Хяналт шинжилгээ (ХШ)

Жишиг хуваарь

- Уурхайн нөхөн сэргээлт: төлөвлөлт, санхүүгийн баталгаа (30 минут)
- Нөхөн сэргээлтийн үйл явц (20 минут)
- Бүлгийн ажил: биологийн нөхөн сэргээлт хийх дараалал (10 минут)
- Нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ (10 минут)
- Бүлгийн ажил: нөхөн сэргээлтийн төлөвлөлт (10 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (5 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл

Уурхайн нөхөн сэргээлт: Төлөвлөлт, санхүүгийн баталгаа (30 минут)

Уул уурхай бол тодорхой хугацаанд газар ашиглах хэлбэр. Бүх уурхай хэзээ нэгэн цагт хаагддаг бөгөөд зарим тохиолдолд эдийн засгийн, нийгмийн, байгаль орчны хүчин зүйлүүдийн нөлөөгөөр төлөвлөснөөс эрт хаагдах нь бий (Модуль 1-ийг харах). Уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрс, ургамлын нөмрөгийг сэргээх, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх, уурхайн газрыг дараагийн газар ашиглалтын хэлбэрт шилжүүлэх зорилготой.

Уурхайн хаалт гэдэг нь уурхайн үйл ажиллагаа бүрэн зогсож, уурхайд ашиглагдсан талбайг эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөхийг хэлнэ. Уурхайг хаах үйл явцад эрдэс боловсруулах үйлдвэр, байгууламжийн үйл ажиллагааг зогсоох, барилга байгууламжийг нүүлгэх, уурхайн үйл ажиллагаанд өртсөн газрыг нөхөн сэргээх зэрэг багтана. Эдгээрийн хэрэгжүүлэх үйл явц тухайн улс орны хууль, тогтоомжийн дагуу явагдана.

1960-аад оноос эхлэн аж үйлдвэржсэн орнуудын засгийн газар, байгаль хамгааллыг дэмжигчид уурхайн үйл ажиллагаагаар бохирдон, доройтсон газрыг “цэвэрлэх”, унаган төрхөнд нь буцаан оруулах шаардлагыг тавьж эхэлсэн. Өнөөдөр дэлхийн улс орнууд уул уурхайгаас үүдэлтэй сөрөг үл мөр, үр дагавараас сэргийлэхийн тулд хууль эрхзүйн орчныг чангатган, сайжруулахад анхаарах болжээ. Уул уурхай ашиглалтын олон жилийн түүхтэй Канад, Австрали зэрэг орнууд уурхайн хаалтыг зохицуулах тусгайлсан хуультай байдаг. Харин Монгол зэрэг хөгжиж буй орнуудад уурхайн хаалтын асуудлуудыг төрийн захиргааны хэд хэдэн салбар нэгжийн оролцоо, хуулийн заалтуудаар зохицуулж байна.

Жишээ слайдууд

Уурхайн нөхөн сэргээлтийн зорилго



2015 оны байдлаар Монгол орны нийт уурхайн үйл ажиллагаанд өртсөн газарт хийх нөхөн сэргээлтийн биелэлт 20 гаруй хувьтай байна (БОНХАЖЯ, 2015).

Монгол орны хувьд, 2014 оны Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөлтийг хийх, уурхайн компаниуд байгаль орчны мэргэжлийн ажилтантай байх зэргийг хуульчилж өгсөн. Уг хуулийн 38 дугаар зүйлд тухайн жилийн БОМ Төлөвлөгөөнд заасан нөхөн сэргээлтийг заасан хугацаанд хийгээгүй уурхайн үйл ажиллагааг сум, дүүргийн холбогдох эрх бүхий этгээд зогсоох эрхтэй. Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдах нь нөхөн сэргээлт хийх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан (39 дүгээр зүйл). Байгаль орчныг бохирдуулсан, бохирдлыг цэвэрлэхээс зайлсхийсэн иргэн, аж ахуйн нэгжийг байгаль орчны тогтвортой байдлын эсрэг санаатай үйлдсэн гэмт хэрэг гэж үзэн, эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүртэл арга хэмжээ авна (Эрүүгийн хуулийн 24.1-24.4, 24.9 дүгээр зүйл, 2015).

Уурхайлсан газрын нөхөн сэргээлт (буюу түгээмэл хэллэгээр *уурхайн нөхөн сэргээлт* гэдэг)-ийн ерөнхий зорилго нь уурхай хаагдсаны дараа уурхайн үйл ажиллагаанд өртсөн газар:

- Хүн амьтны амьдрах орчинд аюул учруулахгүй
- Элэгдэл эвдрэл, байгалийн үзэгдэлд (үер, газар хөдлөлт) тогтвортой, тэсвэртэй
- Бохирдол үүсгэхгүй
- Эдийн засгийн бүтээмжтэй байх зэрэг нөхцөлүүдийг хангах юм.

(Эх сурвалж: Уурхайн хаалт болон үйл ажиллагааг бүрэн дуусгах нь, Австралийн Хамтын Нөхөрлөл, 2006. <http://www.industry.gov.au/resource/Documents/LPSDP/LPSDP-MineClosureCompletionHandbook.pdf>)

Уурхайн нөхөн сэргээлтийг эртнээс нарийвчлан төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх, тогтмол хяналт шинжилгээ (ХШ) хийх нь нөхөн сэргээлтийг бүрэн, төгс гүйцэтгэхийн үндэс болно. Нөхөн сэргээлт бол уурхайн амьдралын туршид тодорхой шат дараатай хийгдэх үйл явц байдаг.

Нөхөн сэргээлтийн төлөвлөлт

Уурхайн нөхөн сэргээлтийг эртнээс төлөвлөх нь үүнд шаардагдах хөрөнгө, хүч, цаг хугацаа, нөөц боллоцоог бодитой тооцон нөхөн сэргээлтийг амжилттай төгс гүйцэтгэхийн үндэс юм. Уурхайн нөхөн сэргээлтийг зөвхөн уурхайн олборлолт явагдсан газарт төдийгүй геологи, хайгуулын ажил явагдсан



газарт хийгдэх ёстой.

Нөхөн сэргээлтийн төлөвлөлт бодитой, тухайн уурхайн орчны онцлог нөхцөл байдалд тохирсон нөхөн сэргээлтийн зорилтыг тодорхойлохоос эхэлнэ. Тавьсан зорилтуудын биелэлтийг нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн итгэлцүүр буюу нөхөн сэргээлтийн явцыг үнэлэх үзүүлэлт, хаалтын нөхөн сэргээлтийн шалгуур үзүүлэлтүүдээр үнэлнэ.

Нөхөн сэргээлтийн зорилтууд нь нарийвчилсан, тодорхой бөгөөд биелэлтийг үнэлэх хэмжүүртэй байх ёстой. Ерөнхийдөө уурхайн үйл ажиллагаанд өртсөн газрын нөхөн сэргээлтийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж болно.

- Хууль, тогтоомжийн шаардлагад нийцүүлэх
- Геотехникийн тогтвортой байдлыг хангах
- Байгалийн унаган төрхийг сэргээх
- Уурхайн үйл ажиллагаанаас өмнөх газар ашиглалтын хэлбэрийг сэргээх
- Өмнөхөөсөө илүү бүтээмжтэй газар ашиглалтын хэлбэрийг бий болгохыг хичээх
- Орон нутагт үзүүлэх нийгмийн нөлөөг бууруулах

(Эх сурвалж: Канадын хайгуулч, олборлогчдын холбоо. И-3 Плас: Хариуцлагатай геологи хайгуулын ажил явуулах хүрээ <http://www.pdac.ca/programs/e3-plus>)

Олборлолт явуулж буй уурхайд нөхөн сэргээлтийн зорилго, зорилтыг хэрхэн тодорхойлсныг Австралийн БиЭйчБи Билитон компанийн Маунт Артур нүүрсний уурхайн жишээнээс харж болно. Үүнд:

Зорилго	Зорилтууд
Хаалтын дараа уурхайн ажил хийгдсэн газарт бохирдол үүсгэхгүй орчин, гадаргын хэв шинжийг	<p>Нөхөн сэргээсэн газар орчин тойрны байгалийн жамаараа орших экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх. Дараах байдлаар сөрөг нөлөөлөл үзүүлж болно:</p> <ul style="list-style-type: none">• Усны чанар (үрсгал ус, уст цэг, газрын доорх ус);• Газар зохион байгуулалт (хог ургамал ургах, байгалийн түймэр, зэрлэг амьтан)• Агаарын чанар (салхиар тоосжилт үүсэх) <p>• Хаалтын дараа нөхөн сэргээсэн газар орчин тойрны байгалийн жамаараа орших гадаргын төрх, хэлбэртэй жигдхэн ижилсэж байх</p> <p>• Аюултай болон бохирдуулагч материалыг тухайн орчноос зайлуулах буюу нөхөн сэргээсэн газарт</p>

бүрдүүлэх	зохих арга, технологийн дагуу хадгалах, түүнээс орчны экосистемд ямар нэг сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх.
Нөхөн сэргээсэн газар бүтцийн хувьд тогтвортой байх	<ul style="list-style-type: none"> • Хаалтын дараа нөхөн сэргээсэн газар хүн, амьтны амьдрах орчинд аюулгүй, гадаргын элэгдэл эвдрэлийн зэрэглэл тухайн орчинд байгалийн тогтоцоороо орших гадаргын хэлбэрүүдтэй (дов толгод, нам дор газар) ижил байх • Уурхайн хатуу хог хаягдлыг нөхөн сэргээлт хийж буй газарт нэгтгэн хэлбэршүүлэх, бүтцийн хувьд тогтвортой, бохирдол үүсгэхгүй байх • Хаалтын дараа нөхөн сэргээсэн газарт үлдэх уурхайн ухаш, нүх зэрэг нь хүн, амьтанд аюул учруулахгүй, бүтцийн хувьд тогтвортой, бохирдол үүсгэхгүй байх • Хаалтын дараах газар ашиглалтын зориулалт, хэлбэрийг холбогдох талуудын хүсэл сонирхлыг харгалзан тогтоох
Нөхөн сэргээсэн газар хаалтын дараах газар ашиглалтын төлөвлөгөөтэй нийцэж байх	<ul style="list-style-type: none"> • Хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг сонгохдоо орчин тойрны газар ашиглалтын зориулалт/хэлбэртэй ижил байх, бүс нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, стратегитэй уялдах байдлыг хангана • Нөхөн сэргээлтээр бий болгохоор сонгосон газар ашиглалтын хэлбэр нь тухайн орон нутаг, мужийн хувьд нийгэм, эдийн засгийн үр ашигтай байх • Хаалтын дараах газар ашиглалтын зориулалт, хэлбэрийг сонгоход талуудыг оролцоог бүрэн хангах гэх мэт.

(Эх сурвалж: БиЭйчБи Биллитон. Маунт Артур нүүрсний уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөө 2015. http://www.bhpbilliton.com/~media/bhp/documents/society/regulatory/_coal/nswec/mt-arthur_coal/150902_coal_nswec_rehabilitation-management-plan--mining-operations-plan.pdf?la=en)

Уурхайн нөхөн сэргээлтийг хийхэд талбарын бүрэлдэхүүн хэсгүүдийг нөхөн сэргээх ялгаатай байж болно. Тухайлбал, овоолгыг ургамалжуулах, уурхайн ухашыг хэвээр үлдээх, гүний уурхайн нүх, цооногуудыг дүүргэлт хийн битүүмжлэх гэх мэт. Уурхайн нөхөн сэргээлт хийх гэдэгт дараах нэгж хэсгүүдийг хамруулж үзнэ:

- Хурдас чулуулгийн овоолго
- Ил уурхайн ухаш (карьер)
- Далд уурхайн ашиглагдсан орон зай
- Цөмрөл, хагарлын бүс, нуралтын хонхор
- Шлам, тунгаагуур, цөөрмүүд, хаягдлын агуулах
- Нуруулдан уусгалтын овоолго
- Хаягдлын байгууламж

- Асгадас, далан, суваг шуудуу
- Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн орчны талбай
- Уурхайн гадаад, дотоод тээврийн замууд
- Уурхайн туслах байгууламжууд (засварын цех, машины зогсоол гэх мэт)

Уурхайн олборлолтын арга, технологиос хамаарч нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө, үйл явц харилцан адилгүй байна. Тухайлбал, алтны шороон ордууд ихэвчлэн 30-50 см гүнд, газрын гадаргад сунаж тогтсон байдаг тул үхалт хийсэн хөрсийг боловсруулж дуусмагц тухайн газрыг хэлбэршүүлэх, ургамалжуулах үйл явц уурхайн үйл ажиллагаатэй зэрэгцэн явагдах боломжтой. Хэрэв уурхайн талбарт ухаш, хаягдал хураах сан, овоолго (жишээ нь алтны үндсэн орд) зэрэг бүрэлдэхүүнүүд хамаарах бол нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэхэд хугацаа, нэмэлт ажиллагаа шаардлагатай. Учир нь уурхайн олборлолт явагдахын хэрээр эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн хэлбэр, хэмжээ, эзлэхүүн тогтмол өөрчлөгдөж байдаг. Тиймээс уурхайн талбарын бүрэлдэхүүн хэсгүүдээс хамаарч нөхөн сэргээлтийн зорилт, гүйцэтгэх арга, хаалтын дараах газар ашиглалтын хэлбэр харилцан адилгүй байдгийг уурхайн барилгажилтын үе шатанд талуудад таниулах шаардлагатай.

Хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг тодорхойлоход олон талт үүлзалт хэлэлцүүлэг зохион байгуулж тус газрыг хүлээн авах орон нутгийн удирдлага, олон нийтийн саналыг тусгана. Олон талт хэлэлцүүлэгт компаниас уурхайн менежер, инженер, гидрологич, байгаль орчны ажилтан, олон нийттэй харилцах ажилтан нарыг оролцуулах нь бодитой, шийдвэр гаргахад тустай. Компани уг хэлэлцүүлэг, ярилцлагыг удирдан явуулахын сацуу шийдвэр гаргахад тухайн нутаг орны эдийн засаг, нийгэм, түүх соёлын үнэт зүйлсийг хүндэтгэнэ.

Монгол орны цаг уур, нийгэм эдийн засгийн онцлогт хаалтын дараах нөхөн сэргээсэн газрыг ашиглах дараах хэлбэрүүд байх боломжтой:

- Хөдөө аж ахуйн чиглэл (Бэлчээр, хадлан, тариалангийн талбай болгох)
- Ойн аж ахуйн (Аж ахуйн зориулалтаар болон хамгаалалтын зурвас үүсгэн ойжуулалт хийх, мод үржүүлгийн газар, үрсэлгээний талбай байгуулах)
- Усны аж ахуйн (Ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, тариалангийн талбайн усжуулалт, усан спортын болон эрүүлжүүлэх зориулалттай усан сан, загасны аж ахуйн зориулалттай усан сан байгуулах)

Жишээ: Эрээн нүүрсний уурхайн бүрэн нөхөн сэргээлт



Дээрхээс гадна тусгай зориулалтаар:

- Амралт сувилал, спорт (Соёл, амралтын хүрээлэн, аялал жуулчлалын бааз, амралт, сувиллын барилга байгууламж, биеийн тамир спортын цогцолбор барьж байгуулах)
- Байгаль хамгаалал (Ойжуулалт, ургамалжуулах, ногоон байгууламж байгуулах)
- Барилга байгууламж (Үйлдвэрлэлийн, иргэний болон бусад төрлийн барилга байгууламж болон уулын чулуулаг, барилгын хог хаягдал, баяжуулалтаас үүссэн хаягдал хадгалах байгууламжийг барьж байгуулах)

Ерөнхийдөө орон нутгийн удирдлага, олон нийт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг уурхай ажиллаж эхлэхээс өмнөх газар ашиглалтын хэлбэрээр үргэлжлүүлэх ашиглах сонирхолтой байдаг (жишээ нь бэлчээр, газар тариалан). Гэхдээ талууд нөхөн сэргээсэн газрыг аялал жуулчлал, амралт зугаалгад ашиглах буюу өмнөхөөс өөр хэлбэрээр газар ашиглахаар шийдсэн тохиолдол олон бий. Жишээ нь, Уэлсийн Блинавон нүүрсний уурхайн хотхонд ил уурхайн ухаш, гүний уурхайн цооногууд, нүүрс тээвэрлэх төмөр замын сүлжээ зэргийг соёлын өвд бүртгүүлсэн бөгөөд хаагдсан уурхайн талбар одоо гүний уурхайн аялал, музей, спортын олон төрөлт талбай бүхий аялал жуулчлал, танин мэдэхүйн цогцолбор болжээ.

Эх сурвалж: Уурхайн нөхөн сэргээлт ба хаалт – Дэлхийн Соёлын Өвд бүртгэлтэй, дэлхийн хамгийн хурдан дүүжин гулсуур байдаг газраас бид юу сурч болох вэ? 2010 <http://www.astron.com.au/news/mine-rehabilitation-and-closure-world-heritage-site/>

Түгээмэл тархацтай ашиг малтмалын уурхайн нөхөн сэргээлтийн туршлагауд

Канадын Онтарио мужийн Пуслинч дэх Капитал Пэйвингийн элс, хайрганы уурхай

Тус уурхайгаас нь олборлолтын явцад ухалт хийсэн газраа газар тариалангийн зориулалтаар нөхөн сэргээлтийг зэрэгцүүлэн хийж болдгийг харж болно. Компани нөхөн сэргээсэн талбайд ойжуулалт, хадлан, бэлчээрийн талбай байгуулж, адууны аж ахуй эрхэлдэг болсон байна. Уг орчны хөрс нь үржил шим муутай, хуурай, хайргархаг бүтэцтэй. Нөхөн сэргээлтийн явцад шимт хөрсөөр хучилт хийж, царгас, гэрийн хошоонгор, соргүй согоовор, дурваалиг зэрэг ургамлыг хослуулан тариалсан ба жилээс жилд ургацын гарц өсөн нэмэгдэж байгаа ажээ. Компанийн нөхөн сэргээлтийн ажлыг Канадын Чулуу, Элс, Хайрганы Холбооноос өндрөөр үнэлж 2003 оны шилдэг нөхөн сэргээлт хийсэн газраар өргөмжилсөн.

Английн Глоусистишейр мужийн Хантсман шохойн чулууны уурхай

Котволд Хиллсд байрлах 70 гаруй жилийн түүхтэй уг уурхай нь Английн байгалийн хамгийн үзэсгэлэнтэй, байгаль экологийн онцгой ач холбогдолтой нутагт оршдог. Тус уурхай хөрснөөс шохойн чулууг ялган авсны дараа үхсэн газрын талыг хүртэл шороогоор дүүргэлт хийж, дээрээс нь өнгөн буюу үр шимт хөрсөөр хучилт хийнэ. Уурхайн орчинд улаан буудай, арвай, бусад үет ургамлуудыг голлон тариалдаг бөгөөд нөхөн сэргээлт хийсэн талбайг газар тариаланд ашиглах зорилготой. Уурхайн тариалсан арвай 2009 оны 8 сараас эхлэн ургацаа өгч эхэлжээ. Хантсманы уурхай нөхөн сэргээлтийн ажлынхаа хүрээнд биологийн төрөл зүйлийг хамгаалах, ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах, тэдгээрийн амьдрах орчныг сэргээхэд байгалийн дурсгалт газрыг сэргээн сайжруулж байна.

(Эх сурвалж: С.И.Юндт лимитэд. Шилдэг нөхөн сэргээлт хийсэн газрууд, 2010.

http://www.toarc.com/pdfs/Outstanding_REHAB_RECLAIM_July2010_.pdf)

Нөхөн сэргээлтийн зорилтууд биелж буй эсэхийг хянахын тулд нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн итгэлцүүр байх хэрэгтэй. Нөхөн сэргээлтийн итгэлцүүрүүд дараах шинж чанартай байх ба эдгээрийг нөхөн сэргээлтийн төлөвлөлтийг хийх явцад сонгон авна. Дараах төрлийн итгэлцүүр байж болно.

- Физикийн: нөхөн сэргээлт хийсэн газрын бүтцийн тогтворжилт, элэгдэл эвдрэлд тэсвэртэй байдал, ус нэвтрүүлэх чанар гэх мэт
- Биологийн: ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын нөмрөгийн бүрхэц, нягтшил, үрийн гарц, амьтдын шилжин ирэлт, хог ургамлын хяналт, газрын үржил шим, хөрсний шим тэжээлт бодисуудын эргэлт, шүүрлийн усны чанарын стандарт гэх мэт.
- Хууль, эрхзүйн орчны: олон нийтийн аюулгүй байдал, хуулийн шаардлага, талуудын сэтгэл ханамж гэх мэт.

Эдгээр итгэлцүүрүүдийг уурхайн аюулгүй байдал, хөрс, усны чанар, ургамалын аж ахуйн тухай хууль, стандарт, зөвлөмжүүд, судалгаа шинжилгээний эх сурвалж дээр үндэслэн сонгон авна. Монгол орны хувьд нөхөн сэргээлтийн итгэлцүүрийг сонгоход дараах стандартууд, аргачлалыг ашиглана:

- MNS 5850:2000. Хөрсний чанарын үнэлгээ.
- MNS 5916:2008. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт.
- MNS 5918:2008. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 5917:2015. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал (БОНХАЖЯ, 2015).

Төлөвлөлтийн өөр нэг чухал хэсэг бол нөхөн сэргээлт бүрэн төгс гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт байна. Уурхайн нөхөн сэргээлтийн зорилтууд бүрэн биелж, уг газрыг төрд хүлээлгэн өгөх шаардлага хангагдсан эсэхийг шалгуур үзүүлэлтүүд шийднэ. Шалгуур үзүүлэлтүүдийг байгаль орчны мэргэжилтэн, экспертүүд, холбогдох төрийн байгууллагын төлөөллүүдийн оролцоотой тогтооно. Ингэхдээ тухайн уурхайн явагдаж буй орон нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн онцлогтой уялдах, нийцэх байдлыг харгалзана.

Уурхайн бүрэн нөхөн сэргээлт хийж, хаалтын дараах хяналт шинжилгээ явуулж буй туршлага

Пийбоди энэржи ХХК-ний Эрээний нүүрсний уурхай

Уурхай Монгол орны төв хэсэг, бэлчээр, газар тариалангийн үржил шимтэй хөрс бүхий Булган аймгийн Сайхан сумын нутагт байрладаг. Эрээний уурхайн нөхөн сэргээлтээс хаалтын дараах газар ашиглалтын төлөвлөлтийн дагуу нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн итгэлцүүр, хаалтын шалгуур үзүүлэлтийг тогтоон, үүний дагуу ХШ-г хэрхэн явуулдгийг харж болно. Компани уурхайн үйл ажиллагаагаар элэгдэж эвдэрсэн газрыг бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээхээр төлөвлөсөн. Техникийн нөхөн сэргээлтэнд газрыг орчны гадаргын хэв шинжтэй ижилсүүлэн, тухайн орчинд дасан зохицсон бэлчээрийн унаган ургамлуудыг байгалийн үрээр тариалсан нь амжилттай болсон байна. Уурхайн нөхөн сэргээлт 2009 онд эхэлснээс хойш нийт 18 га газар нөхөн сэргээлт гүйцэтгэн, орон нутгийн иргэдэд газрыг хүлээлгэн өгчээ. 2015 оны байдлаар компани нөхөн сэргээсэн газарт ургамлын нөмрөгийн бүрхэц, унаган ургамлын ургалт, ан амьтны эргэн ирэлт зэрэг үзүүлэлтүүдийг уурхайн ажилд хөндөгдөөгүй орчныхтой харьцуулан, байнгын ажиглалт, хэмжилт хийдэг.

Эх сурвалж: <https://www.ieca.org/membersonly/cms/viewabstract.asp?AbstractID=695>

Санхүүгийн баталгаа

Уурхайн компаниуд байгаль орчин, нийгмийн хариуцлагын дагуу эвдэрсэн газрыг бүрэн нөхөн сэргээж, төрд хүлээлгэн өгөх баталгаа болох нөхөн сэргээлтэд шаардагдах зардалтай дүйцэх санхүүгийн баталгаа гаргадаг. Санхүүгийн баталгааны мөнгөн дүнгийн бодит хэмжээг зөв тооцоход нөхөн сэргээлтийн зорилт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд үндсэн хүчин зүйлүүд болно. Дэлхийн улс орнуудад төр явцын (тухайн жилийн) нөхөн сэргээлт төдийгүй уурхайн төлөвлөсөнөөс эрт хаагдах тохиолдолд (шалтгаануудыг Модуль 1-ээс харах) уг газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай зардлыг тооцох, санхүүгийн баталгаа гаргах янз бүрийн загварууд ашиглаж байна. Эдгээр загваруудаас хамгийн түгээмэл ашиглагдаж байгаа нь гуравдагч этгээдийн баталгаа, санхүүгийн байгууллагуудаас гаргасан бонд, бэлэн мөнгө байршуулалт,

зээлийн бичиг болно. Загвар бүр давуу болон дутагдалтай талтайг доорх жишээнээс харж болно.

Түгээмэл загварууд	Ажиллах зарчим	Давуу тал	Дутагдалтай тал
Гуравдагч этгээдийн баталгаа	Үүнд нөхцөлт бус банкны баталгаа, даатгалын бонд багтана. Эдгээр нь нөхцөлт бус буюу буцалтгүй баталгаа байна.	<ul style="list-style-type: none"> • Уурхайн компанийн хувьд баталгаа гаргуулахад харьцангуй хямд (нийт дүнгийн 1-1.5%) • санхүүгийн институт зардлыг бүрэн хариуцна ('шаардлагатай үед' л хөрөнгө гаргана) • Ил тод, уурхайн үйл ажиллагааны онцлогт тохирсон • Баталгаа гаргагч ганцаараа баталгаанаас татгалзах эрхгүй • Тавигдах шаардлага өөрчлөгдөхөд баталгааны нөхцөл өөрчлөгдөнө 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн институт эргэлтийн хөрөнгийн тодорхой хэсгийг барьцаалах тул үйл ажиллагааны зардал хумигдах талтай • “жижиг” компаниудад олддоггүй
Бэлэн мөнгө байршуулалт	Мөнгөн хөрөнгийг Төрд тушаах ба энэ нь ихэнхдээ “жижиг” компаниудын хувьд боломжтой	<ul style="list-style-type: none"> • Төр байршуулсан мөнгөн хөрөнгийг дангаар захиран зарцуулах, шаардлагатай үед хөрөнгө гаргах давуу талтай • Уурхайн хаалттай холбоотой ажил бүрэн хийгдсэн бол хөрөнгийг компанид буцаан олгоно 	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгийг бэлнээр урьдчилан гаргахад уурхайн компанид санхүүгийн чадавх сул байх, хөрөнгөнд тооцогдох хүүгийн төлөлтөөс орлого багасах зэрэг асуудал гардаг • Уурхайн компани дампуурвал мөнгөн хөрөнгийг компанийн хөрөнгө гэж үзэн зээлдүүлэгч хураан авах боломжтой эсхүл мөнгөн хөрөнгө нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэхэд хангалтгүй байх • Төр хөрөнгийг тусгаарлан, бусад данснуудтай холихгүй, зөвхөн заасан зорилгод хөрөнгийг зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай

Зээлийн бичиг	Гуравдагч этгээдийн баталгаатай төстэй, ихэнхдээ 1 жилийн хугацаанд хүчинтэй, үүнийг баталгаа гаргагчийн шийдвэрээр сунгах бололцоотой. Сунгалт хийгээгүй тохиолдолд хүлээн авагч (төр) нийт өртгийг бүүруулж болно.	Уурхайн компанийн хувьд баталгаа гаргуулахад харьцангуй хямд	<ul style="list-style-type: none"> • Зээлийн хугацаа дуусахад баталгаа гаргагч талын сонирхлоор татгалзаж болно. • Компанийн бусад төрлийн зээлэнд хамрагдах боломжийг хязгаарлах 		
---------------	--	--	---	--	--

(Эх сурвалж: Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санхүүгийн баталгаа, Судалгааны тайлан, ОУУУМЗ, 2005; Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн санхүүгийн баталгаа, Зөвлөмж, ОУУУМ, 2006)

Монгол орны хувьд “бэлэн мөнгө байршуулах” буюу төрийн тусгай дансанд барьцаа хөрөнгө байршуулах хэлбэрээр уурхайн нөхөн сэргээлтийг хийх санхүүгийн баталгааг гаргадаг. Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн БОМТ-нд тусгасан үйл ажиллганы нийт зарлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг сум дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд (‘тусгай данс’) байршуулна. Олборлолт, ашиглалт явагдаж буй уурхайн хувьд дээрх барьцаа хөрөнгийг уурхайг хаах хүртэл, жил бүр тусгай дансанд төвлөрүүлнэ (БОНБҮ-ний тухай хууль, 2012, 9.9-9.10 зүйл). Нөхөн сэргээлт төлөвлөгөөний дагуу заасан хугацаанд бүрэн хийгдсэн бол барьцаа хөрөнгийг компанид буцаан олгоно. Тусгай дансны орлого, зарлагыг цахим орчинд байршуулах замаар олон нийтэд нээлттэй ил тод байх (Ил тод байдлын тухай Модуль 9-өөс дэлгэрүүлэн харах), хяналт тавих бололцоог хангана (БОНХАЖЯ-ны сайдын тушаал, А-04, 2014).

Тусгай дансанд байршуулсан хөрөнгийн зарцуулалтыг БОНХАЖЯ-наас 2014 онд баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-аар зохицуулна. Нөхөн сэргээлтийн барьцаа мөнгөн хөрөнгийг бүрдүүлэх, хуваарьлах, зарцуулах эрхийг Засаг даргын мэдүүлснээр тухайн аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал батална (Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13, 18 дугаар зүйл).

Гэвч дээрх хууль, тогтоомжийн заалтыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, уурхайн компаниудад зарим бэрхшээл, дутагдалтай талууд байсаар байна. Жишээ нь:

- Тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө нөхөн сэргээлт хийх, компанид буцаан олгогдохоосоо илүү орон нутгийн хөгжил, үйл ажиллагааны зардалд зарцуулагддаг
- Нөхөн сэргээлтэд шаардагдах зардлыг бодитой бус, хэт багаар тооцсон байх
- Орон нутгийн удирдлага компанийн БОМ Төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтэд тавих хяналт сул, үнэлгээ дүгнэлт өгч сайжруулах механизм бүрдээгүй
- Төрийн байгууллагуудын төв, орон нутаг дах нэгжийн хоорондын уялдаат хамтын ажиллагаа сул, үйл ажиллагааг тайлагнадаггүй
- Уурхайн компаниудын санхүүгийн статус ил тод бус

(Эх сурвалж: Үндэсний Аудитын Газар. Дундговь аймгийн аудитын тайлан, 2015)

Баруун Австралийн Уурхайн Нөхөн Сэргээлтийн Сан (УНСС)

Гурван жил гаруй хугацаанд засгийн газраас уул уурхайн салбарт хийсэн судалгаа, тоо баримт дээр тулгуурлан 2015 оноос УНСС-нг нэвтрүүлсэн. УНСС-нь тусгай зориулалтын сан бөгөөд бусад сан, даснуудтай холилдохгүй. Баруун Австралийн засгийн газар уг сангийн хөрөнгийн захиран зарцуулагч байх ба сангийн баланс, ногдол ашгийн хувь, зөв зарцуулалтыг хянах, санд орхигдсон болон орхигдож болзошгүй уурхайн нөхөн сэргээлтийг хийхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгийн төвлөрлийг хангах, холбогдох үйл ажиллагааны үрсгал зардлыг гаргах үүрэгтэй. Тус сангийн онцлог:

- Компани тухайн жилд уурхайн үйл ажиллагаанд өртөж, элэгдэж эвдэрсэн газрын тайлан гаргаж, түүнийг нөхөн сэргээхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийг УНСС-д төвлөрүүлнэ. Газрын элэгдэл эвдрэлийн зэрэглэл нь босго түвшнээс доогуур бол компанийг нөхөн сэргээлтийн төлбөрөөс чөлөөлнө.
- УНСС-ийн хөрөнгө мужийн хэмжээнд явагдаж буй уул уурхайн бүх төрлийн төсөл, үйл ажиллагаа (хайгуул, элс хайрга, эрдсийн олборлолт гэх мэт)-нд зарцуулагдана. УНСС-ийн хөрөнгөнд бодогдох хүүгийн ашгийг орхигдсон уурхайн нөхөн сэргээлтэд зарцуулна.
- Уул уурхай, Газрын Тосны Яамнаас жил бүр санхүүгийн тайлан гаргах ба тайланг олон нийт цахим хэлбэрээр, уурхайн үйл ажиллагааны байршил, уурхайн төрөл, эвдэрсэн газрын хэмжээ, зэрэглэлээр шүүн харах боломжтой байна.

(Эх сурвалж: Уурхайн Нөхөн Сэргээлтийн Сан <http://www.dmp.wa.gov.au/Environment/Mining-Rehabilitation-Fund-MRF-4906.aspx>)

Нөхөн сэргээлт хийх үйл явц (20 минут)

Уурхайн нөхөн сэргээлтийг дараах үе шаттайгаар явуулна:

1. Орчны суурь үнэлгээ, судалгаа, мэдээлэл цуглуулах
2. Бүтцийн хувьд тогтвортой газрын гадаргын хэв шинжид оруулах, хэлбэршүүлэх
3. Ургамалжуулалт ба газар ашиглалтын шинэ хэлбэр бий болгох
4. Нөхөн сэргээлтийн чанар, гүйцэтгэлийг үнэлэх орчны ХШ, аудит

Орчны суурь судалгаагаар хөрс, ургамлын нөмрөгийн онцлог, тухайн үеийн газар ашиглалтын хэлбэрүүд, уур амьсгал, гадаргын хэв шинж, биологийн олон янз байдал, усны нөөц, түүх, соёлын ач холбогдол бүхий газар байдаг эсэх зэрэг мэдээллийг цуглуулна. Ихэнх орнуудад суурь судалгаа буюу төлөв байдлын үнэлгээг уурхайн төлөвлөлтийн үе шатанд заавал хийхээр хуульчилсан байдаг (БОНБУ эсхүл уурхайн ашиглалтын лиценз олгоход тавигдах шаардлага хэлбэрээр). Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулинд ашигт малтмал эрэх, хайх, олборлох тусгай зөвшөөрөл шинээр олгоход төлөв байдлыг үнэлгээг заавал хийхээр хуульчилсан байдаг.

Монгол улсын стандартын дагуу уурхайн нөхөн сэргээлтийг техникийн ба биологийн гэсэн 2 үе шаттай хийнэ.

Техникийн нөхөн сэргээлт (газрын гадаргын хэлбэршүүлэлт): Үүнд ухаж эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, тэгшлэх, хөрсний сийрэгжүүлэлт хийх, биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэж шимт хөрсөөр хучих, бордох зэрэг багтана. Техникийн нөхөн сэргээлтийг уурхайн талбарын бүрэлдэхүүн хэсгүүдийн хэлбэр, хэмжээ (эзлэхүүн, өндөр, гүн), хаалтын дараах газар ашиглалтын төлөвлөгөө зэрэгт нийцүүлэн хийнэ. Аливаа уурхайн талбарт техникийн нөхөн сэргээлтийн явцыг үнэлэх ерөнхий шаардлагууд байна.

Тухайлбал:

- Уурхайн хатуу хог хаягдал, хуулсан хөрс, шороог холбогдох стандартын шаардлага хангасан орчин, нөхцөлд байрлуулах, агуулах, хадгалдаг байх
- Ил болон гүний уурхайн ухаш, нүх, цооногуудыг хаших, тэмдэглэгээ хийх эсхүл дүүргэлт хийн, тэгшилсэн байх
- Суваг, шуудуу, ус зайлуулах шугам, даланг тэгшлэх, дүүргэлт хийсэн байх
- Хэлбэршүүлэх талбайн байршил, налуужилтийг сонгохдоо үерийн ус, ус хурах нам дор цэгийг

Нөхөн сэргээлт хийх үйл явц

1. Суурь судалгаа
2. Газрын хэлбэршүүлэлт
 - Тогтвортой
 - Билэцдэлгүй
3. Газар ашиглалтад бэлтгэх
 - Ургамалжуулалт
 - Тусгай эсрчилэлт
4. Хяналт шинжилгээ
 - Явцын (хэргүүлэх) хяналт
 - Хяналтын дараах



тооцсон байх

- Гадаргын хэлбэржилтийг орчны гадаргын онцлогтой ижилсүүлсэн байх
- Нөхөн сэргээлт хийж буй гадаргууг эхлээд ургамлын үндэс ургах, ус нэвтрүүлэлтийг дэмжих уулын чулуулгаар, дараа нь шимт хөрсөөр хучсан байх
- Уул уурхайн ажилтай холбогдуулан чиглэлийг нь өөрчилсөн гол горхины голдрилыг хуучин сав буюу голын хөндий рүү чиглүүлж, хэлбэршүүлэн засах, усан сан байгуулах үед эргийн хэвгий, налууг үүсгэсэн байх.

Биологийн нөхөн сэргээлт (ургамалжуулалт). Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт өндөр бүтээмжтэй хөдөө аж ахуйн эдэлбэр газар бий болгох, уурхайн үйл ажиллагаанд элэгдэж эвдэрсэн газрыг сэргээн, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, мөн нөхөн сэргээлт хийж байгаа талбайг тухайн нутгийн ургамлын нөмрөгийн үндсэн хэв шинжид ойртуулах зорилготой. Биологийн нөхөн сэргээлтийг хийхэд компани дараах шаардлагуудыг хангах ёстой:

- Биологийн нөхөн сэргээлтийн үед сонгон авсан ургамлын төрөлд тохируулан хөрсний үржил шимийг малын өтөг бууц, сүрэл ашиглан сайжруулах
- Тухайн орон нутгийн нөхцөлд илүү зохицсон бутлаг ба модлог ургамлууд тарих, байгалийн үрээр тарихыг хичээх
- Нөхөн сэргээсэн талбайн сэргээсэн ургамлын нөмрөгийн бүрхэц ойролцоох нутгийн ургамлын нөмрөгийн 60 хувьд хүрсэн байх
- Нөхөн сэргээсэн талбайн ургамлын нөмрөгийн зүйлийн бүрэлдэхүүн ойролцоох эвдрээгүй талбайн зүйлийн бүрэлдэхүүний 30 хувьд хүрсэн байх

Үүнээс гадна нөхөн сэргээсэн талбайд тухайн орчинд дасан зохицсон мэрэгч, шавьж үзэгдэх нь биологийн нөхөн сэргээлтийн биелэлтийн үзүүлэлт болно.

(Эх сурвалж: Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, БОНХАЖЯ, 2015: <http://www.legalinfo.mn/law/details/11004>)

Явцын нөхөн сэргээлтийг жижиг дунд уурхайн компани хариуцлагатай хийж, эерэг үр дүнд хүрсэн туршлага.

Монполимет ХХК-ний Тосон уурхай (алтны шороон орд), Заамар сум, Төв аймаг.

Компани 1996 оноос хойш үйл ажиллагаа явуулж буй бөгөөд 2001-2015 оны хооронд нийт 783 га газар уурхайн ажилд өртсөнөөс 473 га талбайд биологийн нөхөн сэргээлт амжилттай хийсэн. Нөхөн сэргээсэн талбайд бэлчээр, ойн зурвас, жимсний модны төгөл, улсын усны санд бүртгэгдсэн хиймэл нуур зэрэг багтжээ. Хиймэл нууранд олон



төрлийн загас, усны ургамал, усны шувуудад амьдрах таатай орчныг бүрдүүлж экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болжээ. Жимсний модны төгөлд үхрийн нүд, чацаргана тариалсан ба хуураасан ургацаа уурхайн ажилчдын хүнсэнд хэрэглэдэг болсон. Уурхай өөрийн үрсэлгээ, суулгац бэлтгэх задгай болон хүлэмжийн орчинтой, агрономич, экологич, ой зүйч нөхөн сэргээлтээ гардан хийдэг. 2007 оноос 3 удаа аймаг, улсын хэмжээний нөхөн сэргээлтийн үзүүлэх сургалтууд зохион байгуулсан нь уурхайн компаниуд, төрийн байгууллагуудад сургалт, мэдээллийн өндөр ач холбогдолтой болсон.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах: <http://www.monpolymet.mn/portfolio/monpolymet-nuhun-sergeelt/>

Уурхайн нөхөн сэргээлтэд олон нийтийг оролцуулах нь

Компани уурхайн нөхөн сэргээлтийн үйл явцад олон нийтийн оролцоог хангаж, амжилттай ажилласан туршлага олон байдаг.

Олон нийт уурхайн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хаалтын дараах газар ашиглалтыг компанитай хамтран тогтоосон туршлага.

БиЭйчБи Биллитон Мицубиши Алаянс (БМА) Грегори Кринум уурхай (нүүрс), Квинсланд муж, Австрали. Уурхай 1979 оноос хойш ажиллаж буй бөгөөд 2002 онд уурхай тэлэх болсон холбогдуулан компанийн удирдлага орон нутгийн газар эзэмшигч, ашиглагч нартай зөвшилцөх шаардлагатай болсон. Уурхай тэлснээр ойр орчмын мал аж ахуй, газар тариалан, байгаль хамгааллын бүсд багтах томоохон хэмжээний газар нутагт нөлөөлөх, олон талуудын эрх ашиг хөндөгдөхөөр байв. Компани 18 сарын хугацаанд 16 удаа олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулсан. Үр дүнд нь фермерүүд, бүсийн болон дүүргийн төрийн байгууллага, байгаль орчны ажилтнууд, байгаль хамгааллын мэргэжилтнүүд, уурхайн байгаль орчин, нийгмийн асуудал эрхэлсэн ажилтнууд зэргээс бүрдсэн олон нийтийн бүлэг байгуулагдсан. Тус бүлэг тухайн нутгийн олон нийтийг төлөөлөн уурхайн хаалтын дараах газар ашиглалтын хэлбэр, нөхөн сэргээлтийн шалгуур үзүүлэлтийг тогтооход оролцсон. Уг хамтын ажиллагааны загварыг тус компани бусад уурхай дээр амжилттай хэрэгжүүлж байна.

(Эх сурвалж: Уурхайн нөхөн сэргээлт, Австралийн Хамтын Нөхөрлөл, 2006.

<http://www.industry.gov.au/resource/Documents/LPSDP/LSDP-Mongolian-MineRehabilitation-20130527.pdf>)

Нөхөн сэргээсэн газрын ХШ-нд олон нийтийг оролцуулах, шинэ үр чадварт сургах, дадлагажуулах нь орон нутаг, компанийн хооронд эерэг харилцааг бий болгодог. Компани уурхайн үе шатуудад олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог хангах түгээмэл хэлбэрүүдийг дараах хүснэгтэд харуулав.

Хайгуул, олборлолтын өмнөх үе

- Уламжлалт мэдлэгээс суралцах: малчид, өндөр настнууд тухайн нутгийн ус (гол, горхи, нуур), ургамал (эмийн, ховор, бэлчээр, тэжээлийн), биологийн төрөл зүйл, (ховор ан амьтан, ургамал), түүх, соёл, сүсэг бишрэлийн ач холбогдолтой газрын талаар ном, сурах бичигт тэмдэглэгдээгүй, уламжлалт мэдлэг, мэдээлэлтэй байдаг.
- Зөвлөлдөх: нөхөн сэргээлтийн зорилт, гүйцэтгэлийн итгэлцүүрийг тогтоох, хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг сонгох

Олборлолтын үе:


- Хөрс, ус, ургамлын ХШ, ажиглалт, хэмжилтэнд оролцох, мэдээлэл цуглуулах, дүйцүүлэн хамгаалах ажилд оролцох
- Хяналт шинжилгээ хийх, суулгаж, үрсэлгээ тарихад сургах, орон нутгийн ажиллах хүч бүрдүүлэх
- Уурхайн төлөвлөгөөг дахин хянах
- Нөхөн сэргээлтийн явцыг танилцуулах

Хаалт:

- Нөхөн сэргээлтийн үр дүнг үнэлэх
- Хаалтын төлөвлөгөөг хэлэлцэх
- Хөрс, ус, ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээ хийх
- Хаалтын дараа орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн стратегийг боловсруулах

Бүлгийн ажил: Биологийн нөхөн сэргээлт хийх ерөнхий дараалал (10 минут)

- Бүлэгт хуваагдах
- Хоосон нүдэнд тохирох алхмуудыг ярилцах, нөхөж бичих
- Үр дүнг танилцуулах



Сургагч багшид: Дээрх шаталсан аргазүйг баяжуулах, дэлгэрэнгүй тайлбар авах линк:

<http://esec.mn/backend/f/GiOZuOmg5i.pdf>

Түлхүүр.

Алхам 1. Үр соёлуулах, суулгац бэлдэх (хүлэмж, задгай талбайд). *унаган ургамлыг байгалийн үрээр тарих нь хог ургамал, түрэмгийлэгч ургамал ургах нөхцөлийг багасгадаг

Алхам 2. Техникийн нөхөн сэргээлт хийж, зассан талбайн өнгөн хөрсийг хагалах, сийрүүлэх, бордох *малын бууц, ургамлын биомасс өртөг багатай, сайн бордоо болдог.

Алхам 3. Суулгац, тарьц сийрүүлж, бордсон хөрсөнд шилжүүлэн суулгах *суулгацаа үндсэнд зууралдсан хөрстэй нь эсхүл (суулгац худалдаж авах тохиолдолд) бортгон савтай нь шилжүүлэн тарина. Энэ ургамал шинэ орчинд дасан зохицоход тустай.

Алхам 4. Тарьц суулгасан талбайг хаших, хамгаалах

Алхам 5. Усжуулалтын систем байрлуулах (дуслын усалгааны систем гэх мэт)

Алхам 6. Тарьсан суулгацаа арчлах, тордох, хамгаалах *хөрсний чийг, шим тэжээлээр хангаж, талбайг салхи, усны элэгдэл, мал орохоос сэргийлэх, хамгаалах

Нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ (10 минут)

Нөхөн сэргээсэн газрын ХШ-ний гол зорилго нь нөхөн сэргээсэн газар төлөвлөсөн зорилтод хүрч байгаа эсэхийг хянах, үнэлгээ өгөх юм. Хяналт шинжилгээгээр нөхөн сэргээсэн газрын хөрс, ургамалан нөмрөг, ус, биологийн төрөл зүйлд тогтоосон хэм, хэмжээний дагуу ажиглалт, хэмжилт хийх, дээж авах, анализ хийх зэргээр үнэлгээ өгнө. Хяналт шинжилгээний үндсэн бүрэлдэхүүн, түүнийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн жишээг хүснэгтээр үзүүлэв.

Хяналт шинжилгээний үндсэн бүрэлдэхүүн	Хэмжих үзүүлэлтүүд
Ургамлан нөмрөгийн бүтэц	<ul style="list-style-type: none"> Өндөр Зүйлийн бүрэлдэхүүн (унаган ургамал) Ургамлын бүрхэц Хог болон түрэмгийлэгч ургамал үзэгдэх байдал
Гадаргын ба налуужилтын тогтвортой байдал, хөрсний чанарын үнэлгээ	<p>Хөрсний чанар, хөрс боловсрох үйл явц (лаг, овоолго)-ыг үнэлэх үзүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> Биологийн (органик эдийн задрал, бичил биетний идэвх), Химийн (ялзмаг, рН, хүнд металын агуулга, цахилгаан дамжуулах чадвар) Физикийн (нягтшил, ус барих чадвар, ус нэвтрүүлэлт) <p>Элэгдэл, эвдрэлийн хэмжээ, гуу жалга үүсэлт.</p>
Уст цэгүүд	<ul style="list-style-type: none"> Ил уурхайн ухашийн ус Орчны гадаргын болон гүний усны чанар Хаягдлын сан, овоолгоос шүүрэх усны чанар
Экосистемийн нөхөн сэргээлтийн итгэлцүүрүүд	<ul style="list-style-type: none"> Амьдрах орчны нөхөн сэргэлт, шавьж, мэрэгч амьтад эргэн ирэх Хаалтын дараа төлөвлөсөн газар ашиглалтын хэлбэрт тохирох байдал (ургамлын биомасс агуулагдах микроэлементүүд (зэс, цайр, хром) зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрвэл мал идэхэд хортой)

(Эх сурвалж: Уурхайн нөхөн сэргээлт, Австралийн Хамтын Нөхөрлөл, 2006.

<http://www.industry.gov.au/resource/Documents/LPSDP/LSDP-Mongolian-MineRehabilitation-20130527.pdf>

Хяналт шинжилгээний хэмжилт, ажиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй аргагүйн дагуу гүйцэтгэнэ. Монгол оронд нөхөн сэргээсэн газрын ХШ-ний хөтөлбөр боловсруулах, гүйцэтгэхэд дараах стандартуудыг даган мөрдөнө:

- MNS 5917:2015. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- MNS 5918:2008. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага

Хаалтын дараах хяналт шинжилгээ

Нөхөн сэргээлт амжилт гаргаж:

- Орчны боловсрол уртасгаар байх
- Энгийн, хөдөөгийн менежментийг байх
- Газрын эдийн засгийн бүтэцтэй байх
- Тогтвортой нөхөрлөл өөрөө мөхөж ургах чадартай байх



- MNS 5850:2000. Хөрсний чанарын үнэлгээ
- Хэмжилт, дээж авах, анализ хийх аргазүйн бусад стандарт, аргачлал

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалд (БОНХАЖЯ, 2015) хаалтын нөхөн сэргээлт хийсэн газарт 3 жилийн турш ус, хөрсний бохирдлын ХШ хийх ёстой. Үүнээс сүүлийн 2 жилд бохирдол илрээгүй, тарьсан ургамлын 80% буюу түүнээс дээш ургалттай бол нөхөн сэргээлт хангалттай гэж заасан.

Сүүлийн жилүүдэд уурхайн нөхөн сэргээлтийн ХШ-г технологид суурилсан, илүү үр дүнтэй шинэлэг аргагүйг ашиглах болсон байна. Тухайлбал, экосистемийн функцийг анализ буюу ургамлын бүрхэц, хөрсний хими, физик шинж чанар, биологийн төрөл зүйлийн үзүүлэлтүүдийг нэгтгэн тухайн орчны экосистемийн нөхөн сэргээлтийг цогцоор үнэлэх, ХШ хийх аргагүйг Австрали, Канад зэрэг орнуудад түгээмэл ашиглаж байна. Түүнчлэн газарзүйн мэдээллийн сан (ГМС)-гийн арга уурхайн нөхөн сэргээлтийн ХШ-нд түгээмэл хэрэглэгдэж байна. ГМС нь сансрын хиймэл дагуулын мэдээлэл ашиглан газрын гадаргын зураглал гаргах, хэв шинжийг тодорхойлох хэрэгсэл юм. Ялангуяа нөхөн сэргээсэн талбайн бүрэлдэхүүн, хэлбэр хэмжээ, усны урсац (уурхайн хаягдал хураах сан) байгалийн уст цэгүүдтэй нийлэх цэг зэргийг зураглах боломжтой. ГМС-ийн гүнзгийрүүлсэн түвшний хэрэглээнд газрын хэвлий, түүний дотор хөрсний үе давхаргууд, гүний усны тархалт, ургамлын төрөл, зүйлийг өндөр нарийвчлалтай тодорхойлно.



Бүлгийн ажил (10 минут)

Хувилбар 1. Тухайн орон нутагт 5 жил ажиллах ил уурхайн хаалтыг төлөвлөх.

Даалгавар

1. Хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг сонгох, уурхайн нөхөн сэргээлтийн үр дүнг тодорхойлох, эдгээрийг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, нийгэм, байгаль орчны асуудлуудтай холбох
2. Дээрхийг үндэслэн хаалтын төлөвлөгөө гаргах

Хувилбар 2. Хаалтын дараах газар ашиглалтыг тооцон нөхөн сэргээлтийн зорилтыг тодорхойлох

Даалгавар.

- Хаалтын дараах газар ашиглалтын хэлбэрийг тогтоох

- Нөхөн сэргээлтийн зорилго, зорилт, итгэлцүүрийг дараах хүснэгт ашиглан тодорхойлох

Нөхөн сэргээлтийн Зорилго	Зорилтууд	Итгэлцүүрүүд	Төгс гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд
<i>Ж: газар ашиглалтын тогтвортой байдал</i>	<i>Ж: ургамлын нөмрөг өөрөө нөхөн эргэх чадвартай байх</i>	<i>Ж: унаган ургамлын зүйлүүд байх</i>	<i>Ж: сонгосон ургамал ургасан байх, зүйлийн бүрдэл, хог ургамлын менежмент бүрэн хийгдсэний нотолгоо</i>

Асуулт, хэлэлцүүлэг (5 минут)

- Уурхайн нөхөн сэргээлтийг хийх үйл явц, алхмуудыг нэрлэнэ үү?
- Танай уурхайн хувьд нөхөн сэргээлтийн үйл явцад олон нийттэй хамтран ажиллах ямар арга замууд байна вэ?
- Танай орон нутагт/танай уурхай нөхөн сэргээлт хичээлд дурдсан зарчмуудаар явагдаж байна уу?

Унших ном, материал

С. Цэдэндорж, С, Ж. Бямба-Оюу, М. Дагва “Уурхайн хаалт, эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь, Бодлогын судалгааны тайлан” 2009. http://forum.mn/res_mat/res_mat-197.pdf

Газрын нөхөн сэргээлт, олон нийтэд зориулсан гарын авлага, Азийн сан, 2008

<http://documents.tips/documents/-55720f56497959fc0b8c903c.html>

Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал, Азийн Сан, 2016 <http://esec.mn/backend/f/rd1B2g1QB4.pdf>

Уурхайн нөхөн сэргээлт, Австралийн Хамтын Нөхөрлөл, 2006.

<http://www.industry.gov.au/resource/Documents/LPSDP/LSDP-Mongolian-MineRehabilitation-20130527.pdf>

Үндсэн нэр томъёо, ойлголтуудын тайлбар

Үйл ажиллагаа бүрэн зогсох – уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай дах үйл ажиллагаа нэлэнхийдээ эсхүл

талбайн тодорхой хэсэгт үйл ажиллагаа бүрэн зогсох, төлөвлөсөн ажил хийгдэж дуусах.

Уурхайн хаалт – Төлөвлөх, Үйл ажиллагаа бүрэн зогсох, Хаалт, Газрыг хүлээлгэн өгөх зэрэг үе шатуудаас бүрдсэн үйл явц. Хаалт гэсэн нэр, томъёог үйл ажиллагаа зогсож, барилга байгууламжийг нүүлгэсний дараа уурхайн зүгээс зөвхөн нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээ хийх үеийг нэрлэх нь бий.

Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах – уурхайн үйл ажиллагаанд өртөх буюу өртөж болзошгүй амьдрах орчныг өөр газарт экосистемийн адил төстэй байдлаар бүрдүүлэх замаар хүрээлэн буй орчинд үзүүлэх хохирлыг “нөхөн төлөх” арга зам.

Өнгөн хөрс (шимт хөрс) – газрын гадаргын 0-20 см давхарга, ургамлын үндэс, шимт бодисууд, бичил биетнээр баялаг, хамгийн үржил шимтэй давхарга.

Явцын нөхөн сэргээлт – уурхайн олборлолтын шатанд хийгдэх техникийн болон биологийн нөхөн сэргээлт буюу “олборлолт хийнгээ нөхөн сэргээлт зэрэгцүүлэн хийх” үйл явц.

Нөхөн сэргээлтийн итгэлцүүр – хүрээлэн буй орчны чанар, төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд. Үзүүлэлтүүдийг хөрс, усны шинж чанар, экосистемийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг арга зүй, стандартад заасан хэмжигдэхүүнээр тогтооно.

МОДУЛЬ 9. ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРИУЦЛАГА

Сургалтын зорилго

Энэ модулийг судалснаар оролцогч нь дараах мэдлэг, чадварыг эзэмшинэ. Үүнд:

- Уул уурхайн салбар дахь ил тод байдал ба хариуцлагын ач холбогдол, үүргийг ойлгох
- Уул уурхайн салбар дахь ил тод байдал ба хариуцлагын бүрдэл хэсгүүд, шаардлагууд
- Монгол дахь уул уурхайн компаниуд ил тод байдал, хариуцлагын хувьд хууль эрх зүйн шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх талаар авч үзэх
- Орон нутгийн түвшинд ил тод байдал, хариуцлагын гол анхаарах асуудлуудыг судлах
- Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын /ОУИТБС/ мэдээлэлд энгийн дүн шинжилгээ хийх

Удиртгал

Модуль 9 нь уул уурхайн салбарт ил тод байдлыг хангах үндэслэлийг авч үзэж, ингэхдээ ил тод байдал, хариуцлага, мэдээллээр хангах, нээлттэй байдал зэрэг ойлголтуудыг судална. Энэ модуль нь уул уурхайн үйлдвэрлэлийн үйл явцын туршид ил тод байдлыг хангахад анхаарах гол асуудлуудыг авч үзнэ. Модулийн эхний хэсгийн гол анхаарал нь орон нутгийн түвшинд ид тод байдал ба хариуцлагыг хангах асуудал юм. Орон нутгийн иргэд, оролцогч талуудад хэрэгцээтэй тусгай зөвшөөрөл, гэрээ, үнэлгээний тайлан, худалдан авалт, ажил эрхлэлтийн тухай мэдээлэл зэргийг авч үзнэ.

Модулийн дараагийн хэсэгт Монгол улс дахь ОУИТБС-ын зорилго, үр дүнгийн талаар судалж, түүний цахим мэдээллийн сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.


Энэ бүлэгт авч үзсэн зарим онцлох сэдэв, асуудлууд:

- Уул уурхайн салбар дахь ил тод байдал ба хариуцлагын талаарх ойлголтууд
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл явц ба ил тод байдал
- Уул уурхайн орон нутгийн түвшин дэх ил тод байдал, хариуцлагын асуудал
- ОУИТБС

Жишиг хуваарь

- Уул уурхай дахь ил тод байдал ба хариуцлага (45 минут)
- Бүлгийн ажил: Уурхайн төслийн мөчлөг ба ил тод байдал (15 минут)
- ОУИТБС-ын тухай (15 минут)
- ОУИТБС-ын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь (10 минут)
- Асуулт, хэлэлцүүлэг (5 минут)

Сургалтын хэрэглэгдэхүүн

Лекцийн тэмдэглэл	Жишээ слайдууд
<p>Уул уурхай дахь ил тод байдал ба хариуцлага (ИТБХ) (45 минут)</p> <p>Уул уурхай дахь ИТБХ-ын ач холбогдол</p> <p>Ашигт малтмал нь ихэнх улс орнуудад ард түмний өмч байдаг. Ард түмний төлөөлөл болох төр нь компаниудад лиценз олгож, гэрээнд гарын үсэг зурдаг. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулийн 6.16 хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг. Энэхүү заалтын дагуу байгалийн баялаг ашигласнаас үүдсэн эрх, үүрэг, үр ашиг нь уул уурхайтай холбоо бүхий анхан шатны оролцогчдын бүлгүүдээс илүү өргөн хүрээнд нөлөө үзүүлнэ гэсэн тодорхой агуулгатай байна. Тусгаар улсын байгалийн баялгийн эзний хувьд тухайн орны иргэд нь байгалийн баялагийг олборлоход ямар шийдвэр гаргах, уул уурхайн компаниудаас тухайн улсын Засгийн Газар хэр хэмжээний хувь авах, уул уурхайгаас олсон орлогыг хэрхэн зарцуулах зэргийг мэдэх эрхтэй байдаг. Хэдий тийм боловч, эдийн засгийн үйл ажиллагааны бусад хэлбэрээс ялгаатай нь уул уурхайн олборлолт ихэнхдээ алс зайдуу газар явагддаг ба уул уурхайгаас олсон орлого нь ихэнх иргэдийн хувьд мэдэгдэлгүй үлдэх нь цөөнгүй байдаг. Иймээс, тохиромжтой зохицуулалт, зохистой чадавх дутагдсан тохиолдолд уул уурхайн салбарын чухал шийдвэрүүдийг хянахад хүндрэл учирч улмаар авилгал, муу менежментэд хүргэх аюултай.</p> <p>Байгалийн баялгийн засаглал, нөөц бололцоог хөгжилд ашиглаж чадахгүй байх нь ноцтой үр</p>	<p>Жишээ слайдууд</p>  <p>Авилгалын индекс</p>

дагаварт хүргэдэг. Уул уурхайн олборлолт нь авилгал, мөргөлдөөн, ядуурал, нийгмийн эмзэг байдал, байгаль орчны сөрөг нөлөөлөл гэх зэрэг олон ноцтой сорилтуудыг байгалийн баялаг бүхий олон орнуудад авч ирсэн. Олон Улсын Ил Тод Байдлын Авилгалын Төсөөллийн Индекс 2011 оны байдлаар хамгийн доор эрэмбэлэгдсэн хорин таван орны ойролцоогоор гуравны хоёртой харьцуулахад хамгийн өндөр эрэмбэлэгдсэн хорин таван улсын дөнгөж тавны нэг нь, газрын тос, ашигт малтмалын экспортод хамааралтай улс орнууд байна. Дэлхий даяар ойролцоогоор хагас тэрбум хүн хамгийн их байгалийн баялгаас хамааралтай орнуудад ядуурлын түвшинд амьдарч байна. Энэ элбэг байгалийн баялагтай холбоотой хөгжлийн сөрөг үр дагавар нь “баялгийн хараал” буюу “элбэг дэлбэгийн парадокс” хэмээх ойлголтод хамаардаг ажээ.

Баялагийн хараал: Орон нутгийн оролцогчдын бүлгүүд энэ нэр үгийг хэрхэн тайлбарлав?

Монгол Улсын Төв аймгийн Заамар суманд төслийн багийнхан сургалтын хэрэгцээ тодорхойлох үнэлгээний семинар хийж байх үеэр дараах хариултаудыг нутгийн иргэд өгсөн юм.

- Баялагийн хараал гэдэг нь Засгийн Газрын зохих төлөвлөлтгүйгээр уул уурхайгаас орж ирсэн орлогыг зарцуулахад бий болдог нөхцөл байдал юм.
- Цөөн тооны хэт хувиа хичээсэн хүмүүсийн ашиг сонирхол бусад хүмүүсийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдаж байгаа явдал.
- Лус догшруулах үйл ажиллагаа. Газар, шороо, гол, булаг бүгд эзэнтэй байдаг. Хэрвээ хүмүүс газар үхвал, гол, булаг тэднийг хараана.
- Баялагийн хараал гэдэг нь уул уурхайн орлогын буруу ашиглалтаас үүдсэн эдийн засгийн хямралын нэг хэлбэр юм.

Дэлхийн олон орон, бүс нутгуудаас “баялгийн хараал”-ыг харж болох боловч, Австрали, Ботсвана, Канад, Чили, Норвеги зэрэг орнуудын туршлагаас үзвэл хүчирхэг институт, сайн Засаглалтай байх нь баялгийн хараалыг бууруулж, байгалийн баялагтай оронд эерэг өсөлтийг авч ирэх боломжтойг харуулж байна. Ил тод байдал ба хариуцлага нь байгалийн баялагтай оронд засаглалыг сайжруулах, улмаар байгалийн баялгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг сайжруулах чухал шийдэл хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Жишээлбэл: Байгалийн Нөөцийн Дүрэм нь эерэг хөгжилд хүрэхийн тулд улс орнууд байгалийн баялагаа хэрхэн үр ашигтайгаар удирдахад туслах дэлхийн санаачилга юм (Дүрэм 2).

Засгийн Газар нь олон нийтийн өмнө хариуцлагатай үед л байгалийн баялаг нь иргэдийн нэрийн

өмнөөс удирдагдаж, тогтвортой хөгжил, цэцэглэлтэд хүрнэ. Зан үйлийн хатуу хяналт нь авилгалын эсрэг хүчтэй хориглолт болж, Засгийн Газрын бүх түвшинд ажил хэргийн гүйцэтгэлийг сайжруулах механизм болдог. Мөн түүнчлэн, байгалийн баялагийг удирдах үндэсний стратеги нь зөвхөн одоогийн болон ирээдүйн Засгийн Газруудын өөрт тавьсан зорилтуудыг энэ хатуу хяналт холбож байгаа үед л ирээдүйд үр ашигтай байх болно.


Засгийн Газрууд, уул уурхайн салбар, иргэний нийгмийн байгууллагууд авилгалын эсрэг илүү хатуу хууль тогтоомж, ил тод байдлын тухай хууль, шинэ тайлангийн систем, хариуцлагын механизм гэх зэрэг ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх янз бүрийн хэрэгслийг хөгжүүлдэг ч дэлхийг хамарсан онцгой өөрчлөлт хараахан бий болоогүй байна. Байгалийн Баялагийн Засаглалын Индекс байгууллагын судалгаанд хамрагдсан 58 орноос дөнгөж 11 оронд ил тод байдал, хариуцлагын стандарт хангалттай гэсэн дүнг үзүүлсэн байна.

Монгол Улс Авилгалын-Эсрэг Хууль 2006, Мэдээллийн Ил Тод байдал ба Мэдээлэл Авах Эрхийн тухай хууль 2011, Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа, Ажил, Үйлчилгээ Худалдан Авах тухай хуулийн 2011 оны өөрчлөлт, Ашиг Сонирхлын Зөрчлийн тухай хууль 2012, Шилэн Дансны тухай хууль 2014, Аудитын тухай хууль 2015 гэх зэрэг авилгалын-эсрэг, ил тод байдал, хариуцлагын тухай хэд хэдэн чухал хуулийг өнгөрсөн арван жилд батлан мөрдөж байна. Үүний дээр Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын тухай тодруулга, сүлжээнд-сүүрилсэн уул уурхайн кадастрын систем зэрэг бусад сэдэвчилсэн модулийн хэсэгт хэлэлцсэн зарим чухал нэмэлтүүдийг уул уурхайн салбар, донор-санхүүжилттэй санаачилгуудын ил тод байдалтай шууд холбоотой хууль, зохицуулалтад сүүлийн хэдэн жилд шинээр оруулсан. Хэдий тийм боловч хуулийн өөрчлөлт, бодит байдал хоёрын хооронд зөрүү байсаар байна. Доорх хүснэгтээс үзэхэд нэн ялангуяа Засгийн Газар уул уурхайн лиценз, орлоготой харьцаж байгаа байдал нь Монгол Улс дахь уул уурхайн салбарыг ил тод-биш байгааг тодорхой харуулж байна.

Монгол улсад авилгалд хамгийн их өртсөн таван институт

	Нэгдүгээрт	Хоёрдугаарт	Гуравдугаарт	Дөрөвдүгээрт	Тавдугаарт
2011	Газрын алба	Уул уурхайн газар	Шүүх	Гааль	Улс төрийн намууд
2012	Газрын алба	Уул уурхайн	Худалдан авах	Мэргэжлийн	Улс төрийн намууд

Байгалийн нөөцийн засаглалын индекс



		газар	ажиллагааны газар	Хяналтын газар	
2013	Газрын алба	Уул уурхайн газар	Худалдан авах ажиллагааны газар	Улс төрийн намууд	Гааль
2014	Газрын алба	Уул уурхайн газар	Худалдан авах ажиллагааны газар	Шүүх	Гааль
2015	Газрын алба	Улс төрийн намууд	Уул уурхайн газар	Засгийн Газар	Улсын Их Хурал

(Эх сурвалж. Asia Foundation. Survey on Perceptions and Knowledge of Corruption: Strengthening Transparency in Mongolia Project. 2015. www.asiafoundation.org/publications/pdf/1513)

Ил тод байдал ба хариуцлага (ИТБХ): гол ойлголтууд ба хэрэглээ

Ил тод байдал нь ямар нэгэн шийдвэр, гүйцэтгэлийн талаарх найдвартай мэдээлэлд цаг алдалгүй саадгүй хүрэх боломж юм. Хариуцлага гэдэг нь нийтээр эзэмших баялгийн ашиглалт, тогтоосон үйл ажиллагааны зорилтыг хангаж чадаагүйгээс үүдсэн үр дагаврыг тайлагнах механизмуудын цогц юм. Ил тод байдал, хариуцлага нь хоорондоо нягт уялдаатай: Хариуцлага байхгүй бол ил тод байдлын үнэ цэнэ бага байх болно. Өөрөөр хэлбэл, ил тод байдал нь хариуцлагын шаардлагатай нөхцөл боловч хангалттай нөхцөл байж чаддаггүй учраас автоматаар хариуцлагыг бий болгодоггүй. Ил тод байдалгүйгээр төрийн албаныханд хариуцлагатай байхыг уриалах хэцүү. Энэ хоёр нөхцөл нь хоёул төрийн институцуудын үр ашигтай, бүтээмжтэй, шударга байх урьдчилсан нөхцөл юм.

(Эх сурвалж: United Nations Committee of Experts on Public Administration (27-31 March 2006). "Definition of basic concepts and terminologies in governance and public administration." Fifth Session. New York. Web content retrieved from <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/un/unpan022332.pdf>)

Ил тод байдал

Хариуцлагыг бодвол уул уурхай дахь ил тод байдал хэмээх нэр томьёо нь харьцангуй ойлгомжтой байж болох юм. Гэсэн хэдий ч ил тод байдал нь ихэнхдээ мэдээллээр хангах, нээлттэй байх зэрэг ойролцоо ойлголтуудтай хутгалдаж байдаг. Энэ ойлголтууд бүгдээрээ адил биш ч бүгд нууцлаг байдал, авилгалын эсрэг 'вакцин' болдог юм. Нээлттэй байх гэдэг нь Засгийн Газар нь иргэд,

бизнес эрхлэгчдээ сонсдог, төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тэдний саналыг харгалзан үздэг гэсэн утгатай байдаг. Энэ утгаараа ил тод байдал нь нээлттэй байдлын урьдчилсан нөхцөл юм.

Мэдээ, мэдээллээр хангах нь мэдээллийг тараах бол, ил тод байдлын мөн чанар нь ялангуяа Засгийн Газар, уул уурхайн компаниудын хариуцлагатай байдлыг хангаж буй мэдээ, мэдээллийн хэрэгцээт байдал юм. Засгийн Газрын институцууд, төрийн, хувийн хэвшлийн компаниуд их хэмжээний мэдээллээр хангаж болох боловч, нийт ард иргэд, оролцогчдын бүлгүүд, хөрөнгө оруулагчид, орон нутгийн иргэд жинхэнэ нөхцөлийг мэдэж чадахгүй байж болох юм. Ард иргэдийн ихэнх хэсэгт хамаатай, олон нийтэд хүртээмжтэй мэдээллийг боловсруулах, бий болгоход бие даасан судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг байгууллагууд чухал үүрэгтэй. Ихэнх иргэд нийтийн мэдээллээс шаардлагатай мэдээллийг олж авах, боловсруулах цаг хугацаа, хангалттай чадамжгүй байж болно. Хянамгай боловсруулж, олон нийтэд нээлттэй болгох замаар дэлхийн олон оронд хараат бус хэвлэл мэдээллийнхэн, иргэний нийгмийн бүлгүүд бүрүү зүйлс, шударга бус байдлыг амжилттай илчилж ирсэн. Жишээлбэл: Засгийн Газрын институцуудын хоорондох зөрчил, дутагдлыг тодорхойлох, ашиглах замаар Шилэн Дансны тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг сайжруулахад олон нийтийн сүлжээний идэвхтнүүд голлох үүрэгтэй оролцсон.

Шилэн Дансны тухай хууль

Монгол Улс 2014 оны долдугаар сарын 1-ний өдөр (2015 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон) улсын болон орон нутгийн удирдлагын санд байгаа мөнгөн хөрөнгийг үр дүнтэй, зөв зарцуулах, төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг хангах зорилгоор Шилэн Дансны тухай хууль баталсан юм. Энэхүү хууль нь Засгийн Газар, орон нутгийн удирдлагын институц, төрийн өмчит үйлдвэр, байгууллагууд гэх зэрэг улсын болон орон нутгийн төсөвт ажил, үйлчилгээ явуулдаг хэд хэдэн байгууллагуудад жилийн төсөв, худалдан авалтын төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг (жил бүрийн Нэгдүгээр сарын 10-наас өмнө), сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг (дараа сарын 8-ны дотор), дараа жилийн тайланг (жил бүрийн Есдүгээр сарын 15-наас өмнө), төсвийн хуримтлал, илүүдэл, тэдгээрийн шалтгааныг (улирал бүр) гэх зэрэг цахим-хуудасны мэдээллийг ил тод тайлагнаж байх үүрэг хүлээлгэсэн. Эдгээр байгууллагууд нь таван сая төгрөгөөс (ойролцоогоор 2,700 ам доллар) илүү үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан бол түүнийхээ талаар тухайн тохиолдол болсон долоо хоногийн дотор дэлгэрэнгүй тайлагнах үүрэгтэй. Дээр дурдсан мэдээллээс гадна Сангийн Яам

орлого, зарлага, улсын төсвийн хөрөнгө оруулалт, концессын гэрээний гэх зэрэг мэдээллээр хангах ёстой. Шилэн Дансны хуулиар бол Сангийн Яам “шилэн дансны” төв цахим хуудсыг ажиллуулж, данс, санхүүгийн мэдээлэлд тусгайлан зориулсан хэсгээр дамжуулан бусад институцууд өөрсдийн цахим хуудсанд байгаа шаардлагатай мэдээллийг илгээнэ. Мөн энэхүү хуулийн дагуу хуулийн хэрэгжилт, ямар нэгэн болзошгүй зөрчлийн тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах замаар иргэд Шилэн Дансны хуулийн хэрэгжилтийг хянах боломжтой. Хэрэв гаргасан гомдол шийдэгдээгүй бол иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь шууд Төрийн аудитын байгууллагад гомдол гаргаж, аудит хийлгэх хүсэлт тавьж болно. Төрийн аудитын байгууллага шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох иргэн, олон нийтэд гарсан үр дүнгийн талаар бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

(Дэлгэрүүлж унших: Chris Melville. 2015. Mongolia introduces Law on Glass Accounts.
<http://www.hoganlovells.com/en/publications/mongolia-introduces-law-on-glass-accounts>)

Идэвхтэй ба идэвхгүйгээр мэдээллээр хангах

Мэдээллээр хангах нь идэвхтэй, идэвхгүй гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Идэвхгүй эсвэл хүсэлтэд тулгуурласан мэдээллээр хангах явдал нь олон нийтээс ирүүлсэн хүсэлтэд хариу өгөх төрийн байгууллагын эрх бүхий этгээдийн үүрэг хэлбэртэй байдаг. Идэвхтэй байдал нь төрийн байгууллагын эрх бүхий этгээдийн мэдээлэл цуглуулах, шинэчлэх, түгээх үүрэг юм. Хүсэлтэд-тулгуурласан мэдээллээр хангах явдал нь Иргэний болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пактын (ИУТЭОУП) 19 дүгээр зүйлд байдаг мэдээлэл олж авах эрхээс эх үндэстэй. Үүний дагуу “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.” 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 17 дугаар хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж заасан байдаг.

Мэдээллийг ил болгох ба бизнесийн нууц

Гэрээ, концесс, техник, эдийн засгийн үндэслэл гэх зэрэг уул уурхайтай холбоотой мэдээллийг авах хүсэлт

гаргахад компаниуд, Засгийн Газрын агентлагууд тэдний гаргасан хүсэлтэд компанийн нууцын хууль зүйн хамгаалалттай холбогдуулан татгалзсан хариу өгөх нь ердийн үзэгдэл байдаг. Монголд Мэдээллийн Ил Тод байдал ба Мэдээлэл Авах Эрхийн тухай хууль (2011), Байгууллагын Нууцын тухай (1995) хуулиудын дагуу компани нь нууц гэж тооцогдсон, өөрийн зах зээлд эзлэх хувиа хамгаалах, шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх зорилготойгоор технологийн шийдэл, төсөл, судалгаа, хөгжүүлэлтийн баримт бичиг, шаардлагатай тоног төхөөрөмж, машины тухай мэдээллийг хамгаалах эрхтэй байдаг. Хэдий тийм боловч компаниуд өөрсдийн бизнесийн нууцын жагсаалтыг тодорхойлох, түүнийг олон нийтэд мэдээлэх тухай албан ёсны дүрэм, журам батлан гаргавал зохино. Хамгийн гол нь иргэд, олон нийтийн эрж хайх мэдээллийн ихэнх нь дээр дурдсан компанийн нууцтай холбоотой мэдээлэл биш уул уурхайн төсөлтэй холбоотой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Хариуцлага

Хариуцлага гэдэг нь хүний эрх, шударга ёс, тогтвортой хөгжил гэх зэрэг илүү өргөн хүрээтэй багц зорилтуудад хүрэх тухай ойлголт юм. Хариуцлага гэсэн нэр томъёо нь дараах хоёр гол бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг:

- Хариу өгөх боломж: хариуцлагыг үүрч байгаа этгээдүүд болон байгууллагууд тэдэнд хариуцлага тооцох эрхтэй этгээдүүдийн өмнө өөрсдийн гаргасан шийдвэр, хийсэн үйлдлээ зөвтгөх, мэдээллээр хангах үүрэгтэй. Энэхүү гаргасан шийдвэр, хийсэн үйлдлээ тайлагнах, өмгөөлөх явдал нь олон нийтэд нээлттэй байх учиртай. Үүний тулд албан тушаалтнууд тухайн шийдвэрт хүргэсэн бичиг баримт, суурь судалгаа, зөвлөгөөний тайлан, мэргэжилтнүүдийн өгсөн мэдүүлэг зэрэг нотлох баримтыг үзүүлэх ёстой байдаг.
- Албадлага: ажлаа хангалттай гүйцэтгээгүй, үүргээ зөрчсөн этгээдүүдэд шийтгэл оноох эрх нь хариуцлага тооцох эрхтэй этгээдүүд байдаг. Зохицуулалтыг үр ашигтай байлгахын тулд шийтгэлийн механизм байвал зохино. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хариуцлагыг бэхжүүлэхэд парламент, шүүх, хяналтынхан, авилгалын эсрэг болон аудитын агентлагууд, иргэний нийгмийн хүчирхэг байгууллагууд голлох үүрэгтэй. Дараах хоёр мэдээлэл нь хариуцлагын албадлагын бүрэлдэхүүнийг үзүүлж байгаа юм.

(Эх сурвалж: DIFID. 2009. Accountability Briefing Note. www.gsdr.org/docs/open/innovations-in-accountability/ia4.pdf)

Чили Улс байгаль орчны зөрчлөөс болоод Текийн уурхайн ашиглалтын зөвшөөрлийг цуцалж

магадгүй байна (2015 оны 7 сарын 23)

Чили Улсын байгаль орчны асуудлыг зохицуулагч ЭсЭмЭй, Кармен де Андаколло зэсийн уурхайн байгаль орчны асуудлаас болж Тек Ресурсын эсрэг хориг арга хэмжээ эрэлхийлж байгаа юм байна. Тек Ресурс нь уурхайн зөвшөөрлөө хураалгаж, 4 сая хүртэлх ам долларын торгууль төлөх эсвэл төслийнхөө байгаль орчны зөвшөөрлөөс татгалзах зэрэг хориг арга хэмжээтэй тулгараад байгаа юм байна. Усны хангалттай дэд бүтэц барьж байгуулаагүй гэсэн зөрчил удирдах албаныхны дурдсан зөрчлүүдийн дотор байсан байна. Компанид асуудлуудыг шийдэх төлөвлөгөөгөө танилцуулах 10 хоног эсвэл нотлох баримт бүрдүүлж өгөх 15 хоногийн хугацаа байгаа юм.

(<http://www.mining.com/chile-may-revoke-tecks-copper-mine-permit-over-environmental-breaches/>)

Бразилийн шүүх уурхайгаас урссан бохирдолтой орчинд байгаа компаниудын хөрөнгийг царцаалаа (2015 оны 12 сарын 20)

Шүүх тосгодыг бүлжилсэн үхлийн хорт хаягдлаас учирсан хохирлын төлбөрийг төлөх асуудлыг баталгаажуулахаар уул уурхайн томоохон компаниуд болох Вэйл, БиЭйчПи Билтон компаниудын Бразил дахь эд хөрөнгийн битүүмжиллээ. Өнгөрсөн 11 сард далан сэтэрч Бразилын экологийн хамгийн том сүйрэл хэмээн тооцогдсон хэдэн арван хүн нас барж, олон зуун хүнийг орон гэргүй болгон, Досе Голын ойр орчимд 800-км ийн урт газрыг бохирдуулсан үйл явдал болсон юм.

(<http://www.dw.com/en/brazilian-courts-freezes-companies-assets-in-mining-spill/a-18930273>)

Ил тод байдал, хариуцлага ба уул уурхайн үйлдвэрлэлийн үйл явц

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл явц буюу үнэ цэнийн хэлхээ нь ашигт малтмалыг олборлох алхмаас эхлээд, түүнийг боловсруулах, зарж борлуулах хүртэл бүх замын турш үргэлжисэн орлогын зарлагыг хэлнэ. Үнэ цэнийн гинжин холбоо нь уул уурхай дахь ил тод байдал, хариуцлагыг ойлгох, тэдгээрийг сайжруулахад ашиг тустай бүтэц юм. Ил тод байдал, хариуцлага нь бүхий үе шат бүрт байх ёстой.

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл явц / үнэ цэнийн хэлхээ



<p>Үнэ цэнийн гинжин холбоо</p>	<p>Илүү ил тод байдал, хариуцлагыг бий болгоход чиглэсэн үйлдэл</p>	
<p>Ашигт малтмалыг илрүүлэх, эрх авах</p>	<ul style="list-style-type: none"> • Лиценз, геологийн судалгаа, кадастр, нөөц газрын тухай мэдээ, тайлангуудыг ил болгох • Үндэсний кадастрын болон үндэсний мэдээллийн сангийн хөгжил • Байгаль орчны, нийгмийн нөлөөллийн үнэлгээний мэдээллээр хангах • Үндэсний, орон нутгийн түвшний гэрээ хэлэлцээрийн тухай мэдээллээр хангах 	
<p>Олборлолтын зохицуулалт ба хяналт</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний мэдээллээр хангах, албадан гүйцэтгэх • Орон нутгийн иргэдийн түвшинд зөвлөлдөж, тэдний оролцоотой хяналт тавих • Үйлдвэрлэл, экспортын тоо хэмжээнд тогтмол аудит хийх • Олборлолт явуулж байгаа компанийн нэр, ашиг хүртэгч өмчлөгчийн талаарх мэдээллээр хангах 	
<p>Татвар, төлбөрийг цуглуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Байрлал, төсөл, бүтээгдэхүүний төрөл гэх зэрэг зохих түвшний задаргаа бүхий уул уурхайн мэдээллээр хангах • Нөөц ашигласны төлбөр, орлогын татвар, ноогдол ашиг, нийгмийн хувь нэмэр, болон бусад санхүүтэй холбоотой нэр томъёог тодорхойлохын тулд нягтлан бодох бүртгэлийн журмын тодорхой хууль зүйн ухагдахуун бий болгох • Засгийн Газрын данс, компанийн санхүүгийн тайланд тогтмол аудит, тохируулга хийх • ОУИТБС гэх зэрэг тодруулах механизмаар уул уурхайн үйл ажиллагаанаас үүсч байгаа орлогын мэдээллээр тогтмол хангах 	
<p>Орлогын менежмент ба түгээлт</p>	<ul style="list-style-type: none"> • Орлогын менежментийн ил тод шийдвэр гаргах журмыг бий болгох • Ямар нэгэн хуримтлалын зохицуулалтад ил тод байдлын журмыг хэрэглэх • Тайлан тэнцэл дээрх Засгийн Газрын мөнгөн сангийн мэдээлэл, мөнгөний урсгал, төлбөр хүлээн авагч, аудит тайланг ил болгох 	

	<ul style="list-style-type: none"> • Засгийн Газар болон орон нутгийн удирдлагын хооронд орлого хуваах ил тод, энгийн журмыг бий болгох
Тогтвортой Хөгжлийн бодлого/төсөл	<ul style="list-style-type: none"> • Зарлагыг тайлагнах, зарлагын аудитыг тогтмол хийх • Дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийхэд өрсөлдөөн, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлт, худалдан авалтын журмыг сайжруулах

(References: EI Sourcebook. Transparency and Accountability.

http://www.eisourcebook.org/625_4TransparencyandAccountability.html. NRG1. Natural Resource Charter -Precept 2:

Accountability and transparency <http://resourcegovernance.org/approach/natural-resource-charter/precept-2-accountability-and-transparency>; Eleodoro Mayorga Alba.2009. Extractive Industries Value Chain. World Bank; Daniele La Porta. 2011. Extractive Industries Value Chain. EITAF.

<http://www.eisourcebook.org/cms/files/learning/4%20EI%20Value%20Chain%20-%20EI%20Source%20Book.pdf>)

Орон нутгийн түвшний ил тод байдал, хариуцлага

Уул уурхайн олборлолтын нөлөө, үр ашиг нь улсын хэмжээнийхийг бодвол орон нутгийн түвшинд өөр байдаг. Иймээс орон нутагт шаардлагатай мэдээллийн хэрэгцээ ч мөн адил өөр байдаг. Харамсалтай нь уул уурхайн төсөлд хамгийн их өртөж байгаа орон нутгийн иргэд ихэнхдээ боломжит нөлөөлөл, үр ашгийн талаарх маш бага мэдээлэл хүлээн авдаг. Үндэсний үйлдвэрлэл, нийт эдийн засгийн өсөлт гэх зэрэг нэгтгэсэн мэдээлэл нь заримдаа орон нутгийн түвшин дэх уурхайн олборлолт руу чиглэсэн буруу ойлголцол, үл итгэлцэлд хүргэдэг. Компани мэдээллээр хангасан ч орон нутгийн иргэдэд компанийн үйл ажиллагааны бодит нөлөөлөл, үр ашгийг ойлгоход байгаль орчны зузаан тайлан, нэгтгэсэн санхүүгийн тоо баримт нь өчүүхэн үүрэг гүйцэтгэдэг.

Байгаль орчны нөлөөлөл, ажил эрхлэх боломж, олон нийтийн хөгжлийн хөтөлбөр, дэд бүтцийн хөгжил гэх зэрэг яаралтай шийдэх хэрэгтэй асуудлуудын тухай санааширсан орон нутгийн оролцогчдын хувьд цаг хугацаа маш чухлаар тавигддаг. Орон нутгийн удирдлага, олон нийтийн уул уурхайн үйл ажиллагааны талаарх ярвигтай мэдээлэлд хүрэх, боловсруулах чадамж нь боловсрол, сургалт, цаг хугацаа, интернет гэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан маш бага байж болно.

(References: Rebecca Iwerks and Varsha Venugopal. 2016. It Takes a Village: Routes to Local-Level Extractives Transparency. NRG1)

Ердийн олон нийтийг бодвол тухайн нутгийн удирдлага, орон нутгийн иргэдэд уул уурхайн үйл ажиллагааны тухай илүү тодорхой, яаралтай мэдээлэл авах хэрэгцээ байдаг. Дараах асуудлууд нь уул уурхайн үнэ цэнийн бусад асуудлуудыг бодвол тэдэнд илүү хамааралтай байж болох юм.

Лиценз (тусгай зөвшөөрөл), лиценз хуваарилалтын ил тод байдал

Орон нутагт явагдаж байгаа уул уурхайн ажлуудын хамгийн ерөнхий мэдээллийг өгөх үүрэг хэрэгжихгүй байх үед орон нутгийн иргэдийн дунд нийтлэг тавигддаг асуулт нь бидний газрыг хэн ухаад байна гэсэн асуулт байдаг. Нутгийн иргэд лиценз олгох үйл явц, уул уурхайн лицензтэй холбоотой орон нутгийн газрын хэсэг, ирээдүйд уул уурхайн олборлолт явуулахаар төлөвлөж, хуваарилсан орон нутгийн газрын хэсэг, олборлолтын лиценз олголтоос өмнөх орон нутгийн зөвлөлдөх үйл явц, лиценз шилжүүлэлт, лицензийн төлбөр, лицензийн асуудлуудын тухай нарийн мэдээлэл олж авах суваг зэргийн мэдээлэл эрж хайдаг. Энэ төрлийн мэдээллийг бүрэн хэмжээгээр ил болгох явдал нь уул уурхайн төсөлд хэн өртөгдөх, түүнчлэн, орон нутгийн газар ашиглалтын төлөвлөгөөг ямар хэмжээнд сайжруулах, газар ашиглалтын зөрчлийг бүүруулах тухай нэгдмэл ойлголтыг бий болгох юм.

Ашигт Малтмалын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 1.22. дугаар хэсэгт ‘сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй танилцах бололцоо олгох, эдгээр бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар зохих байгууллагад мэдэгдэж нийтэд мэдээлэх’ гэж заасан байдаг. Монгол Улсын Ашигт Малтмалын Газрын Кадастрын хэлтэс 2014 онд бодит цагийн холболттой шинэ цахим порталыг кадастрын мэдээллийн баазтай холбон ажиллуулж эхэлсэн (<https://cmcs.mram.gov.mn/cmcs>). Энэхүү портал хуудас нь Монгол Улсад явагдаж байгаа ашигт малтмалын лиценз олгох үйл ажиллагааны тухай мэдээллийг интернетээр дамжуулан ард иргэд, төр, хувийн хэвшлийн байгууллагын удирдлагууд, байгууллагуудад хүргэх замаар уул уурхайн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэх гол зорилготой юм. Ашигт малтмалын лицензийн талбайн тендер, нэвтрэх хуудас, бичиг баримт, өргөдөл гаргахад шаардлагатай гол мэдээллүүд зэрэг уул уурхайн салбарт одоо явагдаж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг сэргээх, ашигт малтмалын лиценз олгох бодит цагийн хандах эрх олж авах боломжийг сүлжээний порталаар хүрч буй үйлчилгээгээр зочилсон этгээдүүд авах боломжтой. ОУИТБС-ын хэсэгт хэлэлцэх Монголын ОУИТБС-ын Тайлангууд болон шинэ Цахим-Тайлангийн систем лицензийн талаар олон төрлийн мэдээлэл өгдөг.

Байгаль орчин ба нийгмийн нөлөөллүүд

Орон нутгийн иргэдэд уул уурхайн байгаль орчны менежментийн ил тод байдал чухал хэрэгтэй байдаг. Тэд уул уурхайн компани юу хийхээр төлөвлөөд байгаа, уурхай хэр том болж өргөжих, ямар технологи ашиглах, эсвэл бүр байгаль орчин, орон нутгийн иргэдэд ямар нөлөөлөл үзүүлэх талаар мэдэх хэрэгтэй. Уурхайн олборлолтоос болж үүсдэг байгаль орчны нөлөөллийн хамрах хүрээ, ноцтой байдлын (аюулын түвшин) мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх хэрэгтэй. Байгаль орчны нөлөөллийн талаарх иргэдийн харах хүрээ нь ил тод байдал, мэдээллийн хүртээмжтэй байдлын эрэлттэй холбоотой олон нийтийн хүчтэй шаардлагад хүргэдэг. Түүнээс гадна, Засгийн Газраас баталсан байгаль орчны үйл явцад орон нутгийн засаг захиргаа, нутгийн олон нийт, байгаль орчныг хөдөлгөөний идэвхтнүүд ихэнхдээ итгэдэггүй. Хэдийгээр энэ нь иргэдийн Засгийн Газарт итгэх ерөнхий итгэлтэй холбоотой боловч энэ нь мөн орон нутгийн засаг захиргааг оролцуулан, орон нутгийн оролцогчдын бүлгүүд, уул уурхайн компаниуд хоорондох мэдээллийн тэнцвэргүй байдалтай холбоотой байдаг. Мэдээллийн тэнцвэргүй байдал нь мөн хөгжиж буй олон орны Засгийн Газрын агентлагууд, уул уурхайн компаниудад илэрч байдаг. Засгийн Газрын агентлагууд нь ихэнхдээ хувийн компаниудын бэлтгэсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, тайланд найддаг ба тэд санал болгож буй төслийн бүх нөлөөлөлд сайтар дүн шинжилгээ хийх, бүх уул уурхайн компаниудын байгаль орчны гүйцэтгэлийг хянаж, шалгах чадавх сул байдаг.

Дэлхий даяар олон газар орон нутгийн иргэд нь эсэргүүцэл, зөрчилд хүргэсэн уул уурхайн байгаль орчин, нийгмийн тухай асуудлуудад санаа зовнидог. Дэвис, Франк нарын тэмдэглэснээр (2014) байгаль орчны бохирдол, байгалийн нөөцийг ашиглах өрсөлдөөн нь уул уурхайн зөрчлийг үүсгэдэг хамгийн түгээмэл асуудлууд юм. Компаниудын ил болгож байгаа байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мэдээлэл нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, 'олборлолтын 'нийгмийн зөвшөөрөл' олж авахад чухал шаардлагатай байдаг. Байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой асуудлын талаарх мэдээллээр хангах нь байгаль орчныг хамгаалах, нөөцийг ашиглахтай холбоотой мэдээлэлд хамаарах ба, нийгмийн нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг ил болгох нь ихэвчлэн компанийн орон нутгийн иргэд болон ажилчидтайгаа харьцах харилцааны тухай мэдээлэлд хамаарна. Компанийн нийгмийн болон байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг ил болгох нь Байгаль Орчны Тайлангууд, Олон Нийтийн Тайлангууд, Тогтвортой Хөгжлийн Тайлангууд, тогтмол хэвлэлийн мэдээнүүд, цахим хуудсанд тавигдсан мэдээллүүд зэрэг олон хэлбэртэй байж болно.

Гуравдагч этгээдээр баталгаа гаргуулах замаар зарим компаниуд тайландаа оруулсан мэдээллийнхээ чанарыг нэмэгдүүлдэг.

Монгол Улсын хувьд техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, олборлосон газрыг нөхөн сэргээхэд зориулсан сангийн тухай мэдээлэл, ус, газар ашиглалтын мэдээлэл, үйлдвэрлэлийн эрүүл мэнд, аюулгүй байдлын мэдээлэл, дэд бүтэц хөгжүүлэх, ашиглах төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө, нөхөн олговрын хөтөлбөр, орон нутгийн эдийн засгийн оролцоо, олон нийтийн хөрөнгө оруулалт, Засгийн Газрын хяналт шалгалтын тайлан, уурхайн хаалтын төлөвлөгөөний мэдээлэл зэргийг орон нутгийн иргэд ихэнхдээ шаарддаг. Эдгээр мэдээлэл нь боломжит байгаль орчны нөлөөлөл, санал болгож байгаа төслийн талаар баримтад суурилсан санал боловсруулах, бодит нөлөөллийг хянах, зохистой нөхөн төлбөр авахыг баталгаатай болгох, сөрөг нөлөөллийг буруулах, нөхөн сэргээх ажилд оролцох боломжийг нутгийн удирдлага, иргэдэд ойлгох боломж олгодог. Компаниудын хувьд ил тод байдал нь үл итгэлцлийг бууруулж, “олборлолтын нийгмийн зөвшөөрөл”-ийг авах эсвэл баталгаажуулах боломж олгоно.

(Эх сурвалж: Jenkins, H, and Yakovleva, N. 2006. Corporate social responsibility in the mining industry: Exploring trends in social and environmental disclosure. Journal of Cleaner Production. Journal of Cleaner Production, 14, 271-284; Davis, Rachel and Daniel M. Franks. 2014. “Costs of Company-Community Conflict in the Extractive Sector.” Corporate Social Responsibility Initiative Report No. 66. Cambridge, MA: Harvard Kennedy School.)

Орон нутгийн түвшний гэрээ хэлэлцээрийн ил тод байдал

Уул уурхайн компаниуд, иргэд, тэдний төлөөлөгчдийн хооронд хийгддэг, ихэвчлэн “Олон Нийтийн Хөгжлийн Гэрээ”, “Нөлөөлөл, Үр Ашгийн Гэрээ” хэмээн нэрлэгддэг гэрээг хэрэглэх явдал уул уурхайн салбарт нэмэгдэж байна. Австрали, Канад зэрэг цөөхөн хэдэн орны уул уурхайн салбарын нутгийн иргэдтэй (Орон Нутгийн Уугуул Иргэд) гэрээ хийх явдал нь стандарт үйл явц болсон байхад, энэ нь байгалийн баялаг ихтэй хөгжиж буй олон орны хувьд харьцангуй шинэ зүйл юм. Монгол Улсын хуулиар бол олон нутгийн түвшний гэрээ нь уул уурхайн компани, хүлээн авч байгаа орон нутгийн удирдлага хооронд хэлэлцээр хийхийг шаарддаг.

Худалдааны нууц мэдээллийг хамгаалах нууц заалтуудаас болоод ихэнхдээ ард түмэнд ил болгодоггүй Засгийн Газар, уул уурхайн компаниудын хооронд хийгддэг гэрээнээс ялгаатай нь

хамрах хүрээ, агуулга нь үйлдвэрлэл, орлого хуваалт, технологийн талаар гэхээсээ нөлөөлөл, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэрийг хамтран удирдахад чиглэсэн байдаг учраас орон нутгийн түвшинд хийгдэж байгаа гэрээ ил тод байвал зохино. Гэрээний ил тод байдлын эсрэг ердийн маргаан энэ тохиолдолд хэрэг болохгүй. Гэсэн хэдий ч Хамтын Ажиллагааны Гэрээ, Нийгмийн Хариуцлагын Гэрээ гэх зэрэг орон нутгийн түвшний гэрээнүүд нь ихэнхдээ олон нийтэд ил тод байхын эсрэг тодорхой хязгаарлалтгүй ч нийтэд хүрдэггүй.

Хэдий тийм боловч, сайн жишиг бас байгаа. Өмнөговь аймаг, Оюу Толгой Компани хоёрын хооронд 2015 оны Дөрөвдүгээр сард хийсэн Хамтын Ажиллагааны Гэрээ нь дөнгөж хийгдсэнийхээ дараа олон нийтэд нээлттэй болсон. Үүний дээр, саяхнаас Монголын орон нутгийн түвшний гэрээний нээлттэй мэдээллийн баазыг Монголын ОУИТБС болон бусад байгууллагууд үүсгэн бий болгоод байна. Энэ нь орон нутгийн түвшний гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээллээр хангахад орон нутгийн олон нийт шаардахад бодууштай зүйл юм.

(Эх сурвалж: Д.Бямбажав, 2015. Монголын уул уурхайн орон нутгийн түвшний гэрээний ил тод байдлыг сайжруулах нь. http://goxi.org/profiles/blogs/mongolia-s-model-cda-intent-and-limitations?xg_source=activity)

Орлогын урсгал ба менежмент

Олон орны нутгийн удирдлагууд компаниудаас тэдэнд төлөх шууд төлбөр, улсаас орон нутагт шилжүүлж байгаа төлбөрийн аль нэг хэлбэрээр олборлох үйлдвэрлэлээс шууд орлого олдог (NRGI, 2015).

Шууд төлбөр: компанийн орон нутагт төлж байгаа шууд төлбөр нь гэрээний үүрэг, улсын хууль, орон нутгийн зохицуулалтын дагуу байж болно. Жишээлбэл: Индонез, Филиппин улсуудын орон нутгийн удирдлагууд өөрсдийн олгосон ашигт малтмалын олборлолтын лицензээс төлбөр авдаг.

Уул уурхайн орлого шилжүүлэлт: уул уурхайн орлогын шилжүүлэлт нь тухайн улсын Засгийн Газар уул уурхайн компаниудаас хурааж авсан орлогоо олборлолт явагдаж байгаа дүүрэг, аймаг, орон нутагтай хуваалцаж байгаа явдал юм. Орон нутагт хэр их мөнгө шилжүүлж байгаа нь улс бүрт өөр өөр байдаг. Зарим орнууд тухайн орон нутгаас олсон орлогын тодорхой хувийг орон нутагт буцаан

олгодог. Харин зарим улсад тухайн орон нутгийг хүн ам, нэг хүнд ногдох орлого эсвэл орлого хураан авах хүчин чармайлт гэх зэрэг хэд хэдэн онцлог шинжид суурилан орон нутаг бүрийн авах хувийг тооцоолдог уул уурхайн орлогыг хуваарилах хуулиар тогтоосон томъёоллыг ашигладаг байна.

(Iwerks, R and Venugopal, V. 2016. It Takes a Village: Routes to Local-Level Extractives Transparency. NRG. <http://www.resourcegovernance.org/analysis-tools/publications/it-takes-village-routes-local-level-extractives-transparency>)

Уул уурхайн орлогын хуваарилалт: Орон Нутгийг Хөгжлийн Сан

Монголд уул уурхайгаас олсон орлого нь орон нутгийн санхүүжит, Орон Нутгийн Хөгжлийн Сан (ОНХС) хэлбэртэйгээр тараадаг. Хуулийн дагуу дотоодын Нэмэгдсэн Өртөгийн Албан Татварын 25 хувь, уул уурхайн нөөц ашигласны төлбөрийн 5 хувь, газрын тосны нөөц ашигласны 30 хувь, орон нутгийн төсвийн илүүдэл нутгийн удирдлагад шилждэг. Засгийн Газар эхлээд энэхүү мөнгийг Орон Нутгийн Хөгжлийн Нэгдсэн Санд /ОНХНС/ шилжүүлэх ёстой. Үүний дараагаар энэхүү мөнгөн хуримтлалыг аймаг, нийслэлд хүн ам, хүн амын нягтаршил, алслагдсан байдал, орон нутгийн хэмжээ, хөгжлийн шалгуур үзүүлэлт, татвар үүсгэх чадамж зэргийг багтаасан томъёоны дагуу дахин хуваарилах хэрэгтэй. Аймаг, нийслэлд хамгийн багадаа энэ санхүүжилтийн 60 хувийн сумдад дахин хуваарилах нь зүйтэй. Монгол Улсын Засгийн Газар 2015 онд ОНХНС-д шилжүүлсэн нөөц ашигласны төлбөр 30 хувийг өөрийн нутаг дэвсгэртээ уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аймгуудад шууд шилжүүлэх хэрэгтэй гэсэн шинэ хууль баталсан юм. Эдгээр аймгууд нь мөн ашиглалтын төлбөрийн гуравны нэг хувийг уул уурхайн үйл ажиллагааг өөрийн нутаг дэвсгэр дээрээ явуулдаг сумдад хуваарилах ёстой юм. Үүний дээр, лицензийн төлбөрийн 50 хувь нь уул уурхайн үйл ажиллагааг өөрийн нутаг дэвсгэр дээр явуулдаг аймгийн ОНХС-д байрших ёстой. Үүний мөн 50 хувийг уул уурхай эрхэлдэг сумдад шилжүүлэх ёстой. Энэ шинэ орлого хуваарилах зохицуулалт нь “том хэмжээний уул уурхайн төслүүдэд” хэрэглэгдэхгүй болно.

(Эх сурвалж: NRG. Кейс: Монгол Орлого Хуваарилалт.

http://www.resourcegovernance.org/sites/default/files/nrgi_sharing_Mongolia_revenue-sharing.pdf.)

Үр дүнтэй орлогын ил тод байдал нь Засгийн Газар, орон нутгийн иргэд, компаниудад чухал ашиг тустай

- Авилгалаас урьдчилан сэргийлж, орон нутгийн засаг захиргааны үйлчилгээний чанарыг сайжруулна
- Уул уурхайн компаниуд болон Засгийн Газрын агентлагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ

- Өөр өөр оролцогчдын бүлгүүдийн хоорондох мэдээллийн тэнцвэргүй байдлыг бууруулна
- Орон нутгийн удирдлага, иргэд, компаниудын харилцан итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлнэ
- Байгаль орчны менежмент, олборлосон газрыг нөхөн сэргээлт сайжирна

Орон нутгийн контент

Орон нутгийн засаг захиргаа, иргэд уурхайн амьдралын мөчлөгийн турш ямар төрлийн ажлуудад хичнээн иргэнийг авч ажиллуулж болох болон тэдгээр ажлуудыг хийж сурахад шаардлагатай сургалтын тухай маш их сонирхдог. Мөн нутгийн иргэд төсөл дээр ажиллуулахаар төлөвлөсөн ба үнэхээр ажиллах (гадны иргэд болон тухайн улсын иргэдийн харьцаа) тухайн улсын иргэд болон орон нутгийн иргэдийн харьцааны тоон задаргааны тухай мэдээллийг сонирхдог. Компаниуд шаардлагатай үр чадвар шаардсан ажил, ажилд авах үйл явцын тухай мэдээллийг аль болох эрт нийтэд мэдээлэх хэрэгтэй.

Хэрвээ боломжтой бол энэ төрлийн мэдээлэлд шаардлагатай бараа, үйлчилгээ, тэдгээрийг гүйцэтгэх гэрээ байгуулсан орон нутгийн, улсын, гадаадын байгууллагуудын хувь хэмжээ, ханган нийлүүлэлтийн үйл явц, шаардлага зэрэг мэдээллүүд агуулагдсан шууд бус эдийн засгийн хөгжлийн боломжууд байвал зохино.

Энэ төрлийн мэдээллээр хангах нь нутгийн захиргаа, иргэдэд компанийн үүргийн гүйцэтгэлийг хянах, орон нутгийн эдийн засгийн төлөвлөлт хийх, орон нутагт бизнесийг хөгжүүлэх боломжийг олгодог. Харин компаниудад орон нутгийн олж байгаа ашиг, уул уурхайн төслөөс бодит ашиг хүртэгчдийг хянах боломж олгоно.

(Эх сурвалж.Rebecca Iwerks and Varsha Venugopal. 2016. It Takes a Village: Routes to Local-Level Extractives Transparency. NRG1)

Ашиг хүртэгч өмчлөгч

Уул уурхайн компаниудын жинхэнэ өмчлөгчдийн биеийн байцаалтыг - ‘ашиг хүртэгч өмчлөгч’ - ил болгох нь уул уурхайн салбарын ил тод байдалтай холбоотой чухал асуудал юм. Зарим олборлогч компаниуд татвараас зайлсхийх эсвэл Засгийн Газрын өндөр албан тушаалтантай холбоотой

харилцаагаа нууцлахын тулд өмчлөгчдөө нууцалдаг. Жишээлбэл: 2010-2012 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дор хаяж 1.36 тэрбум америк долларыг таван уул уурхайн гэрээнээс алдсан, яагаад гэвэл тэд нууц компанийн өмчлөгчийн ард нуугдсан байсан. “Ашиг хүртэгч өмчлөгч”-тэй холбоотой мэдээллийг тайлагнах нь дээр дурдсан сөрөг практикийг илрүүлэх, бууруулахад тус дөхөм болох болно. (NRGI, 2015)

Монголын Олон Талт Орлоцогчдын Бүлгүүд (ОТОб) 2014 онд дараа жилийн ОУИТБС Тайланд ашиг хүртэгч өмчлөгчийн тухай мэдээллийг оруулахаар шийдсэн юм. ОТОб олборлолтын лицензийн 5% болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг энгийн асуулгын хуудсаар дамжуулан мэдээлхийг хүссэн юм. Хэдийгээр энэ нь сайн дурын судалгаа байсан ч гэсэн 250 компаниас 215 ашиг хүртэгч өмчлөгчтэй холбоотой мэдээллээ ил болгосон юм. Үүгээр 215 компанийн 215 нь хувь хүн, 144 нь аж ахуйн нэгж, 13 нь төвийн эсвэл орон нутгийн захиргааны хуулийн этгээд гэсэн 368 хувьцаа эзэмшигч тодорхойлогдсон байна. Шинээр 2016 онд батлагдсан ОУИТБС-ын Стандарт нь бүх хэрэгжүүлэгч улсуудыг 2020 он гэхэд ашиг хүртэгч өмчлөгчийн шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх баталгаатай байхын тулд замын зураглал хийхийг шаардсан байна.

(Эх сурвалж: ОУИТБС. 2016. Ашиг Хүртэгч Өмчлөгч. https://eiti.org/files/eiti_bo_factsheet_en_final.pdf; EITI. Pilot project. <https://eiti.org/pilot-project-beneficial-ownership>)

Компанийн хувьд нь бенефициар өмчлөгч хувь хүн (хүмүүс) аж ахуйн нэгжийг шууд болон шууд бусаар өмчилдөг юм уу эсвэл аж ахуйн нэгжийн аж ахуйн нэгжийг хянадаг эцсийн өмчлөгч, хянагч гэсэн үг юм. Дараах жишээ ашиг хүртэгч өмчийн тухай мэдээллээр хангахын ач холбогдлыг ойлгоход тустай.

Азербайжан Улсын Човдар Уурхайн Кейс

Азербайжаны Олон Улсын Эрдэсийн Олборлогч Компанийг ('АОУЭОК') Човдар алтны уурхай болон бусад таван уурхайг ашиглахыг 2007 онд гарсан хоёр тогтоолоор зөвшөөрсөн юм. АОУЭОК нь тухайн зургаан уурхайн эзэмшлийн хувьцааны 70%-ийг эзэмшдэг ба үлдсэн 30%-ийг Азербайжаны Засгийн Газар эзэмшдэг байна. Үнэндээ АОУЭОК нь Londex Resources, S.A, Willy and Meyris S.A, Fargate Mining Corporation, Globex International LLP гэсэн дөрвөн гадаадын компаниас бүрдсэн концерциум юм. Азербайжаны албаныхны хэлж байгаагаар дөрвөн компани дөрвүүлээ өөрийн гэсэн өмч, үйл ажиллагаагүй (бизнесийн шилжүүлгийн

хөдөлгүүр болдог) компаниуд бөгөөд зөвхөн энэ хэлэлцээрт зориулагдан үүсгэн байгуулагдсан ба тухайн компаниуд нь уул уурхайн салбарт ажиллаж байсан туршлага, өөр уул уурхайн төсөлтэй эсэх талаар нотолгоо байхгүй байсан байна. Консерциумын тав дахь компани болох Mitsui Mining Development Engineering Co Ltd ('MINDECO') нь Japan's Mitsui Mining and Smelting Company ('JMIMSC') компанийн охин компани юм. Хэдийгээр JMIMSC нь MINDECO-ийн албан ёсны харгалзагч гэж заагдсан ч гэсэн энэ компани нь өмчлөгчгүй буюу хэн өмчилдөг нь тодорхойгүй байсан байна.

Консерциумд багтсан компаниудын нэг болох Их Британид байрладаг Globex компани нь уурхайнуудын нийт хувьцааны 200 сая долларын үнэ бүхий 11 хувийг эзэмшдэг байна. Гэсэн хэдий ч энэ компани нь Панамд бүртгэлтэй Hising Management SA, Lyndel Management Group, Inc, Arblos Management Corporation гэх гурван компанийн өмч юм. Сонирхолтой нь гурван компанийн гурвуулангийнх нь ахлах менежерүүд нь Азербайжаны ерөнхийлөгч Илхам Алиевийн охид болох Лейла Алиева, Азру Алиева болон Швейцарийн бизнесмэн Оливер Местелан гэсэн нэртэй байсан байна.

Азербайжаны ерөнхийлөгчийн 2006 оны захирамжаар Globex компани консерциумын бүрэлдэхүүнд багтсан байна. Дараа жил нь АОУЭОК консерциум 30 жилийн хугацаатайгаар уурхайнуудыг ашиглах эрхийн эзнээр шалгарсан байна. Азербайжаны Байгаль Орчны Яамны тайлангаар Човдар нь бусад уурхайнуудаасаа хамгийн баялаг нь бөгөөд 2.5 тэрбум ам долларын үнэ бүхий алт (44 тонн), мөнгөний (164 тонн) орд юм.

2007 оны 6 дугаар сард болсон Парламентын сонсголын үеэр консерциумын өмчлөгч нь тодорхойгүй, шалгаруулалт нь тендерийн үйл явцыг зөрчсөн, консерциумын гишүүд нь уурхай ажиллуулах туршлагагүй, тендер нь Азербайжаны ард түмний үндэсний ашиг сонирхолтой зөрчилдсөн гэсэн үндэслэлүүдээр АОУЭОК консерциумыг шалгаруулсан шийдвэрийг парламентын гишүүд эсэргүүцсэн байна.

Хэдийгээр Азербайжаны хууль ерөнхийлөгч болон Засгийн Газрын гишүүдийг бизнес эрхлэх эрхийг хаасан боловч энэ хязгаарлалт нь эдгээр албан тушаалтнуудын гэр бүлийн гишүүдийн бизнес эрхлэх эрхийг хязгаарлаагүй юм. Энэ бол олборлогч компанийн ашиг хүртэгч өмчлөгчийг төлөөлөн өөр хүн үйл ажиллагаа явуулж байгаа жишээ юм.

(Эх сурвалж: OCCRP. 2012 Azerbaijan's President Awarded Family Stake in Gold Fields.
<https://www.occrp.org/en/investigations/1495-azerbaijans-president-awarded-family-stake-in-gold-fields>)

Бүлгийн ажил (15 минут)

Сонголт 1

Оролцогчид 4-6 хүнтэй баг болгон хуваагаад, дараах асуултуудыг хэлэлцэхийг хүсээрэй. Баг бүр өөрсдийн тоймыг танилцуулах ёстой. Уурхайн амьдралын мөчлөгийг үзүүлэхдээ зураг, график ашиглаарай.

Асуулт 1: Уурхайн амьдралын мөчлөг бүрт ил болговол зохих, ил болгох хэрэгтэй мэдээллийн үндсэн төрөл юу юу байж болох вэ?

Асуулт 2: Уурхайн амьдралын мөчлөгийн үед ил тод байдал, хариуцлагатай байдлыг хангах шүүхийн бус ямар арга зам эсвэл алхам байж болох вэ?

Сонголт 2

Оролцогчдыг 4-6 хүнтэй баг болгон хуваагаад дараах хүснэгтийг ашиглан өөрийн аймгийн юм уу, сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын ил тод байдлыг үнэлэхийг хүсээрэй. Багууд хүснэгтийг засаж, өөрчилж болно. Баг бүр тоймоо танилцуулах ёстой.

Мэдээллийн ил тод байдал	Компани А	Компани Б	Компани В
Лиценз			
Нөлөөллийн менежмент			
Орлого			
Орон нутгийн эдийн засгийн хүртээмж			
Нийгмийн зарцуулалт			
Тойм			
Тэмдэглэл			

Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (15 минут)

ОУИТБС нь баялгийн хараалын хариу үйлдэл юм; Үүнийг байгалийн баялагтай хөгжиж буй орнуудыг байгалийн баялгаа илүү үр ашигтай ашиглахад туслах зорилготойгоор Их Британийн Засгийн Газраас 2003 онд эхлүүлсэн үйл ажиллагаа юм. Тэр цагаас хойш ОУИТБС байгалийн баялагтай

орнуудад ил тод байдал, хариуцлагыг дэвшүүлсэн хамгийн өргөн тархсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стратеги болсон юм.


ОУИТБС-д нэгдсэн байгалийн баялагтай орнууд хэд хэдэн тодорхой үйлдлүүдийг хийх шаардлагатай байдаг.

- Нэгдүгээрт, эдгээр улсуудын Засгийн Газрууд өөрийн нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулж байгаа олборлогч аж ахуйн нэгжүүдийг энерги, эрдэс баялаг хайх, олборлох эрхийнхээ дагуу "юу төлснөө хэвлүүлэхийг" шаардах.
- Хоёрдугаарт, засгийн газар хүлээж авсан орлогоо баримтжуулах ёстой ба хараат бус мэргэжлийн аудитын байгууллага компаниудын төлсөн төлбөр ба хүлээн авсан баримтыг тулгадаг.
- Эцэст нь, Засгийн Газрууд Иргэний Нийгмийн төлөөллийг багтаасан олон талт оролцогчдын бүлгийг үүсгэнэ. Энэхүү олон талт оролцогчдын бүлэг нь компаниуд, Засгийн Газраас өгсөн мэдээллийг үнэлэх, бие даасан аудитын байгууллагын үнэлгээнд хяналт тавих үүрэгтэй.

ОУИТБС Стандарт нь жил бүр Олборлох Салбарын аж ахуйн нэгжүүдийн төлсөн төлбөр, Засгийн Газраас ирүүлсэн төлбөрийн баримтыг хянан, ОУИТБС-ын стандартын дагуу тохируулгын үр дүнтэй хамт тухайн орны олборлох салбарын талаарх мэдээллийг оруулсан зохицуулах тайлан гаргахыг шаарддаг.

ОУИТБС-ын 2016 Стандартын дагуу дараах мэдээллүүдээр хангах шаардлагатай:

- Гэрээ, лицензийн хуваарилалтыг багтаасан хуулийн, институцийн тогтолцоо: хуулийн тогтолцоо, санхүүгийн дэглэм, лиценз хуваарилалт, лицензийн бүртгэл, гэрээ; ашиг хүртэгч өмчлөгч; олборлогч салбар дахь төрийн оролцоо.
- Олборлолт ба үйлдвэрлэл: олборлолтын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, экспортын тухай мэдээ.
- Орлого цуглуулах: татвар, орлогын тухай дэлгэрэнгүй мэдээллээр хангах, бүтээгдэхүүний хувийн улсын худалдаа, болон дараах төрлөөр цуглуулсан бусад орлого, дэд бүтцийн заалтууд, бараа солилцох арга, Төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйлгээ, орон нутгийн төлбөр, задаргааны түвшин, мэдээний цаг хугацаа, мэдээний чанар.



- Орлого хуваарилалт: орлого түгээлт, орон нутгийн гүйлгээ, орлогын менежмент ба зарлага.
- Нийгмийн ба эдийн засгийн зарлага: компаниуд, төрийн өмчит үйлдвэрийн газрын quasi-fiscal зарлага, эдийн засагт оруулж байгаа олборлогч салбарын хувь нэмэрийн тойм

2015 он гэхэд ОУИТБС-д 48 орон нэгдэн орсон байна. Монгол Улс анх 2006 онд тохируулга хийхээр ОУИТБС-ын Стандартыг хэрэгжүүлсэн ба хамгийн сүүлийн 2015 оны тайланг орлцуулан есөн Монголын ОУИТБС тайланг гаргасан байна. Манай улсын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгын Үндэсний Зөвлөлийг ерөнхий сайд толгойлдог. Одоогоор Үндэсний Зөвлөл нь Уул Уурхайн Яамны стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, ОУИТБС-ын ажлын хэсгийн зохицуулагч, Байгаль Орчны Иргэний Зөвлөлийн Удирдах Зөвлөлийн гишүүн, Уул Уурхайн Холбооны ерөнхийлөгч гэсэн гишүүдээс бүрдэж байна.

2014 онд Монголын ОУИТБС Цахим-Тайлангийн систем нэвтрүүлсэн (M.EITI, 2015). Цахим-Тайлангийн системийн олон давуу талуудын дотроос жирийн иргэдийн мэдээлэлд хандах боломж нэмэгдэх нь хамгийн чухал ач холбогдолтой юм. Мөн түүнчлэн Цахим-Тайлангийн систем нь Монгол, Англи хэл дээр байх бөгөөд энэ нь Монголчууд болон сонирхсон гадныханд мэдээллийг хүргэх боломжтой болгож байгаа юм.

Түүнчлэн, шинэ Цахим-Тайлангийн систем нь мэдээлэл цуглуулах хугацаа, тайланд гарах алдааны эрсдэл, тайлагнагч аж ахуйн нэгжүүдийн нийт ачааллыг буруулдаг. Монголын ОУИТБС Нарийн Бичгийн Газрын авсан судалгаагаар тайлан гаргаж байгаа аж ахуйн нэгжүүдийн 71% нь тайлангийн мэдээлэлд зориулан гурав хүрэхгүй хоног зарцуулсан бол, 69% нь Цахим-Тайлангийн систем хэрэглэхэд хялбар байсан гэсэн судалгаа гарсан байна.

(Эх сурвалж: EITI. 2016. The EITI 2016 Standard. <https://eiti.org/document/standard>; M.EITI Mongolia. 2015. 9th EITI Report; Dorjdari, N. 2013. Data mining: An Analysis of 2006-2011 EITI reports. http://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=948&menu_id=3&resmenu_id=113)

Бүлгийн ажил: ОУИТБС-ын мэдээллийн шинжилгээ (10 минут)

1. <http://e-reporting.eitimongolia.mn/> гэсэн цахим хуудсыг нээгээрэй.

2. <http://e-reporting.eitimongolia.mn/reportList> хуудас руу ороорой.
3. 4-5 хүнтэй бүлгийн оролцогчдоос нэг сум сонгоод, тухайн сумын нутаг дэвсгэр дээр лицензтэй, олборлолт явуулж байгаа бүх компаниудыг сонгохыг хүсэх. Компанийн тайланг ашиглан сумын түвшний ОУИТБС-ын тайлангийн тойм бэлтгээрэй.
4. Хэрвээ шаардлагатай бол ОУИТБС-ын цахим хуудсанд байрлуулсан видео хичээлүүдийг үзээрэй.

Асуулт, хэлэлцүүлэг (10 минут)

- Илүү ил тод байх нь Засгийн Газар, компани, иргэний нийгэм, олон нийтэд ямар ашигтай вэ?
- Үндэсний, орон нутгийн түвшний ил тод байдал, хариуцлагын хоорондох гол ялгаанууд юу вэ?
- ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийн үр ашиг нь юу вэ?

Ном, унших материал

Пол Коллиер. Адагт үлдсэн тэрбум. Улаанбаатар

Rebecca Iwerks and Varsha Venugopal. 2016. It Takes a Village: Routes to Local-Level

Extractives Transparency. NRGi. <http://www.resourcegovernance.org/analysis-tools/publications/it-takes-village-routes-local-level-extractives-transparency>

NRGi. Natural Resources Charter. <http://resourcegovernance.org/approach/natural-resource-charter>

Х.Наранжаргал ба бусад, D. 2005. Мэдээллийн эрх чөлөө

http://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=909&menu_id=3&resmenu_id=59

Цахим хэрэглэгдэхүүн

Resource Governance Index <http://www.resourcegovernance.org/resource-governance-index>

'Glass Accounts' <http://www.shilendans.gov.mn/>

EITI Mongolia E-reporting system <http://e-reporting.eitimongolia.mn/>

Global Reporting Initiative. <https://www.globalreporting.org/>

Үндсэн нэр томъёо, ойлголтуудын тайлбар

Олборлогч үйлдвэрлэл - ихэнхдээ газрын тос, байгалийн хий, уул уурхайн салбаруудад хамаардаг.

Хариуцлага - Нийтийн өмчийн баялгийг ашиглах, тогтоосон зорилтуудын гүйцэтгэлийг хангаж чадаагүйгээс үүдсэн үр дагаварыг тайлагнах механизмын цогц.

Ашиг хүртэгч өмчлөгч - Аж ахуйн нэгжийг шууд болон шууд бусаар эцэслэн өмчилж, хянаж байгаа хүн (хүмүүс).

Кадастр - Газрын тос, байгалийн хий, уул уурхайн лицеэзийн албан ёсны бүртгэл. Энэ бүртгэлд ихэнхдээ лиценз эзэмшиж байгаа компанийн нэр, лицеэнзийн хугацаа, лицензийн талбайн солбицол зэрэг мэдээллийг агуулдаг.

Баялгийн хараал - Байгалийн баялгаас олсон орлого нь хүний хөгжлийн муу стандарт, муу засаглал, авилгал, заримдаа зөрчилд хүргэдэг үзэгдэл юм.

Ил тод байдал - Шийдвэр, гүйцэтгэлийн тухай цаг алдаагүй, найдвартай мэдээлэлд саадгүй нэвтрэх явдал.

ОУИТБС-ын Тайлан - ОУИТБС-ын Стандартыг хэрэгжүүлэгч улс орнууд тухайн орныхоо байгалийн баялгаас олсон орлого болон олборлолтын тухай бусад мэдээллээр хангасан ОУИТБС-ын Тайлангуудыг гаргах ёстой байдаг.